

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛЖ БУЙ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ /2015-2020/

Судалгааны захиалагч: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Судалгааны багийн гишүүд:

Б.Алтангэрэл

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

М.Хүрэлбат

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

Агуулга

Өмнөх үг		4
Товчилсон үгийн жагсаалт		5
Нэр томъёоны тайлбар		6-8
Зураг, хүснэгтийн жагсаалт		9-10
Нийгэмшүүлэх ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн акт		11-14
Удиртгал		15-37
НЭГ. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ОНОЛЫН АСУУДАЛ		
1.1.	Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын ойлголт, онцлог	38-62
1.2.	Монгол Улсад хорих байгууллагад хоригдлыг нийгэмшүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал	62-91
ХОЁР. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛЖ БҮЙ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ		
2.1.	Хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ	92-106
2.2.	Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ	107-123
2.3.	Хорих байгууллагын нийгмийн ажилтан, түүний чиг үүрэгт хийсэн шинжилгээ	124-131
ГУРАВ. ХОРИГДЛЫГ НИЙГЭМШҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ		
3.1.	Хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой Олон улсын баримт бичиг	132-139
3.2.	Гадаадын зарим оронд хоригдлыг нийгэмшүүлж буй байдалд хийсэн шинжилгээ	140
3.2.1.	Оросын Холбооны Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	140-151
3.2.2.	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	151-153
3.2.3.	Америкеей Нэгдсэн Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	153-155
3.2.4.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	155-164
3.2.5.	Англи Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	164-167
3.2.6.	Франц Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	167-168
3.2.7.	Польш Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог	168-169

3.2.8.	Финляндын хорих байгууллагын нийгмийн ажлын онцлог	169-170
3.2.9.	Швейцарын хорих байгууллагын нийгмийн ажлын онцлог	170-171
3.2.10.	Япон улсын хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын онцлог	171-175
3.2.11.	Канад улсын хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын онцлог	175-176
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ		
4.1.	Дүгнэлт	177-183
4.2.	Зөвлөмж	183-184
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ		185-187
ХАВСРАЛТ		188-222

Өмнөх үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгын дагуу Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв, Хорих ял эдлүүлэх албаны Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс хамтран “Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан нь 2015-2020 оны хооронд хорих байгууллагад явагдсан хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн судалгааны бүтээл юм.

Дэлхийн улс орнуудын эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого, үзэл баримтлалдаа тусган, хэрэгжүүлж буй нэг үндсэн асуудал нь хорих ял шийтгэгдсэн этгээдийг нийгэмшүүлэн, дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршиж байна.

Монгол Улсын Хорих байгууллагын үйл ажиллагаанд хоригдлыг нийгэмшүүлэх арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш даруй 20-д жил болсон хэдий ч тухайлан үр дүнг тооцон, хэрэгжилтийг эрх зүйн зохицуулалтын болон практикийн хүрээнд судлан, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон судалгаа шинжилгээний бүтээл хомс байна.

Түүнчлэн шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актын хүрээнд өөрийн орны хорих байгууллагын нийгэмшүүлэх ажиллагааны нөхцөл байдлыг тоймлон харах боломжийг энэхүү дүн шинжилгээний тайлан олгоно гэдэгт итгэж байна.

Судалгааны тайланд нийгэмшүүлэх ажлын чиглэлээрх мэргэжлийн багш, судлаачдын бүтээлээс онолын хувьд тусгаж өгсөн ба гадаадын зарим орны хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх үйл ажиллагааны онцлогын талаар мэдээлэл оруулсан нь танин мэдэхүйн болоод судалгаа, шинжилгээний чухал ач холбогдолтой материал болсон гэж найдаж байна.

Судалгаанд ашигласан статистик тоо баримт, үйл ажиллагааны мэдээлэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон холбогдох хорих ангиудын албан ёсны тайлан, мэдээнд тулгуурласан хэдий ч энэхүү судалгааны тайлан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагын байр суурь болон үйл ажиллагааны чиг хандлага, хэрэгжилтийн түвшинг илэрхийлээгүй, зөвхөн судлаачдын хөндлөнгийн судалгаа боловсруулалтын ажлын үр дүн болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хамтран ажилласан Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс болон судалгааны мэдээлэл цуглуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач, практик ажилтнууд, магистрант нарт талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Б.АЛТАНГЭРЭЛ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ, ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА

Товчилсон үгийн жагсаалт:

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
УДШ	Улсын Дээд Шүүх
ХЯЭА	Хорих ял эдлүүлэх алба
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
ХАДЖ	Хорих ангийн дотоод журам
НААЗ	Нийгмийн ажлын аргачилсан заавар
НСЗХ	Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс

Нэр томьёоны тайлбар

(Нийгэмшүүлэх ажиллагаанд хамаарах зарим нэр томьёог тайлбарлав.)

Албадан эмчлэх	
	сэтгэцийн болон согтуурах мансуурах донтой, халдварт өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх ажиллагаа.
Албан тушаалтан	
	улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан.
Биечилсэн хяналт, хамгаалалт	
	Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төрөл бөгөөд алба хаагчдын хүчээр гүйцэтгэнэ.
Биеийн хүч	
	бие хамгаалах урлагийн мэхээр тулалдах, довтлох, хамгаалах, няцаах, баривчлах, хүлэх, боох, тонгорох, өчих гэх мэт биеийн хүчээр хийх үйлдэл.
Гадаадын иргэн	
	Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн.
Гомдол	
	төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт
Гэмт хэрэг	
	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй.
Гэм буруу	
	бусдын өмнө хийсэн алдаа дутагдал, гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна.
Дэглэм	
	хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр юм.
Захидал	
	хүмүүсийн энгийн харилцаанд ашиглан илгээх бичиг.
Зарчим	
	Нийгмийн амьдралын эрх зүйн бодит байдлыг ханган, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж.
Итгэмжлэл	
	өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх бүрэн эрхийг нөгөө этгээдэд бичгээр тодорхойлсон баримт.
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамруулах	
	тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон

	харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа.
Мэргэжлийн дадлага олгох	
	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын үйл явц.
Нээлттэй, хаалттай хорих анги	
	хорих ял эдлүүлэх дэглэмийн төрөл.
Нээлттэй, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэл	
	хорих ял эдлүүлэх дэглэмийн ангилал
Нээлттэй, хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл	
	хорих ял эдлүүлэх дэглэмийн ангилал
Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал	
	түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирсан үйлдэл.
Нийгэмшүүлэх ажил	
	хоригдлыг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамран, суллахад бэлтгэх, сулласны дараах үйл явцаар дуусгавар болдог сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, анагаах, хууль зүй, нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай нөлөөллийн цогц арга хэмжээ.
Хорих ял	
	иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжуулан цээрлэл амсуулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг төрийн албадлагын онцгой төрөл юм.
Хорих байгууллага	
	эрүүгийн ял гүйцэтгэх тогтолцооны төрөлжсөн байгууллага.
Хорих ял эдлүүлэх ажиллагаа	
	хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйлийг төлөвшүүлэн нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хуулиар эрхийн хязгаарлалт тогтоон, тодорхой дэглэм, журмын хүрээнд аюулгүй байдлыг ханган хорьж буй арга хэмжээ.
Хоригдол	
	хорих ял эдэлж байгаа ялтан
Хорих анги	
	шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага
Хорих ангийн дарга	
	хорих ангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаалтан
Хорих ял эдлүүлэх албаны дарга	
	хорих ангиудын үйл ажиллагааг нэгдсэн болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтан
Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс	
	хүний оюун ухаан, бие бялдын хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж, тахир дутуу хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас хэсэгчлэн алдсан болон

	шалтгаан түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох мэргэжлийн үйл ажиллагаа.
Сахилгын зөрчил	
	мөрдөгдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан үйлдэл.

Зураг, хүснэгтийн жагсаалт:

Зураг 1.	Судалгаанд хамрагдагсдын хүйсийн байдал
Зураг 2.	Судалгаанд хамрагдагсдын насны байдал
Зураг 3.	Судалгаанд хамрагдагсдын урьд ял эдэлж байсан талаарх судалгаа
Зураг 4.	Судалгаанд хамрагдагсдын боловсрол
Зураг 5.	Судалгаанд хамрагдагсдын мэргэжил
Зураг 6.	Судалгаанд хамрагдагсдын гэр бүлийн байдал
Зураг 7.	Хоригдлоос авсан нийгэмшүүлэх ажлын ойлголтын талаарх асуулгын дүн
Зураг 8.	Хоригдлын нийгэмшүүлэх ажлын хэрэгцээний судалгааны дүн
Зураг 9.	2015- 2019 оны нийт хорих ял эдлэгсэдийн судалгаа
Зураг 10.	Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн судалгаа /2015-2020/
Зураг 11.	Хугацааны өмнө суллагдсан хоригдлуудын судалгаа /2015-2020/
Зураг 12.	Давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдлэгсэдийн судалгаа /2015-2020/
Зураг 13.	Давтан гэмт хэрэг үйлдэгчдээс авсан судалгааны дүн /2015-2020/
Зураг 14.	Дэглэм буурсан хоригдлуудын судалгаа /2015-2020/
Зураг 15.	Дэглэм дээшилсэн хоригдлуудын судалгаа /2015-2020/
Зураг 16.	Хорих ял эдлүүлэх нөхцөл, журмын талаарх асуулгын дүн
Зураг 17.	Хорих ангид хөдөлмөр эрхэлдэг талаарх асуулгын дүн
Зураг 18.	Суллагдсаны дараах төлөвлөгөөны асуулгын дүн
Зураг 19.	Суллагдахын өмнөх хийгдсэн ажлын талаарх асуулгын дүн
Зураг 20.	Суллагдасны дараах эргэх холбооны асуулгын дүн
Зураг 21.	Суллагдагдсаны дараах нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн асуулгын дүн
Зураг 22.	Суллагдсаны дараах нийгмийн байдлын судалгаа
Зураг 23.	Суллагдсаны дараах хүмүүсийн харьцааны талаарх судалгаа
Зураг 24.	Уулзалтад хамрагддаг талаарх асуулгын дүн
Зураг 25.	Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагддаг талаарх асуулгын дүн
Зураг 26.	Нийгэмшүүлэх ажлын сэтгэл ханамжийн судалгаа
Зураг 27.	Нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн асуулгын дүн
Зураг 28.	Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээрх хоригдлын гаргасан саналын нэгтгэл
Зураг 29.	Нийт сургалтад хамрагдсан хоригдлын тоо
Зураг 30.	Үүнээс бясалгалд хамрагдсан хоригдлын тоо
Зураг 31.	Хорих ангид зохион байгуулагдсан сургалтын төрөл
Зураг 32.	2012-2020 оны хооронд бүрэн дунд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Зураг 33.	2012-2020 оны хооронд бичиг үсгийн сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт

Зураг 34.	2015-2020 оны хооронд мэргэжлийн дадлага олгох сургалтад хамрагдсан хоригдлын тоо
Зураг 35.	2019 оны эхний хагас жил мэргэжлийн дадлага олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Зураг 36.	2012-2020 оны хооронд дээд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Зураг 37.	Сургалтад өгсөн үнэлгээ
Зураг 38.	Сургалтын хэрэгцээний судалгаа
Зураг 39.	Сургалтын зохион байгуулалтын талаарх санал асуулгын дүн
Зураг 40.	Бие даан сурах хэрэгцээний судалгаа
Зураг 41.	Сургалтад учирч буй бэрхшээлийн судалгаа
Зураг 42.	2015-2020 оны хооронд хорих байгууллагад ажиллаж байсан нийгмийн ажилтны судалгаа
Зураг 43.	Нийгмийн ажилтны хүйсийн судалгаа
Зураг 44.	Мэргэжлийн нийгмийн ажилтны судалгаа
Зураг 45.	Нийгмийн ажилтнуудын мэргэжлийн судалгаа /2020.05.01/
Зураг 46.	Сэтгэл зүйчдийн мэргэжлийн судалгаа /2020.05.01/
Зураг 47.	Нийгэмшүүлэх чиглэлээр хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын судалгаа
Зураг 48.	Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний судалгаа
Зураг 49.	Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээрх саналын судалгаа
Зураг 50.	Нийгмийн ажилтны ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа
Зураг 51.	Нийгмийн ажилтны нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр гаргасан саналын судалгаа
Зураг 52.	Нийгмийн ажилтны үйл ажиллагаанд өгсөн хоригдлуудын үнэлгээ
Хүснэгт 1.	2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийгэмшүүлэх ажлын талаар туссан байдалд хийсэн харьцуулалт
Хүснэгт 2.	Нийгэмшүүлэх ажлын зааврын харьцуулалт
Хүснэгт 3.	Сэтгэл зүйчийн үйл ажиллагааг зохицуулж ирсэн зааврын харьцуулалт
Хүснэгт 4.	ШШГЕГ-ын харьяа хорих ангиудын нийгэмшүүлэх үйл ажиллагааны зааврын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ /2015-2020/
Хүснэгт 5.	Хорих ангиудын сургалтын танхимын багтаамжын судалгаа
Хүснэгт 6.	Хорих ангийн нийгмийн ажилтан болон ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолтод хийсэн харьцуулалт

Нийгэмшүүлэх ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн акт

д/д	Журмын нэр	Дугаар	Огноо	
			Баталсан	Дагаж мөрдөж эхэлсэн
Нэг. Хууль				
1	Үндсэн хууль			
2	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/		2015-12-03	2017-07-01
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/		2017-06-09	2017-07-01
4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль			
5	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай		1999-01-07	
6	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/		2017-12-07	2019-01-01
7	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай		2014-04-15	
8	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай		1994-06-13	1995-01-01
9	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/		2017-05-11	2017-07-01
Хоёр. Засгийн газрын тогтоол				
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	204	2017-07-04	
2	Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам	217	2002-10-23	
3	Хорих байгууллагын алба хаагчдын ажлын онцгойн нэмэгдэл	189	2011-06-22	
4	Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг батлах тухай	204	2017-07-04	
5	МУ-ын Засгийн газрын 258-р тогтоол - Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	258	2018-08-22	
6	МУ-ын Засгийн газрын 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 01 албан	01	2017-10-26	

	даалгавар - Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай			
Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал				
1	Хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай	87/11 1/118	2011-06-23	
2	Баривчлах шийдвэр биелүүлэх журам	A/227	2014-12-08	
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам	A/194	2017-07-21	
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журам	A/187	2017-07-16	
5	Хорих ангийн дотоод журам	A/183	2017-07-04	
6	Зөвлөлийн бүрэлдэхүүн үйл ажиллагааны дүрэм батлах тухай	A186 A/74	2017-07-04	
7	Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам	A/192 A/81	2017-07-18	
8	Хорих ангийн харуул хамгаалалтын журам	A/197	2017-07-25	
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээллэх журам	A/225 a/101	2017-09-06	
10	Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч хадгалах, устгах, шилжүүлэх журам	A/233 A/100	2017-09-07	
11	Хоригдлыг ял эдлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ангийг солих тухай санал гаргах журам	A/235 A/105	2017-09-07	
12	Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам	A/236 A/104	2017-09-07	
13	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам	A/260 A/112	2017-10-18	
14	Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагналын журам	A/87	2017-04-13	
15	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам	A/73	2017-04-04	

16	Жишиг норматив шинэчлэн батлах тухай	A/247 A/167, 303	2017-09-29	
17	ШШГБ-д ажиллаж буй цэргийн жинхэнэ алба хаагаагүй цэргийн насны алба хаагчдад цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөр батлах тухай	A/448	2017-10-20	2017-11-01
18	Хоригдлын нормын хувцас, ахуйн хэрэглэлийн нэр төрөл, тоо, эдэлгээний хугацааг тооцох журам	A/18	2018-02-01	
19	ШШГБ-ын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам	A/29	2018-02-15	
20	Нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн эмнэлгийн дэглэм	A/127 A/69	2018-06-29	
21	Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх журам	A/130	2018-07-30	
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилга, ёс зүйн дүрэм /Шинэчилсэн/	A/183	2018-09-27	
23	Хоригдлыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт, шилжүүлэн эмчлүүлэх журам	A/2141 A/462	2018-11-19	
Дөрөв. ШШГЕГ-ын даргын тушаал				
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм	A/32	2008-02-18	
2	Нийгмийн ажилтны аргачилсан заавар	A/129	2018-07-03	
3	Сэтгэл зүйн ажлын заавар	A/110	2019-06-07	
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны шалгалт явуулах журам	A/34	2013-02-06	
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт	A/81	2013-04-24	
6	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам	A/80	2013-04-24	
7	ШШГБ-ын үйлчилгээний стандартыг батлах тухай	A/81	2013-04-24	
8	ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журам	A/82	2013-04-24	
9	ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм батлах тухай	A/51	2017-03-10	

10	ШШГБ-ын бага бүрэлдэхүүний бодлогын баримт бичиг	A/96	2017-05-03	
11	Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам	A/169	2017-08-31	
12	ШШГБ-ын алба хаагчийн мэргэшлийн түвшин үнэлэх журам	A/178	2017-09-06	
13	ШШГБ-ын хүний нөөцийн журам	A/192	2017-09-19	
14	ШШГБ-ын алба хаагчийн дүрэмт хувцас, чимэг хэрэглэлийг хураан авах, тооцоо хийх журам	A/194	2017-09-20	
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам	A/260 A/242	2017-12-14	
16	Ахлагчийн зөвлөлийн ажиллах журам	A/167	2018-09-25	
17	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт өөрчлөлт	A/148	2018-08-31	

УДИРТГАЛ

Хүний нийгмийн амьдралд оролцон, хөгжиж төлөвших, зохицон амьдрах чадвар эзэмших нь нийгэмшлийн үндсэн асуудал бөгөөд үүнийг судлан үзэхэд эн тэргүүний шалгуурын үзүүлэлтийн нэг болох хүний хөгжлийг судлан тодорхойлох, түүнийг үнэлэх, хөгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулсаар иржээ.

Нийгэмшлийн тухай ойлголтын талаар тухайн салбарын судлаачид харилцан адилгүй байдлаар томъёолжээ.

Нийгэмшил буюу нийгэмшихүй гэсэн ухагдахуун нь орос хэлний социализация, англи хэлний socialization гэсэн үгний орчуулга бөгөөд тайлбар толь болон эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна.

Нийгмийн ухааны болон хууль зүйн толь бичиг, мэргэжлийн судалгааны бусад бүтээлд¹ анализ хийн үзвэл:

-“социализация” буюу “нийгэмших”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томъёо нь хүмүүний нийтлэг үнэт зүйлс, ёс суртахуун, аж байдал, эрх зүйн дэг журмыг хүндэтгэн сахиж, зохицож амьдрах, түүнд хэвшүүлэх ухамсарт үйл явц, зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа, түүний үр дүн;

-харин эдгээр үнэт зүйлс, журмыг үл ойшоон, санаатайгаар зөрчсөн гэм буруутай хүмүүнийг ухааруулан ойлгуулах /ухамсарлуулах/, сөрөг зан байдал, харьцаа, амьдралын хэв маяг, сэтгэхүй, сэтгэлгээг нь өөрчлөн засан төлөвшүүлэх үйл ажиллагааг “ресоциализация”,

-зан байдал, сэтгэхүй, үг хэллэг, амьдралын гажуудал-эвдрэл, хэв маягыг нь засан өөрчлөх үйл ажиллагааг “коррекция”, “исправление”

-сэтгэц гэм судлал, анагаах ухааны үүднээс эдгээр хүмүүсийн зан байдал, сэтгэл зүйг нөхөн сэргээх, өөрчлөх, өөртөө болон бусдад итгэх итгэлийг нь бий болгохыг “реабилитация”,

-дэмжин туслах үйл ажиллагааг “социальная работа”(“social work”),

-иргэний, чөлөөт нийгэмд дасан зохицож, хариуцлагаа хүлээн, ухамсарлах, бие даан амьдрах дадал хэвшил, чадварт сургахыг “адаптация” (адаптирование) гэсэн нэр томъёогоор илэрхийлэн хэрэглэдэг байна.²

¹ Ж.Амарсанаа “Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь”, УБ. 2004; С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008; А.Я.Сухарев “Российская юридическая энциклопедия” М.1999; “Хорих байгууллага дахь нийгмийн ажил” сурах бичиг, УБ 2013, 2015 он зэрэг

² Н.Гантулга. Ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаан дахь хамтын оролцоо. Хууль сахиулахуй сэтгүүл /тусгай дэвтэр/. УБ., 2015

1983 онд хэвлэгдсэн “Сэтгэл судлалын толь бичиг”-т “Нийгэмшил бол хувь хүний нийгмийн туршлага, нийгмийн харилцаа, холбоо зэргийг эзэмшиж, цааш хөгжүүлэх идэвхитэй үйл явц”³, 1999 онд хэвлэгдсэн “Мэргэжлийн боловсролын толь бичиг”-т “Нийгэмшил бол хувь хүн тодорхой хэмжээний мэдлэг, хэм хэмжээ, соёлын үнэт зүйлийн системийг өөрийн болгон эзэмших үйл явц”⁴, 2001 онд хэвлэгдсэн “Философийн толь бичиг”-т “Нийгэмшил бол хувь хүн нийгэм соёлын туршлага болох хөдөлмөрийн дадлага, мэдлэг, хэм хэмжээ, үнэт зүйл, уламжлал зэргийг өөрийн болгон эзэмшиж, эдгээрийг цааш нь хөгжүүлэх үйл явц”⁵ гэж тус тус тодорхойлжээ.

“Нийгэмшил” (социализация, socialization)-ийн тухай ойлголт, ухагдахууныг XIX зууны сүүлчээр Францийн хуульч, социологич Габриэл Тарданлан гаргасан бөгөөд 1956 онд Америкийн социологийн холбооны нэр томъёоны цэсэнд нийгэмшил (lat, socials –олон нийтийн) гэсэн ойлголтыг тайлбарлаж, “нийгэмшил ба нийгмийн бүтцийг судлах хороо” байгуулагдан нийгэмшлийн талаар хоёр үндсэн чиглэл, үзэл хандлага түгэн дэлгэрсэн байна. Өөрөөр хэлбэл нэг хэсэг нь “хүн бол байгалийн амьтан учраас өөрийн төрөлх зан араншин, зөн билгээ нийгмийн нөхцөлд тохируулан зохицуулж амьдардаг” гэж үзэж байгаа бол нөгөө хэсэг нь “хүн төрөлхтөний соёлжиж буй бүх шинжийг нийгэмшлийн нөхцөл” гэж үзэн өөр өөрсдийн үзэл хандлагыг тайлбарлажээ. Тухайлбал, нийгэм судлал, сэтгэл судлал, угсаатан судлал, нийгмийн сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг салбарын эрдэмтэд болон тайлбар тольд нийгэмшлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Т.Холт “Нийгэмшил нь бодгаль тухайн соёлын голлох стандартад нийцүүлэн биеэ авч явж сурах үйл явц”, Ч.Кули, Дж.Мид нар “Нийгэмшлийг процесс гэж үзээд нийгэм, бодгаль хоёр нь салгаж болохгүй нэг цул юмны 2 тал” гэж⁶ үзсэн төдийгүй нийгэмшил нь хүмүүс хоорондын харилцааны хүрээнд явагдаж, нийгмийн тодорхой тогтолцоонд гүйцэтгэх үүргээ эзэмшиж, түүний явцад хувь хүний “би” төлөвших үйл явц юм гэж үзсэн⁷.

Түүнчлэн А.Гиндденс “Нийгэмшил гэдэг нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд өөрийн ухамсар бүхий ухаант амьтан болон хувирч, төрж өссөн соёлынхоо мөн чанарыг ойлгох явц, зарим нөхцөл байдалд насанд хүрсэн

³ Давыдова В.В, Запорожца А.В(ред.), Психологический словарь. 1983.

⁴ <http://didacts.ru/termin/socializacija.html>

⁵ Фролов И.Т. (ред.). Философский словарь., 2001, Москва

⁶ Б.Туяа. Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид. УБ., 2003. 59 дэх тал

⁷ Л.Уранцэцэг, М.Дэлгэржав. Нийгмийн сэтгэл судлал. УБ., 2012. 133 дахь тал

хүмүүс дахин нийгэмшилд орж болно, өөрөөр хэлбэл урьд өмнө тогтсон үнэт зүйлс, бие хүний зан үйлийн загвараа өөрчилж өмнөхөөс эрс ялгаатай үнэт зүйлсийг эзэмших нь буй. Хүмүүсийн үнэт зүйлс, ертөнцийг үзэх үзэл нь яг нэг хэвэндээ байдаггүй, амьдралын бүхийн л мөчлөгийн туршид хуримтлуулсан туршлагатайгаа хамт хувиран өөрчлөгдөнө”⁸, Т.Парсонс “сурч, хөгжих ба амьдралын үечлэлд нийгмийн хяналт дор дүгнэгдэх зан үйлийг хадгалах, тэдгээрийн тусламжаар өөрийн байр суурь ба нийгмийн гишүүн бие хүн болох цогц үйл явц” гэх зэргээр олон эрдэмтэд судлан тодорхойлсон байна.

Тайлбар толь болон эрдэмтэн, судлаачдын тодорхойлолтыг нэгтгэн дүгнэж үзвэл, нийгэмшил хэмээх ойлголтод хувь хүн-бодгаль, нийгэм, соёлын туршлага-хэм хэмжээ, тасралтгүй үргэлжлэх үйл явц гэсэн үндсэн агуулга илэрхийлэгдэж байгаа бөгөөд нийгэмшил бол хүнд нийгмийн шинж чанарууд төлөвших үйл явц гэж ерөнхийлөн үзэж болохоор байна.

Нийгмийн ажлын талаар сонирхон судалж буй хэн нэгний хувьд хамгийн түрүүнд сонирхох зүйл бол “Нийгмийн ажил хэмээх мэргэжлийн онцлог, мөн чанар нь юу вэ?” гэсэн асуулт байх нь дамжиггүй. Юуны өмнө нийгмийн ажил бол социаль (social profession) буюу хүнтэй ажилладаг мэргэжил мөн. Цаашилбал тусламж, дэмжлэгийн үйл ажиллагаа явуулдаг мэргэжил хэмээн хэлж болох юм.

Нийгмийн ажлын толь бичигт “нийгмийн ажил бол хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд тэдний нийгмийн үүргээ гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх, дахин сэргээх зорилгоор тусламж үзүүлдэг, энэ зорилгыг хэрэгжүүлэхэд тааламжтай нийгмийн нөхцөлийг бүрдүүлдэг мэргэжлийн үйл ажиллагаа юм” гэж тодорхойлсон байдаг. Магадгүй бүхий л хүнтэй ажилладаг мэргэжлүүд хүмүүсийн амьдралд ямар нэг хэлбэрээр тусламж, дэмжлэг үзүүлж байдаг гэж хэлж болох юм.

Профессор Дэйлийн бичсэнчлэн тусламжийн талбарт хамаарах бусад мэргэжлүүдээс “нийгмийн ажлын мэргэжлийн ялгарах онцлог нь нэг талаас хүмүүс (гэр бүл гэх мэт бусад нийгмийн нэгж хэсгүүд), нөгөө талаас тэдний хоорондын харилцаа явагдаж байдаг социаль орчны уулзвар зааг, уялдаа холбоон дээр анхаарлаа хандуулдагт” оршдог байна.

Мэргэжил бүхэн нийгмийн хөдөлмөрийн хуваарийн хүрээнд бусдаас ялгарах, бас дахин давтагдахгүй чиг үүрэг бүхий практик үйл ажиллагааг явуулж байдаг билээ. Багш нарын гол ажил бол хүмүүст зааж сургах, мэдлэг олгох, харин эмч нарын хувьд өвчтөнийг эмчлэх анагаах, инженерийн хувьд техникийн юм уу байгууламжийн тооцоолол

⁸А.Гидденс. Социологи.УБ.,2006. 59-60 дахь тал.

боловсруулах эсвэл зохион бүтээх, бүтээн байгуулах гэж хэлж болох юм. Тэгвэл нийгмийн ажлын мэргэжлийн үндсэн практик үйл ажиллагаа нь хүмүүст туслах, нийгмийн тогтолцоонд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Түүхийн урт удаан хугацааны туршид тусламж нь мэргэжлийн үйл ажиллагаа биш байсан ч, ердөө зуу гаруй жилийн тэртээгээс мэргэжил болж өдгөө нийгмийн хөдөлмөрийн хуваарийн дотор нийгмийн ажилтан гэгдэх байр сууриа эзэлж чадсан байна. Австрали улсад 2014 онд зохион байгуулсан Олон Улсын Нийгмийн Ажлын Нийгэмлэгийн (IFSW) Ерөнхий Чуулганаас уг мэргэжлийн талаарх тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна. Уг тодорхойлолт ёсоор “Нийгмийн ажил нь нийгмийн өөрчлөлт, хөгжил, нэгдэл нягтралыг дэмжиж, хүмүүсийн эрх чөлөөг хангаж, чадавхжуулахад чиглэсэн практик үйл ажиллагаанд суурилсан мэргэжил бөгөөд шинжлэх ухааны салбар юм. Нийгмийн шударга ёс, хүний эрх, хамтын хариуцлага болон хүмүүсийн ялгаатай байдлыг хүндэтгэн үзэх зэрэг нь нийгмийн ажлын үндсэн зарчмууд юм. Нийгмийн ажил нь нийгмийн шинжлэх ухааны, хүмүүнлэгийн болон өөрийн онолууд хийгээд уугуул соёлын мэдлэгт суурилах замаар хүмүүсийн амьдралд тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг даван туулах, тэдний сайн сайхан байдлыг дээшлүүлэхийн тулд хүмүүс болон нийгмийг бүрдүүлэгч хэсгүүдийг хооронд нь холбож огдог” гэжээ.

Нийгмийн ажлын мэргэжил хувь хүн, бүлэг, гэр бүл, олон нийт, бүс нутаг, улс орон гээд янз бүрийн түвшинд үйл ажиллагаа явуулж болох ба хувь хүн, гэр бүл, бүлгийн түвшингийн практикийг гол төлөв микро буюу клиник практик, харин олон нийтийн зохион байгуулалтын ажлыг бодлого болон менежментийн баримжаалал бүхий макро практик гэсэн ангилалд хамруулж үзэх нь бий. Гэвч, нийгмийн ажлын мэргэжлийн онцлог, мөн чанарын тухай танилцуулж байгаа энэ тохиолдолд практикийг ангилж авч үзэхээс илүүтэй ерөнхий нийгмийн ажлын тухай өгүүлэх нь илүү зохимжтой болно.

Микро болон макро практик гэсэн ангилалгүйгээр авч үзэх нь ерөнхий практик (generalist practice) болон ерөнхий нийгмийн ажил (generic social work) гэсэн ойлголтыг бий болгох бөгөөд нийгмийн ажлын нийтлэг өргөн хүрээний мэдлэг, ур чадвар, асуудал шийдвэрлэх стратегын талаар эргэцүүлдэг.

Энэ мэргэжлийг яагаад “нийгмийн ажил” хэмээж буй тухайд орчин үеийн судлаачдын үзэлд тулгуурлан энгийн байдлаар эргэцүүлэх боломжтой. Нэгдүгээрт, хэн нэгэн хүний сайн сайхан байдал (аз жаргал гэж хэлж болно) нь бусад хүмүүсгүйгээр огт боломжгүй зүйл юм. Маш энгийнээр түүний бусад хүмүүстэй холбогдож байгаа байдал бол нийгэм

мөн. Хүнийг нийгмээс нь салгаж авч үзэх огтхон ч боломжгүй. Тиймээс хүний аз жаргал бол нийгмээс гадуур бүрэлдэх ямар ч боломжгүй. Нийгмийн ажлын хамгийн эхний ээлжинд анхаарах ёстой асуудал бол хүнийг нийгмийн оршихуй (social being) болох хувьд нь ойлгох явдал юм. Өөрөөр хэлбэл хүнд аз жаргалтай амьдрахад бусад хүмүүс хэрэгтэй. Хэн нэгэн хүний өсөх, хөгжих, сурах боловсрох, ажиллаж амьдрах үндсэн нөхцөл нь бусад хүмүүсийн асрамж, халамж, хүмүүжүүлэлт, тэжээн тэтгэлт, удирдлага, заавар зөвлөгөө, хамгаалал юм. Нийгмийн ажлын зорилго бол хүмүүст аз жаргалын үндсэн хэрэгцээ болсон бусад хүмүүсээр нь дутаахгүй байлгах явдал мөн.

Нөгөө талаас хэн нэгэн хүн аз жаргалтай байх нь тэрээр зүгээр нэг бусдын дунд орших, бусдаар тэтгүүлээд байх хангалтгүй болно. Тиймээс нийгмийн ажлын анхаарлын төвд байх ёстой дараагийн чухал зүйл бол хүний нийгмийн үүрэг, үйл ажиллагаа (social functioning) мөн. Энэ нь хүмүүсийн бусадтайгаа (гэр бүл, найз нөхөд, олон нийттэй) хэлхээ холбоотой байх хэрэгцээ хийгээд хүмүүс бие биенээсээ зайлшгүй харилцан хамааралтай байх мөн чанарыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хүн бусад хүмүүст хэрэгтэй байх гэсэн үг агаад дээрхийн нэгэн адил хүмүүст туслах зорилго бүхий нийгмийн ажил гэгч мэргэжил үүсч бий болох үндсэн шалтгаан болдог.

Нийгмийн ажлын зорилго бол хүмүүс бусдынхаа дунд амжилттай орших, бусдад хэрэгтэй байх нөхцөл, боломжийг дээшлүүлэх явдал мөн.

Лонгресс (Longress) хүний нийгмийн үүрэг бол "хүмүүсийн өөрсдийн байр суурь хийгээд дүртэй холбоотойгоор нийгмээс хүлээгдэж буй хүлээлтийг хэрэгжүүлэх чадамж" гээд энэ утгаараа нийгмийн сайн сайхан байдалд ихээхэн чухал зүйл гэсэн байдаг. Харин Карлс (Carls) болон Вандлэй (Vandley) нарын хувьд нийгмийн үүрэг нь "хувь хүмүүсийн зүгээс өөрсдийн өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаануудыг гүйцэтгэх чадвар, бусдын дунд өөрсдийн үндсэн дүрээ хэрэгжүүлэх түвшин" хэмээн тодорхойлсон байна. Тэд цааш нь хэлэхдээ нийгмийн ажлын үндсэн зорилго нь хүмүүсийн зүгээс эцэг эх, хүүхэд, хосууд, оюутан, ажилтан, найз нөхөд, хөрш, иргэн, өвчтөн гэх мэт өөрсөддөө бий болж буй нийгмийн дүрийг амжилттай хэрэгжүүлэхэд нь туслах явдал" гэснийг анхаарах хэрэгтэй. Энэ бүхнээс үзэхэд хүний бусдын дунд, бусадтайгаа байх хэрэгцээ болон бусдад хэрэгтэй нэгэн байх чадварыг төлөвшүүлэх нь нийгмийн ажил хэмээх мэргэжлийн үндсэн үйл ажиллагаа болж байна. Хүний амьдралд аз жаргал бүрэлдэх үндсэн нөхцөл нь хүн бусадтайгаа байх хэрэгцээ, бусдад хэрэгтэй байх тэр нөхцөл бөгөөд нийгмийн харилцаанд орж буй энэ үйл явцыг социаль (social) гэж нэрлэнэ.

Профессор Пүүл үүнийг “нийгмийн ажлын зорилго нь хэн нэгэн хүнд заримдаа алс хөндий болсон байдаг “социаль”-ийг хайх, ач холбогдол өгөх, түүний энэхүү “социаль” хэмээх шинж чанарыг сэргээхэд оршино.

Нийгмийн ажил нь бидний амьдралын ертөнцөд (Die Lebenswelt) алдагдаж гээгдсэн тэрхүү “социаль”-ийг эргүүлэн авч ирэхийн төлөө байдаг гэж болно” хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл нийгмийн ажилтнууд ядуус, ажилгүйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүчирхийллийн хохирогчид, архинаас хамааралтай хүмүүс, өнчин болон хараа хяналтгүй хүүхдүүд, хоригдож байсан хүмүүс, гэмт хэргийн хохирогчид, өрх толгойлсон эцэг эх, харилцааны асуудалтай гэр бүл, нийгмээс ялгаварлагдсан, гадуурхагдсан хүмүүс болон бусад тусламж хэрэгтэй бүхий л “социаль”-аа алдсан болон алдаж болзошгүй хүмүүст амин зуулгыг нь, эрхэлж байсан болон эрхэлж чадах ажлыг нь, хайр халамжийг нь, хайртай хүмүүсийг нь, гэр бүлийг нь, нандин сайхан харилцааг нь, амьдрах итгэлийг нь, бүхэл амьдралыг нь сэргээх юм уу, эргүүлж өгнө гэсэн утгатай юм.

Хүмүүс яагаад “социал”-аа алддаг вэ?. мэдээж энэ нь хүмүүсээс өөрсдөөс нь болон түүнийг тойрон хүрээлж буй хүмүүсээс, нийгмийн тогтолцооноос нь хамаарч байдаг. Орчин үеийн нийгмийн ажлын онолч Штауб-Бернаскони “нийгмийн асуудал бол хувь хүний зүгээс болон нийгмийн зүгээс хамааран үүсч байгаа доройтол мөн” гэжээ. Мөн нийгмийн ажлын хүрээнд нийгмийн асуудал гэдэг нь аливаа хүн болон нийгмийн тогтолцооны хэрэгцээг хангах хэн нэгний (тогтолцооны) нийгмийн үүрэг хэрэгжихээ больсон эсвэл тийм байдалд ороход хүрсэн байдлыг илэрхийлдэг байна. Энд нийгмийн ажил хэмээн нэрлэсэн шалтгааны нэгэн учир тайлагдаж байна. Учир нь нийгмийн ажилтан нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хувь хүнтэй ч, нийгмийн тогтолцоотой ч ажиллах шаардлага бий болно. Нийгмийн ажилтан бол хүмүүсийг тойрон хүрээлж, тэдний сайн сайхан байдлын гарцаагүй орчин нөхцөл болж буй янз бүрийн түвшин, олон төрөл нийгмийн тогтолцооны дунд ажилладаг, тэдгээрийн хэвийн, цаашилбал үр нөлөөтэй үйл ажиллагааг хангахыг зорьдог нийгмийн инженер мөн.

Нийгмийн ажил мэргэжлийн зорилго:

Аливаа мэргэжилд нийгмийн зорилго гэж байх ба үүнийг тухайн мэргэжлийн нийгмийн захиалга ямар байх, эсвэл хөдөлмөрийн хуваарьт ямар байр суурь эзлэх, цаашилбал мэргэжлийн эрхэмлэх үнэт зүйл, баримтлах зарчим юу болох гэх зэрэг хэд хэдэн чиглэлээр тодорхойлж байх нь бий. Аливаа хүнтэй ажилладаг мэргэжлийн хувьд тэдгээрийн зорилгыг нэг үгээр тодорхойлох нь явцуу хэрэг болох юм. Зарим

судлаачдын дүгнэсэнчлэн нийгмийн ажлын уг гарвал өөрөө олон талт шинжийг агуулдаг нь эргээд энэхүү мэргэжлийн зорилгын талаар олон ишт байр суурь өөд аяндаа хөтөлж байдаг гэлцэх нь буй. Түүнээс гадна нийгмийн ажил нь улс орнуудад тухайн орны соёл, уламжлал, улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооноос хамаарч нийгэмд үүсэх харилцан адилгүй хүлээлт, захиалгын доор хөгжиж ирсэн нь дамжиггүй. Гэсэн хэдий ч, уг мэргэжлийн харьцангуй нийтлэг зорилгыг тодорхойлж болох билээ. Өөрөөр хэлбэл, нийгмийн ажлын мэргэжил бий болох үндэслэл шалтгаан нь хүмүүс боловсрол мэдлэггүй байх, эсвэл тэдний эрүүл мэнд доройтох, иргэний бичиг баримт бүрдээгүй байх, гэмт хэргийн хохирлоо төлүүлэх хэрэгтэй байх зэрэг асуудал өмнө биш, харин хүмүүс нийгмийн (буюу бусдын) өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж чадахгүй байх, тэдний бусадтай харилцах харилцаа хэвийн биш байх, тэдний өмнө бусад хүмүүс үүргээ хэрэгжүүлэхгүй байх, хүмүүс өөрсдийн амьдралаа хэвийн авч явах боломжгүй болох үүнээс үүдээд нийгмийн аль нэг тогтолцооны (гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийт, орон нутаг, институт) хэвийн үйл ажиллагаа доголдох зэрэг асуудал билээ.

Дээр үеэс барууны судлаачид нийгмийн ажлын практикийн зорилго бол хүмүүсийн асуудал шийдвэрлэх болон даван туулах чадварыг дээшлүүлэх, хүмүүсийг нөөц, үйлчилгээ болон боломжийг бий болгож чадах тогтолцоонуудтай холбох, тэдгээр тогтолцооны үр нөлөөтэй хийгээд хүмүүнлэг үйл ажиллагааг дэмжих, нийгмийн бодлогын хөгжил болон түүнийг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах зэрэг болох тухай бичиж байв. Бусад мэргэжлийн нэгэн адил нийгмийн ажил нь өөрийн суурь үнэт зүйлс, ёс зүйн зарчмуудыг бүтээж ирсэн бөгөөд тэдгээрийг өөрийн мэргэжлийн үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн харилцаанд түгээх, байршуулах, хадгалахын төлөө байдаг. Мэргэжлийн суурь үнэт зүйлсүүдэд тулгуурлах замаар нийгмийн ажлын үндсэн зорилгуудыг тодорхойлсон байдаг. Эдгээрийг дурдвал:

- Хүний сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, ядуурал, дарангуйлал болон бусад шударга бус явдлыг бууруулах;

- Хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага болон олон нийтийн нийгмийн үүрэг, үйл ажиллагааг дээшлүүлэх, ингэхдээ тэдгээрийг энэхүү зорилгодоо татан оролцуулах, нөөцийг хөгжүүлэх, зовлон бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах;

- Хүмүүний суурь хэрэгцээг хангах нийгмийн бодлого, үйлчилгээ болон хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, хүмүүний чадавхийн хөгжилд дэмжлэг үзүүлэх;

- Нийгэм, эдийн засгийн шударга ёсыг дэмжихүйц нөлөөлөл,

хамгаалал болон нийгэм, улс төрийн үйл ажиллагаагаар дамжуулан бодлого, үйлчилгээ хийгээд нөөцийг эрэн сурвалжлах;

- Нийгмийн ажлын практикийг сайжруулах судалгаа, мэдлэг болон ур чадварыг хөгжүүлэх, ашиглах.

Нийгмийн ажлын мэргэжлийн институцчилэл дэх түүхэн үйл явдлууд⁹:

- 1915 онд Гаг хотноо болсон Эмэгтэйчүүдийн энх тайвны бага хуралд нийгмийн ажилтнууд оролцсон.

- 1923 онд Хүүхдийн эрхийн анхны бичмэл бэлэн болсон.

- 1924 онд Үндэстнүүдийн зөвлөлөөр Хүүхдийн эрхийн тунхаг батлагдсан.

- 1928 онд Парис хотноо анхны “Олон улсын нийгмийн ажлын бага хурал”-ыг хөтөлбөртөө багтаасан Нийгмийн халамжийн чуулган зохион байгуулагдсан.

- 1928-1929 онд “Олон улсын нийгмийн халамжийн хурал”, “Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбоо”, “Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг” зэргийг үүсгэн байгуулсан.

- 1932 онд Франкфурт хотноо хоёр дахь удаагийн “Олон улсын нийгмийн ажлын бага хурал”- ыг зохион байгуулсан.

- 1936 онд Лондон хотноо гурав дахь удаагийн “Олон улсын нийгмийн ажлын бага хурал”-ыг зохион байгуулсан.

- 1944-1947 онд “НҮБ-ийн Тусламжийн болон Нөхөн сэргээлтийн Газар”-аас Европ болон Хятадад тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлсэн.

- 1945 онд НҮБ байгуулагдсан.

- 1946 онд НҮБ-д Засгийн газрын бус байгууллагуудын төлөөх зөвлөлдөх статус бүхий тогтолцоо байгуулагдсан.

- 1948 онд Атлантик хотноо дөрөв дэх удаагийн “Олон улсын нийгмийн ажлын бага хурал”-ыг зохион байгуулсан.

- 1950 онд НҮБ-аас нийгмийн ажлын боловсролын талаарх анхны асуулга судалгаа хийгдсэн.

- 1955 онд НҮБ-аас нийгмийн ажлын боловсролын талаарх хоёр дахь асуулга судалгаа хийгдсэн.

- 1958 онд НҮБ-аас нийгмийн ажлын боловсролын талаарх гурав дахь асуулга судалгаа хийгдсэн.

- 1965 онд НҮБ-аас нийгмийн ажлын боловсролын талаарх дөрөв дэх асуулга судалгаа хийгдсэн.

- 1971 онд Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбооноос гэр

⁹ Г.Түмэннаст нар. Нийгмийн ажил. 2017 он.УБ хот., 36-37 дахь тал

бүл төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

- 1971 онд НҮБ-аас нийгмийн ажлын боловсролын талаарх тав дахь асуулга судалгаа хийгдсэн.

- 1976 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг Ёс зүйн кодоо баталсан.

- 1970-аад онд Олон улсын нийгмийн хөгжлийн төлөөх Их сургууль хоорондын Консерциум байгуулагдсан.

- 1988 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг “Хүний эрхийн комисс”-ийг байгуулсан.

- 1988 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэгээс бодлогын баримт бичгүүдийг гаргасан.

- 1994 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг/Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбоо Хүний эрхийн талаарх НҮБ-ийн удирдамжийг нийтэлсэн.

- 1994 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг Ёс зүйн зарчмуудын шинэчилсэн тунхаглалаа баталсан.

- 1995 онд Копенгаген хотноо НҮБ-ийн Нийгмийн хөгжлийн төлөөх дэлхийн дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулсан.

- 2000 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг /Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбоо дэлхий нийтийн “Нийгмийн ажлын тодорхойлолт”-ыг шинэчлэн баталсан.

- 2004 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг /Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбоо Нийгмийн ажлын ёс зүйн шинэчилсэн баримт бичиг болон Нийгмийн ажлын боловсрол хийгээд сургалтын дэлхий нийтийн стандартыг баталсан.

- 2010 онд Олон улсын нийгмийн ажлын нийгэмлэг нь Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбоо болон Олон улсын халамжийн нийгэмлэгтэй хамтран Нийгмийн ажил ба нийгмийн хөгжлийн глобал асуудлууд хэлэлцүүлгийг эхлүүлсэн байна.

2014 онд Австрали улсад Олон улсын нийгмийн ажлын холбоо/Олон улсын сургуулийн нийгмийн ажлын холбоо дэлхий нийтийн “Нийгмийн ажлын тодорхойлолт”-ыг шинэчлэн баталсан.

Ийнхүү нийгмийн ажил нь хөгжлийн явцад хувьсан өөрчлөгдөж, хөгжсөөр мэргэжил болтлоо төлөвшсөн байна. Нийгмийн ажлын мэргэжлийн хөгжлийг дараах үндэслэлээр тайлбарлаж болно.

1. Хүмүүсийн хамтын амьдралын харилцаанаас үүссэн олон асуудал нь нийгмийн ажлын хурдацтай хөгжлийн гол түлхэц юм. Өөрөөр хэлбэл янз бүрийн соёл, нийгэмд аж төрөх ёсны харилцан адилгүй нөхцөлд урган гарч буй аливаа асуудлыг шийдэх явцад нийгмийн ажил улам

боловсронгуй болж, салбарлан хөгжсөөр байна.

2. Хүмүүсийн хэрэгцээ, нийгмийн хөгжил, өөрчлөлтөнд тулгуурлан хувьсан өөрчлөгдөж байдаг. Нийгмийн ажлын энэ шинж нь нийгмийн шинжлэх ухааны онцлог юм. Нийгмийн ажил бол үнэт зүйл, онол, практик хосолсон цогц систем юм.

Нийгмийн ажилтны үүрэг:

Аливаа мэргэжил бүхэн нийгэмд тодорхой үүргийг хэрэгжүүлэхээр зориулагдсан байдаг. Мэргэжлийн үүрэг бол аль нэг мэргэжлийг эзэмшсэн хүмүүсийн зүгээс өөрсдийн ажил мэргэжилд хамаарах тусгай мэдлэг, боловсрол, болон ур чадварыг эзэмшсэний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа ялгаатай үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, тухайн мэргэжлийн хүний зүгээс нийгмийн хөдөлмөрийн хуваарийн харилцаанд оролцон тоглож буй дүр хэмээн сэтгэж болно. Мэргэжлийн үүргээс гадна мэргэжлийн үйл ажиллагаа гэж буй. Мэргэжилтэн нэг мэргэжлийн үүргийн хүрээнд хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. Өөрөөр хэлбэл, мэргэжилтнүүд амьдрал дээр өөрсдийн үндсэн дүрүүдээр дамжуулан хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байдаг. Мэргэжлийн үүрэг болон үйл ажиллагаа нь тухайн мэргэжлийн ажил хөдөлмөрийн хуваарьт эзлэх байр суурь, мэргэжлийн зорилго, үнэт зүйл, хэм хэмжээ, мэргэжлийн боловсрол буюу тусгай бэлтгэл зэрэгтэй амин чухал холбоотойгоор бүрэлдэн бий болдог билээ. Тухайн мэргэжлийн гишүүдээс хүлээгдэж байгаа үүрэг болон үйл ажиллагаа нь нийгмийн хэм хэмжээ, түүхэн уламжлал, хууль зүйн код, байгууллагын дүрэм журам, бодлого ба үйл ажиллагаагаар тодорхойлогддог. Аливаа мэргэжлийн хүрээнд тодорхой үүргийг гүйцэтгэхдээ тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэхийг шаардаж байдаг учраас мэргэжил бүхэнд олон янзын үүрэг болон тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа байдаг. Мэдээж хэрэг аль ч мэргэжилд тэдгээр үүргээс гадна зайлшгүй үндсэн үүргүүд гэж бий. Нийгмийн ажил нь янз бүрийн талбарт, янз бүрийн түвшинд хэрэгждэг гэдэг утгаараа олон янзын үүргийг гүйцэтгэж байх нь бий. Гэвч, аливаа нийгэмд нийгмийн ажилтан хүнээс хүлээж байх үндсэн амин чухал үүргүүд болоод тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа бий. Тэдгээрийн талаар товч авч үзэж болох юм.

Нийгмийн ажилтан зуучлагч болох нь:

Зуучлах үүрэг нь үйлчлүүлэгчийг боломжит нөөц эх сурвалж болон үйлчилгээтэй холбох гэсэн утгатай юм.

Хүнтэй ажилладаг бусад мэргэжлүүдтэй харьцуулах аваас нийгмийн ажил хүнийг нийгмийн орчинтой нь ямагт холбож авч үздэгээрээ онцлогтой билээ. Энэ утгаараа нийгмийн ажилтнууд өөрийн үйлчлүүлэгч

болон түүний хүрээлэн буй орчинтойгоо холбогдох харилцаа холбоонд анхаарлаа хандуулах бөгөөд тусламж үзүүлэхийн тулд үйлчлүүлэгч болон түүний амьдарч буй олон нийтийн дундах холбоо харилцааг хөгжүүлэх, сэргээх, дэмжих хэрэгтэй болдог. Энэхүү холбоо харилцааны нэг том илрэл нь нөөцийн асуудал юм. Зуучлагчийн үүрэг гэдэг нь мэргэжилтэн үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээг танин мэдэж, үйлчлүүлэгчийн зүгээс янз бүрийн нөөцийг ашиглах сэдэл болон чадвар ямар түвшинд байгааг үнэлэх, хамгийн чухал нөөцийг олж авахад нь туслах үйл явцыг хэлдэг. Нийгмийн ажилтан энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд нийгэмд буй янз бүрийн нөөцийн талаар тухайлбал, үйлчилгээ болон хөтөлбөрийн талаар сайтар мэдлэгтэй байх хэрэгтэй, мөн үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээ, нөөцийн талаарх мэдлэг, түүний нөөцийг ашиглах чадварыг байнга дээшлүүлдэг байх ёстой болдог.

Нийгмийн ажилтан зуучлагчийн үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагаануудыг гүйцэтгэх болно.

- Үйлчлүүлэгчийн нөхцөл байдалд үнэлгээ хийх: Үйлчлүүлэгчийн хэрэгцээ болон чадамжийг яв цав тодорхойлох, ингэхийн тулд үйлчлүүлэгчийн эмзэг байдал, соёл, нөөц, хэл ярианы чадвар, сэтгэл хөдлөлийн тогтворжилт, оюун ухааны байдал, өөрчлөлтөд бэлэн байдал зэргийг үнэлдэг.

- Нөөцийг үнэлэх: Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхийн тулд боломжит бүх нөөцийг үнэлдэг. Ингэхдээ бүлэг, олон нийт, гэр бүл, байгууллага, орон нутаг гээд бүх түвшинд байгаа нөөцийг үнэлж, тэдгээрийг ашиглах боломжийн талаар судална гэсэн үг.

- Тусламж үзүүлэх: Энэ нь үйлчлүүлэгчийг дээрх нөөцтэй холбох үйл ажиллагаа юм. Үйлчлүүлэгчийн хэрэгцээг хэрхэн хангаж байгаа, түүнчлэн хэрэгцээний аль талыг хангаж буйгаас хамааран дараагийн нөөцтэй холбох үйл ажиллагаа ч явагдах болно.

- Үйлчилгээний тогтолцоог холбох: Үйлчлүүлэгчид цаашид тогтвортой дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэхийн тулд янз бүрийн салбарын, хэд хэдэн төрлийн үйлчилгээтэй холбох, харилцааг бий болгох, дэмжих шаардлагатай болдог. Мэдээлэл харилцааны сувгийг бий болгох, нөөцийг хуваарилах талаар хэлцэл хийх, салбар хоорондын төлөвлөлтөд оролцох, мэдээлэл солилцох, болон зохицуулалт хийх зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

- Мэдээлэл өгөх: Үйлчлүүлэгч, олон нийтийн бүлгүүд, шийдвэр гаргагчид болон бусад эрх мэдэлтэй хүмүүст мэдээллийг байнга дамжуулахыг шаарддаг. Үйлчилгээний тогтолцооны талаарх мэдээллийг бусдад хуваалцах бөгөөд цаашилбал, хэрэгцээ болон түүнийг хангах нөөц

хоорондын зай завсрыг нөхөх зорилгоор олон нийтийн ойлголт, мэдлэгийг ч нэмэгдүүлэх шаардлагатай.

Нийгмийн ажилтан нөлөөлөн хамгаалагч болох нь:

Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийнхээ үйлчилгээ авах болон нөөцөөс хүртэх эрхийг сэргээх, олж авахад нь туслах хэрэгтэй болдог. Үйлчлүүлэгч хувь хүн, бүлэг, олон нийтэд сөрөг нөлөө үзүүлж байгаа бодлого болон хөтөлбөрүүдийг өөрчлөх үндэслэлийг идэвхтэй гаргах, дэмжих болно. Энэхүү нөлөөллийн үүрэг нь нийгмийн ажлын мэргэжлийн зүрхэнд оршиж байдаг. Тиймээс, нөлөөлөл нь мэргэжлийн эрхэм зорилгын суурь болох ба улс орнуудын мэргэжлийн ёс зүйн кодексод бодитой тусгагдсан байдаг. Тухайлбал, АНУ-ын Нийгмийн ажлын ёс зүйн кодексод "нийгмийн ажилтан өөрийн үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангахад шаардлагатай нөөцийн төлөө байгууллагын гадна, дотор ч нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, баялгийн хуваарилалтын үйл явцыг бүх үйлчлүүлэгчийнхээ хувьд нээлттэй бөгөөд шударга болгоно. Макро түвшинд, хүний хэрэгцээг хангаж, шударга ёсыг дэмжихүйц нөхцөл байдлыг бий болгохын тулд өөрчлөлтийг хийхээр нөлөөлөх болно" гэжээ. Микелсон нийгмийн ажил дахь нөлөөлөл бол нийгмийн шударга ёсыг хамгаалах, хадгалж үлдэх зорилгоор нэг юм уу эсвэл илүү олон хувь хүн, бүлгүүд, олон нийтийн өмнөөс хийж буй шууд төлөөлсөн, хамгаалсан, хөндлөнгөөс оролцсон, дэмжсэн, санал болгож зөвлөсөн цогц үйл ажиллагаа хэмээжээ.

Нийгмийн ажилтан нөлөөллийн үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах чиг үүргийг гүйцэтгэх болно.

■ Үйлчлүүлэгчийн төлөөх буюу кейс нөлөөлөл: тухайн үйлчлүүлэгч хувь хүний хувьд эрхийн дагуу авах ёстой үйлчилгээ болон нөөцийг хүртэж чадахгүй байгаа тохиолдолд энэ үүргийг гүйцэтгэх шаардлагатай болдог. Үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл цуглуулж, түүний эрх болон үйлчилгээнд хамрагдах шалгуур хангасан байдалд үнэлгээ хийж, хувийн хэрэг материалыг бүрдүүлсний дараа холбогдох байгууллага, агентлагт хандана. Ямар арга замаар, ямар үе шатаар байгууллагад хандах талаар сайтар мэдлэгтэй байхыг шаарддаг. Заримдаа байгууллагын эсрэг хууль зүйн тодорхой ажиллагааг явуулах хэрэгтэй ч байж болно.

■ Нийгмийн анги, бүлгийн төлөөх нөлөөлөл: энэ нь нийтлэг асуудал болон санаа зовоож буй зүйл бүхий нийгмийн томоохон бүлэг хүмүүсийн ашиг сонирхлын төлөө хийж буй үйл ажиллагаа юм. Тэдний зүгээс иргэний эрхээ эдлэхэд болон хүртэх ёстой нийгмийн үйлчилгээ, нөөцийг ашиглахад нь учирч буй саад бэрхшээлийг үгүй хийхийн тулд явуулах үйл ажиллагаа мөн. Энэ нь ихэвчлэн, институци, байгууллагын дүрэм журам, бодлого, хууль дүрмийн өөрчлөлтийг шаарддаг.

Нийгмийн ажилтан багш, сургагч болох нь:

Энэ үүргийг үйлчлүүлэгчид тулгарах асуудлаас урьдчилан сэргийлэх, өөрсдийн өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааг дээшлүүлж чадах мэдлэг, ур чадвар бүхий үйлчлүүлэгчдийг (хувь хүн, бүлэг, олон нийт) бэлтгэх үйл ажиллагаа юм. Нийгмийн ажлын практик үйл ажиллагааны үлэмж хэсэг нь үйлчлүүлэгчийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, тэдэнд зааж сургах үйл явцыг агуулж байдаг. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэйгээ ажиллах явцдаа тэдэнд өөрсдийн мэдлэг туршлагыг дамжуулах ба энэ үйл явцад үйлчлүүлэгчийг чадваржуулах үр нөлөө бий болдог гэж хэлж болно. Нийгмийн ажлын зорилго нь үйлчлүүлэгчдийн сөрөг нөлөө бүхий зан үйлийг өөрчлөх, нийгмийн харилцаанд сургах явдал юм. Түүний тулд үйлчлүүлэгчид нийгмийн хэм хэмжээ, дүрэм журмыг эзэмшүүлэх хэрэгтэй болдог. Нийгмийн ажлын мэргэжил дэх багш, сургагчийн үүрэг зөвхөн хувь хүн, гэр бүл, жижиг бүлэг гэхчлэн микро түвшинд бус, макро түвшинд хэрэглэгдэх ба энэ тохиолдолд олон нийтийн ойлголт төсөөллийг нэмэгдүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа юм.

Нийгмийн ажилтан багш, сургагчийн үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг гүйцэтгэх болно.

■Нийгмийн болон өдөр тутмын амьдралын ур чадварт сургах: Хүмүүсийн зөрчлийг шийдвэрлэх, мөнгө төгрөгөө зохистой хэрэглэх, нийтийн тээвэр ашиглаж сурах, шинэ амьдралын хэмнэлийг өөртөө тохируулах, биеэ бодох, тордох, эрүүл ахуй, ариун цэврийг хангах, бусадтай үр ашигтай харилцаж сурах зэрэг ур чадварыг нийгмийн ажилтан мэргэжлийн өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан сургах хэрэгтэй болдог.

■Зан үйлийн өөрчлөлтийг дэмжих: Нийгмийн ажилтан хэн нэгэн үйлчлүүлэгчийн бусдын өмнө хүлээх үүрэг, хэрэгжүүлэх дүрийг тодорхойлох, түүний үнэт зүйлсийг тодруулах, зан үйлийг хэлбэршүүлэх зэргээр тэдэнд илүү нийгэмших боломжтой харилцааны арга хэлбэрийг сургах үйл ажиллагаа юм.

■Анхдагч урьдчилан сэргийлэлт: Нэлээд ноцтой байдалд орж буй нийгмийн асуудал болон нөхцөл байдалд анхаарлаа хандуулах замаар уг асуудлын төлөвийг өөрчлөх, түүнээс бий болох үр дагаварыг багасгах зэрэг үйл ажиллагааг явуулдаг. Нийгмийн ажилтан олон нийтийн анхаарлыг нийгмийн асуудалд хандуулах замаар гэрлэлт, гэр бүл төлөвлөлт, эцэг эх байх арга барил зэргийн талаар соён гэгээрүүлж болно.

Нийгмийн ажилтан зөвлөгч болох нь:

Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчиддээ өөрсдийн мэдрэмжийг илүү сайн ойлгох, өөрсдийнхөө зан үйлийг өөрчлөх, асуудлаа өөрсдөө даван туулахад нь туслах замаар тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоо,

гүйцэтгэх үүргийг нь дээшлүүлэх үйл ажиллагаа юм. Энэ үүрэг нь нийгмийн ажлын мэргэжлийн сонгодог хоёр чиглэлийн нэг болох клиник нийгмийн ажлын түүхийн хуудсанд илүү тусгалаа олсон юм. Америкийн Нийгмийн ажлын Үндэсний Нийгэмлэгийн тодорхойлсноор “клиник нийгмийн ажлын салбар нь хувь хүн, гэр бүл, жижиг бүлгийн сэтгэц нийгмийн үйл ажиллагааг сайжруулах болон дэмжих туршлагаа мэргэжлийн бусад бүхий л салбаруудтай хуваалцдаг чиглэл юм. Клиник нийгмийн ажил нь сэтгэц нийгмийн үйл ажиллагаа алдагдах, бэрхшээлтэй болох, сэтгэл хөдлөлийн болон оюуны өвчлөл гэх мэт эмгэг бий болохоос урьдчилан сэргийлэх, эмчлэхийн тулд онол болон аргыг хэрэглэж буй мэргэжлийн хэрэглээ юм. Клиник нийгмийн ажил нь хувь хүн хоорондын харилцан үйлдэлд, хувь хүний дотоод сэтгэцийн динамикт шууд чиглэсэн үйл ажиллагаа бөгөөд амьдралын дэмжлэг болон удирдан зохион байгуулах асуудлуудыг өөртөө багтаадаг” гэжээ. Нийгмийн ажилтан зөвлөгчийн үүргийг хэрэгжүүлэхийн тулд хүний зан үйл болон нийгмийн орчны талаар маш сайн мэдлэгтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хүний зан үйлд нийгмийн орчин хэрхэн нөлөөлдөг тухай мэдлэг юм. Нийгмийн ажилтан зөвлөгчийн үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагаануудыг гүйцэтгэх болно.

- Нийгэм, сэтгэл зүйн үнэлгээ ба оношилгоо хийх: Үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг нэвт шувт ойлгох хэрэгтэй бөгөөд тэдэнд нөхцөл байдлыг өөрчлөх (өөрчлөгдөх) сэдэл, чадавхи, боломж ямар түвшинд байгааг үнэлэх болно. Нийгмийн ажилтан хэрэгжих боломжтой төлөвлөлт хийхийн тулд үйлчлүүлэгч болон түүний нийгмийн орчныг сайтар ойлгох хэрэгтэй болдог. Үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл цуглуулан, түүний сэтгэц нийгмийн амьдралын талаарх ойлголтоо нэмэгдүүлэх болно.

- Халамж үйлчилгээг тогтворжуулах: Зөвлөгчийн үүргийн хүрээнд нийгмийн ажилтан үйлчлүүлэгч болон түүний орчныг өөрчлөх үйл ажиллагааг явуулаад байдаггүй. Гэвч зарим нөхцөлд энэ үүргийг гүйцэтгэх ажил нь арай өргөн хүрээнд өрнүүлэх шаардлага бий болдог. Тухайлбал, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн эсвэл тодорхой хугацаанд өвчин эмгэгт нэрвэгдсэн хүмүүст болон тэдний гэр бүлд зөвлөгөө өгч байгаа тохиолдолд тэдний сонголтыг нэмэгдүүлж, хэрэгцээг нь илүү хангахуйц байдлаар ажиллахын тулд мэргэжилтэн орчин тойрны өөрчлөгдөшгүй хүндрэл бэрхшээлтэй нүүр тулгарах болдог.

- Нийгмийн эмчилгээ хийх: Энэ нь үйлчлүүлэгчдэдээ ойр тойрныхоо хүмүүс болон бүлгүүдийн хоорондын харилцааг ойлгоход нь туслах, нийгмийн хандлагаа өөрчлөх оролдлогыг нь дэмжих, өөрөө болон бусадтай хамтран асуудал шийдвэрлэх үйл явцад оролцуулах, хувь хүмүүсийн болон нийгмийн институцийн хоорондын зөрчилт байдалд

эвлэрүүлэн зуучлал хийх зэрэг чиг үүргүүдийг багтаадаг. Виттэйкер “нийгмийн эмчилгээ бол хувь хүн, гэр бүл, жижиг бүлгийн нийгмийн үйл ажиллагаа, үүргийг дэмжих болон тэдгээрт асуудлаа даван туулахад нь туслах зорилгоор шууд болон шууд бус стратегыг ашиглаж байгаа хувь хүн хоорондын тусламжийн үйл ажиллагаа” хэмээн тодорхойлжээ. Шууд стратеги нь нүүр тулж ажиллах аргыг хамарч байдаг бол шууд бус нь нөлөөлөл, итгэмжлэн төлөөлөх, тодорхой үйлчилгээг явуулах зэрэг арга хэрэгслийг ашигладаг байна. Шууд бус арга хэмжээнд үйлчлүүлэгчийн өмнөөс нийгмийн үйлчилгээний хэлцлийг хийх явдал юм.

Нийгмийн ажилтан кейс менежер болох нь:

Үйлчлүүлэгчийг хэрэгцээг шаардлагатай байгаа үйлчилгээнд нь холбох, тэдгээр үйлчилгээг өөр хооронд нь уялдуулан зохицуулах замаар үйлчилгээний цогц хийгээд үргэлжлэх боломжийг бүрдүүлэх явдал юм. Хэрэв үйлчлүүлэгч олон төрлийн үйлчилгээг хэд хэдэн агентлагаас авч байгаа бол кейс менежерийн үүрэг амин чухал болж ирдэг. Энэ үүргийг хувь хүн, гэр бүлийн хэрэгцээг хангах, нийгмийн үйлчилгээний төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх болон түүнд хяналт, үнэлгээ хийх үйл ажиллагаа хэмээн тодорхойлох нь бий.

Кейс менежерийн үүрэг нь хоёр үндсэн загвартай бөгөөд эхнийх нь үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээнүүдийг уялдуулан зохицуулах үйл ажиллагаагаар хязгаарлагддаг. Харин удаах нь, зохицуулах чиг үүрэг дээр нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн хамгийн ойрын зөвлөгч болон засалч байх хэрэгтэй болдог. Зохицуулагчийн үйл ажиллагааны загвар нь хүүхэд хамгааллын салбарт, харин зохицуулагч, зөвлөгч (засалч) загвар нь сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээнд ихээхэн хэрэглэгддэг. Мокслеи кейс менежментийн үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчийн түвшин дэх зорилго, үйлчилгээ болон мэдээллийг уялдуулан зохицуулах, үйлчлүүлэгчийн төлөө (үйлчилгээ үзүүлэгчийн төлөө) хариуцлагыг төвлөрүүлэх, тусламжийг нэг мэргэжлийн эсвэл мэргэжилтнүүдийн багийн зүгээс нэгдмэл утгаар харах, үйлчлүүлэгчид үйлчилгээг хүртээмжтэй байлгах зэрэг үндсэн чиг үүргүүдийг тоочсон байдаг. Түүнийхээр, нэг талаас, хүн амын аргаар үйлчилгээ үзүүлж буй тогтолцооны үед гадна нь хаягдсан үйлчлүүлэгч, нөгөө талаас тухайн үйлчлүүлэгч тулгарсан хавсарсан олон асуудлаас болж аль нэг үйлчилгээ авагсдын ангилалд таарахгүй байгаа үйлчлүүлэгчид кейс менежерийн анхаарлын төвд байх ёстой хүмүүс гэжээ.

Ротмэн болон Мокслеи нарынхаар нийгмийн ажилтан кейс менежерийн үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг гүйцэтгэх болно.

- Үйлчлүүлэгчийг танин мэдэх, баримжаалах: Кейс менежментийн

үйлчилгээнд хамрагдсанаар үйлчилгээнээс илүү үр нөлөө өгөх, амьдралын чанарт илүү сайн үр дүн гарах, үйлчилгээний өртгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой үйлчлүүлэгч хаана байна, тэдгээр үйлчлүүлэгчийг судалж, сонгох үйл ажиллагаа юм.

- Үйлчлүүлэгчид нөхцөл байдлын үнэлгээ хийх: Үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл цуглуулан, түүний хэрэгцээ, амьдралын нөхцөл байдал болон нөөцийг тодорхойлох явдал юм. Энэ нь бас үйлчилгээ авахаар ямар нэг хүсэлт гаргаагүй боломжит үйлчлүүлэгчдийн дунд ч хийгдэж болно.

- Үйлчилгээг төлөвлөх: Үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангахуйц үйлчилгээг тодорхойлж, тэдгээрийг төлөвлөх болно.

- Үйлчилгээнд холбох ба зохицуулах: Холбон зуучлах үүргийн нэгэн адил үйлчлүүлэгчийг шаардлагатай үйлчилгээнд холбох болно. Гэвч, кейс менежерийн үүргийн гол онцлог нь холбоод зогсохгүй, үйлчилгээ үзүүлэх үйл явцад идэвхтэй оролцогч байж үлддэг.

Нийгмийн ажилтан захиргааны ажилтан болох нь:

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хүрээнд ямар нэг бодлого, үйлчилгээ болон хөтөлбөрийг төлөвлөх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийгмийн ажилтан явуулж байдаг. Скидмор нийгмийн ажлын удирдлага, захиргаа гэдэг нь нийгмийн бодлогыг нийгмийн үйлчилгээ болгож хувиргаж буй үйл явцыг удирдах үйл ажиллагаа бөгөөд ихэнхдээ төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөцийн хангалт, зааварчилгаа, хяналт зэрэг арга хэрэгслийг ашигладаг хэмээн тодорхойлжээ. Энэ үүргийг гүйцэтгэж буй тохиолдолд нийгмийн ажилтан захиргааны ажилтан болж ирэх бөгөөд захиргааны ажил нэн тэргүүний үүрэг байдаг. Тэр үед, нийгмийн ажилтан бусад практик үүргийн хамт захиргааны зорилтыг шийдвэрлэх хэрэгтэй болно.

Нийгмийн ажилтан захиргааны ажилтан болохын хувьд бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг. Агентлагын удирдлагууд нийгмийн үйлчилгээний байгууллагын зорилго зорилтыг тодорхойлж, захиргааны удирдамжуудыг боловсруулж, нөөцийг хуваарилж байдаг. Тухайн байгууллагын бүтэц, хэмжээнээс хамаарч нийгмийн ажилтан захиргааны үүрэгт хамаарах дараах чиг үүргүүдийг бүхэлд нь эсвэл заримыг гүйцэтгэж байдаг.

Нийгмийн ажилтан захиргааны ажилтан болохын хувьд дараах үйл ажиллагааг гүйцэтгэх болно.

- Менежмент: Нийгмийн ажилтан аль нэг хөтөлбөр, үйлчилгээний үед эсвэл байгууллагын нэгжийн түвшинд, цаашилбал байгууллагын хэмжээнд зорилгоо хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хэлдэг. Энэ нь байгууллагын удирдлагад дэмжлэг үзүүлэх, ажилчдыг сонгох, тэдгээрийн ажил үүргийг

уялдуулан зохицуулах, зорилгыг эрэмбэлэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтад шинжилгээ хийх, байгууллага дахь стандартыг хөгжүүлэх, зөрчлийг шийдвэрлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг багтаадаг. Түүнээс гадна, байгууллагын төсөв, баримтжуулалт, төсвийн зарцуулалт болон техник хэрэгслийн ашиглалтыг зохицуулдаг.

- Дотоод ба гадаад зохицуулалт: Захиргааны ажилтны анхдагч үйл ажиллагаа бол байгууллагын ажлыг зохицуулах явдал мөн. Дотоод зохицуулалт бол бодлого болон хөтөлбөрийг үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийх явдал юм. Үүнд байгууллагын дотоод нэгжүүд харилцан ойлголцох, мэргэжилтнүүд шинээр бий болсон зүйлсийн талаар нэг мөр ойлголттой болсон эсэхийг баталгаажуулах зэрэг баггдаг. Түүнчлэн, захиргааны ажилтан байгууллагынхаа гадаад орчныг хариуцаж, байгууллагаа төлөөлөх болдог. Олон нийт, үйлчлүүлэгчдийн зүгээс ирэх дарамт шахалтыг зохицуулах, тэдгээрт үйлчилгээний талаар тайлбар хийх, тэдэнтэй хэлцэл хийх үйл ажиллагаа шаардлагатай юм.

- Бодлого ба хөтөлбөрийг хөгжүүлэх: Нийгмийн ажилтан одоо агентлагын зүгээс хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, үйлчилгээнд бүх нөөц бололцоогоо зориулж ажиллах нь зүйтэй боловч, өнөөгийн хэрэгцээнд үнэлгээ хийсний үндсэн дээр шинэ үйлчилгээний төрөл, хэлбэрийг эсвэл одоогийн үйлчилгээний хүрээнд зарим шинэчлэл хийх шаардлагатай гэдгийг дэвшүүлэх ёстой.

- Хөтөлбөрийн үнэлгээ: Захиргааны ажилтан болохын хувьд нийгмийн ажилтан үйлчилгээний чанарт хяналт тавьдаг хүн юм. Үйлчилгээний хэрэгжилт буюу орц гарц, үйл явц, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай үйл ажиллагаа, үйлчилгээний нийгэмд үзүүлж байгаа үр дагавар, үр нөлөөг хяналт шинжилгээ, үнэлгээний арга зүйд тулгуурлан дүгнэлт, зөвлөмж гаргах болдог.

Нийгмийн ажилтан өөрчлөлтийн агент болох нь:

Амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатай олон нийт буюу талбарыг судлан танин мэдэх, өөрчлөлт болон шинэ нөөцийн төлөө сонирхлын бүлгийг идэвхжүүлэх үйл ажиллагаа юм. Хөршийн холбоо, олон нийт, нийгмийн тогтолцоонд хэрэгцээтэй өөрчлөлтийг дэмжихийн тулд хувь хүн болон түүний орчны аль алинд анхаарлаа хандуулах болно.

Нийгмийн ажлын өөрчлөх үүрэг нь түүний үүссэн цагаас хойш л хамт хөгжиж ирсэн зүйл юм. Энэ үүрэг нийгмийн ажилд хамаардаг учраас түүнийг хүнд тусалдаг бусад ажил мэргэжлүүдээс ялгах онцлогыг бий болгодог. Хэрэв нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй шууд тулж ажиллаж байвал түүний асуудал юунаас үүдээд байгаа, ямар нөхцөл байдал түүнд

хүргээд байгааг танин мэдэх ихээхэн боломж бүрддэг. Нийгмийн ажилтан хүмүүсийн хэрэгцээг хангах нөөц эх үүсвэрийг бүрдүүлэх, олон нийтийн анхаарлыг эдгээр хүмүүст хандуулахдаа бусад хүмүүсийн үйл ажиллагааг ашигладаг. Нийгмийн өөрчлөлт гэдэг бол тийм амар хялбар, хурдан явагддаг зүйл биш учраас, энэ үүрэг хаа сайгүй хэрэгжээд байдаггүй. Өөрчлөлт нь нөлөөллийн бүлгүүд болон шийдвэр гаргагчдын үйл ажиллагааг асуудал шийдвэрлэхэд түлхэх, өдөөх үр чадварыг илүүтэй шаарддаг. Нийгмийн ажилтан өөрчлөлтийн агент болохын хувьд дараах чиг үүргийг гүйцэтгэх болно.

- Нийгмийн асуудал болон бодлогод дүн шинжилгээ хийх: Өөрчлөлтийн эхний алхам бол асуудлын мөн чанарыг ойлгох явдал юм. Бодитой оршин буй асуудлыг судалж, дүн шинжилгээ хийж шийдвэр гаргагчдад ойлгомжтой байдлаар танилцуулах хэрэгтэй болдог. Энэ суурь ажлыг гүйцэтгэхгүйгээр өөрчлөлт өөрөө амжилт олохгүй. Энэ хүрээнд, тухайн асуудлын шалгуур үзүүлэлтийг тогтоох, хүмүүсийн амьдралд болон асуудалд үзүүлж байгаа нөлөөллийг тодорхойлох, олон нийтийн үнэт зүйлс болон итгэл үнэмшил уг асуудалд нөлөөлж байгаа эсэхийг шинжлэх зэрэг ажлууд ордог.

- Олон нийтийн анхааралд оруулах: Санаа тавьж буй хувь хүмүүс, бүлэг болон олон нийтийг идэвхжүүлэх, эрчимжүүлэхийн тулд хүмүүсийн ойлголт төсөөллийг нийгмийн өөрчлөлт хийх оролдлого болгон хувиргах болно. Энд үйлчлүүлэгч, олон нийт, сонирхлын бүлгүүд, болон үйлчлүүлэгчдийн бүлгийг тухайн асуудалд анхаарах хийгээд идэвхтэйгээр хэлэлцүүлэгт оролцуулах ажил явагддаг. Идэвхжүүлэлтийн ажил нь ашиг сонирхлын талуудыг холбон нэгтгэх, нөхцөл байдлын шинжилгээг танилцуулах, тухайн асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, зорилгоо тодорхойлох, стратегийн сонголтоо хийх, шийдвэр гаргагчдыг тодорхойлох, төлөвлөх, өөрчлөлтийн үйл ажиллагааг явуулах зэрэг үе шатуудыг хамаардаг.

- Нийгмийн нөөцийг хөгжүүлэх: Өөрчлөлтийн агент болох ажил нь хэрэгцээ шаардлагатай хөтөлбөр болон үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэдэг. Нөөцийг хөгжүүлэх гэдэг нь байхгүй нөөцийг шинээр бүтээх, оршин буй нөөцийг нэмэгдүүлэх, нөөцийг төлөвлөх болон хуваарилах үйл ажиллагаа бөгөөд энэ нь нийгмийн үйлчилгээний үед зайлшгүй бус давхардсан зардлыг бууруулахын тулд хийгддэг.

Нийгмийн ажилтан ажлын ачааллаа зохицуулагч болох нь:

Нийгмийн ажилтан нэгэн зэрэг хэд хэдэн үйлчлүүлэгчид үйлчилгээг хүргэж байдаг бөгөөд түүнчлэн өөрийн ажиллаж буй байгууллагаас ажлын ачааллаа зохицуулах хүрээнд тавигдах шаардлагыг хангах хэрэгтэй

болдог. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчийн болон байгууллагын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлэх хэрэгтэй. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй нүүр тулж ажиллах, шууд бус замаар түүний орчинтой ажиллах, түүнчлэн байгууллагын өдөр тутмын ажил үүрэгтэй тулгардаг. Энэ бүхэн нь түүний ажлын ачааллыг нэмэгдүүлдэг.

Нийгмийн ажилтан ажлын ачааллаа зохицуулахын тулд дараах үйл ажиллагааг гүйцэтгэх болно.

- **Ажлаа төлөвлөх:** Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн тулд үйлчлүүлэгчтэй холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөх, үйлчилгээ үзүүлэх, үнэлгээ хийх, үйлчилгээг төгсгөх зэрэг мэргэжлийн үйл ажиллагааны үе шатуудыг дамждаг. Түүнчлэн, үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл цуглуулах, хувийн хэрэг бүрдүүлэх, уулзалт хийх, үйлчлүүлэгчийн мэдээллийг цахим санд оруулах, мэдээллийг дээд тушаалын албан хаагчид хүлээлгэн өгөх зэрэг захиргааны ажлыг амжуулах болно. Эдгээр ажлуудыг хамгийн тулгамдсан болон чухлаас нь эрэмблэх ба хамгийн үр дүнтэй бөгөөд үр ашигтай аргаар хэрэгжүүлэх шаардлагатай болно. Энэ бол хувь хүн, бүлэг, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг төлөвлөх тухай асуудал биш ерөөс байгууллага дээрх бүхий л үйл ажиллагаагаа төлөвлөх тухай асуудал юм.

- **Цагийн менежмент:** Хэрэв нийгмийн ажилтан үйлчлүүлэгч бүрд анхаарлаа хандуулах аваас, цаг хугацааг хэрхэн ашиглах дэс дарааллыг бий болгох асуудалтай тулгарна. Ажлын цагийг няхуур хуваарилах хэрэгтэй гэсэн үг. Цагийн менежментийг бүрдүүлэхийн тулд нийгмийн ажилтан байгууллагынхаа компьютер мэдээллийн системийг ашиглаж болно.

- **Чанарт хяналт тавих:** Нийгмийн ажилтан өөрийн үйлчилгээний үр нөлөөг үнэлэх хэрэгтэй болох ба ингэхдээ өөрийн үнэлгээ хийх, эсвэл мэргэжил нэгт хамтран ажиллагчдаар үнэлгээ хийлгэж болно. Энэ үнэлгээ нь байгууллагын зүгээс хийсэн тэмдэглэлийг үзэх, ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийх, хурал хэлэлцүүлгийн хэрэгжилтийг эргэн харах зэрэг үйл явцыг багтааж болно.

- **Мэдээлэл боловсруулах:** Нийгмийн ажилтан хэрэгцээ болон үйлчилгээг баримтжуулах, тайлан үйлдэх, үйлчлүүлэгчийн талаарх тэмдэглэлийг хадгалах, янз бүрийн зарлагын баримт бүрдүүлэх зэргээр олон төрлийн мэдээллийг цуглуулж боловсруулах шаардлагатай болдог. Тиймээс эдгээр олон төрлийн баримтыг боловсруулах, бүрдүүлэх, хавтаслах арга зүйд суралцах хэрэгтэй.

Судалгааны ажлын хүрээг нийгмийн ажлын нэг салбар болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх чиглэлээр сонгон авч судалсан болно.

Олон улсын эрүүгийн ял эдлүүлэх салбарт өргөнөөр хэрэглэгддэг социализация (opoc), socialization (англи), sozialisierung (герман), ресоциализация, resocialization, resozialisierung, реабилитация, rehabilitation, social rehabilitation, rehabilitierung, sozialerehabilitierung, коррекция, исправление, адаптация үг хэллэг-нэр томьёо илэрхийлэгдсэн эсхүл тэдгээрийг төлөөлүүлэн хэрэглэсэн “хоригдлыг нийгэмшүүлэх”, “хоригдолд нийгмийн ажлын, сэтгэл зүйн, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх”, “хоригдолд нийгэмд, бусдад, эрх зүйн нийтлэг журамд хүндэтгэлтэй хандах харьцааг төлөвшүүлэх”, “хоригдолд суллагдсаны дараа бие даан амьдрах дадал, чадварт сургах” зэрэг нэр томьёо тусгагдан хэрэгжиж байна. Ял эдлүүлэх салбарын хэмжээнд эдгээр үйл ажиллагааг нийтэд нь “хоригдолын дунд явуулах нийгэмшүүлэх ажил” гэсэн ерөнхий хэллэг-агуулгаар хэрэглэж хэвшсэнийг тэмдэглэе.

Иймээс эрүүгийн эрх зүйн журмыг зөрчсөн гэмт этгээдийг “нийгэмшүүлэх” гэж нэр томьёог ашиглавал үйл явцын агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлнэ гэж үзлээ.

Судалгааны ажлын зорилго, зорилт:

Бид судалгааны ажлын хүрээнд хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалтыг уламжлалыг судлан, 2015-2020 оны хооронд хэрэгжиж буй хоригдлыг нийгэмшүүлэх ажиллагааны чиглэлээрх эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, улмаар тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон дүгнэлт-зөвлөмж гаргах зорилгыг өмнөө тавин ажиллалаа.

Зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1.Монгол Улсад хоригдлыг нийгэмшүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлалд дүн шинжилгээ хийх;

2.Хорих байгууллагын хэмжээнд хоригдлыг нийгэмшүүлэх ажиллагааны 2015-2020 оны хүрээнд хэрэгжилтэд шинжилгээ хийх;

3.Хорих байгууллагын нийгмийн ажилтны чиг үүрэгт дүн шинжилгээ хийх;

4.Гадаадын зарим орны хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны онцлогыг судлах зэрэг болно.

Судалгааны ажлын арга зүй:

Судалгааны ажлыг явуулахад нийгмийн шинжлэх ухааны нийтлэг судалгааны арга болох диалектикийн аргыг иш үндэс болгон түүхчлэх,


харьцуулах, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, анкетын болон ярилцлагын аргыг ашигласан болно.

Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохдоо эрдэм шинжилгээ, судалгаа-боловсруулалтын ажлын нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, ажиглалт болон ярилцлагыг ашиглаж боловсруулалт хийсэн болно.

Түүнчлэн хорих ял эдэлж буй хоригдлуудаас сонгон зөвхөн урьд хорих ял эдэлж байсан 1289 буюу нийт хоригдлын 30,2%-иас нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний талаар судалгаа авлаа. Судалгаанд оролцсон хоригдлуудыг ангилан авч үзвэл:


1. Судалгаанд нийт 1289 хоригдол хамрагдсанаас 1280 нь эрэгтэй, 9 нь эмэгтэй хоригдол байв.

Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын хүйсийн байдал:




2. Судалгаанд хамрагдагсдын 139 буюу 11% нь 18-25, 266 буюу 21% нь 26-30, 264 буюу 21% нь 31-35, 178 буюу 14% нь 36-40, 192 буюу 15% нь 41-45, 133 буюу 10% нь 46-50, 57 буюу 4% нь 51-55, 55 буюу 4% нь 56-с дээш настай байв.

Зураг 2. Судалгаанд хамрагдагсдын насны байдал:




3. Судалгаанд хамрагдагсдын 542 буюу 43% нь 2, 279 буюу 22% нь 3, 204 буюу 16% нь 4, 230 буюу 19% нь 5 ба түүнээс дээш удаагийн ял шийтгэлтэй байв.

Зураг 3. Судалгаанд хамрагдагсдын урьд ял эдэлж байсан талаарх судалгаа:




4. Судалгаанд хамрагдагсдын 93 буюу 7% нь дээд, 103 буюу 8% нь тусгай дунд, 451 буюу 35% нь бүрэн дунд, 363 буюу 28% нь бүрэн бус дунд, 174 буюу 14% нь бага, 102 буюу 8% нь боловсролгүй байв.

Зураг 4. Судалгаанд хамрагдагсдын боловсрол:




5. Судалгаанд хамрагдагсдын 748 буюу 59% нь мэргэжилтэй, 529 буюу 41% нь мэргэжилгүй байв.

Зураг 5. Судалгаанд хамрагдагсдын мэргэжил:



6. Судалгаанд хамрагдагсдын 622 буюу 47% нь гэр бүлтэй, 419 буюу 32% нь салсан, 282 буюу 21% нь гэрлэж байгаагүй байлаа.

Зураг 6. Судалгаанд хамрагдагсдын гэр бүлийн байдал:



Хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх зорилго бүхий асуулгыг хорих ангийн 50 нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдээс авч дүнг судалгааны ажилдаа ашигласан болно. Түүнчлэн нийт 21 хорих ангийн 2015-2020 оны нийгэмшүүлэх ажлын чиглэлээр хийгдсэн тайлан, мэдээ болон нийгмийн ажилтан, нийгмийн ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийсэн болно.

НЭГ. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ОНОЛЫН АСУУДАЛ

1.1.Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын ойлголт, онцлог

Нийгмийн ажлын гол зорилго нь нийгмийн асуудалтай, тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа хүмүүст туслах явдал байдаг. Нийгмийн ажилтан нь бусдад хүргэх тусламж үйлчилгээгээ өөрийн сонирголоос дээгүүрт тавьж өөрийн мэдлэг, үнэт зүйлс, чадвараа дайчилж нийгмийн асуудалтай, тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа хүмүүст үйлчилгээгээ хүргэдэг. Ингэхдээ нийгмийн ажил, үйлчилгээг үнэ төлбөр нэхэлгүй, сайн дураараа хүргэхэд бэлэн байна гэсэн ерөнхий ойлголт гарч ирсэн.

Харин Олон Улсын нийгмийн ажлын холбоо, нийгэмлэгээс нийгмийн ажлыг мэргэжил болохын хувьд тодорхойлохдоо "Нийгмийн ажил нь нийгмийн өөрчлөлтийг дэмжих хүмүүсийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, хүмүүсийн сайн сайхны төлөө тэдний эрх чөлөө, боломжийг нь өргөжүүлэх, чадваржуулахад туслах мэргэжлийн үйл ажиллагаа юм"¹⁰ гэж тодорхойлсон байдаг.

Дээрх хоёр тодорхойлолтоос үүдэн Нийгмийн ажилтан нь хүмүүст боломж, нөөц, хүч чадлаа нэмэгдүүлэх замаар тулгарсан саад бэрхшээлээ даван туулах, хэрэгтэй байгаа нөөц боломжоос хүртэхэд нь тусалж, хүн нийгмийн хоорондын харилцааг холбоог бэхжүүлж, хүмүүсийн сайн сайхан амьдралын тулд байгууллага, нийгмийн бодлогод нөлөөлдөг мэргэжлийн үйл ажиллагаа гэж үзэж болно.

Манай оронд 1996 оноос хүүхэд хамгаалал, 1999 оноос боловсрол, 2000 оноос хороо, 2002 оноос хорих ял эдлүүлэх ажиллагааны, 2007 оноос халамж, 2008 оноос эрүүл мэндийн салбарын нийгмийн ажилтнууд бий болон өөр өөрсдийн онцлогийг тусган хөгжиж байна¹¹.

Түүнчлэн хорих ангийн "нийгмийн ажил" гэсэн нэр томъёо, ойлголт бий болоод 20-оод жил болсон энэ цаг хугацаанд нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт, нийгмийн ажлын заавар, нийгэмшүүлэх хөтөлбөр зэрэг эрх зүйн бичиг баримтууд боловсрогдон гарсан билээ.

Практикт хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас, хүйс, ял эдлэх дэглэмийг ялгаатай оногдуулдагаас нийгмийн ажлыг харилцан ялгамжтай явуулдаг.

¹⁰ Д.Солонго. Хувь хүнтэй ажиллах нийгмийн ажил. УБ., 2010.11 дэх тал

¹¹ Б.Сүх-Ичир. Бодит жишээтэй ажиллах арга зүй. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал" сэтгүүл. 2014. №3. 34 дэх тал

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажил нь хорих ялаар шийтгэгдсэн хүнийг нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцох төлөвшлийг бий болгоход чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сургах, иргэд, бусад нийгмийн байгууллагатай зөв харилцаа үүсгэх, хөдөлмөрийн дадал, хүмүүжил олгох, хууль, дэг журмыг хэвшүүлэх нөлөөллийн цогц үйл ажиллагаа юм.

Монгол Улсын Хорих байгууллага түүхэн хөгжлийнхөө явцад хорих ял эдлэгсэдийг сурган хүмүүжүүлэх талаар тодорхой бодлогыг барьж, эрх зүйн актуудыг гаргаж байсан. Тухайлбал, 1924 оны 8 дугаар сард МАХН-ын 3 дугаар их хурлаас “Гяндангийн дотоод байдлыг сайжруулах, хэрэгтэн ардуудыг гэгээрүүлэх тухай”, 1934 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар их хурлаас ялтан, хэрэгтнийг хорихдоо сурган хүмүүжүүлэх ажлыг чухалчлах хэрэгтэйг онцлон тэмдэглэж байсан ба 1931 оны “Монгол Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль”, 1966 оны “Засан хүмүүжүүлэх хөдөлмөр хууль”-д хоригдогсодыг хөдөлмөрт сургах, мэргэжил эзэмшүүлэх зэргээр ял эдлэгсдэд зориулсан сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж иржээ.

Түүнчлэн 1997 он хүртэлх хугацаанд Хорих байгууллагуудын Удирдах байгууллагын бүтцэд “Улс төр, хүмүүжлийн хэлтэс”, хорих ангиудад “Сурган хүмүүжүүлэгч” ажиллаж байсан бол 1997-2003 оны хооронд хоригдолтой холбогдсон бүхий л харилцааг зохицуулж, тэдний эрх ашгийг хамгаалах, амьдрах, ажиллах, орчныг чөлөөт амьдралын хэв маягт аль болохоор ойртуулах, иргэншүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй “Ахуй дэглэмийн байцаагч” гэсэн нэршилтэй ажлын байрыг бий болгон ажиллуулж байжээ.

Харин 2003 оноос эхлэн хоригдлыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий “Нийгмийн ажилтан”-ны орон тоо батлагдсанаар өнөөгийн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийгмийн ажилтан ажиллах болж, 2006 оноос “Сэтгэл зүйч”-ийн орон тоог бий болгосноор одоогийн “Хорих байгууллагын нийгмийн ажилтан-сэтгэл зүйч” гэсэн нэр томъёо гарч ирсэн байна.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, цагдан хорих төвд хоригдож буй хоригдогсдын сэтгэл зүйн онцлог, тэдний хэрэгцээ, шаардлагад үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бүтэц, орон тоонд сэтгэл зүйчдийг ажиллуулахаар шийдвэрлэж, 2006 онд анх Цагдан хорих 461 дүгээр анги, Хорих 405 дугаар ангид мэргэжлийн сэтгэл зүйчийг томилон ажиллуулжээ.

2008 оны 2 дугаар сараас ШШГЕГ-т “Сургалт, нийгмийн ажлын тасаг”-ийг бий болгож, 2010 онд онд “Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтэс”, 2012 оноос “Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс” нэртэйгээр өргөтгөн зохион байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Хоригдлыг нийгэмшүүлэх асуудал нь хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад болон ял эдлээд суллагдсаны дараа гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гэмт зуршлаас нь татгалзуулах, хуулиа сахидаг (law binding) иргэншсэн бие хүн болон төлөвшүүлэх, нийгмийн амьдралд буцаан нэгтгэхэд чиглэсэн сэтгэл зүй, нийгмийн ажил, эрх зүй, менежментийн цогц арга хэмжээ¹² гэж ойлгож болно.

Хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын үйлчилгээ нь хорих байгууллагын зүгээс хоригдолд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг үе шаттай, үр дүнтэй явуулснаар тэднийг нийгэмшүүлэх буюу нийгэмд нь эргэн нэгтгэх (resocialization, reintegration into society), суллагдахаас өмнө эрх чөлөөт амьдралд нь бэлтгэх, суллагдаж гараад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэн явагддаг.

Үүнийг онолын үүднээс тайлбарлавал тусгайлан боловсруулсан хөтөлбөр, сургалтын дагуу тухайн хоригдлын зан байдал, хувийн онцлог, нас хүйс зэрэг онцлогийг харгалзан ялгамжтай явуулдаг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээгээр дамжин хэрэгжиж үр дүн нь гардаг байна.

Хорихын нийгмийн ажлын түвшин, үйлчилгээ:

Нийгмийн ажилтнууд ямар түвшинд үйл ажиллагаа явуулах нь тухайн салбарын ажлаас ихээхэн шалтгаалдаг. Тухайлбал боловсролын салбарын нийгмийн ажилтнууд, нийгмийн хамгааллын салбарын нийгмийн ажилтнуудын үйл ажиллагаа харилцан өөр түвшинд байна.

Нийгмийн ажилтнууд нийгмийн ажлын практикийн микро, мезо, макро түвшинд үйл ажиллагаа явуулна.

- Хорих байгууллагын нийгмийн ажилтан микро түвшинд хоригдогч-хувь хүн, түүний гэр бүл, хоригдогч-үйлчлүүлэгчийн бүлгийн түвшинд ажиллах нийгмийн ажил багтана. Микро практикийн үйлчилгээнд нь хоригдогч-үйлчлүүлэгч нарт ганцаарчлан үзүүлэх үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө засал, хоригдогчийн гэр бүлтэй ажиллах, хоригдогч-үйлчлүүлэгчийн төрөл хэлбэр болох хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настанд чиглэсэн үйлчилгээг үзүүлнэ.

- Нийгмийн ажлын практикийн мезо түвшин гэдэг нь нийгмийн үйлчилгээний байгууллагаар дамжин зохион байгуулагдах мэргэжлийн

¹² Г.Баттулга. “Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлж буй олон улсын туршлага” “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2016 он, 8 дахь тал

нийгмийн ажлын интервенцүүд орно. Сургууль, эмнэлэг, сум, хороо, шүүх, цагдаа, номын сан, нийгэмд үйлчилдэг төрийн болон төрийн бус бүхий л байгууллагууд нийгмийн үйлчилгээний байгууллагын жишээ болно. Хорих байгууллага бол нийгмийн үйлчилгээний байгууллагын нэг жишээ юм. Тухайлбал, хорих ангийн эмнэлэг, соёл урлаг, ахуйн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, иргэний бүртгэл, асрамжийн үйлчилгээ, тусгайлсан хүүхэд хамгааллын үйлчилгээ гэх мэт байна. Хорих байгууллага нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд хоригдол буюу үйлчлүүлэгч нарт үйлчилгээ үзүүлж байдаг.

• Нийгмийн ажлын практикийн макро түвшний нийгмийн ажил нь харьцангуй өргөн хүрээг хамарна. Энэ нь орон нутаг, олон нийттэй хамтран ажиллах, нийгмийн бодлого боловсруулах түүнийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх, нийгмийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад чиглэгддэг. Олон нийтийн оролцоог сайжруулах, хамтын ажиллагааг дэмжих, эрх нь зөрчигдсэн хүмүүст туслах зэрэг үйл ажиллагааг явуулна. Улс орны хэмжээнд ШШГБ-ын бодлого, төлөвлөлт, өөрчлөлт, шинэчлэлт, хууль эрх зүй, хүний эрхийн асуудал, зэрэг өргөн хүрээний асуудлууд багтана. Мөн хорих байгууллагад хандах олон нийтийн нөлөөллийн ажлууд орно. Жишээлбэл, өвчин зовлонтой хүмүүст туслах, байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах, хандив цуглуулах гэх зэрэг өргөн хэмжээний нийтийг хамарсан үйл ажиллагаанд хоригдол-үйлчлүүлэгч нарыг зохион байгуулан оролцуулах нь олон нийттэй ажиллах нийгмийн ажлын аргын нэг хэлбэр болно¹³.

Үйлчлүүлэгчтэй ажиллах нийгмийн ажлын практикийн орчин:

Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн амьдарч буй орчин, тэдний найз нөхөд, хамт ажиллагсад, байгалийн баялаг нөөц гэх мэт орчны нөлөөллийг анхааран үзэж ажиллах шаардлагатай. Үүнд, хоригдолд тулгамдаж буй асуудалд орчин ямар нөлөө үзүүлж байна, орчныг өөрчлөхөд анхаарах уу?, үйлчлүүлэгчийг өөрчлөхөд анхаарах уу? гэдэгт нийгмийн ажилтан нь анхаарч ажиллах хэрэгтэй юм. Жишээлбэл, гэмт хэрэг үйлдэгчийн орчны асуудлыг дараах байдлаар авч үзэж болох юм. Тэд хаана амьдарч байна, ямар орчинд ажил хийж, амьдарч байна, үйлчилгээний газрууд ойрхон байна уу? үгүй юу?, хамт олон найз нөхөдтэйгөө хэр зэрэг харилцаа холбоотой байна, ажил сургууль нь хэр зэрэг хол байна, мэдээллийг хаанаас авч байна, ойр хавьд нь ямар хүмүүс голдуу амьдарч байна гэх зэргээр орчны асуудлыг харж болно.

Хорихын нийгмийн ажлын практикийн орчны тухай авч үзвэл

¹³ Каратис Чех ТББ.Хорих байгууллаг дахь нийгмийн ажил.УБ.,2015 он.35 дахь тал

хоригдогч-үйлчлүүлэгчийг өөрчлөх үү? шоронгийн орчин, нөхцөлийг өөрчлөх үү? гэдэг асуудлыг анхаарах хэрэгтэй. Магадгүй зарим тохиолдолд үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхдээ үйлчлүүлэгчтэй тулж ажиллахаас илүү тэдэнд сөргөөр нөлөөлж буй хорих ангийн орчин нөхцөлийг сайжруулах нь үр дүнтэй байж болно.

Хорихын нийгмийн ажлын практикийн орчны элементүүд

Нийгмийн орчин: хорих ангид янз бүрийн хүн амын бүлгүүд байна. Үүнд: залуучууд, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүд, мөн хорих анги дахь хоригдлын тоо их, бага байх гэх мэт. Мөн хоригдлын нийгмийн байдал, мэргэжилтэй, мэргэжилгүй, ар гэрийн амьжиргааны байдал гэх мэт орно. Энэ бүгд нь улс орны хэмжээнд бас яригдана.

Газар зүй: хорих ангийн газар зүйн орчин нөлөөлдөг. Говийн бүс, хангайн бүс, хот, хөдөө гэх мэт. Жишээлбэл, хотод байрладаг бол гэр бүл, найз нөхдийн эргэлт байнга ирдэг байх гэх мэт.

Байршил: хотын төв, аймаг, сум, баг хороо гэх мэт төвөөсөө хэр их алслагдсан юм бэ? гэх мэт. Хотын байрлалд ч гэсэн төвөөс хол байрладаг бол бас орчны асуудал үүсч байдаг. Европын зарим улсад хотын төвд хорих байгууллагууд байрлаж байдаг. Энэ нь олон нийтэд эерэг хандлага төрүүлдэг байж болно.

Цаг агаар /хүйтэн сэрүүн, халуун гэх мэт/: үйлчлүүлэгч нарт цаг агаарын орчны хүчин зүйл байнга л нөлөө үзүүлж байдаг. Хувцас хунар, хоол тэжээл, орон байр гэх мэт олон асуудлууд энд бий.

Орон нутгийн нөөц: орон нутгийн байгалийн баялаг, үйлдвэр, хөдөлмөрийн насны хүн амын тоо, иргэдийн идэвх оролцоо ордог. Манай орны хувьд хорих анги байгуулсан практикаас харахад ихэвчлэн байгалийн баялгийг түшиглэсэн нь харагддаг. Энэ нь тухайн үеийн хөдөлмөрөөр дахин хүмүүжүүлэх явдалтай тохирч байсан юм. Одоогийн нөхцөлд орчны энэхүү хүчин зүйлийг тооцон үйлчилгээ үзүүлэх судалгаа, шинжилгээний ажлын эрэлт хэрэгцээ хэрэгтэй байна.

Түүх уламжлал ёс заншил: орчны ёс заншил буюу түүхээ хэр зэрэг нандигнадаг, ёс заншлаа хэр дээдэлдэг гэх мэт. Хоригдлын дунд үндэстэн ястны олон хэлбэр байдаг. Үүнтэй холбоотой өвөрмөц үйлчилгээнүүд бий. Жишээлбэл, шашин шүтлэгтэй холбоотой асуудал орно.

Соёл: уламжлалт соёлоо хэр зэрэг хадгалсан гэдгээс гадна тухайн орчин дахь хүмүүсийн соёлын хүрээ, харилцаа хандлага ямар байна вэ? гэдгийг анхаарах хэрэгтэй. Хорих ангийн орчин дахь хүмүүсийн соёлын хүрээг сайжруулах нь нийгмийн ажилтны анхаарах асуудлын нэг байна. Энэ үйл ажиллагааг үйлчлүүлэгч нарын хоорондын харилцааг сайжруулахаас эхэлнэ.

Нийгэм, эдийн засаг, улс төрийн бүтэц: улс төрийн тогтолцоо, ардчилал хэр зэрэг хөгжсөн, дотоодын нийт бүтээгдэхүүн ямар байгаа, ядуурал, ажилгүйдлийн түвшин, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ямар байна гэдэгт анхаарах. Ер нь аливаа улсын хөгжил нь дээрх орчны хүчин зүйлээс шалтгаалдаг бөгөөд энэ нь тухайн улсын нийгмийн бүхий л салбарт нөлөөлж байдаг. Үүнийг нийгмийн ажилтан өөрийн үйл ажиллагаанд тусган ажиллах ёстой.

Сайн дурын хөдөлгөөн: үйлчлүүлэгчдийн дунд сайн дурын үүсгэл санаачлагын бүлэг байгуулан ажиллах нь хувь хүний сөрөг зан үйлийг эерэгжүүлэхэд ихээхэн тустай болохыг хорихын практикаас харж болно. Гэхдээ эдгээр сайн дурын хөдөлгөөн нь олон нийт, хоригдогч-үйлчлүүлэгч нарт эерэг нөлөөлөл үзүүлэх зорилготой байх ёстой. Хоригдлуудын өөртөө туслах бүлгүүдийг ажиллуулах нь хоригдогч-үйлчлүүлэгч нарт нөлөөлөл үзүүлэх практик ач холбогдолтой юм.

Гэр бүл, бүлэг: үйлчлүүлэгчийн хамгийн чухал, нөлөө ихтэй орчны хүрээнд багтана. Гэр бүлийн байдал, хойд эцэг эхтэйгээ амьдардаг эсэх, харж хандах хүнтэй эсэх, найз нөхөд, хэнтэй хамгийн их ойр дотно ажиллаж байна гэдэгт анхаарах хэрэгтэй. Хорихын нийгмийн ажлын салбарын хувьд хоригдогч-үйлчлүүлэгчийн гэр бүл, тэдгээрийн бүлэгтэй ажиллах нь үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй.

Нийгмийн үйлчилгээний байгууллага: тухайн үйлчлүүлэгчид хамгийн ойр ямар нийгмийн үйлчилгээний байгууллага байна. Үйлчилгээний байгууллагуудын хамрах хүрээ ямар байна гэх мэт. Нийгмийн үйлчилгээний байгууллага бол хорихын нийгмийн ажилтны хамтран ажиллах чухал объект юм. Эдгээр байгууллагуудын тусламжтайгаар үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэнэ. Эмнэлэг, халамж, боловсрол, соёл, урлаг, иргэний, олон нийтийн байгууллагууд байна.

Үйлчлүүлэгчийг дэмжин туслах харилцааны тухай:

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх үйл явц нь нийгмийн ажилтан ба үйлчлүүлэгчдийн хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагааны үндсэн дээр явагддаг. Ялангуяа хорих ангид ял эдэлж буй хүмүүст нийгмийн ажилтны дэмжлэг туслалцаа маш их хэрэгтэй байдаг нь практикаас харагддаг. Иймээс хорихын нийгмийн ажилтан хоригдогч-үйлчлүүлэгч нартай харилцах харилцаандаа дэмжин туслах шинж чанарыг ашиглах хэрэгтэй. Энэхүү харилцаа холбоог тодорхойлох шинж чанаруудад:

- Бусдад санаа тавьсан байх-хоригдогч-үйлчлүүлэгчид халуун дулаан, элэгсэг дотноор хандаж, түүний нөхцөл байдал, санаа зовоож буй зүйлийг үнэхээр сонирхож харилцахыг илэрхийлнэ.

• Үүрэг, хариуцлага хүлээсэн байх-хоригдогч-үйлчлүүлэгчид туслах үйл ажиллагааны хариуцлагыг ухамсарласан байх ёстой. Зөвхөн сайхан сэтгэлтэй байх нь шаардлагатай дэмжлэг үйлчилгээ үзүүлэхэд хангалтгүй гэдгийг ойлгон мэргэжлийн үйлчилгээг чанартай, мэргэжлийн түвшинд хүргэхийг хичээх ёстой.

• Хүлээн зөвшөөрөх-хоригдогч-үйлчлүүлэгчийн мэдрэмж, сэтгэгдэл, шийдвэрийг хүндэтгэн үзэж, шүүмжлэн буруушаахгүйгээр үйлчлүүлэгчийн байгаа байдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Гэхдээ хүлээн зөвшөөрнө гэдэг нь түүний байгаа байдлыг сайшаан дэмжинэ гэсэн үг биш юм. Харин одоогийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч цаашдын үйл ажиллагааны явцад өөрчлөх чиглэлээр ажиллана гэсэн үг юм.

• Импати буюу бусдын сэтгэлийг ойлгож харилцах-хоригдогч-үйлчлүүлэгчид санаа тавьж, түүний мэдэрч, ойлгож, санаа зовж байгаа зүйлийг сонсож, хуваалцаж, ойлгохыг хичээж харилцана гэсэн үг юм.

• Харилцаа тодорхой байх-хоригдогч-үйлчлүүлэгчид өгч буй мэдээлэл түүнд бүрэн дүүрэн ойлгомжтой, тодорхой байхаар харилцах ёстой.

• Шударга, нээлттэй байх-нийгмийн ажилтан өөрт төрж буй мэдрэмж, сэтгэгдлээ илэн далангүй, шударгаар тунгаан бодох, хандах явдлыг хэлнэ. Түүнчлэн өөрийн мэдрэмж, сэтгэгдлээ үйлчлүүлэгчийнхээс салгаж ойлгох явдал чухал юм. Нийгмийн ажилтан шударга, нээлттэй байснаараа үйлчлүүлэгчид ямар байхыг хүсэж байгаагаа мэдэх бололцоог олгодог.

• Эрх мэдэл, зөвшөөрөл ба хүчин чадал-хоригдогч-үйлчлүүлэгч өөрийн асуудлаа шийдвэрлэж, хэрэгцээгээ хангахын төлөө ажиллаж чадна гэсэн итгэл найдвар бусдад туслах харилцаанд чухал байдаг. Нийгмийн ажилтны мэдлэг, ур чадвар нь энэхүү эрх мэдэл, зөвшөөрөл ба хүчин чадлын суурь болдог.

• Зорилготой байх-тусалж дэмжих харилцаа холбоо нь нийгмийн ажилтан ба үйлчлүүлэгчийн аль алиныг хүлээн зөвшөөрч, дэвшүүлсэн тодорхой зорилгын үндсэн дээр явагдах ёстой.

Нийгмийн ажлын үйлчлүүлэгчтэй шууд тулж ажиллах практикт нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх Вестекийн зарчмыг баримтлан ажилладаг¹⁴. Эдгээр зарчмууд үйлчлүүлэгчийн онцлог, харилцаа зэргийг харгалзан үзэх шаардлагатайг авч үздэг. Үүнд:

- Хувь хүний өвөрмөц онцлог, шинж чанарыг хүндэтгэн үзэх;
- Сэтгэгдэл, мэдрэмжээ зорилготойгоор илэрхийлэх;
- Сэтгэлийн хөдөлгөөнийг ажиглах, хянах;

¹⁴ Нийгмийн халамжийн сургалтын гарын авлага.УБ.,2007 он

- Хүлээн зөвшөөрөх;
- Шүүмжлэлт бус хандлага;
- Үйлчлүүлэгчийн өөрийн шийдвэр, өөрийгөө тодорхойлох байдлыг хүндэтгэх;
- Нууцыг хадгалах.

Хэрэгцээ ба хорих байгууллагын үйлчлүүлэгчийн онцлог:

Хорих байгууллагын нийгмийн ажилтны үйлчлүүлэгчийг авч үзвэл, насны байдлаар нь: хүүхэд, залуучууд, ахмад настан, дэглэмээр авч үзвэл: нээлттэй, хаалттай, энгийн тусгай зэрэглэлийн хоригдол, хүйсээр: эмэгтэй, эрэгтэй, байршлаар: хотын бүсийн болон орон нутгийн хорих ангийн хоригдол, иргэншлээр: Монгол Улсын болон гадаадын харьяат хоригдол гэх мэтчилэн олон төрөлтэй байна.

Манай орны хорихын нийгмийн ажлын практикийн хувьд бас нэг томоохон бэрхшээл бол хорих ялаар шийтгүүлсэн хүмүүсийн дийлэнх нь ядуу иргэд байдаг. Иймээс хоригдол- үйлчлүүлэгчийн ахуй байдлыг дээшлүүлэх хэрэгцээ их байна. Мөн суллагдах үеийн үйлчилгээнд хоригдогчийн гэр бүл болон бусад нийгмийн хүчин зүйлд зайлшгүй анхаарах шаардлага нийгмийн ажилтанд тулгарч байна.

Үйлчлүүлэгч болох үйл явц нь нийгмийн ажилтны үйлчилгээг үзүүлэх байгууллагатай анх харилцсан цагаас эхэлнэ. Үйлчлүүлэгч гэдэг нь нийгмийн ажилтантай харьцаж байгаа хүмүүсийг хэлдэг учраас тогтвортой ойлголт юм. Үйлчлүүлэгч болох арга зам нь тухайн хүн өөрийнхөө амьдралд шийдвэрлэх шаардлагатай асуудал байгааг мэдсэнээр эхэлдэг учраас түүний байр суурь ч нийгмийн ажилтантай эн тэнцүү байх шаардлагатай байдаг. Жишээлбэл, нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн өмнөөс нөлөөлөх үйл ажиллагаа явуулахад тэднийг хамтран ажиллагсад гэж үзэж болно.

Хоригдол нийгмийн ажлын үйлчлүүлэгч болох үйл явц:

Хоригдлын хувьд нийгмийн ажлын үйлчлүүлэгч болох үйл явц нь иргэн буюу яллагдагч гэмт хэрэгт холбогдон анх цагдан хорих байранд ирснээс эхлэх бөгөөд шүүхийн шийдвэр гарч ял эдлэх үеэс жинхэнэ үйлчлүүлэгч болж ял эдлэх буюу байнга оршин суух, амьдрах хорих ангид хуваарилагдана. Тодорхой хугацааны дараа суллагдах үед шийдвэр гараад нийгмийн хэвийн амьдралд эргэн нэгтгэгдэж байдаг. Энэ бүхий л үйл явцад нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй тулж ажиллаж байдаг.

Хорихын нийгмийн ажилтны үйлчлүүлэгч бол маш олон төрөл, хэлбэрийн хүмүүс байдаг. Иймээс нийгмийн ажилтан үйлчлүүлэгч бүрийн онцлогт тохирсон үйлчилгээг үзүүлж байх ёстой. Хорихын нийгмийн ажилтны нэг чухал үйлчилгээ бол үйлчлүүлэгчийг анх хорих ангид хүлээн

авахаас эхэлнэ. Учир нь зарим үйлчлүүлэгч анх удаа гэмт хэргийн улмаас ял эдлэхээр ирдэг. Энэ үед хоригдол-үйлчлүүлэгчдэд хорих ангид дасан зохицох үйлчилгээ зайлшгүй үзүүлэх хэрэгцээ шаардлага гарна. Дахин гэмт хэрэг үйлдэн ирж буй үйлчлүүлэгчийн хувьд энэхүү төрлийн интервенц тэр бүр шаардлагагүй байж болно. Анх удаа ирж буй үйлчлүүлэгчийн хувьд шоронгийн амьдрал бол үнэхээр айдас, түгшүүрээр дүүрэн байдаг.

Юуны өмнө нийгмийн ажилтан хоригдогч-үйлчлүүлэгчийг хорих ангид анх ирэхэд нөхцөл байдлын үнэлгээний маягт бөглөж, сэтгэл зүйн тестүүдийг аван үйлчлүүлэгчийн хэрэгцээ болон сэтгэл зүйн байдал, зан байдлыг тодорхойлохоос үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

Хорих ялаар шийтгүүлэн хорих ангид ирж буй хоригдогч-үйлчлүүлэгчийн амьдралын мөчлөгийг нийгмийн ажилтан өөрийн ажилдаа анхааран ажиллах ёстой. Энэхүү амьдралын мөчлөг нь үйлчлүүлэгч бүрт харилцан адилгүй байна. Иймээс нийгмийн ажилтан үйлчлүүлэгч бүрийн онцлогт тохируулан үйлчилгээг үзүүлэх шаардлагатай.

Хоригдол-үйлчлүүлэгчийн шинэ орчин нөхцөлд дасан зохицоход нөлөөлөх хүчин зүйлс:

- Үйлчлүүлэгчийн гэр бүлийн онцлог;
- Үйлчлүүлэгчийн хувийн онцлог;
- Хорих ангид үйлчлүүлэгчийг хүлээн авахад бэлтгэгдсэн байдал;
- Хорих ангийн орчин, нийгмийн ажилтны арга;
- Хорих ангийн нөхцөл;
- Хорих ангийн нийгмийн ажилтны арга барил, үйлчлүүлэгчдэд хандах хандлага.

Эдгээр хүчин зүйлийг нийгмийн ажилтан өөрийн үзүүлж буй үйлчилгээндээ анхаарч хэрэглэвэл үйлчлүүлэгч хорих ангид хурдан хугацаанд дасан зохицож, аливаа эрсдэлтэй асуудалд өртөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой болох бөгөөд нийгмийн хэвийн амьдралд хүмүүжсэн, иргэншсэн иргэн болон эргэж нэгтгэгдэнэ. Хоригдол-үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан хорих ангид дасан зохицох үйл явц харилцан адилгүй явагдана.

Хорих ангийн нөхцөлд дассан зохицох байдлаар нь үйлчлүүлэгчийг доорх байдлаар ангилна:

- Сайн дасан зохицсон үйлчлүүлэгчид;
- Дунд зэрэг дасан зохицсон үйлчлүүлэгчид;
- Муу дассан зохицсон үйлчлүүлэгчид.

Сайн дасан зохицсон үйлчлүүлэгч нар нь:

- Аливаа үйл ажиллагаанд оролцох хүсэл сонирхол сайн;

- Аливаа үйл ажиллагаанд идэвхитэй, бие даах чадвар сайн;
- Хорих анги дотроо таатай байр суурьтай;
- Нийгмийн идэвх сайтай;
- Өөртөө итгэлтэй, үүрэг даалгаврыг сайн, дуртай гүйцэтгэдэг.

Дунд зэрэг дасан зохицсон үйлчлүүлэгч нар нь:

- Аливаа үйл ажиллагаанд оролцох, явахаасаа дургүйцдэггүй;
- Ажилтны хий гэснийг хийдэг, өөрийн санаачилга дунд зэрэг;
- Сонирхолтой зүйлээ сайн хийдэг;
- цөөнгүй найзтай;
- Үүрэг, даалгавраа ихэвчлэн гүйцэтгэдэг;
- Сайн ойлгосон буюу сонирхолтой зүйлийг итгэлтэй хийдэг.

Муу дасан зохицсон үйлчлүүлэгч нар нь:

- Аливаа үйл ажиллагаанд оролцдоггүй;
- Шалтаг тоочин явахгүйг хичээдэг;
- Сэтгэл санаа өөдрөг биш, зовлонтой, дарамттай байдалтай;
- Ажилтны шаардлагагүйгээр аливаа үйл ажиллагааг хийх дургүй;
- Зарим нь дэг журам зөрчдөг.

Энэ бүгд нь нийгмийн ажилтны хорих ангид үйлчлүүлэгчийг анх хүлээн авахаас эхлэх үйл ажиллагааны үр дүнд бий болно. Гэхдээ муу дасан зохицсон үйлчлүүлэгч байлаа гээд нийгмийн ажилтны үйл ажиллагаа үр дүнгүй болсон гэсэн зүйл биш бөгөөд энэ нь үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, онцлогоос ихээхэн шалтгаална гэдгийг анхаарах хэрэгтэй. Үүнд нөлөөлөх олон хүчин зүйл, орчин бий. Жишээлбэл, боловсролын хоцрогдол, зан чанарын доголдол буюу хүнтэй харилцах чадвар сул, ядуурлаас гэх мэт хүчин зүйл бий.

Өнөөгийн нөхцөлд хорихын нийгмийн ажилтны хоригдогч-үйлчлүүлэгчтэй ажиллах хоёр хандлага судалгааны явцад ажиглагджээ. Үүнд:

1. Үйлчлүүлэгчийн байр байдлыг тоочин шүүх:

- Сөрөг талыг тоочиж шүүнэ;
- Шууд туслахгүй;
- Тодорхой арга хэрэглэхгүй;
- Үүний улмаас үйлчлүүлэгч итгэлээ алдана.

2. Туслах ба хамтарч ажиллах:

- Шууд тусалцаа үзүүлнэ;
- Тодорхой аргыг хэрэглэнэ;
- Үйлчлүүлэгчдэд бодитой тусална;
- Үүний улмаас үйлчлүүлэгчийн итгэл нэмэгдэнэ.

Хорихын нийгмийн ажилтны хоригдол-үйлчлүүлэгчийг дасгах

аргуудаас авч үзвэл:

- Үйлчлүүлэгчээс мэдээлэл байнга авч байх;
- Хорих ангийн нөхцөлд аажмаар дасгах;
- Ойр дотныхонтой нь байлгах;
- “Ээжийн дээл” буюу ойр дотны нь хэн нэгний эд зүйл, хэрэглэл;
- Дуртай эд хогшлыг өрөөнд байлгах;
- Өөрийн төрөлх гэрийн эд зүйлсийг хамтад нь байлгах;
- Манайхан-зураг, эд хөрөнгө.

Дасгаж чадахгүй бол яах вэ?

- Ар гэрийнхэнд нь хэл өгөх;
- Туршлагатай мэргэжилтэн нартай зөвлөх;
- Өөр нийгмийн ажилтнаас туслалцаа авах.


Хорих ангид анх удаа ирж буй үйлчлүүлэгч нарыг шинэ орчин, нөхцөлд дасан зохицох, айдсыг даван туулахад нийгмийн ажилтан дараах аргуудыг хэрэглэж болно. Үүнд, айдсыг арилгадаг аргуудыг хэрэглэх, сайн ярилцах, урьдчилан сэргийлэх, шинэ хоригдлуудад хатуу шаардлага тавихгүй байх, ёс зүйг сахих, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эмчид хандах, айдас түгшүүрийг намжаах аргууд: дуусаагүй өгүүлбэрийн арга, хийж буй үйл ажиллагааг нь судлах, харанхуйг ялах, айдсыг зурах, яриулах зэрэг болно.

Хоригдогч-үйлчлүүлэгчдэд тохиолддог өөр нэг асуудал бол хорих анги дах дарамт байдаг. Энэ нь бусдаасаа өөрийгөө дээгүүрт тавьсан хэсэг бүлэг хүмүүсийн дарамт, ялгаварлал юм. Үүнийг хорих ангийн зүгээс анхааран ажиллах ёстой. Манай орны нөхцөлд үүнийг жирийн, хэвийн үзэгдэл мэтээр үзэх хандлага ажиглагддаг.

Хоригдогч-үйлчлүүлэгч нарт тулгарч байдаг бас нэг асуудал хорих ангийн албан хаагчийн харилцааны асуудал юм. Энэ нь албан хаагч нарын ёс зүйн асуудалтай холбоотой асуудал. Иймээс ёс зүйн асуудлыг нийгмийн ажилтан баримтлан, бусдад үлгэр дууриалал үзүүлэн ажиллах ёстой.

Судалгааны явцад 1293 хоригдлоос “та хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлыг хэрхэн ойлгодог вэ” гэсэн асуултад 514 буюу 40% нь хүний эрхийг хангахад чиглэсэн үйлчилгээ, 189 буюу 14% нь ахуй нөхцөлийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээ, 359 буюу 28% нь сургалтын үйл ажиллагаа, 231 буюу 18% нь сайн мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 7. Хоригдлоос авсан нийгэмшүүлэх ажлын ойлголтын талаарх асуулгын дүн



Хэдийгээр өргөн утгаараа нийгмийн ажил нь хүний эрхийг хангаж буй боловч яг хоригдлын хувьд нийгэмшүүлэх ажлын утга, агуулгыг бүрэн ойлгоогүй нь судалгаанаас харагдлаа.

Хоригдогч үйлчлүүлэгчийн хэрэгцээ:

Хорихын нийгмийн ажлын хувьд үйлчлүүлэгчийн хэрэгцээний асуудал чухлаар тавигдана. Учир нь үйлчлүүлэгчийн хэрэгцээ нь хүний эрхийн асуудалтай холбоотойгоор хязгаарлагдмал эрх, хэрэгцээг шийдвэрлэх үйл ажиллагаа байна. Үйлчлүүлэгчийн амьдралын мөчлөг тодорхой хугацаанд буюу “шоронгийн нөхцөлд” үргэлжилнэ. Иймээс нийгмийн ажилтан хоригдогч-үйлчлүүлэгчийн хэрэгцээг авч үзэхдээ хүний эрхийн хандлагад тулгуурлан ажиллах зарчмуудыг удирдлага болгон ажиллана. Хорихын нийгмийн ажилтан хоригдогч үйлчлүүлэгчийн хэрэгцээг мэдрэх нь мэргэжлийн ур чадвар шаардах зүйл юм. Учир нь хорихын нийгмийн ажлын үйлчлүүлэгч нь олон төрөл, хэлбэрийн хүмүүсээс бүрдэнэ. Жишээлбэл, эмэгтэй хоригдогч үйлчлүүлэгчийн хэрэгцээ нь маш олон төрлийн өвөрмөц хэрэгцээнүүд байна. Мөн хүүхдийн эрхийн асуудал ч энд орно. Сүүлийн үед хорихын нийгмийн ажлын практикт гарч буй асуудал бол гадаадын харьяат иргэд хорих ялаар шийтгүүлэн хоригдох болсон явдал юм. Хэрэгцээг мэдрэх болон хэрэгтэй байна гэдгийг ялгаж салгаж ойлгох нь нийгмийн ажилтны чухал ойлголт юм.

Хорихын нийгмийн ажлын практикт хоригдогч-үйлчлүүлэгч нар ихэвчлэн хэрэгцээгээ хангуулах хүсэл сонирхол давамгайлсан байдаг гэж үздэг. Тиймээс үйлчлүүлэгчийн хэрэгцээг хүсэл сонирхлоос ялгаж салгаж, үйлчилгээ үзүүлэх чадварыг нийгмийн ажилтан эзэмших ёстой.

Нийгмийн ажлын практикийн ерөнхий зарчимд “Нийгмийн ажил нь хэрэгцээнд тулгуурласан үйл ажиллагаа болох нь” гэж байдаг. Нийгмийн ажилд “хэрэгцээг хангах” гэдэг ойлголтыг зөвхөн тухайн үйлчлүүлэгчийн хувьд төдийгүй, уг нөхцөл байдалд тухайн хүний төлөөлж байгаа нийгмийн бүлэг, давхаргын болоод системийн хувьд авч үздэг. Учир нь хувь хүмүүс хэрэгцээгээ хангахын тулд нийгмийн харилцаанд ордог. Өөрөөр хэлбэл, хувь хүмүүсийн нийгмийн харилцаанд хэр амжилттай орж

байгаа үйл явц нийгмийн ажлын гол анхааралд байдаг. Энэ нь нийгмийн харилцаанд ороход нь хүмүүст туслах, түүнд сөргөөр нөлөөлж байгаа орчны хүчин зүйлүүдэд анхаарал хандуулна гэсэн үг.

Хорихын нийгмийн ажилтан хоригдогч-үйлчлүүлэгчийн хэрэгцээг шийдвэрлэхдээ хорих ангид ирсэн хугацаагаар нь ялгаж үзэх, нас, хүйсийн хувьд ялгавартай хэрэгцээг үнэлэх, дэглэмийн ялгааг тооцох, хорих ангид анхны болон дахин ирсэн байдал, хорих ангийн байршил зэргийг нийгмийн ажлын үйлчилгээндээ нэн тэргүүнд авч үзэх ёстой. Үүний дараа хорих байгууллагын орчин нөхцөлд анхааран ажиллана. Хоригдогч-үйлчлүүлэгчийн хэрэгцээ нь хүний эрхтэй салшгүй холбоотой байна. Иймээс хүний эрхэд суурилсан үйлчилгээнүүдийг санал болгодог. Үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлоход үндсэн 3 асуудлыг харгалзан үзэх ёстой. Үүнд:

1.Хүний хэрэгцээ нь хүний хөгжлийн асуудлаас шууд хамааралтай. Үүнд, үйлчлүүлэгчийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэм, сэтгэл хөдлөл, оюун санааны хөгжлийн асуудлыг авч үзэх ёстой. Хэрэгцээг тодорхойлох ялгаатай байдлыг харгалзан үзэхэд хүний хөгжлийн асуудал хамгийн их нөлөөлж байдаг хүчин зүйлийн нэг гэдэг нь тодорхой болж байна. Хүн эрх чөлөөгөө тодорхой хэмжээ, хугацаагаар хасуулсан байдаг учир хоригдогч-үйлчлүүлэгчийн бие бялдрын, танин мэдэхүйн, нийгмийн, сэтгэл хөдлөлийн, оюун санааны хөгжлийн асуудлыг тодорхойлон, үйлчлүүлэгчийн хэрэгцээг үнэлэн, үйлчилгээ үзүүлнэ.

2.Хувь хүний онцлог ба хүний ялгаатай байдал. Хүний хэрэгцээний асуудлыг авч үзэхэд хэрэгцээ гэдэг нь харьцангуй ойлголт бөгөөд түүнд нөлөөлж байдаг маш олон хүчин зүйлээс хамааран өөр өөр байх тухай асуудал зүй ёсоор гарч байдаг. Өөрөөр хэлбэл хэрэгцээ нь газар зүй, соёл, нийгмийн, эдийн засгийн, нас, хүйс зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Хорихын нийгмийн ажлын практикт үйлчлүүлэгчийн ялгаатай байдал нь нийгмийн ажлын үйлчилгээг өвөрмөц байдлаар тодорхойлж байна. Жишээлбэл гадаадын харьяат хоригдол, шашин шүтлэгийн ялгаатай байдал, боловсролын түвшингийн ялгаа, амьжиргааны ялгаатай байдал, нас, хүйсийн ялгаанууд нь ихээр нөлөөлж байна.

3.Нийгмийн тогтолцоо буюу систем. Хүний хэрэгцээний асуудлыг нийгмийн тогтолцоо, системээс ангид авч үзэж болохгүй. Учир нь үйлчлүүлэгч энэхүү системийн нэг хэсэг төдийгүй бусад системтэй нарийн нягт уялдаа холбоотой ажиллаж байдаг. Эдгээр системүүдэд гэр бүл, бүлгүүд, олон нийт, нийгмийн янз бүрийн байгууллагууд багтаж байдаг. Гэхдээ энэхүү үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлох үндсэн асуудлыг нь манай орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинтэй шууд холбон авч

үзэх хэрэгтэй. Монголын хүн амын 60 гаруй хувь нь ядуу, 20 хувь нь нэн ядуу амьдралтай байгаа нь хүмүүс гэмт хэрэг үйлдэх бас томоохон нөхцөл болж байна. Энэ нь нийгмийн систем үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлоход гол түлхэц болж байгааг харуулж байна.

Нийгмийн ажлын шинжлэх ухаанд хэрэгцээний талаар олон онол, загваруудыг ашигладаг. Үүнээс үйлчлүүлэгчтэй шууд тулж ажиллах практикт түлхүү хэрэглэдэг онолуудыг авч үзье.

Маслоугийн хэрэгцээний шатлал:

Америкийн эрдэмтэн судлаач Абрахам Маслоу 1940-өөд оны үед хэрэгцээний шатлалын онолоо боловсруулан гаргасан. Хүнд маш олон талын хэрэгцээ байдаг ба эдгээр нь чанд эрэмбэлэгдэн, шаталсан байдаг гэж А.Маслоу үзсэн. Хүний олон янзын хэрэгцээг таван үндсэн ангилалд хувааж үзсэн байна.

Маслоугийн хэрэгцээний шатлалын онол ёсоор хүний хэрэгцээг:

1.Бие, физиологийн хэрэгцээ: хүн юуны өмнө хооллож ундлах, унтаж амрах, өмсөх, орон байртай байх зэрэг бие физиологийн хэрэгцээ байдаг. Үүнийг анхдагч буюу төрөлхийн хэрэгцээ гэж үзсэн. Хоригдогч-үйлчлүүлэгчийн хувьд энэхүү анхдагч хэрэгцээг ямар нэгэн байдлаар хангаж өгсөн байдаг. Мөн зарим тохиолдолд үйлчлүүлэгч өөрөө хүссэн хоол хүнсээ хийж, хэрэглэх боломжийг нь хорих ангийн зүгээс бүрдүүлж өгч байна. Энэ нь үйлчлүүлэгчийн анхдагч хэрэгцээг хангах нөхцөл болж байгаа юм.

2.Аюулгүй байх, ирээдүйдээ итгэлтэй байх хэрэгцээ: ирээдүйд хүний бие физиологийн хэрэгцээ баталгаатай хангагдаж байх, хүрээлэн байгаа орчны зүгээс ямар нэгэн аюул заналгүй байх хэрэгцээ юм. Хорих байгууллагын хувьд энэ нь нийгмийн асуудлын хувьд баталгаатай байх, ажлын байранд санаа зовохгүй байх, ажиллах болон хоригдох хугацаандаа ая таатай нөхцөлөөр хангагдсан байх хэрэгцээ юм. Мөн аюулгүй эрүүл саруул орчинд амьдрах буюу хоригдох орон байр, эрүүл мэндийн тусламж авах, хүчирхийллээс хамгаалуулах зэрэг байна.

3.Нийгмийн социал хэрэгцээ буюу харьяалагдах, хайрлах, хайрлагдахын хэрэгцээ: нийгмийн бүлэгт хамааралтай байх, нийгмийн харилцаанд орж байх, нийгэм, хамт олон, бүлгийн зүгээс дэмжлэг авах хэрэгцээ бөгөөд хорих ангид анх ирэхэд нь хоригдогч-үйлчлүүлэгчийг хамт олонтой болгох алхмыг хийх нь нийгмээс хамааралтай болгож буй явдал юм. Мөн хоригдогчийн хувьд гэр бүлээс харьяат байж, эцэг эх, эхнэр нөхрийн болон үр хүүхдийн хайр халамжийг хүртэх, бусдыг хайрлаж, халамжлахад суралцах явдал энэхүү хэрэгцээг хангагдахад чиглэгдэнэ.

4.Өөрийгөө хүндэтгэх ба хүндлүүлэх хэрэгцээ: өөрийн авьяас чадвар,

ажлын амжилтаа бусдаар хүлээн зөвшөөрүүлэх, тэдэнд хүндлүүлэх, хоригдогч-үйлчлүүлэгчдэд өөрийгөө таньж мэдэх, өөрийнх хүсэл сонирхлыг хүндэтгэх, ингэснээр бусад хүмүүсийг хүндэтгэх арга ухаанд сурах хэрэгцээ юм.

5.Өөрийгөө идэвхижүүлэх хэрэгцээ: сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэх, өөрийн бие даах чадварт сургах, өөрийгөө хөгжүүлэх чадварыг олгох гэж хүний хэрэгцээг ангилж үзсэн байдаг. Мөн өөрийн авьяас чадвар, дадлага туршлага, боломжоо амьдралд хэрэгжүүлэх, хувь хүний хувьд өсөн дэвжих хэрэгцээ юм. Хоригдогч-үйлчлүүлэгчийг нийгмийн амьдралд эргэн нэгтгэхэд энэхүү хэрэгцээг хангаж өгөх нь чухал хэрэгцээ байна. Үүнд мэргэжил боловсролыг нь дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах, урлаг, спортын арга хэмжээнд татан оролцуулах, амьдрах ухааны үйл ажиллагаанд татан оролцуулах замаар энэхүү хэрэгцээг хангаж болно.

А.Маслоу эдгээр хэрэгцээ нь нарийн тогтсон дэс дараалал, шатлалд байна гэж тодорхойлоод хэрэгцээний шатлалын загвараа боловсруулсан. Эдгээр суурь хэсэгт зонхилох хэрэгцээ ямар нэгэн хэмжээгээр хангагдаж байж сая дээд талд орших хийсвэр хэрэгцээнүүдээ хүн авч чаддаг. Жишээ нь, аюулгүй байдлын хэрэгцээ үүсэхийн тулд физиологийн хэрэгцээ заавал хангагдсан байх шаардлагатай.

Хорихын нийгмийн ажлын хувьд үйлчлүүлэгчийн бие, физиологийн хэрэгцээнээс илүүтэйгээр дээд шатны хэрэгцээнүүдэд анхаарч ажиллах нь чухал байдаг. Учир суурь хэрэгцээг хорих ангийн хувьд үйлчлүүлэгч нарт бий болгож өгсөн байдаг. Хамгийн чухал нь үйлчлүүлэгч нарт өөрийгөө хөгжүүлэх, бусдын төлөө байх, нийгмийн бүрэн эрхт гишүүн байх гэх мэт хэрэгцээнүүдэд нийгмийн ажилтан үйл ажиллагаа, үйлчилгээгээ чиглүүлэх ёстой. А.Маслоугийн онол ёсоор бол суурь хэрэгцээ хангагдаж байж дээд хэрэгцээнүүд хангагдах ёстой байдаг ч хорихын нийгмийн ажлын хувьд хоол хүнс, орон байр, хувцас хунар болон бусад ахуйн хэрэглэлээр бүрэн хангаж байна.

Маклелендын хэрэгцээний онол:

Дээд шатны хэрэгцээнд тулгуурласан онолын өөр нэг загвар бол Дэвид Маклелендын онол юм. Тэрээр дээд шатны дараах 3 хэрэгцээ байдаг гэж үзсэн.

- 1.Эрх мэдэлтэй байх;
- 2.Бүтээмжтэй байх (амжилтын);
- 3.Аль нэг зүйлд татагдаж байх (хамаарлын).

Эрх мэдэлтэй байх хэрэгцээ нь бусдад нөлөөлөх хүслээр илэрхийлэгддэг. Маслоугийн хэрэгцээний шатлалын хүрээнд ийм хэрэгцээ

байхгүй ч гэсэн энэ нь хүндлүүлэх ба өөрийгөө илэрхийлэх хэрэгцээтэй холбоотойгоор илэрдэг. Амьдрал дээр эрх мэдлийн хэрэгцээ хүчтэй илэрсэн хүн ихэвчлэн удирдлагын хүрээнд ажилладаг байна. Тэд өөрийн бололцоогоо нээн илрүүлэх хэрэгжүүлэх талаар бусдаас давуу ба тэд дур зоргоороо захирах бус өөрийн нөлөөг илэрхийлэх чанар давамгайлсан, аливаа сөргөлдөөнөөс үл шантран өөрийн байр суурин дээр хатуу зогсдог байна. Хорихын нийгмийн ажлын практикт энэхүү хэрэгцээг бий болгохын тулд хоригдогч-үйлчлүүлэгч нарыг боловсрол, мэдлэгтэй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй. Нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчийг эрх мэдэлтэй болгох өөр нэг арга зам бол менежментийн ухаанд суралцуулах явдал бас байна. Энэ нь үйлчлүүлэгчийг бусдад хүндпүүлэх, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээг хангах алхам болно.

Бүтээмжтэй байх хэрэгцээ нь хүндлүүлэх ба өөрийгөө илэрхийлэх хэрэгцээний завсарт байдаг байна. Хүний амжилтыг тунхагласнаар энэ хэрэгцээ хангагдахгүй харин амжилттай дуусгах үйл явцаар хангагддаг. Бүтээмжтэй байх хэрэгцээ хүчтэй илэрдэг хүмүүс эрсдэлд аядуу ханддаг, асуудлыг шийдэх хувийн хариуцлага өндөртэй, эгзэгтэй үед бие даан шийдэл эрж хайх сонирхолтой байдаг. Мөн хүрсэн бодитой үр дүндээ тохирсон шагнал урамшуулал хүртэх сонирхолтой байдаг. Иймд хүмүүсийн хөдөлмөрийг тухай бүр үнэлж, урамшуулж байвал бүтээмжтэй байх хэрэгцээтэй хүмүүсийг үр дүнтэй ажиллуулж болно. Хоригдогч-үйлчлүүлэгч нарт аливаа үйл ажиллагааг бие даан зохион байгуулах, хийж гүйцэтгэх эрх өгснөөр илүү их бүтээмжтэй байдлыг бий болгоно.

Хамаарлын хэрэгцээ нь хүмүүс танил нөхөдтэй байх, танилын харьцаа тогтоох, бусдад тусламж үзүүлэх сонирхлоор илэрдэг. Энэ хэрэгцээг заримдаа холбогдох хүчин зүйлийн хэрэгцээ гэж бас нэрлэдэг. Хамаарлын хэрэгцээ ихтэй хүмүүсийг идэвхижүүлэхийн тулд тэдэнд нийгэм, олон нийтийн чанартай ажил үүрэг, эрх мэдлийг санал болгох хэрэгтэй. Мөн удирдлагын зүгээс байгууллагын доторх хувь хүн хоорондын харьцааг нээлттэй чөлөөтэй байлгах тал дээр анхаарвал зохино. Найз нөхөдтэй байх, хамтарч аливаа нэгэн үйл ажиллагааг зохион байгуулах, хийж гүйцэтгэх зэрэг нь бусдаас хамааралтай байх хэрэгцээг хангах боломжийг олгоно.

Д.Маклелендын онолын хандлагаар нийгмийн ажилтан үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа хоригдол-үйлчлүүлэгчийг тодорхой хэмжээнд өөрийнхөө төлөө эрх мэдэлтэй буюу мэдлэгтэй байх, хийсэн ажлаасаа таашаал, хүндэтгэл хүлээж авч чаддаг байх, хэн нэгнээс хамааралтай байх буюу гэр бүлийн бүрэн эрхт гишүүн байх зэрэг олон зүйлийг анхаарна гэсэн үг юм. Энэ онолоор хоригдол-үйлчлүүлэгчийн

хэрэгцээнд бусадтай хамааралтай байх хэрэгцээ байгаа бөгөөд гал хамтай болох явдлыг энд дурьдаж болно.

Clayton adlerfer-ийн хэрэгцээний онол:

АНУ-ын сэтгэл судлаач Clayton Adlerfer, А.Маслоугийн онол дээр суурилж өөрийн ЕКС онолоо боловсруулсан нь өнөөгийн Нийгмийн ажлын практикт их сонирхол татахуйц юм. К.Адлерферийн онол нь А.Маслоугийн онолоос дараах байдлаар ялгагдана.Үүнд:

- Тухайн цаг үед хоёр хэрэгцээ зэрэгцэн оршиж болно.
- Дээд шатны хэрэгцээ хангагдах үед доод шатны хэрэгцээг хангах хүсэл нэмэгдэнэ.

- Маслоугийн онолоор хүмүүс нэг шатны хэрэгцээгээ бүрэн хангахаас нааш тэр шатан дээрээ л байсаар байдаг гэж үзсэн бол Адлерфер дээд шатны хэрэгцээг биелүүлэхэд саад учирвал нэг шат ухран доод шатны хэрэгцээг хангах сэдэл бий болдог гэж үзсэн.

- Маслоугийн онол хатуу дараалалтай, доод шатны хэрэгцээгээ хангаж байж дараачийн шатанд шилжинэ гэж үздэг. Харин Адлерферийн онолоор илүү уян хатан, хүн оршихуйн хэрэгцээгээ хангаагүй ч гэсэн хөгжих хэрэгцээгээ биелүүлж болно хэмээн үздэг. Үүний тод жишээ бол "өлсөж буй зураачид". Тэд хэдий хоосон ходоодтой ч гэсэн хөгжих, бүтээх хэрэгцээ өндөр байгаа юм.

Хорихын нийгмийн ажлын практикаас үзэхэд хорих ангид ирж буй үйлчлүүлэгч эхлээд хорих ангидаа дасан зохицох буюу тухайн хүний оршихуйн хэрэгцээ бий болдог нь харагддаг. Үйлчлүүлэгч юуны өмнө өөрийгөө бусдад танилцуулах, улмаар гал хам буюу найз нөхөдтэй болох зэрэг үйлүүдийг хийдэг. Энэ нь хамаарлын хэрэгцээг бий болгох суурь юм. Ийм нөхцөлд үйлчлүүлэгчийн онцлогийг харгалзан нийгмийн ажилтан анхны үйлчилгээг үзүүлэх ёстой. Тодорхой хугацааны дараа үйлчлүүлэгчийг хөгжүүлэх шаардлага гарч ирдэг.

Дээрх онолын үзэл баримтлалуудыг нийгмийн ажилтан өөрийн ажилдаа ашиглан үйлчлүүлэгчийн хэрэгцээг авч үзэх шаардлагатай. Хориход байгаа үйлчлүүлэгчийн хувьд дараах нийтлэг хэрэгцээнүүд хангагдаж чадсан эсэхэд нийгмийн ажилтан анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүнд:

1.Бие, физиологийн үндсэн хэрэгцээ:

- Хоол хүнс-хангалттай тэжээллэг хоол хүнс хэрэглэх, витамин, хоолны илчлэг болон цэвэр усаар хангагдсан эсэх;
- Хувцас-гутал, дотуур хувцас, гадуур хувцас, оймс, малгай;
- Ариун цэврийн хэрэгцээ-шүдний оо, сойз, саван, нүүр угаах болон хувцас угаах, алчуур, юм угаах сав, 00-н цаас;

- Цагаан хэрэглэл-гудас, ор дэрний цагаан хэрэглэл;
- Дасгал хийх болон спортоор хичээллэх боломж.

2.Сэтгэл зүйн болон нийгмийн үндсэн хэрэгцээ

- Хорих байгууллагын амьдралын хэв маяг болон тогтсон дэг, хэв журамд дасан зохицох;


- Оюун ухааны үйл ажиллагаа-суралцах боломж, ном, сэтгүүл, сонин;
- Гэр бүлийн гишүүд болон найзуудтайгаа холбоо харилцаатай байх;
- Монголын хууль, эрх зүйн талаар мэдлэгтэй байх-эрүүгийн болон иргэний хууль эрх зүй.

3.Зарим нэг бүтээлч үйл ажиллагаа-гар урлал, урлаг, уран сайхан гэх мэт

- Оюун санааны үндсэн хэрэгцээ;
- Үзэл бодлоо илэрхийлэх, бусад хүмүүс түүнийг сонсох;
- Өөрт чухал хүмүүстэй уулзах-гэр бүлийн харилцаа холбоо;
- Өөрийн бодол, сэтгэлээ илэрхийлэх-зурах, бичих;
- Өөрийн сонголтоор шашны үйл ажиллагаанд оролцох эрхтэй байх;
- Өөрийн үнэлэмж, өөрийн талаарх өөрийн үзэл бодлоо өөрчлөх, сайжруулах боломж, боллоцоотой байх¹⁵.

Судалгаанд хамрагдсан 1291 хоригдлоос “Хорих ангиас үзүүлж буй нийгэмшүүлэх үйлчилгээ нь таньд зайлшгүй шаардлагатай хэрэгцээг хангаж байсан уу” гэсэн асуултад 832 буюу 64% нь тийм, 189 буюу 15% нь үгүй, 270 буюу 21% нь бага зэрэг гэж хариулсан.

Зураг 8.Хоригдлын нийгэмшүүлэх ажлын хэрэгцээний судалгааны дүн



Нийгмийн ажлын үйлчилгээний үе шатууд¹⁶:

Ерөнхий нийгмийн ажлын практикт нийгмийн ажлын үйлчилгээг дараах үе шатуудаар үзүүлдэг. Үүнд:

1.Үйлчлүүлэгчтэй анхны уулзалт хийж, харилцаа холбоо тогтоох үе шат:

¹⁵ Каратис Чех ТББ.Хорих байгууллаг дахь нийгмийн ажил.УБ.,2015 он.49 дэхь тал

¹⁶ Р.Оюунбадам нар. Хорих байгууллага дахь нийгмийн ажил. 2015 он., УБ хот. 34-49 дэх тал

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн тулд үйлчлүүлэгчтэй уулзаж, харилцаа холбоо тогтооно. Хорих ангийн нийгмийн ажилтны хувьд үйлчлүүлэгч нь хоригдогч хувь хүн, бүлэг юм. Бидний өмнө нь судалсанчлан ял эдэлж буй эдгээр хувь хүн нь дараах байдлаар нийгмийн ажилтны үйлчлүүлэгч болно. Үүнд:

а) хоригдогч өөрийн хүсэлтээр нийгмийн ажилтанд хандаж үйлчлүүлэгч болох;

б) бусад мэргэжилтэн, албан хаагч болон байгууллагын санал хүсэлтийн дагуу нийгмийн ажилтан нь хоригдогчтой уулзаж, үйлчлүүлэгчээ болгох.

Эхний тохиолдолд хоригдогч сайн дурын үндсэн дээр өөрөө нийгмийн ажилтанд хандаж байгаа тул уулзаж, харилцаа тогтоох нь тийм ч хүндрэлтэй биш байна. Харин хоёр дахь тохиолдолд бусдын санал хүсэлтийн дагуу нийгмийн ажилтан тухайн хоригдогчтой уулзаж, холбоо тогтоох шаардлагатай болдог. Ийм нөхцөлд зарим хоригдогч нь нийгмийн ажилтантай уулзаж, өөрт нь нийгмийн ажлын үйлчилгээ үнэхээр шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг бол, зарим нь түүнийг огт хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс бусдын шахалтаар нийгмийн ажлын үйлчлүүлэгч болж буй хоригдогчтой харилцаа холбоо тогтоох нь амаргүй байх болно. Нийгмийн ажилтан шүүмжилсэн, буруутгасан өнгө аясаар хэзээ ч хандаж болохгүй. Ойлгож, хүндэтгэн, хэрэгцээг нь мэдэрч харилцсанаар тухайн хоригдогч өөрийн асуудал, санаа бодлоо хуваалцах болно.

Энэ үе шатанд үйлчлүүлэгч болон нийгмийн ажилтны хооронд харилцан итгэлцэл бүхий холбоо бий болсон байх ёстой. Өөрөөр хэлбэл, нэг талаас үйлчлүүлэгч болох хоригдогч нь нийгмийн ажилтанд итгэх, нөгөө талаас нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ шаардлагатайг бодитойгоор ойлгуулна гэсэн үг. Нийгмийн ажлын үйлчилгээний эхний үе шат амжилттай бус болох тохиолдолд дараагийн үе шатууд хэрэгжихэд хүндрэлтэй байх болно. Тиймээс үйлчлүүлэгчтэй харилцаа холбоог үр дүнтэй, амжилттай тогтоох хэрэгтэй. Хорих ангийн нийгмийн ажилтан нь хоригдогчдод нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих ямар асуудал тулгараад байгааг, мөн нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эсэхийг анхны уулзалтаар тодорхойлно.

Анхны уулзалтыг зохион байгуулахын тулд тодорхой бэлтгэл шаардлагатай байдаг. Тухайн үйлчлүүлэгч болон түүнд тулгамдсан асуудалтай холбоотой мэдээллийг тоо бүртгэл болон бусад хүмүүс, албан хаагчдаас боломжийн хэрээр авч судалсан байх (асуудлыг улам хурцатгаж, дэвэргэж болохгүйг анхаарах, нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах), уулзалтын хөтөлбөрийг боловсруулсан байх,

ярилцах зүйлстэй холбоотой асуултыг урьдчилан бэлтгэх, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нь тогтоогдвол дараагийн уулзалтыг хэзээ хийж болохыг урьдчилан тодорхойлсон байх гэх мэтчилэн зүйлсийг анхаарна.

2.Мэдээлэл цуглуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шат:

Нийгмийн ажлын үйлчилгээний энэ үе шатанд үйлчлүүлэгчид тулгамдаад байгаа асуудлыг илрүүлж, нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлсны дараа тухайн асуудалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Туршлагагүй зарим нийгмийн ажилтны хувьд нөхцөл байдлын үнэлгээг зөвхөн мэдээлэл цуглуулахаар хязгаарлан ойлгодог. Гэтэл үнэн хэрэгтээ дараах зүйлсийг хийх шаардлагатай байдаг. Үүнд:

а) шаардлагатай мэдээллийг холбогдох хүмүүс болон эх сурвалжаас цуглуулах;

б) тодорхой аргыг ашиглан цуглуулсан материалдаа анализ дүгнэлт хийснээр нөхцөл байдлын үнэлгээ төгс утгаараа хийгдэнэ.

Нөхцөл байдлын үнэлгээ хийхийн тулд хоригдогчийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор ямар мэдээлэл цуглуулах шаардлагатайг тодорхойлох нь чухал. Тулгамдаад байгаа асуудлын мөн чанар, түүнд үзүүлэх үйлчлүүлэгчийн хариу үйлдэл, орчны нөлөө, асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой хувь хүний чадвар, боломж, нөөц эх сурвалж зэрэг мэдээллийг цуглуулна.

Шаардлагатай мэдээллийн жагсаалтыг гаргахад тухайн нийгмийн ажилтны ашиглах онолын үзэл баримтлал, хорих ангийн дэглэмийн ялгаатай байдлаас хамааран үзүүлдэг үйлчилгээний төрөл, чиглэл гэх мэт зүйлс нөлөөлж болно. Тухайлбал, нийгмийн ажилтан давуу талд тулгуурлах онолын үзэл баримтлалыг практик үйл ажиллагаандаа ашиглах бол хоригдогч, түүний хүрээлэн буй орчин дахь давуу тал, нөөц боломжийн (хувь хүний авьяас чадвар, давуу талууд, гэр бүл, найз нөхдийн дэмжлэг туслалцаа гэх мэт) талаар мэдээллийг голлон цуглуулж, дүн шинжилгээ хийнэ. Харин асуудалд тулгуурлах онолын үзэл баримтлалыг үндэс болговол тухайн хоригдогчийн сул тал, нөлөөлж буй сөрөг хүчин зүйл, саад бэрхшээл зэргийг голлон судлах жишээтэй.

Хорих ангийн дэглэмийн ялгаатай байдлаас хамааран хоригдогчид үзүүлэх үйлчилгээний төрөл хэлбэр өөр өөр байж болох талтай. Тухайлбал, нээлттэй дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдогчийн хувьд нийгмийн ур чадваруудад суралцах сургалт нээлттэй байх бол хаалттай хорих ангийн хоригдогчид ийм боломж бага байна гэсэн үг. Тиймээс хорих ангийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх мэдээлэл цуглуулахдаа эдгээр байдлыг тооцох шаардлагатай.

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн тулд бодит нөхцөл байдлыг сайтар судлах нь чухал бөгөөд үүнд шаардлагатай мэдээллүүд нь үнэн зөв бодитой байх асуудал ч хамаарагдана. Мэдээллийн эх сурвалж нь үйлчлүүлэгч өөрөө байхаас гадна түүний гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсад, эмчлэгч эмч, сэтгэл зүйч, харуул хамгаалалтын ажилтнууд, сургуулийн багш, хорооны нийгмийн ажилтан гэх мэтчилэн байж болно. Эдгээрийн зэрэгцээ албан байгууллагын тодорхойлолт, эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, хорих ангид анх ирэхэд нь хүлээн авах үеийн бүртгэл мэдээлэл, тухайн хоригдогчийн үйлдсэн хэргийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэл, хэрвээ дэглэм өөрчлөгдөж, шилжиж ирсэн тохиолдолд өмнө нь ял эдэлж байсан хорих ангийн нийгмийн ажилтны тодорхойлолт зэрэг бичиг баримтууд нь мэдээллийн эх сурвалж болно.

Гадаадын зарим орны туршлагаас авч үзвэл хорих анги нь хоригдогчийг анх хүлээж авахдаа хувийн намтар түүх, ерөнхий анкетыг бүртгэхийн зэрэгцээ эрүүл мэндийн үзлэгт хамруулж карт нээх, боловсролын түвшин, чадварыг үнэлэх тест бөглүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, дасан зохицох чадварыг үнэлэх зэргээр тодорхой мэдээллүүдийг бүрдүүлдэг бөгөөд нийгмийн ажилтан тухайн хоригдогчид үйлчилгээ үзүүлэх шаардлагатай тохиолдолд тэдгээрийг ашиглах боломжтой байдаг.

Мэдээллийг дээр өгүүлсэн эх сурвалжуудаас дараах аргаар цуглуулах боломжтой. Үүнд:

- Ганцаарчилсан ярилцлага хийх;
- Янз бүрийн сорил, тест ашиглах;
- Бодит болон хийсвэр нөхцөлд ажиглах;
- Асуулга бөглүүлэх;
- Холбогдох бичиг баримтуудыг уншиж, судлах;
- Эко зураглал, генограмм, амьдралын шугам, нийгмийн дэмжлэгийн сүлжээний тор, нэгдмэл загвар гэх зэрэг тодорхой зорилго бүхий мэдээлэл цуглуулах техникүүдийг ашиглаж болно.

Мэдээлэл цуглуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шатанд үйлчлүүлэгчид тулгамдаад байгаа асуудлын мөн чанар, түүнд үзүүлж буй үйлчлүүлэгчийн хариу үйлдэл, тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой үйлчлүүлэгчийн чадвар, боломж, нөөц, дэмжлэг туслалцаа зэрэг бүхий л мэдээлэлд дүн шинжилгээ хийж, чухам ямар үйлчилгээ тухайн үйлчлүүлэгчид тохиромжтой болох нь тодорхой болсон байдаг. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний ерөнхий зорилго, чиглэл тодорхойлогдсон байна.

3.Үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж, гэрээ байгуулах үе шат:

Нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шатанд тухайн үйлчлүүлэгч, түүний тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой бүхий л мэдээлэл, үйлчлүүлэгчийн хэрэгцээ, үзүүлэх үйлчилгээний чиглэл тодорхой болсон байх тул тэдгээрийг ашиглан цаашид хэрэгжүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна. Нийгмийн ажлын зарим ном, сурах бичигт үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах үйл явцыг нөхцөл байдлын үнэлгээний нэг хэсэг буюу хамт нэг үе шатанд авч үзсэн байдаг. Гэвч ихэнх тохиолдолд төлөвлөгөө боловсруулах үе шатыг тусад нь авч үзсэн байдаг бөгөөд энэ нь практикийн хувьд илүү ач холбогдолтой юм.

Үйлчилгээний төлөвлөгөө боловсруулахад тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан, түүнд байгаа нөөц боломжыг ашиглан, үйлчлүүлэгчийн хүсэж буй зүйл буюу тавьсан зорилгодоо хүрэх хамгийн оновчтой, үр дүнтэй арга замыг сонгох нь чухал. Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас хүлээж буй тодорхой үр дүнгээс гадна өөр гарч болох бусад үр дүнг тооцоолж, төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй. Төлөвлөгөө боловсруулах үе шатанд нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчтэй хамтран дараах зүйлсийг хийнэ. Үүнд:

- Үйлчилгээний зорилгыг оновчтой, тодорхой байдлаар томъёолох;
- Зорилгодоо хүрэх арга замыг тодорхойлох;
- Хэн, юу хийхийг тодорхой болгох;
- Тэдгээр зүйлсийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг тодорхойлох;
- Хэзээ хувилбарт төлөвлөгөө шаардлагатай болохыг тодорхойлох;
- Шаардлагатай нөөц, эх сурвалжийг тодорхойлох;
- Үйлчилгээг хэзээ дуусгавар болгохыг тодорхойлох.

Хорих ангийн нийгмийн ажлын үйлчилгээний хувьд дэглэмийн онцлог, ялгаатай байдлаас хамааран хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга, ашиглах нөөц боломж, хугацаа зэргийг тохиромжтой байдлаар тодорхойлох хэрэгтэй.

Ерөнхий нийгмийн ажлын практикт нийгмийн ажилтан, үйлчлүүлэгчийн хамтын ажиллагаа чухал байдаг. Тухайлбал, үйлчлүүлэгчийн хүсэл, хэрэгцээ, үйлчилгээний зорилгыг нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч хоёр хамтран зөвшилцөж, тодорхойлдог. Харин хорих ангийн нийгмийн ажлын үйлчилгээний хувьд тодорхой тохиолдолд нийгмийн ажилтан байгууллагын зорилго, чиглэл, үйл ажиллагаа болон нийгмийн хэрэгцээ шаардлагын улмаас үйлчлүүлэгчийн өмнөөс үйлчилгээний хэрэгцээ, зорилго, үйл ажиллагааг бие даан, эсвэл мэргэжил нэгт нөхдийн хамт тодорхойлж болно. Хэдийгээр сайн дурын бус үйлчлүүлэгч байж болох ч шаардлагатай тохиолдолд хоригдогчдыг

нийгэмшүүлэхэд чиглэсэн албадан сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх зэрэг интервенцийг төлөвлөгөөндөө тусгана гэсэн үг.

Нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөхийн тулд ял эдлэх нийт хугацаа, тухайн хорих ангид байх хугацаа, үйлдсэн гэмт хэргийн төрөл хэлбэр, нас, хүйс зэргийг харгалзан үзнэ. Эхний 1-3 дах уулзалтууд ихэвчлэн судлах, нөхцөл байдлыг үнэлэхэд чиглэгдэнэ. Харин асуудлыг шийдвэрлэх буюу үйлчилгээ үзүүлэх уулзалтын тоо нь тухайн хоригдогчийн асуудал, орчны нөхцөл байдлаас хамааран янз бүр байна.

Гэрээ байгуулах нь сайн дурын үйлчлүүлэгчийн хувьд өөрийн хүсэж буй зорилгодоо хүрэхийн тулд, харин сайн дурын бус үйлчлүүлэгчийн хувьд хэдийгээр нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, улмаар эцсийн дүнд өөрт нь үр ашигтай байх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг хариуцлага хүлээж, түүндээ эзэн болоход тустай байх болно. Үйлчилгээний төлөвлөгөөний нэлээдгүй зүйлсийг гэрээний маягтад тусган оруулдаг. Тухайлбал, үйлчилгээний зорилго; хэн, юуг, ямар хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай; үйлчилгээний үр дүнг хэрхэн тооцох гэх мэтчилэн. Үйлчлүүлэгчтэй хийх гэрээний маягтын олон янзын загвар байдаг бөгөөд дэглэмийн ялгаатай байдлаа харгалзан өөрийн гэсэн нэгдсэн загварыг ашиглах хэрэгтэй.

4.Төлөвлөгөөний дагуу үйлчилгээ үзүүлэх (интервенц) ба мониторинг хийх үе шат:

Интервенц гэдэг нь нийгмийн ажлын үйлчилгээний хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Тэдгээр үйл ажиллагаа нь үйлчилгээний зорилгоос хамааран янз бүр буюу маш өргөн хүрээтэй байна. Тухайлбал, хоригдогчийн зан үйлийг өөрчлөх буюу сөрөг зан үйлийг бууруулах эсвэл өөрийнх нь эерэг зан үйлийг улам батжуулж, хөгжүүлэх, шинэ зан үйлийг хэвшүүлэх, амьдрах арга ухаанд сургах, тодорхой үйлчилгээ авахад гэр бүлд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, уур бухимдлаа зохицуулж сурах сургалтад хамруулах, өрхийн төсөв, тооцоо хийж сургах, асуудлыг даван туулах чадварт сургах, мэргэжлийн чиг баримжаа олгох, тодорхой түвшний боловсрол эзэмшүүлэх гэх мэтчилэн. Эдгээрээс гадна интервенц нь үйлчлүүлэгчтэй зөвхөн ярилцаж, түүнийг сонсож, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх хэлбэрээр ч байж болно. Ингэснээр тухайн үйлчлүүлэгч аливаа зүйлийг өөрөөр бодож, олж харахад тусалснаар түүний амьдралын шинэ хуудсыг ч нээж өгч чадна.

Хорих ангийн нийгмийн ажилтнууд холбогдох байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран тодорхой интервенцүүдийг хөтөлбөр байдлаар боловсруулан хэрэгжүүлэх боломжтой. Жишээ нь:

- Нийгмийн харилцаанд ороход шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх

хөтөлбөр;

- Хорт зуршлаас татгалзуулах хөтөлбөр;
- Суурь боловсрол олгох хөтөлбөр;
- Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр гэх мэтчилэн.

Гэхдээ эдгээр инвервенцийн хөтөлбөрүүд нь хорих ангийн дэглэм тус бүрт өвөрмөц онцлогтойгоор хэрэгжих шаардлагатай байж болно. Тиймээс дэглэм тус бүрт ялгаатай байдлаар ашиглах боломжтой хувилбаруудыг боловсруулах нь чухал.

Дээрх зүйлээс та бүхэн тодорхой нэг салбарын нийгмийн ажлын үйлчилгээнд ашиглах интервенцийн бэлэн жор гэж байдаггүйг ойлгосон биз. Хэдийгээр ерөнхий нийтлэг хэрэглэгддэг интервенц байж болох ч үйлчлүүлэгчийн онцлог, өвөрмөц байдал, түүний ялгаатай орчин болон нөхцөл байдал, мэргэжилтний ур чадвар, үйлчилгээг үзүүлэх орчин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан шууд таарч тохирох интервенц гэж бараг л үгүй. Тиймээс ямар ч салбарын нийгмийн ажилтан өөрийн үйлчлүүлэгчид тохирох өвөрмөц интервенцийг оновчтой сонгож, тохиргоо хийн, хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэрвээ та мэргэжлээрээ төдийлөн туршлагажаагүй бол үүнийг туршлагатай нийгмийн ажилтнууд, ахлах нийгмийн ажилтнууд эсвэл мэргэжлийн зөвлөлөөр хамтран хэлэлцэж хийх нь тохиромжтой байх болно.

Интервенцийг хэрэгжүүлэх явцдаа түүний тохиромжтой байдал, үйлчлүүлэгчид гарч буй ахиц өөрчлөлт, үр дүнтэй байдлыг үнэлэх нь нийгмийн ажлын үйлчилгээний нэгэн чухал үйл явц юм. Явцын үнэлгээ буюу мониторингийг хэзээ, ямар аргаар хийхийг үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан байдаг. Нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх явцад мониторингийг хэд хэдэн удаа хийж болох бөгөөд энэ нь үйлчилгээг өөрчлөх шаардлагатай эсэх, эсвэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтойг тодорхойлж өгнө. Ихэнх тохиолдолд үйлчилгээний ерөнхий хугацаанаас хамааран, үйлчилгээг тогтвортой үзүүлж эхэлснээс хойш 1-2 долоо хоногийн дараа эхний мониторинг хийх боломжтой. Мониторинг хийхэд хэрэглэдэг ерөнхий аргын зэрэгцээ үзүүлж буй үйлчилгээтэй уялдуулан өвөрмөц аргуудыг ашиглаж болно. Тухайлбал, үйлчлүүлэгчийн харилцааны ур чадварыг сайжруулах интервенцийг хэрэгжүүлсэн бол тухайн үйлчлүүлэгч бусадтай хэрхэн харилцаж байгааг бодит нөхцөлд ажиглаж, тэмдэглэл хөтлөх; харилцааны ур чадвараа хэрхэн ашиглаж, дадал хэвшил болгож байгаа талаар асуулга бөглүүлж, өөрийн үнэлгээ хийлгэх гэх мэт аргуудыг хэрэглэж болно.

5. Үйлчилгээний үр дүнг үнэлж, үйлчилгээг төгсгөх үе шат:

Үйлчилгээг үзүүлж дуусах үед үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт,

үйлчилгээний үр дүнг үнэлнэ. Эцсийн үнэлгээг хийх нь үйлчилгээний үр дүнг тооцохоос гадна дараагийн удаа ижил төстэй асуудалтай өөр үйлчлүүлэгчид тус үйлчилгээг үзүүлэхэд юуг анхаарах, цаашид хэрхэн сайжруулах зэргийг тодорхойлох ач холбогдолтой. Үйлчилгээг үнэлэхэд тоон, чанарын, объектив, субъектив үнэлгээний аргууд, стандартчилагдсан сорил, тест, өөрийн үнэлгээ, эргэцүүлэл гэх мэтчилэн олон төрлийн аргыг ашиглаж болно.

Үйлчилгээний үр дүнг тодорхойлсны дараа үйлчилгээг төгсгөнө. Зарим байгууллагын хувьд үйлчилгээг төгсгөх сүүлийн уулзалтын үеэр үйлчилгээний үр дүнг тодорхойлж, үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт ахиц дэвшлийн талаар болон цаашид үйлчлүүлэгч хэрхэн бие даан асуудлаа шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нийгмийн ажилтанд дахин хандаж болох тухай ярилцаг. Үйлчилгээг төгсгөх талаар эртнээс бэлтгэлтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний явцад үйлчилгээ тодорхой хугацаатайгаар үргэлжлэх бөгөөд үйлчилгээ дуусахад хэр хугацаа үлдэж байгааг сануулж байх нь зүйтэй. Үйлчилгээг төгсгөх уулзалтын хөтөлбөртөө нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч хоёр үйлчилгээний үр дүн, үйлчлүүлэгчид гарсан ахиц дэвшлийн талаар ярилцахын зэрэгцээ харилцан бие биедээ талархлын үг хэлэх, дурсгалын зүйл өгөх зэрэг зүйлсийг оруулж болно¹⁷.

1.2.Монгол Улсад хорих байгууллагад хоригдлыг нийгэмшүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал

Монгол Улс хэдийгээр төр хууль, цаазын өнө их уламжлалтай хэдий ч тухайлан хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж ирсэн хууль тогтоомжийн хөгжлийг харьцангуй сүүлд буюу 1921 оны Ардын хувьсгал ялж шинэ үеийн Эрүүгийн болон Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй үүсч хөгжсөн үеэс эхлэн авч үздэг.

Энэ үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаа нь дараах онцлог шинжтэй байдаг.

1.Тусгайлсан хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт батлагдсан;

2.Хорих ял эдлүүлэх чиг үүрэг бүхий хорих ангиуд байгуулагдан, ял эдлэх тодорхой дэглэм, нөхцөл журам бий болсон;

3.Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь тодорхой зорилгыг агуулан, түүнд чиглэсэн үйл ажиллагааг явуулах болсон.

Ардын хувьсгалын дараах үеийн хорих ажиллагааг судлан авч үзэхэд тухайн үеийн мөрдөгдөж ирсэн эрх зүйн зохицуулалтын онцлогоос

¹⁷ Каратис Чех ТББ.Хорих байгууллага дахь нийгмийн ажил.УБ.,2015 он.58-62 дахь тал

хамааруулан 1921-1931, 1931-1966, 1966-1981, 1981-1993, 1993-2002, 2002-2017 он, 2017 оноос хойшхи гэж хууль тогтоомжийн үйлчлэлээр судлан авч үзэж болохоор байна¹⁸.

Хорих байгууллагын түүхэн хөгжлийн явцад хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь суртал ухуулга, сургалт-хүмүүжлийн ажил, ахуй нөхцөл зэрэг олон хэлбэрээр явагдаж ирсэн баримт бий.

1921-1931 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

1921 оны долдугаар сард Ардын Намын Төв Хороо, Түр Засгийн газрын хамтарсан хуралдаанаар төрийн яамдыг шинэчлэн байгуулахад Шүүх Яамны ерөнхий хэлтсийн харьяанд "Гяндан хороо" нэртэй байгууллага бий болсноор эдүгээгийн Хорих байгууллагын эх суурь тавигдсан байна.

1924 оны 11 дүгээр сард Улсын анхдугаар их хуралдаанаар тус улсыг "Бүгд Найрамдах Монгол Ард Улс" гэж тунхаглан анхдугаар Үндсэн хуулийг батлан, 1925 оны 11 дүгээр сард хуралдсан хоёрдугаар их хуралдаанаар тус улсад шүүн таслах эрхийг шинэтгэн явуулах тухай тогтоол гарган эрүүгийн эрх зүйн үндсэн зорилго, зарчмуудыг тодорхойлохдоо:

а. Шүүх таслах газрууд Ардын хувьсгалаар олсон эрх чөлөөг хамгаалах зорилготой тул ардчилсан эрх чөлөөг устгах гэсэн ардын дайсныг хатуу чанга цээрлүүлэн шийтгэх;

б. Хэрэгтэн этгээдийг шийтгэхэд шинэ хууль цааз баримтлахаас гадна манжийн хууль цааз, ард түмнийг боолчлох зорилготой тул түүнийг устган хэрэглэхийг цаазалж, шинэ хууль цааз зохиохдоо хувьсгалын үзэл суртал, одоо цагийн байдалд үл харшлах ард түмний уламжлалыг иш татах;

в. Хэрэгтний хэргээ хүлээсэн ба гэрч зэргийг баримтлан ял оногдуулахаас гадна элдвээр хэрэгтний биеийг зовоон ял хүлээлгэх, загнах, айлгах, өлсгөх зэрэг зэрлэг аргыг бүрмөсөн устгах;

г. Хэрэгтэн хүнийг шийтгэх ял, улс төрийн бодлого бол хэрэгтнийг сурган хүмүүжүүлэхийг гол болгох, оногдуулах ял нь хууль зүйд нийцсэн, хэрэгтэн этгээдийг засрах бололцоо олгосон хөдөлмөр хийлгэх, цаг хугацаа дуусахын өмнө тэнсэн суллах зэргийг оролцуулсан байвал зохино гэж заасан байна.

1926 оны Шүүх цаазын бичигт заасан ялын төрлүүд дотор "гянданд хорьж албадан үйлдвэр хийлгэх" ялыг оногдуулах ба хорих ял нь нэг өдрөөс 10 жил хүртэл хугацаагаар гяндан ба аливаа аж үйлдвэрийг хийлгэн сургаж засан сайжруулах газар хорьж эдлүүлдэг байжээ.

¹⁸ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.,2018 он.12 дахь тал

Тухайн үеийн хорих ял эдлүүлэх ажиллагааг 1925 оны "Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм", 1926 оны "Гяндангийн дэргэд түр мөрдөх дүрэм", 1929 оны "Хэрэгтэн, ялтнаар ажил үйлдвэр хийлгэх", "Аливаа гяндан, хорионы газарт эрдэм боловсролын хэргийг явуулах" зэрэг дүрмээр зохицуулж байсан байна.

Тухайн үеийн хорих ял эдлүүлэх ажиллагааг хяналт, ахуй нөхцөл, сургалт, хүмүүжлийн ажил, хөдөлмөр эрхлэлт гэсэн байдлаар ангилан авч үзье.

1. Ялтанд тавих хяналтын талаар тусгасан нь:

1925 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн Засгийн газрын 16 дугаар хурлын 4 дүгээр зүйлд баталсан "Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм"-д гяндангийн ерөнхий хуягууд нь аливаа ялтан, албан тушаалаар орон гарах хүмүүсийг цагдан байцаах, бүртгэн үзэх зэрэг гяндангийн дотоод бүхий л эрхийг хүлээн гүйцэтгэнэ. Цэргийн дарга, цэргүүд нь гяндангийн дотоод, гадаад хашааны хооронд завсар тойрон манаж, гадаад хаалгыг харгалзан ялтны оргож зайлахад хүргүүлэхгүй, сэргийлэн сахих албыг гүйцэтгэхээс гадна Шүүх явдлын яамнаас гянданг сахин харгалзах тухай тусгай тушаасан зүйлүүд буй бол бүрэн ёсоор даган гүйцэтгэвээс зохино. Харьяат гяндангийн ерөнхий болвоос тус гяндангийн газар ямагт сууж өглөө бүр ялтныг бүртгэн тоолж, тэднээс мэдүүлэх хэрэг буй бол уламжлан харьяат яаманд мэдүүлж байвал зохино гэжээ.

Харин 1926 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн Засгийн газрын 7 дугаар хурлын тогтоолоор баталсан "Гяндангийн дэргэд түр хэрэглэх заавар дүрэм"-д

а/ Гянданд хоригдож байгаа хэрэгтэн, ялтныг өглөө бүр 7 цагт босгож байвал зохино.

б/ Өдөр бүр өглөөний 7-8 цаг хүртэл хэрэгтэн, ялтнаар гяндангийн өрөөний хог шороог цэвэрлүүлэх ажлыг хуяг ба хэрэгтэн, ялтны дотроос сонгогдсон ээлжийн дарга нараас зааж захиран гүйцэтгэвэл зохино.

в/ Муу сурталтай хэрэгтэн, ялтныг ялган тусгай тасагт хоривол зохино. Эдгээр хэрэгтэн ялтныг хорих хэсгийн дотор тусгай сав тавьж шээлгэж баалгах ба тэдний ураг төрлийн зэрэг хүмүүстэй үл уулзуулан хоол ундыг оруулахыг зогсоовол зохино.

г/ Гяндангийн дэргэд хэрэглэж байгаа буу, зэвсэг, багаж зэргийг арчилж хайрлан, сайн байлгахаас гадна хэрэв эвдэх ба алдахад хүрвэл ерөнхий ба хуягууд ял төлбөрийг хүлээнэ зэргээр заасан байна.

2. Ялтны ахуй нөхцөлийн талаар тусгасан нь:

1925 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн Засгийн газрын 16 дугаар хурлын 4 дүгээр зүйлд баталсан “Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм”-д зааснаар:

а/ Гяндангийн дотор шөнийн цагт гэрэлгүй болвол цагдан байцааж сэргийлэн сахихад саатал боогдол үлэмж, ялтныг шөнийн урт цагт ямагт гэрэлгүй харанхуй суухад бэрхшээлтэй бөгөөд тостой лампочек зэрэг гэрлийг хэрэглэвээс гал түймэр гарах зэргийн хашлагатай явдал буй тул эрхбиш цахилгаан гэрлийг байгуулбаас зохих. Үүнд:

1. Ерөнхий дарга, цэрэг, хуяг суух байшин, гэр тус бүрт 15 лааны гэрэл нэжгээдийг нийтийн нэгэн адил хэрэглүүлсүгэй.

2. Ялтны суух тасалгаа бүр 15 лааны гэрэл нэжгээдийг жил бүр 9 дүгээр сарын 1-ээс 3 дугаар сарын 1-ийг хүртэл зургаан сард шөнө бүр 10 цаг хүртэл хэрэглэсүгэй.

3. Ялтны суух байшингийн гудамж, гадаад хаалга тус бүрт 15 лааны гэрэл нэжгээдийг нэгэн адил хэрэглүүлсүгэй гэжээ.Түүнчлэн:

-Ялтны суух байшин, тасалгааны дотор хүйтэн нойтон чийг, элдэв муу үнэр, хорт бөөс байгаа зэрэг нь ямагт орших ялтны бие тэсвэрлэн суухад бэрх тул ялтны биеийг өдөр бүр нэг цаг гяндангийн хашаанд салхинд явуулан, тэдний шар дэвсгэрийг сар бүр 3 удаа салхинд гаргаж тусгай өлгүүрт өлгөн, басхүү байшин тасалгааны хаалгыг нээж ариун салхи оруулан ариутгаваас зохино.

-Ялтны суух байшин, тасалгааны дотор хог шороо, буртаг зүйлийг өдөр бүр сайнаар шүүрдэн арилгаж ариутган цэвэрлэсний хойно ариун үнэрт арц зэрэг зүйлийг шатааж доторх муу үнэр танарыг арилгаваас зохино.

-Ялтны суух байшин, тасалгаа, гудамжинд нулимах, нүүр гар угаах сав бэлтгэн, ялтны нүүр гарыг өдөр бүр угаалган, сар бүр нэг удаа халуун усанд оруулж биесийг угаалган махбодыг сайжруулбаас зохино. Жич: Цэргийн албаны буюу энгийн худалдааны халуун ус, гэрийн ажилтантай зүй зохисоор хэлэлцэж, тэдний бие угаах усыг үнэ хөлсгүй, эрхбиш бусдаас хялбархнаар тогтоовоос зохино.

-Гяндангийн хашаан дотор ерөнхий дарга, цэрэг, хуягийн баах, шээх, бага пин нэг суурь, ялтны суух дөрвөн суурийг байшин тус бүрийн гадна талд нэгэн үргэлж бат бэх бага тасалгаа нэжгээдийг тус тус нэмэн байгуулж, баах шээх сав болгон бэлтгэж, урьд адил хашааны дотор суух, идэх уух тасалгаа бүрийн хог бузар буртаг болгохыг зогсоосугай. Тэдний суух байшингийн тасалгаа бүрийн хог шороо, баас, шээс, жич: Гяндангийн

хашаан доторх хог буртаг зүйлийг цөөн ялтан нар арилган цэвэрлэвээс зохино.

-Ялтны суух байшингийн гадаад хаалгыг батлан битүүмжилж доторх тасалгааг үл битүүмжлэн ялтны баах, шээх явдлыг саатуулан боогдуулахгүй болгосугай. Гагцхүү онц хүнд ялд буюу эс бөгөөд дадсан муу суртал явдалтай, бусад ялантай хэрэлдэх, жанчилдах зэрэг хэрэг будилаан өдүүлэх ялтныг тусгай тасалгаанд хорьж хаалгыг батлан битүүмжилсүгэй.

-Олон ялтан өөрсдийн дотроос орос, хятад зэрэг итгэлтэй бөгөөд чадамгай 3 хүнийг сонгон гаргаж, басхүү хуяг нэг хүнээр захиран даалгаж ялтны хоол ундыг хийлгэн бэлтгүүлэн, хоол ундыг хоцроосон, хассан, амт чанар муу болов хэмээн үг шүүмжлэл, бичиг даалгаврыг арилгасугай. Жич: Ялтны ураг төрлийн зэрэг хүмүүсээс ялтанд идээ хоол өгөх ба өдөр бүрийн өглөөний 8 цагаас 11 цаг, үдийн хойно 2 цагаас 4 цаг хүртэл хаалганы хуягт мэдүүлж үзүүлэн оруулбаас зохино.

-Ялтны ураг төрлийн зэрэг хүмүүс тэдэнтэй уулзах хэрэг учир байвал урьдаар Шүүх явдлын яаманд мэдүүлж зөвшөөрөл олгосны хойно өдөр бүр өглөөний 8 цагаас 11 цаг, үдийн хойно 2 цагаас 4 цаг хүртэл тус гяндангийн газрын ерөнхий даргын дэргэд 20 минутын дотор уулзуулбаас зохино гэж заажээ.

1926 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн Засгийн газрын 7 дугаар хурлын тогтоолоор баталсан "Гяндангийн дэргэд түр хэрэглэх дүрэм"-д

-Өглөө бүр 8 цагт хэрэгтэнд цай өгч байна.

-Үдшийн 7 цагт хэрэгтэн, ялтанд цай өгч байвал зохино.

-Үдшийн 10 цагт бүх хэрэгтэн, ялтан унтвал зохих бөгөөд тасалгаан доторх гэрлийг унтрааж гадаа гэрлийг үлдээвэл зохино.

-Өдөр бүр үдийн хойд 2 цагт хэрэгтэн, ялтанд хоол өгөхөд гадагш ажлаар гараад эргэж ирээгүй байгаа хүмүүсийн хувь хоолыг үлдээж, тэднийг ирэхэд өгч байвал зохино. Хоол ундыг өгөхөд хуяг, ээлжийн дарга нар үзэж журамтай байлгавал зохино зэрэг зохицуулалтыг тусгажээ.

3.Ялтны дунд явуулах сургалт, хүмүүжлийн ажлын талаар тусгасан нь:

1925 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн Засгийн газрын 16 дугаар хурлын 4 дүгээр зүйлд баталсан "Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм"-д:

-Ялтан нарт лекц хэмээн сайн суртал журам, одоо цагийн улс төрийн шинэ хуучин байдал зэргийг ялган салгаж тодорхойлон хэлж ухуулахуйд олон сургуулийн багш, оюутан, сургуулийн шавь нар мэтийн эрдэмтнийг урин ирүүлж ухуулан гэгээрүүлбээс тустай бөгөөд одоо гяндангийн газар

байшин савгүй тул энэ лекцийг өдрийн дулаан сайныг үзэж сар бүр хоёр удаа гяндангийн хашаан дотор ухуулан уншуулж, сэнхрүүлэн хэрэглэвээс зохино¹⁹ гэжээ.

4. Ялтны ажил хөдөлмөр эрхлэлтийн талаарх зохицуулалт:

1926 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн Засгийн газрын 7 дугаар хурлын тогтоолоор баталсан “Гяндангийн дэргэд түр хэрэглэх заавар дүрэм”-д:

- Өглөө бүр 9 цагт хэрэгтэн, ялтныг гаргаж гяндангийн дэргэдэх баас, шээсний орон сав ба гяндангийн хашаан доторх хогийг арилгуулах, ус зэргийг бэлтгүүлбэл зохино.

- Албаны ба ард олноор байгуулсан газруудад хэрэгтэн ялтнаар ажил, үйлдвэр хийлгэх нь өглөөний 9 цагаас үдээс хойш 2 цаг хүртэл, дараа 3 цагаас 6 цаг хүртэл болно. Ганцхан өвлийн хүйтнээр 4 цагт харанхуй болгохоос урьд зогсоовол зохино гэж заажээ.

1929 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын 19 дүгээр хурлын 1 дүгээр зүйл, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлын 2 дугаар зүйлд баталсан “Аливаа хэрэгтэн, ялтнаар ажил, үйлдвэр хийлгэх тухай дүрэм”-д зааснаар

Ялтны хөдөлмөрийн зорилгыг:

- Хоригдогсдын ажил үйлдвэр бол тэднийг сургаж боловсруулах ба засан сайжруулахыг хичээсэн хэрэг болно.

- Хоригдогсдоор ажил үйлдвэр хийлгүүлэх нь тэднээр ажил үйлдвэр хийлгэж дадал олгохоос гадна аливаа ажил үйлдвэрийн зүйлүүдээс нэгийг сурваас гяндангаас гарахдаа ажил хийж амьдарч чадах болно гэж тодорхойлсон байна.

Ялтны хөдөлмөрлөх нөхцөлийг тогтоохдоо:

- Хоригдогсдын дотроос ажил үйлдвэрт онц хичээлтэй ба дадал олж сурч чадсан бөгөөд ажил хийж амьдарч чадахаар болсон этгээд байх ахул захирах тушаах комиссоор хянан тогтоолгож түүний ажил хийсэн хоёр өдрийг гурван өдөрт тооцож суллан тавьж аливаа ажил үйлдвэрийг албадан гүйцэтгүүлж байх болно.

- Чөлөөгөөр хасагдах хоригдогсод болвоос харьяа гянданы тэргүүлэгчдийн тушаалыг дагаж ажил үйлдвэрийг гүйцэтгэнэ.

- Гянданы тэргүүлэгчдээс тушааж хоригдогсдоор ажил үйлдвэр хийлгэхэд тэдний дур авьяас ба дадлыг баримтлахаас гадна гяндангаас

¹⁹ А.Думбарай, А.Лхагва, Л.Чүлтэмсүрэн. БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар гарсан хууль, эрхийн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1991. 10 дахь тал

гарсны хойно тэдний амьдралд тустай болохыг харгалзах, биеийн эрүүлийг нэгэн адил баримталж гүйцэтгэвээс зохино.

- Хоригдогсдоор гяндан хорионы дотор буюу гадагш гаргаж ажил үйлдвэр хийлгэнэ. Тайлбарлах нь: гяндан хорионы газар аар саар хөнгөн ажил хийх ба хог шороо арилгахад хөлс олгохыг хэрэгсэхгүй болговоос зохино.

- Урлах, дархлах газруудад тусгай үйлдэх ажлыг харьяат газраас гүйцэтгэнэ. Хоригдогсдоор урьдаар харьяат газруудад хэрэглэгдэх ажил, үйлдвэрийн зүйлүүдийг гүйцэтгэсний дараа мөн ажлын зүйлийг хэлэлцэн авч тэд нараар үйлдвэрлүүлэн гүйцэтгэвээс зохино гэжээ.

- Хоригдогсдын дотроос ажил үйлдвэр хийж чадах бүгдийг хийлгэж байваас зохих тул гяндангийн эрх баригчдаас зохих ажил үйлдвэрийг гүйцэтгүүлж байвал зохино.

- Гяндан хорионы дэргэд гүйцэтгэх аливаа ажил үйлдвэрийн хэргүүдийг хэрхэн явуулж байгааг шүүх яам буюу бусад захирах албаны газруудаас хянаж зааварлахдаа эрхбиш уул газруудаас зүй зохисыг үзэж хувийн хөрөнгө хогшил зэргийн хир хэмжээг харгалзуулан гүйцэтгэж байвал зохино гэх зэргээр зааж байсан байна.

Тухайн үеийн хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад тусгагдсан ажил хөдөлмөр эрхлэх, сурган хүмүүжүүлэх зэрэг зохицуулалт нь дараа дараагийн хууль тогтоомжид тусгалаа олсон ба өнөөгийн эрх зүйн зохицуулалтын үндэс суурь болж өгсөн ач холбогдолтой юм.

1931-1966 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн хөгжилд нэгэн шинэ үе эхэлсэн нь Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар хуралдаанаар "Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль" батлагдан гарсан явдал юм. Энэ нь хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулах анхны бие даасан хууль бөгөөд бүтцийн хувьд 15 бүлэг, 126 зүйлээс бүрдэж байжээ.²⁰

Хуулийн зорилгыг тус улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг хорих газруудыг байгуулах ба хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг гүйцэтгэх, уул хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлыг хэрхэн гүйцэтгэх тухай дүрмийг баталсугай гээд хорих ажиллагааны зорилгыг аливаа

²⁰ А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2011. 105 дахь тал

тохиноогүй этгээдүүдээс гэмт явдлыг үйлдэхээс ерөнхийд нь урьдчилан сэргийлэх ба уул явдлыг цаашид үйлдэхгүй болгохыг мөн сэргийлэн гүйцэтгэхэд эрхбиш засан сайжруулах ажлыг хамт гүйцэтгэвээс зохино гэжээ. Түүнчлэн ялтныг засан сайжруулах газар хорихдоо ангийн шинж чанар ба хүнд хөнгөний байдал, ялын хэмжээг харгалзан үздэг байсан байна.

1934 оны Шүүх цаазын бичигт буудан алах, хорих, албадан ажил хийлгэх, улс төрийн болон хувийн зарим эрхийг 1-5 жилийн хугацаагаар хасах, нутаг зайлуулах буюу нутаг зааж суулгах, албан тушаалаас огцруулах буюу ажлаас хөөх, донгодох буюу олон нийтийн өмнө буруутгах, эд хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах, мөнгө торгох, учруулсан гэм хорыг арилгах үүрэг даалгах, гадаадын иргэдэд бол улсын хязгаараас хугацаагаар буюу бүрмөсөн хөөх гэсэн ялын тодорхой төрлүүдийг хуульчилсан төдийгүй эмнэлгийн чанартай албадах болон сурган хүмүүжүүлэх албадах арга хэмжээнүүдийг нарийвчлан тогтоожээ.

Хорих ялын доод хэмжээ 1929 оны хуульд нэг өдрөөс эхэлж байсан бол нэг сар болгосон байна.

Тухайн үед хорих ял эдлүүлэх байгууллагын бүтцийг анхлан хуульчлан тогтоосон байна. Тухайлбал:

а/ Түр хорих байшинд:

Аливаа хэргийн учир шүүн таслах газар буюу байцаагч нараас байцааж байгаа хүмүүс, хорих ял шийтгэгдсэн бөгөөд уг тогтоолыг хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүсийг хорино.

б/ Засан сайжруулах газарт:

-хоригдохоор шийтгэгдсэн бүх хүмүүс;

-хэрэв тухайн орон нутагт өөрөө хорих газар байхгүй бол бусад хэрэгтэн, ялтныг хорино.

в/ Хөдөөгийн аж үйлдвэрийн колонид:

3 жилээс дээшгүй хугацаанд хоригдох хүмүүс, урт хугацаагаар хоригдох этгээдийн эдлэх ялын хугацаанаас үлдсэн 3 жил хэтрэхгүй үлдсэн жинхэнэ ажлын ардуудыг тус тус хорихоор заасан байна.

Хуулийн хорих газруудын дотоод байдал ба түүний үндсэн бодлого, зохион байгуулалтын тухай 11 дүгээр зүйлд "хоригдогсдыг эрхбиш аливаа боловсролын ажилд оролцуулан сургаж, тэдгээрээс алсдаа ажлын дадлагыг олж, суллагдан дараа гарсны хойно ард олонд тустай ажил үйлдвэр хийж, гэмт явдлыг үйлдэх хэв заншлаа устгахад дөхөм болгохыг хичээнэ" гэсэн бодлого барьж байжээ.

Хуулийн 5 дугаар бүлэг "Хоригдогсдыг сурган гэгээрүүлэх ажлын зорилго, чанар ба түүнийг хэрхэн байгуулах тухай"-т тусгахдаа:

31. Аливаа засан сайжруулах газар нь хоригдогсдыг сурган гэгээрүүлэх, боловсруулах ажлыг гүйцэтгэвэл зохимой.

32. Сурган гэгээрүүлэх явдлыг удирдах этгээд нь тусгай эрхлэгч байхгүй ахул уул газрын эрх баригчдын тушаалаар хоригдогсдын дотроос чадамгай бөгөөд бичиг үсэг сайн мэдэх ба улс төрийн талаар итгэмжтэйгийг нь тусгай томилж гүйцэтгүүлнэ. Тусгай эрхлэгчдээс тухайн ажлыг зүй зохистойгоор явуулах эцсийн үүргийг хүлээхээс гадна Ардыг гэгээрүүлэх яамны ерөнхий удирдлагыг баримталвал зохино.

33. Сурган гэгээрүүлэх гэсний уг зорилго болбоос хоригдогсдод нийтийн эрдэм ба аливаа ажил үйлдвэрлэлийн ангид боловсруулах аргуудыг зааж сургахаас гадна тус улсын байгуулалтын үндсэн бодлого хийгээд харьяат ардын эрх үүрэгтэй танилцуулж, суллагдан тавигдасны хойно улсын ажил явуулгын хэрэгт биеэр оролцоход дөхөм тустай болгохыг хичээсэн хэрэг болно.

34. Хоригдогсдын дотроос жинхэнэ ажлын хүмүүсийг олноор сургаж гэгээрүүлэх ажилд оролцуулбаас зохих бөгөөд тэдгээр ажилчны дундаас 3-5 хүртэл хүн сонгон сурган гэгээрүүлэх хэрэгт оролцох комисс байгуулна.

35. Сурган гэгээрүүлэх комиссын уг зорилго нь бол хоригдогсдыг өөрсдөө аливаа хэрэг ажилд идэвхтэй санал онолыг гаргах ба түүнээс гүйцэтгэх явдлыг бэхжүүлэх ажилд жинхэнэ ажлыг олныг оруулах, санамсаргүйн харгайгаар гэмт хэрэг үйлдсэн ажилчин этгээдүүдийг улс төрийн ба ангийн утга чанарыг дэлгэрэнгүйгээр ухаж мэдэхэд туслах ёстой. Тус комиссоос аливаа ажил явуулах, илтгэл хийх, лекц унших, жич, ханын сонинг гаргах зэрэг ажлыг явуулан гүйцэтгэвээс зохино.

36. Сурган гэгээрүүлэх хамгийн бага ажил нь бичиг үсэгт сургах ба улс төрийн бодлогыг огт мэдэхгүйг нь ном сонинг чангаар уншиж чаддаг болгохын дээр, тэр уншсаныг нь асууж тайлбарлуулж байваас зохино.

37. Хоригдогсдоос гаргах ший бүжиг зэрэг боловсролын утга чанар бүхий тоглоом наадмын зүйлүүдийг ард олны зорилго байдалд таацуулан гүйцэтгүүлж уул хоригдогсдын дотроос, ялангуяа ажилчныг өөрчлөн сургаж боловсруулбаас зохино.

38. Засан сайжруулах газар дутам харьяат хоригдогсдод хэрэглүүлэхээр номын санг байгуулан, түүнд улс төрийн бодлогыг тодорхойлсон гэгээрүүлэх, ерөнхийд нь хэрэглэх аливаа эрдэмд сурах зэрэг эрдэм боловсролын чанар бүхий ном дэвтэрүүдийг хуралдуулбаас зохихоос гадна биеийн тамирыг сайжруулах ажил сургуулийг тогтоосон цаг хэмжээнд гүйцэтгүүлж байваас зохино гэжээ.

Түүнчлэн тус хуулийн нэг онцлох зохицуулалт болон 13 дугаар бүлэг “Засан сайжруулах газруудаас суллан тавигдсан хүмүүст тусламж олгох явдлыг хэрхэн байгуулан гүйцэтгэх”-т заахдаа:

80. Аливаа хоригдогсод ба суллагдан тавигдагсдад тусламжийн зүйлийг олгох явдлыг харьяат аймгуудад байгуулсан бөгөөд Шүүх яамны дэргэдэх Засан сайжруулах газруудын хэргийг эрхлэх хэлтсийн ерөнхий удирдлага ба зааврын ёсоор хэрэг ажлыг явуулах тусгай комендатуудаас эрхлэн гүйцэтгэнэ.

81. Аймгуудын захиргааны ба шүүн таслах газруудын дарга хийгээд засан сайжруулах газрын эрхлэгч нар, жич, үйлдвэрчний эвлэл ба Дотоодыг хамгаалах газрын төлөөлөгчийг оролцуулан, даргад нь аймгийн захиргааны дарга нарыг суулцуулан байгуулсан комендатуудаас засан сайжруулах газраас суллагдан тавигдсан хүмүүст олгох тусламжийн хэргийг эрхлэн гүйцэтгэнэ. Улаанбаатар хотод бол уул комендатыг шүүх яамны төлөөлөгч ба харьяат хотын захиргааны дарга, аймгийн шүүх таслах газрын гишүүн, төвийн засан сайжруулах газрын дарга, жич, үйлдвэрчний төв зөвлөлийн төлөөлөгчийг оролцуулан даргад нь Шүүх яамны төлөөлөгчийг суулцуулахаар байгуулна.

82. Уул комендатууд нь болбоос тус тусын хэрэг ажлыг шүүх яамнаас баталсан тусгай дүрмийн дагуу баримтлан гүйцэтгэнэ.

83. Засан сайжруулах газруудаас суллагдан тавигдагсдыг тэтгэн туслах гэсэн уг зорилго нь:

1/ жинхэнэ ажлын ангийн бөгөөд хоосон ядууд мөнгө зоосоор буюу эд юмаар туслах;

2/ суллагдан тавигдсаны дараа уул нутагтаа буюу үргэлж оршин суун газар эргэж буцахад нь зохих зүйлээр туслах;

3/ суллагдан тавигдсаны дараа түр хэрэглэх орон сав ба хоол ундны зүйлийг хямд хөлс үнээр олгож туслах;

4/ аливаа ажил үйлдвэрийг эрж;

5/ хууль дүрмэнд холбогдох хэргийн учир тусласугай хэмээсэн зорилго болно.

84. Уул комендатуудаас хэрэглэх хөрөнгөний зүйлсийг хаанаас гаргуулах вэ гэвэл:

1/ улсын ба орон нутгийн орлого, данснаас тусгай зүйлээр гаргах;

2/ аливаа яам, албан газруудаас тусгай ба аливаа зүйлд хэрэглэхээр шууд зааварлан олгосон ба мөн аливаа энгийн хүмүүс буюу газруудаас сайн дураар олгосон тусламжийн зүйлүүд;

3/ засан сайжруулах газрын ажил үйлдвэрийн ангийн цэвэр орлогоос гаргасан зүйлүүд болно²¹ гэжээ.

1966-1981 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлигаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль найман бүлэг, 55 зүйлтэйгээр батлагджээ. Тухайн хуулийн үйлчлэлийн үед хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад гарсан томоохон өөрчлөлт нь хорих ял эдлүүлэх байгууллагын төрлийг гяндан, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, хүмүүжил-хөдөлмөрийн колони гэж ангилан жирийн, чанга, онцгой дэглэмтэй байхаар заасан төдийгүй тус бүрийн нөхцөлийг хуульчилсан байна.

Жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид:

а/ Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор жирийн дэглэмтэй колонид хоригдох ял шийтгүүлсэн этгээд;

б/ хүнд биш гэмт хэрэг анх удаа буюу 2 дахь удаа хоригдох ял шийтгүүлсэн хоригдол;

в/ онц аюултай бус этгээд, чанга дэглэмтэй колониос шилжиж ирсэн хоригдлын ялыг эдлүүлнэ.

Чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид:

а/ Хүнд гэмт хэрэгт анх удаа хоригдох ял шийтгүүлсэн хоригдол;

б/ Хүнд бус гэмт хэрэгт гурав ба түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн этгээд;

в/ Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор чанга дэглэмтэй колонид хоригдох ял шийтгүүлсэн онц аюултай бус этгээд;

г/ Онцгой дэглэмтэй колониос шилжиж ирсэн хоригдлыг хүмүүжүүлнэ.

Онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид:

а/ Хүнд гэмт хэрэгт хоёр, түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн онц аюултай этгээд;

б/ Цаазаар авах ял шийтгэгдэж өршөөл, уучлалын журмаар хорих ялаар солигдсон ба гянданд хоригдох хугацаанаасаа өмнө колонид шилжсэн хоригдлыг хүмүүжүүлнэ.

Гянданд:

а/ Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор гянданд хорих ял шийтгэгдсэн этгээд;

²¹ А.Лхагва. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт /1931-2005/. УБ.,2005 он. 60 дахь тал

б/ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониос шилжиж ирсэн хоригдлыг гянданд эдлүүлнэ гэж тусгажээ.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой дараах заалтууд орсон байна.Үүнд:

1-р зүйл. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн зорилт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, тэднийг хууль ёсыг хүндэтгэн сахиж, социалист нийгмийн амьдрал, хөдөлмөрт хэвшүүлэн дахин хүмүүжүүлэх, тэднээс шинээр гэмт хэрэг үйлдэх буюу нийгэмд хортойгоор нөлөөлөх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино.

6-р зүйл. Ял шийтгүүлсэн этгээдийг засан хүмүүжүүлэх үндсэн арга

Ял шийтгүүлсэн этгээдийг засан хүмүүжүүлэхдээ тэднийг нийгмийн тустай хөдөлмөрт заавал оролцуулж, хорих дэглэмийг нарийн сахиулах замаар албадлага хэрэглэх, хүмүүжлийн ажлыг явуулах, ерөнхий боловсролын ба мэргэжлийн сургалт зохиох зэрэг үндсэн аргыг хэрэглэнэ. Эдгээр үндсэн аргыг ял эдлэгчдийн үйлдсэн гэмт хэрэг, зан төрх, хувийн байдал, хөдөлмөрт хандаж байгаа байдлг харгалзан хэрэглэнэ.

8-р зүйл. Ял шийтгүүлсэн этгээдийг засан хүмүүжүүлэхэд олон нийтийн байгууллагуудыг оролцуулах

Ял шийтгүүлсэн этгээдийг засан хүмүүжүүлэх ажилд олон нийтийн байгууллага, тэдгээрийн төлөөлөгчдийг зохих журмын дагуу оролцуулна. Сум, район, хорооны ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа нь үйлдвэрчний эвлэл, бусад олон нийтийн байгууллагын төлөөлөгчдөөр бүрдсэн хянах комиссыг, хянах комиссын дүрмийн дагуу байгуулж засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн үйл ажиллагаанд хяналт тавиж, ял шийтгүүлсэн этгээдийг хүмүүжүүлэх ажилд туслалцаа үзүүлнэ.

15-р зүйл. Хоригдлын дотор явуулах хүмүүжлийн ажил

Хоригдлын дотор явуулах хүмүүжлийн ажил нь хууль ёсыг нарийн чанд биелүүлэх, хөдөлмөрт үнэнчээр хандах, социалист өмчийг хайрлан хамгаалах үзлээр хоригдлыг хүмүүжүүлж, тэдний ухамсар, соёлын хэмжээг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Хүмүүжлийн ажлыг хоригдлын хувийн ба үйлдсэн хэргийн байдлыг судалсны үндсэн дээр нийтээр буюу нэг бүрчлэн явуулах хөдөлмөрийн уралдаан өрнүүлэх, соёл хүмүүжил, биеийн тамирын ажил зохионх зэрэг хэлбэрээр явуулна.

16-р зүйл. Хоригдлын мэргэжлийн ажилд сургах

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага нь хоригдож байгаа тодорхой мэргэжилгүй хүмүүсийг хөдөлмөрийн дадлагатай болгох, мэргэжил олгох ба мэргэжлийг ахиулах ажил зохион байгуулна.

17-р зүйл. Хоригдлын сайн дурын байгууллага

Хоригдлыг засан хүмүүжүүлэхэд хамт олны нөлөөлөх хүчийг зохистойгоор зөв ашиглах, социалист нийгмийн дадал заншилд сургах, идэвхи санаачилгыг дээшлүүлэх зорилгоор засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааны удирдлагын хяналтын дор хоригдлуудын сайн дурын байгууллага байгуулж болно. Эдгээр байгууллагын төрөл, ажиллах журмыг БНМАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам тогтооно.

35-р зүйл. Хүмүүжил-хөдөлмөрийн колони дахь ерөнхий боловсрол, техник мэргэжлийн сургалт

Хүмүүжил-хөдөлмөрийн колонид Ардын гэгээрлийн байгууллагын удирдлага, оролцоо, шаардлагын дагуу бага, дунд боловсролын сургалтыг зохион байгуулна. Хүмүүжил-хөдөлмөрийн колонид буй хоригдлууд Ерөнхий боловсролын сургуульд суралцах бөгөөд сургалтын ажлыг нийгмийн тустай хөдөлмөртэй заавал холбож явуулна. Хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгаа хоригдлууд техник мэргэжлийн сургалтын программаар ажил мэргэжилд суралцах, мэргэжлээ дээшлүүлэх үүрэгтэй.

54-р зүйл. Суллагдсан хүмүүст үзүүлэх тусламж

Ял эдлэж байгаад суллагдсан этгээд ял шийтгүүлэхийн өмнө байнга оршин сууж, захирагдаж байсан орон нутагтаа даруй хүрэлцэн очиж бүртгүүлнэ. Хэрэв өөр орон нутагт шилжин суух, ажиллахыг хүсвэл тийнхүү бүртгүүлсний дараа ердийн журмаар зохих зөвшөөрөл, шилжүүлэг авна. Ял шийтгүүлэхийн өмнө нэг газар байнга оршин сууж, бүртгэгдэж байгаагүй этгээдийг суллагдсаны дараа түүний байнга буюу түр оршин суухаар сонгон авсан газарт нь хүргэж өгнө. Ял эдлэж байгаад суллагдсан тахир дутуу буюу өндөр настай хүмүүсийг тэдний хүсэлтээр зохих журмын дагуу асрамж-хөдөлмөрийн газар шилжүүлж болно. Хүмүүжил-хөдөлмөрийн колониос суллагдсан 18 нас хүрээгүй хүмүүсийг тэдний эцэг, эх, ойрын садан төрөл, хууль ёсны асран хамгаалагчийн байгаа газар хүргэж хүлээлгэн өгнө. Суллагдсан хүмүүст шаардлагатай бол хорих байгууллагын захиргаа зохих фондоос мөнгөн ба эд материалын туслалцаа үзүүлж болно.

55-р зүйл. Суллагдсан хүмүүсийг хөдөлмөрт зохион байгуулах

Ял эдлэж байгаад суллагдсан буюу хүмүүжил-хөдөлмөрийн колониос суллагдсан хүмүүс хуулиар тогтоосон хугацаанд нийгмийн тустай хөдөлмөрт орно. Тэднийг өөрсдийнх нь хүсэлт, мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзан хөдөлмөрт зохион байгуулж оруулах асуудлыг орон нутгийн ардын депутатуудын хорооны гүйцэтгэх захиргаа шууд хариуцна гэжээ.

1981-1993 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 11-р сарын 16-ны өдрийн 403 дугаар зарлигаар БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль батлагдан гарч 1982 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн мөрдөж эхэлсэн бөгөөд Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулах 3 дахь хууль билээ.

Хуулийн зорилтыг “ялтныг үйлдсэн гэмт хэрэг нь цээрлүүлэх төдийгүй, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн ял эдлэлтийн биелэлтийг хангах, түүнчлэн гэмт хэргийг арилгахад тус дөхөм үзүүлэх явдалд оршино” гэж тодорхойлоод ял эдлүүлэх нь хүний бие махбодыг зовоох, нэр алдрыг доромжлон гутаах зорилгогүйг заасан байна²². Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой дараах заалтууд орсон байна.Үүнд:

6-р зүйл. Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх үндсэн арга

Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх үндсэн арга нь ял эдлүүлэх дэглэм, нийгмийн тустай хөдөлмөр, улс төр-хүмүүжлийн ажил, ерөнхий боловсрол болон мэргэжил олгох сургалт мөн. Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх аргыг хэрэглэхдээ түүний үйлдсэн гэмт хэргийн шинж байдал, нийгмийн хор аюулын хир хэмжээ, хувийн байдал, зан төлөв, хөдөлмөрт хандах байдлыг харгалзан үзнэ.

8-р зүйл. Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд олон нийтийн оролцоо

Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, түүнчлэн хорих, нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж байгаа байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийт оролцоно. Ялтныг хүмүүжүүлэхэд олон нийтийн оролцох хэлбэр, журмыг энэ хууль болон бусад хууль тогтоомжоор тогтооно.

41-р зүйл. Улс төр-хүмүүжлийн ажлын зорилт

Хорих ял эдэлж буй ялтны дунд зохиох улс төр-хүмүүжлийн ажлыг ялтныг үнэнч шударга хөдөлмөрлөх, хуулийг нарийн чанд биелүүлэх, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн сахих, социалист өмчид хайр гамтай хандах үзэлтэй, хүнлэг чанартай болгон хүмүүжүүлж, тэдний ухамсар, соёлын хэмжээг дээшлүүлэх, үр ашигтай санаачилгыг нь хөгжүүлэхэд чиглүүлэн явуулна. Улс төр-хүмүүжлийн арга хэмжээнд ялтан

²² Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.,21 дэх тал

идэвхтэй оролцож байвал сайшаан урамшуулж байх бөгөөд түүний засарч, дахин хүмүүжиж байгаа байдлыг тодорхойлохдоо уг арга хэмжээнд хэрхэн оролцсоныг харгалзан үзнэ.

42-р зүйл. Улс төр-хүмүүжлийн ажлын зохион байгуулалт, хэлбэр

Хорих ял эдэлж байгаа ялтны дунд зохиох улс төр-хүмүүжлийн ажлыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаа зохион байгуулна. Улс төр-хүмүүжлийн ажлыг ялтны дунд хөдөлмөрийн уралдаан зохиох, БНМАУ-ын хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, суртал ухуулгын болон соёл, олон нийт, биеийн тамир-спортын ажил зохиох, ялтан тус бүрийн үйлдсэн гэмт хэрэг, тэдний нас, боловсрол, мэргэжил болон бусад онцлогыг судалсны үндсэн дээр ганцаарчилсан ажил зохиох зэрэг үндсэн хэлбэрээр явуулна. Улс төр-хүмүүжлийн ажлыг засан хүмүүжүүлэх байгууллагын төрөл, түүний дэглэмийн онцлогыг харгалзан ялгавартай явуулна. Гянданд ял эдэлж буй ялтны дунд зохиох улс төр-хүмүүжлийн ажлыг байранд нь явуулна.

43-р зүйл. Хорих газрын сайн дурын байгууллага

Хорих газарт ял эдэлж байгаа ялтны хамтач дадал заншлыг хөгжүүлэх, тэдний үр ашигтай санаачилгыг сайшаан дэмжих, түүнчлэн ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд хамт олны нөлөөг ашиглах зорилгоор ялтны сайн дурын байгууллага байгуулж, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны удирдлагын дор ажиллуулна.

44-р зүйл. Ялтны сайн дурын байгууллагын төрөл, ажиллах журам

Зан төлөвөөр үлгэр жишээч, хөдөлмөр сургалтад үнэнч шударга ханддаг болохоо харуулсан ялтнаас бүрдсэн хамт олны зөвлөлийг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгуулна. Хамт олны зөвлөлийг ялтны хурлаас сонгож, колоний дарга батална. Хамт олны зөвлөл нь ялтны хуралд өөрийн ажлын тухай тайлагнаж байна. Хамт олны зөвлөлийн гаргасан шийдвэр нь колоний дарга хянаж баталсны дараа хүчин төгөлдөр болно. Сайн дурын байгууллага нь ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх талаар засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас зохиож байгаа ажилд туслалцаа үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг байнга авч явуулна.

45-р зүйл. Хорих ял эдэлж буй ялтанд ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах

Хорих ял эдэлж байгаа ялтанд ерөнхий боловсрол, мэргэжил олгох ажлыг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс тогтоосон журмын дагуу зохион байгуулна.

46-р зүйл. Хорих ял эдэлж буй ялтны ерөнхий боловсролын сургалт

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад хорих ял эдэлж байгаа ялтны боловсролын хэмжээг харгалзан ерөнхий боловсролын оройн сургалтыг зохион байгуулна. Ялтан ерөнхий боловсролын сургалтад заавал оролцох үүрэгтэй. Харин 40-өөс дээш насны болон тахир дутуугийн I, II группд орсон ялтныг ерөнхий боловсролын сургалтад саналаар нь оролцуулна. Ерөнхий боловсролын сургалтад ялтан идэвхтэй оролцож байвал сайшаан урамшуулж байх бөгөөд тэдний засарч, дахин хүмүүжиж байгаа байдлыг тодорхойлохдоо уг сургалтад хэрхэн оролцсоныг харгалзан үзнэ.

47-р зүйл. Хорих ял эдэлж байгаа ялтанд мэргэжил олгох сургалт

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага нь мэргэжилгүй ялтанд өөрийн үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх ажил зохиох үүрэгтэй. Ялтанд мэргэжил олгох сургалтыг хүмүүжил-хөдөлмөрийн колонид ажлын цагаар явуулна. Тахир дутуугийн I, II группд орсон ялтныг ерөнхий боловсролын сургалтад саналаар нь оролцуулна. Мэргэжил олгох сургалтад ялтан идэвхтэй оролцож мэргэжлээ дээшлүүлж байвал сайшаан урамшуулж байх бөгөөд тэдний засарч, дахин хүмүүжиж байгаа байдлыг тодорхойлохдоо уг сургалтад хэрхэн оролцсоныг харгалзан үзнэ.

48-р зүйл. Хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа ялтныг шалгалтын үед ажлаас чөлөөлөх

Ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалтын шалгалтад бэлтгэх, шалгалт өгөхөд зориулан хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа ялтныг колонийн дарга хууль тогтоомжид заасан хугацаагаар ажлаас нь чөлөөлнө.

105-р зүйл. Хорих газраас суллагдсан хүмүүст материалын тусламж үзүүлэх

Хорих газраас суллагдсан нэрийн дансандаа мөнгөгүй бол оршин суух буюу ажиллах газартаа очиход үнэ төлбөргүй уналгаар хангаж, тогтоосон нормоор замын хүнс буюу мөнгө олгоно. Суллагдаж байгаа этгээд улирлын хувцасгүй буюу түүнийг авах мөнгөгүй байвал түүнд улирлын хувцсыг үнэ төлбөргүй олгоно.

103-р зүйл. Хорих газраас ялтныг суллах журам

...Хорих ялын хугацаа дуусахаас 3 сарын өмнө засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаа ялтны хөдөлмөрийг зохион байгуулах боломжийг судалж, ажилд оруулах талаар урьдчилан арга хэмжээ авна. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага нь суллагдаж байгаа насанд хүрээгүй хүнийг эцэг эх буюу тэднийг төлөөлөх хүмүүст нь явуулна. Хэрэв ийнхүү явуулах боломжгүй байвал ял эдлэхийн өмнө оршин сууж байсан Орон нутгийн Ардын депутатуудын хорооны гүйцэтгэх

захиргааны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисст хүргүүлнэ. Уг комисс суллагдсан хүнийг хүлээж аваад засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн захиргааны санал, суллагдсан хүний эзэмшсэн мэргэжил, боловсролыг харгалзан ажилд буюу сургуульд оруулах, түүнчилэн шаардлагатай орон байр, ахуй нөхцөлөөр хангах арга хэмжээ авна.

Насанд хүрээгүй хүнийг ял эдлэхийн өмнө оршин сууж байсан газарт нь явуулах нь түүний хүмүүжлийн хувьд зохимжгүй гэж үзсэн онцгой тохиолдолд засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн захиргааны саналаар уг колонийн оршин байгаа газрын дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс түүний ажил, сургууль, ахуй амьдралыг зохион байгуулна. Хорих газраас суллагдсан бөгөөд бусдын асрамж шаардлагатай, түүнчилэн 16 нас хүрээгүй хүмүүсийн оршин суух газарт нь засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтан хүргэж өгнө.

106-р зүйл. Ялаас суллагдсан хүмүүсийг ажлаар хангах, тэдний ахуй нөхцлийг зохион байгуулахад туслах

Орон нутгийн Ардын депутатуудын хорооны гүйцэтгэх захиргаа ялаас суллагдсан хүнийг ажилд оруулах тухай асуудал хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор аль болохоор мэргэжлийн дагуу ажлаар хангах үүрэгтэй. Зайлшгүй шаардлагатай байвал ялаас суллагдсан хүнд орон байр олгоно. Ялаас суллагдсан хүнийг ажилд оруулах тухайн орон нутгийн Ардын депутатуудын хорооны гүйцэтгэх захиргааны шийдвэрийг үйлдвэр, албан газар, байгууллагын удирдлага заавал биелүүлнэ. Ялаас суллагдсан тахир дутуу, өндөр настай хүнийг тэдний хүсэлтээр асрамжийн байгууллагад шилжүүлж болно. Эцэг эхгүй насанд хүрээгүй хүнийг насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс зайлшгүй тохиолдолд дотуур байртай сургууль буюу хүүхдийн бусад байгууллагад шилжүүлэх, эсвэл хуульд заасан журмаар асран хамгаалалт тогтооно.

112-р зүйл. Хянах комисс

Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд болон хорих, нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавихад орон нутгийн Ардын депутатуудын хорооны депутат, үйлдвэрчний эвлэл, залуучуудын эвлэл, бусад олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олны төлөөлөгчдөөс бүрдсэн хянах комисс шууд оролцоно. Хянах комиссын зорилт, эрх үүрэг, ажлын зохион байгуулалтыг энэ хууль болон БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн баталсан хянах комиссын дүрмээр тодорхойлно.

113-р зүйл. Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс

Хүмүүжил-хөдөлмөрийн колонид хорих ял эдэлж байгаа буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдэлж байгаа насанд хүрээгүй хүмүүсийг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд болон энэ хоёр төрлийн ял шийтгэсэн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг орон нутгийн Ардын депутатуудын хорооны гүйцэтгэх захиргааны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс шууд эрхлэн гүйцэтгэнэ. Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын зорилт, эрх үүрэг, ажлын зохион байгуулалтыг энэ хууль болон БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн баталсан насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын дүрмээр тодорхойлно.

114-р зүйл. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг хөдөлмөрийн хамт олон, олон нийтийн байгууллага шефлен авах

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг үйлдвэрийн газар, сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл, соёл, боловсролын байгууллага, түүнчилэн улс, олон нийтийн байгууллага шефлен авна. Шефлен авах нь засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн болон хүмүүжил-хөдөлмөрийн колонийн захиргаанаас ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, түүнчилэн хорих газраас суллагдсан этгээдийн хөдөлмөр, ахуй нөхцлийг сайжруулахад туслах үндсэн зорилготой байна. Хөдөлмөрийн хамт олон, олон нийтийн байгууллага нь засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улс төр-хүмүүжлийн ажил явуулах, ерөнхий боловсролын болон техник мэргэжлийн сургалт зохион байгуулахад туслалцаа үзүүлнэ.

115-р зүйл. Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн олон нийтийн зөвлөл

Шефлен авах ажлыг зохион байгуулах зорилгоор хүмүүжил-хөдөлмөрийн колонид төрийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, залуучуудын эвлэл болон бусад олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олны төлөөлөгчдөөс бүрдсэн олон нийтийн зөвлөл байгуулан ажиллана. Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнд колонийн дарга, эсвэл түүний орлогч оролцоно. Олон нийтийн зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс баталсан дүрмээр тодорхойлно.

116-р зүйл. Ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийн олон нийтийн хүмүүжүүлэгч

Насанд хүрээгүй хүмүүсийн засрал хүмүүжлийг бататгаж, дахин хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ял эдэлж дууссан буюу ялын хугацаа дуусахаас өмнө суллагдсан насанд хүрээгүй хүмүүст олон нийтийн

хүмүүжүүлэгч томилж болно. Олон нийтийн хүмүүжүүлэгчийг томилох журам, түүний үйл ажиллагааг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс баталсан дүрмээр тодорхойлно.

117-р зүйл. Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд олон нийт оролцох бусад хэлбэр

Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжлэх ажилд энэ хуульд заагаагүй боловч БНМАУ-ын хууль тогтоомжид заасан эрүүгийн ялыг эдлүүлэх ерөнхий заалт, зарчимд тохирох олон нийтийн оролцооны өөр хэлбэрийг хэрэглэж болно гэж тус тус заажээ.

1993-1996 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

1990 онд ардчилсан хувьсгал ялж, улмаар 1992 онд ардчилал, хүний эрхийн дэлхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг тусгасан Үндсэн хуулийн хүрээнд хорих ял эдлэгсдийн эрхийг дээдлэх, нөхцөл, журмыг сайжруулах чиглэлээр олон хууль тогтоомж гарч хэрэгжиж иржээ. Үүний нэг 1993 оны 12 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль юм.

Энэ хуулиар хорих ял эдлүүлэх ажиллагаа гэдгийг гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдийг нийтээс тусгаарлаж, эрх, эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоосон хорих ял оноосон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг хэрэгжүүлэх төрийн албадлагын онцгой ажиллагаа гэж тодорхойлон, хорих ял эдлүүлэх ажиллагаанд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэж, хоригдлын эрхийг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, хорих ялыг ялгамжтай нөхцөлд эдлүүлэх зарчмыг хуулиар тогтоож өгсөн байна. 1993-1996 онд Хорих байгууллагын тогтолцоо нь насанд хүрээгүйчүүдийн болон насанд хүрэгчдийн хорих анги, гяндан, хорих анги тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллага, хорих байгууллагуудын удирдах газар гэж заажээ. Тус хуульд хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой дараах заалтууд орсон байна. Үүнд:

9-р зүйл. Хорих анги, түүний эрх хэмжээ

1. Хорих анги нь шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн албан газар мөн бөгөөд хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

2. Хорих анги нь хорих ялыг эдлүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ.

1/....

....

3/хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх

....

5/ насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулах.

36-р зүйл. Хүмүүжлийн ажил

1. Хүмүүжлийн ажил нь хоригдлыг үйлдсэн гэмт хэрэгт нь гэмшүүлж, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг хангахад чиглэгдэнэ.

2. Хүмүүжлийн ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас хүйс, ял эдлүүлэх дэглэмийг харгалзан ялгамжтай явуулна.

37-р зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт

1. Хоригдлыг нийгэм, улс төр, эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад хэлбэрийн хүмүүжлийн ажил зохион байгуулна.

2. Хоригдлын дунд зохиох хүмүүжлийн ажлыг энэ хуульд нийцүүлэн тогтоосон журмын дагуу зохион байгуулна.

3. Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна энэ хуульд заасан бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.

38-р зүйл. Хорих анги дахь сургалт

1. Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтанд бүрэн хамруулж, бусад хоригдол бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих байгууллага туслалцаа үзүүлнэ. Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.

2. Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулж болно. Дадлага олгох сургалтанд хоригдлын сайн дурын үндсэн дээр хамруулна.

39-р зүйл. Хоригдлын сайн дурын байгууллага

1. Хорих ангид тогтоосон дэг журмыг хангахад туслах, хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтын ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор хоригдлын сайн дурын байгууллага ажиллуулж болно.

2. Хоригдлын сайн дурын байгууллагын ажиллах журмыг Удирдах газар тогтооно.

40-р зүйл. Хүмүүжлийн ажилд олон нийтийг оролцуулах

1. Хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх ажилд төрийн байгууллага, албан тушаалтан, шашны болон ивээн тэтгэгч байгууллага, шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, эрүүл мэндийн байгууллага, түүнчлэн хоригдлын ойрын садангийн хүнийг оролцуулж болно.

2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, хорих байгууллагатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хүмүүжлийн ажилд өөрсдийн санаачилгаар оролцож болно.

42-р зүйл. Хоригдлын суллах журам

1.....

....

3. Шаардлагатай бол суллагдаж байгаа хүнд тухайн улирлын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих байгууллагаас олгож болно. Уналгын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгоно гэжээ.

1996-2002 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

Нийгмийн хөгжлийн даган эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хурлаас 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн шийдвэр биелүүлэх хуулийг батлан гаргаасан нь хорих ял эдлүүлэх ажиллагааны тав дахь хууль юм.

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд өмнө батлагдан хэрэгжиж байсан Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай /1993/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай /1994/, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай /1995/ хуулиуд агуулга, зарчмын өөрчлөлтгүйгээр тусгагдсан байна.²³

Энэ хуулийн зорилт нь Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино гэж заан, Шүүхийн харьяанд байсан Шийдвэр гүйцэтгэх газрыг Хорих байгууллагатай нийлүүлэн шүүхээс гарч буй иргэний болон эрүүгийн шүүхийн шийдвэр биелүүлэх хамтатгасан бүтэцтэй болгон өөрчилсөн онцлогтой юм. Тус хуульд хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой дараах заалтууд орсон байна.Үүнд:

75-р зүйл.Хорих анги, түүний эрх хэмжээ

1. Хорих анги нь шүүхийн шийдвэрээр оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн албан газар мөн бөгөөд хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

2.....

3. Хорих анги нь хорих ялыг эдлүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ.

1/....

....

3/хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх

....

²³ А.Лхагва. Дурдсан зохиол. УБ., 2008. 136 дахь тал

5/ насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох

93-р зүйл. Хүмүүжлийн ажил

1. Хүмүүжлийн ажил нь хоригдлыг үйлдсэн гэмт хэргийг ухамсарлуулж, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг хангахад чиглэгдэнэ.

2. Хүмүүжлийн ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас хүйс, ял эдлүүлэх дэглэмийг харгалзан ялгамжтай явуулна.

94-р зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт

1. Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад хэлбэрээр зохион байгуулна.

2. Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.

3. Хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор хоригдлын сайн дурын байгууллага ажиллуулж болно.

95-р зүйл. Хорих анги дахь сургалт

1. Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтанд бүрэн хамруулж, бусад хоригдол бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих байгууллага туслалцаа үзүүлнэ. Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.

2. Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулж болно. Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлын сайн дурын үндсэн дээр хамруулна.

100-р зүйл. Хоригдлын суллах журам

1.....

....

3. Шаардлагатай бол суллагдаж байгаа хүнд тухайн улирлын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих байгууллагаас олгож болно. Уналгын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгоно.

101-р зүйл. Хорих ял эдэлж байгаад суллагдсан хүнд олгох тэтгэвэр

Хорих ял шийтгүүлэхээс өмнө тэтгэвэр авч байсан хүнд суллагдсны дараа урьд тогтоосон тэтгэврийг үргэлжүүлэн олгоно гэжээ.

2002-2017 он хүртэлх хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт:

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2002 онд Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулиуд батлагдсан бөгөөд тэдгээрийн нэг нь "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" Монгол Улсын хуулийг 2002 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан юм. Энэ хууль батлагдсанаар хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтанд зарим өөрчлөлт, шинэчлэлт, гарсныг тэмдэглэх хэрэгтэй. Хуулийн зорилтыг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс, журмыг тогтооход оршино", хэмээн тодорхойлоод хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхолыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зэрэг зарчмыг зааж өгчээ. Түүнчлэн иргэний хэргийн холбогдолтой шүүхийн шийдвэрийг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, харин эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг тогтоол гүйцэтгэх ажиллагаа гэж тодорхойлон хуульчилсан байна. Тус хуульд хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой дараах заалтууд орсон байна. Үүнд:

8.2. Баривчлах, хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.3.ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх;

8.2.4.ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох;

8.2.5.насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох.

124 дүгээр зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт

124.1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна.

124.2.Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буюны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.

124.3.Ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно.

125 дугаар зүйл. Хорих анги дахь сургалт

125.1.Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ.

125.2.Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.

125.3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.

125.4.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.

130 дугаар зүйл. Ялтныг суллах журам

130.4.Шаардлагатай бол суллагдаж байгаа ялтанд тухайн улирлын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих ангиас олгож болох ба уналгын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцно.

Тус хуулийн үйлчлэлийн хүрээнд 2009 онд Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр” болон ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн тушаалаар “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-ийг тус тус батлан хэрэгжүүлж ирсэн байна.

Ялтны нийгэмшүүлэх хөтөлбөрийн агуулгыг авч үзвэл:

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь ШШГЕГ-ын харьяа шийдвэр гүйцэтгэх алба, хорих ангиудын хэмжээнд ял эдэлж байгаа хүмүүсийн дунд явуулж байгаа нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэхэд чиглэгдэж байна. Үүнд:

1.ШШГБ-ын ажилтнуудад төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголт өгөх, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах эрхийн актуудыг шинэчлэн боловсруулах, орчин үеийн нийгмийн ажлын чиг хандлагыг судлан түүнийг нэвтрүүлэх, хүн төвт хөгжлийн үзэл хандлагыг төлөвшүүлэх;

2.Ялтныг нийгэмшүүлэх ажлын өнөөгийн түвшин, олсон ололт, ашигтай давуу тал, алдаа дутагдал, саад бэрхшээлд үнэлгээ хийх, энэ чиглэлээр авах зарим арга хэмжээний талаар санал солилцон цаашид хорих байгууллагын салбарын нийгмийн ажлыг шинэ агуулгаар тодорхойлж, гүйцэтгэх үйл ажиллагааных нь хүрээг мэргэжлийн чиг үүрэгт нийцүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилтууд:

- Хорих ангийн нийгмийн ажилтан болон сургалт арга зүйн ажилтнуудыг чадваржуулах, мэргэжлийн арга зүйгээр хангах

- ШШГЕГ-ын харьяа алба, хорих ангиудад нийгэмшүүлэх ажлын чиглэлээр нөхцөл байдлын үнэлгээ хийх, судалгааны ажлуудыг зохион байгуулах;

- Ном гарын авлага бэлтгэх, сургалтын орчин үеийн шинэлэг арга барил нэвтрүүлэх, ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэм сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, төлөвшүүлж нийгэмшүүлэх, зан байдлыг нь засах нийгмийн

ажлыг дэмжих “Мэдээллийн сан” байгуулах;

- Ялтныг нийгэмшүүлэхэд олон нийтэд эерэг хандлагыг өгөх, олон нийтийн зүгээс оролцох оролцоог тодорхойлох;

- Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох үндэсний хөтөлбөртэй уялдуулан ялтанд нөхөн боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх;

- Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд цагдан хорих байр болон хорих ангид хоригдож байгаа хоригдогсдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх;

- ШШГБ-ын талаарх мэдээ, мэдээллийг байгууллагын албан хаагчид болон олон нийтэд сурталчлах;

- ШШГА, хорих ангиудад зохион байгуулах нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах;

- Ялтныг хорих ангиас суллагдан нийгмийн амьдралд ороход нь бэлтгэх.

Хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл:

Хорих ангийн нийгмийн ажилтан болон сургалт арга зүйн ажилтнуудыг чадваржуулах, мэргэжлийн арга зүйгээр хангах:

- Сургагч багш бэлтгэх нийгмийн ажлын бүсчилсэн мэргэжлийн сургалт зохион байгуулах, албан хаагчдын болон ялтнуудын дунд явуулах өвөл цагийн сургалтыг зохион байгуулах;

- ШШГА, хорих ангиудад ажиллаж байгаа сургалт арга зүй, сэтгэл зүйч нийгмийн ажилтнууд болон бусад албаны бие бүрэлдэхүүнийг дотоодод сургах боломжийг судлах;

- ШШГБ-ын нийгмийн ажилтнуудын мэргэжил сургалтын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд хүргэх;

- Нийгмийн ажилтны зааврыг шинээр боловсруулан батлуулах;

- Ялтны сургалт, нийгэмшүүлэх ажлын чиглэлээр ШШГТХуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах талаар судлах;

- Ном гарын авлага бэлтгэх, сургалтыг орчин үеийн шинэ арга барилд шилжүүлэх;

- Хөгжингүй улс орнуудын тэргүүн туршлагаас судалж, нийгэмшүүлэх үйл ажиллагааны чиглэлээр гаргасан дүрэм журам, ном, товхимлыг орчуулан хэвлүүлэх;

- Сургалт арга зүй, нийгмийн ажлын тасгаас мэргэжлийн сэтгэл зүй, нийгмийн ажлын тусгайлсан сургалтын гарын авлагыг гаргах;

- Олон улсын хорих байгууллагуудын сургалт, нийгмийн ажлын ололттой туршлагыг өөрийн орны хорих байгууллагын системд нэвтрүүлэх талаар судалж, санал боловсруулах;

- Орчин үеийн сургалтын шинэ арга хэрэгслийг хорих ангиудад

нэвтрүүлэх, сургалтад ашиглагдах тоног төхөөрөмж, бусад хэрэглэгдэхүүнүүдийг нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэхүйц төсөл хэрэгжүүлэх;

ШШГЕГ-ын харьяа алба, хорих ангиудад нийгэмшүүлэх ажлын чиглэлээр нөхцөл байдлын үнэлгээ хийх, судалгааны ажлуудыг зохион байгуулах;

- Нийгмийн ажлыг хөгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох, байгууллагын зохион байгуулалт зан төлөвийг тодорхойлох;

- ШШГА, хорих ангиудад ял эдэлж байгаа хүмүүсийн нийгэм сэтгэл зүй, зан байдлын онцлогийг тодорхойлох судалгааны ажил зохион байгуулах.

Ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэм сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, төлөвшүүлж нийгэмшүүлэх, зан байдлыг нь засах:

- Алба, хорих ангиудад нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх өрөө, танхим байгуулах;

- АНУ, болон Зүүн өмнөд азийн орнуудын хорих байгууллагуудад сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа Бурхан багшийн бясалгалын нэгтөрөл болох шоронгийн бясалгалыг Монголын хорих ангиудад эрчимтэй зохион байгуулах, тухайн зан үйлийг ач тустай талаас нь авч үзэх.

Ялтанд мэргэжил эзэмшүүлэх:

- Барилгын болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт ажиллах чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах;

- Ялтны ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжил олгон чадваржуулах;

- Хөдөлмөрийн дадал олгох мэргэжлийн түр сургалтад хамруулж унэмлэх олгох

- Ялтны ял эдлэх хугацааг үр ашигтай байлгаж тэднийг суллагдсаны дараа эзэмшсэн мэргэжлээрээ нийгэмд бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх.

Ялтныг нийгэмшүүлэх эерэг хандлагыг бий болгон, олон нийтийн зүгээс оролцох оролцоог тодорхойлох:

- Төрийн болон төрийн бус байгууллагууд олон улсын сайн дурын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх;

- Төрийн бус байгууллагуудтай шинээр холбоо тогтоон үйл ажиллагаагаа тогтмолжуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох үндэсний хөтөлбөртэй уялдуулан ялтанд бага суурь болон бүрэн дунд боловсрол нөхөн олгох, мэргэжил

эзэмшүүлэх:

- Бичиг үсэг үл мэдэгч ялтанг сургах, бага дунд боловсрол олгох сургалтыг зохион байгуулах;

- Ардын уламжлал, зан үйлд тулгуурлан төлөвшүүлэх, багаар ажиллах, харилцан бие биенээ хүндэтгэх.

Мэдээллийн нэгдсэн сан байгуулах:

- ШШГЕГ-т нийгэмшүүлэх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн санг байгуулах, энэхүү мэдээллийн санг хорих ангиудад зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, гадаадын хорих байгууллагуудын талаарх баримт материалуудаар тогтмол баяжуулалт хийх;

- Хорих ангиудын номын сан шинэчлэх, номын фондод баяжилт хийх.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд цагдан хорих байр болон хорих ангид хоригдож байгаа хоригдогсдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх:

- Хорих анги, Цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогсдыг тодорхой товлосон хугацаанд эмнэлэгийн үзлэг шинжилгээнд хамруулах;

- Эрүүл мэндийн болон ДОХ \ХДХВ\БЗДХӨ\, сүрьеэгийн шинжилгээнд хамруулах, сургалт зохион байгуулах;

- Хар тамхи, мансууруулах бодист донтохоос урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах, хүчирхийллийн эсрэг сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх;

- Хөдөлмөрийн орчин, нийгмийн хамгааллын нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах, тухайн алба хорих ангийн эрүүл ахуй, аюулгүй орчинг сайжруулахад нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, тодорхой төсөл боловсруулах.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг байгууллагын албан хаагчид болон олон нийтэд сурталчлах:

- “Эрх зүйн албаны мэдээлэл” сэтгүүлийг тогтмол гаргах.

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, ялтныг хуульд заасан шаардлага, олон улсын стандарт, жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлнэ

- Ялтныг нийгэмшүүлэх ажилд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

- Хоригдогсдын байрыг шинэчилж, хорих анги болон цагдан хорих байрны харуул хамгаалалтыг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.

- Хорих анги, цагдан хорих байранд хоригдогсдод зориулсан гарын авлага, зөвлөмж бэлтгэн гаргах

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ялтнуудыг хангах, "Өчил" сонины нийтлэлийн бодлогыг боловсронгуй болгон үргэлжлүүлэн эрхлэн гаргах

Ялтныг хорих ангиас суллагдан нийгмийн амьдралд ороход нь бэлтгэх:

- Хөдөлмөрийн биржүүдтэй холбоо тогтоох, суллагдагсдыг ажлын байртай болгоход зуучлах;

- Суллагдсан иргэдэд зориулсан мэдээллийн гарын авлага, зөвлөмж боловсруулах;

- Цагдаагийн байгууллага, Иргэний бүртгэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж суллагдсан иргэний бичиг баримтыг бүрдүүлэхэд зуучлан эрх зүйн туслалцаа үзүүлэх;

- Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан нийгмийн амьдралд төлөвшүүлэхэд байнгын холбоотой ажиллан ялтанд зөвлөгөө өгч хамтран ажиллах.

Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд дараах дэд төслүүдийг хэрэгжүүлнэ:

- ШШГА, хорих ангиуд болон хорих ангид ял эдэлж байгаа хумүүсийн дунд явуулах нийгэмшүүлэх ажлын чиглэлээр судалгааны төсөл боловсруулах;

- ШШГА, хорих анги, цагдан хорих, баривчлах байруудад хүний эрхийн чиглэлээр хийх нөхцөл байдлын судалгааны төсөл боловсруулах;

- Хорих ангиудад ажиллаж буй нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйчдийг чадваржуулах сургалтын төсөл боловсруулах, мэргэжлийн бие даасан байдлыг хангах;

- Ном гарын авлагыг нэмэгдүүлэх шинээр гарын авлага бэлтгэх төсөл боловсруулах;

- Гадаадын улс орнуудад туршлага судлах, экспертүүдийн тусламжтайгаар зөвлөмж авах;

- Хорих ангиудад нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх өрөө, танхимуудыг байгуулах төсөл.

Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

• Нийгэмшүүлэх ажил, сургалтын үйл ажиллагааны төсөл хэлбэр нэмэгдэн түүний үр дүнг тооцдог механизм тогтмолжсон байна. Хорих ангиудад сургалтын иж бүрэн орчин, хэрэгсэлтэй болно.

• Гадаад, дотоодын адил чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай холбоо харилцааг сайжруулж, шинээр харилцаа холбоо тогтоон хамтран ажиллана. Хорих байгууллагын бие даасан салбарын мэргэшсэн нийгмийн ажилтнуудыг бэлтгэн ажилтнуудын үр чадвар

нэмэгдэж, ажпын үр өгөөж дээшилнэ.

- Ял эдэлж байгаа хүмүүсийн өөрсдийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг сайжруулсан байна.

- Ялтны хуульд заасан эрх болон олон улсын хүрээнд хүний эрхийн талаар гаргасан баримт бичгүүдийг өдөр тутам бодит үйл ажиллагаанд мөрдлөг болгоно. Хоригдогч этгээдийн зан байдал, нийгэм сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийдэг болсон байх.

- Хорих ангид сэтгэл зүйн тогтвортой уур амьсгалыг бодитойгоор бий болгох, хамтач хөдөлмөрийн эерэг хандпагыг төлөвшүүлэхэд нийгмийн ажилтнуудын үүрэг ролийг эрчимжүүлэн ялтны дундаас гарах хэрэг зөрчлийн тоог бууруулсан байна.

- Хорих ангиудад нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах ажилтныг ажлын байрны гол багаж, техник хэрэгслүүдээр хангасан байх.

- Ялын хугацаа дуусах дөхсөн ялтнуудтай ажилладаг арга хэлбэрээ боловсронгуй болгож, суллагдан гарахын өмнөөс эхлэн нийгэмд хуулийн хүрээнд бие даан амьдарч, ард иргэдтэй хэрхэн харьцах, олон нийтийн дунд хэрхэн бие авч явах талаар тусгайлсан сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллана.

“Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-т зааснаар:

Нийгмийн ажил гэж хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажил нь хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хоригдогчийн нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа юм. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хоригдогчийг чадваржуулах, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлган нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараас бүрдсэн баг ажиллуулах ба мэргэжлийн бие даасан үйл ажиллагаатай байхаар зохион байгуулна.

Нийгэмшүүлэх ажлын үе шат:

1. Хоригдогчийн нийгмийн болоод сэтгэл зүйн хэрэгцээнд үндэслэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох.

2. Хоригдогчид ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

3 Хоригдогчийн хувийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тэдгээрийг чадваржуулах, хувь хүний давуу тал, нөөц боломжийг нээн хөгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

4. Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх.

5. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хэрэгжүүлэх нийгмийн ажилд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах,

6. Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах;

7. Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэлзүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр явуулахаар тусгажээ²⁴.

2017 оноос хойшхи үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаа:

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхэлжээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсон ба тухайлбал, хорих ял эдлүүлэх төрөл, дэглэм, зэрэглэлийг шинээр тогтоон нээлттэй, хаалттай хорих анги, энгийн ба тусгай зэрэглэл, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой болон бусад асуудлуудыг шинээр хуульчилж өгсөн байна.

Шинэ хуульд нийцүүлэн ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 тоот тушаалаар “Нийгмийн ажлын аргачилсан заавар”, 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн сэтгэл зүйн ажлын заавар”-ыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа даган мөрдөж байна.

²⁴ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ /2003-2018/. УБ.,85 дахь тал

ХОЁР. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛЖ БУЙ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

2.1.Хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ

Манай улсын хувьд хорих байгууллага дахь “нийгмийн ажил”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томъёо, ойлголт 2017 онд шинээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /ШШГТХ/ батлагдах хүртэл “салбарын хуульд тусгаагүй” бөгөөд “хорих байгууллага дахь нийгмийн ажил”, “нийгмийн ажилтан” гэсэн бие даасан ажил, мэргэжлийн ойлголт 2003 оноос л манай оронд бүрэлдэн бий болсон байна²⁵.

Харин XIX зууны сүүлчээр барууны зарим орнуудад “Forensic social work буюу шүүхийн нийгмийн ажилтнууд” гэсэн ойлголт бий болж шүүхийн төдийгүй хууль зүйн салбарт хүчтэй түрэн орж ирсэн. Ийнхүү хууль зүйн салбарт нийгмийн ажил гэсэн нэр томъёо, үйлчилгээ нэвтэрч эхэлсэн үеэс их сургууль төгссөн нийгмийн ажилтнууд парол (parole office) болон пробацын (probation office) алба, хорих байгууллагад орж ажиллах болжээ²⁶. Манай хөрш Оросын холбооны улсын хувьд ОХУ-ын Хууль зүйн сайдын 2000 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тушаалаар бүх төрлийн хорих байгууллага, урьдчилан хорих байр болон тэдгээрийн салбар нэгжийн бүтэц орон тоог баталсан бөгөөд “хүмүүжлийн ажлын хэлтэс” гэсэн нэрийг “нийгэм-сэтгэл зүйн хэлтэс” хэмээн өөрчилж хорих байгууллагын бүтэцэд хамааруулжээ. Ийнхүү ОХУ-ын хорих байгууллагад анх удаа хоригдолтой ажиллах мэргэжлийн нийгмийн ажлын алба байгуулагдсан²⁷ түүхтэй.

Бусад улсын туршлагаас үзэхэд хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө боловсруулж, тэднийг нийгэмшүүлэхэд чиглэсэн олон хууль, эрхийн акт, хөтөлбөрүүд хэрэгжүүлж ихээхэн туршлага хуримтлуулж байна.

Манай улсын хорих байгууллага дахь нийгмийн ажлын агуулга, зохион байгуулалт, эрх зүйн орчин, үйл ажиллагааг олон улсын

²⁵ ШШГЕГ-аас 2003 онд зохион байгуулсан төв, орон нутгийн хорих ангийн дарга, ахуй дэглэмийн байцаагч нарын нэгдсэн зөвлөгөөнөөс “нийгмийн ажилтан” гэсэн нэр томъёог хэрэглэхээр тогтсон.

²⁶ Robert L. Barker, Douglas M. Branson. Forensic Social Work. Legal Aspects of Professional Practice, 1993. The Haworth Press, Inc., Binghamton, NY. p 2-3

²⁷ С.А.Лузгин, М.И. Кузнецов, В.Н. Казанцев, Хорих байгууллагын нийгмийн ажил: Сургалтын гарын авлага. Орос хэлнээс орчуулсан Д.Шатарбал. УБ. 2009 он., 89 дэх тал.

хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн бүрэлдүүлэхэд бусад орны энэ талаар хуримтлуулсан арвин туршлага, алдаа онооноос суралцах нь зохистой юм.

Өнөөгийн байдлаар хоригдогчийг нийгэмшүүлэх чиглэлээр зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хязгаарлахгүйгээр хорих байгууллагаас суллагдсан хүнд тавих хяналт, бусад чиглэлээр холбогдох хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Тухайлбал,

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2-т хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох, 15.1.5-т хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон *хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж*, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.

2.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-т Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно: 13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн;

3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын

44 дүгээр зүйл. Зан үйлд нөлөөлөх сургалт

44.1.Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байна.

44.2.Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.

44.3.Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

44.4.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.

44.5.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн

чиглэлийг хэрэгжүүлэх

9.1.Тодорхой этгээд гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх, түүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэл гэнэ.

9.2.2.гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих;

9.2.3.гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх;

9.2.4.хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тодорхой үүрэг хүлээлгэсэн, хориглолт, хязгаарлалт тогтоосон хүнд хяналт тавих;

9.2.5.гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, үр чадвар олгох;

9.2.6.энэ хуулийн 12.1.5, 12.1.6-д заасан хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт, шалгалт хийх, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх;

41 дүгээр зүйл.Хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтоох

41.1.Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан болон хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан хяналтыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, түүний алба хаагч гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд цагдаагийн төв байгууллагын шийдвэрээр үйлдсэн гэмт хэргийн төрлөөс хамааран тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг дагнан хэрэгжүүлж байгаа цагдаагийн байгууллагын нэгж, алба хаагчид даалгаж болно.

41.3.Хяналтад байгаа хүний хяналтын хугацаа дууссан бол уг хяналтыг тавьж байгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтыг дуусгавар болгоно.

41.4.Энэ хуулийн 41.1-д заасан хүн хорих ял эдлэн суллагдаж, эсхүл чөлөөлөгдөж байнга оршин суух газартаа очсоноос хойш долоо хоногийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

41.5.Хорих байгууллага хорих ял эдэлж байгаа хүнийг суллагдахаас 30 хоногийн өмнө, хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйлд заасан хяналтын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн даруй тус тус байнга оршин суух газрын цагдаагийн байгууллагад түүний суллагдах тухай мэдэгдлийг зохих тодорхойлолтын хамт хүргүүлнэ.

42 дугаар зүйл.Хяналт тавих хугацаа

42.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хяналтыг энэ хуулийн 41.1-д заасан хүнд оногдуулсан хорих ялын хугацаатай уялдуулан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр нэгээс гурван жил хүртэл хугацаагаар тогтооно.

42.2.Хяналтад байгаа хүн урьд өмнө хяналтад байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн бол хяналтын хугацаа нь энэ хуулийн 42.1-д заасан хугацаан дээр хоёр жилийн хугацааг нэмж тогтооно.

42.3.Хяналтад байгаа хүн хяналтаас зайлсхийсэн /хуульд заасны дагуу бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн боловч гурван сар, түүнээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй/, оргон зайлсан /хуульд заасны дагуу бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн боловч зургаан сар, түүнээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй/, эсхүл энэ хуулийн 43.1-д заасан үүргээ удаа дараа /3 ба түүнээс дээш удаа/ биелүүлээгүй бол энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр хяналтын хугацааг тухай бүр зургаан сарын хугацаагаар сунгаж тогтооно.

42.4.Хяналтад байгаа хүн гэмт хэрэг дахин үйлдэж болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдэн эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдан шалгагдаж байгаа тохиолдолд энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр тухайн үндэслэл арилах хүртэл хугацаагаар хяналтын хугацааг сунгаж болно.

42.5.Хяналтад байгаа хүн хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа бөгөөд ажил хөдөлмөр эрхлэлт, зан төлөвийн хувьд засарч нийгэмд бүрэн дасан зохицсон, цаашид гэмт хэрэг үйлдэхгүй гэх хангалттай үндэслэл тогтоогдсон, эсхүл гадаад улсад удаан хугацаагаар зорчих бол энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр хугацаанаас өмнө хяналтыг дуусгавар болгож болно.

42.6.Энэ хуулийн 42.2, 42.3, 42.4-т заасны дагуу хяналтын хугацааг сунгасан бол хяналт тавих нийт хугацаа нь тухайн хүний үйлдсэн гэмт

хэрэгт оногдуулахаар Эрүүгийн хуульд заасан хорих ялын дээд хугацаанаас хэтэрч болохгүй.

42.7.Хяналтын хувийн хэргийн загвар, хугацааг тогтоох жишгийг цагдаагийн төв байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн тогтооно.

45 дугаар зүйл.Хяналтын хэлбэр

45.1.Хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналтын хүрээ, хяналтад ашиглах арга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хяналтад байгаа хүний үйлдсэн гэмт хэргийн төрөл, онцлог, түүний хувийн байдалд нийцүүлэн ялгамжтайгаар тогтооно.

45.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ дараах хэлбэртэй байна:

45.2.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ярилцлага хийх, зөвлөгөө өгөх;

45.2.2.хяналтад байгаа хүнийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

45.2.3.ял шийтгүүлсэн гэмт хэргийн төрөл, хувийн байдлаас хамааран урьд өмнө гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэсэн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар тодорхой үүрэг өгч, биелэлтийг хангуулах;

45.2.4.хяналтад байгаа хүний зан үйл, хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны талаар тусгайлсан шаардлага, хориглолт, хязгаарлалт тогтоох;

45.2.5.ажил хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааг нь биечлэн шалгах;

45.2.6.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэж тэнсэн харгалзсан этгээд мансууруулах эм, бодис хэрэглэсэн эсэхийг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар шалгах;

45.2.7.хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авах, захиргааны журмаар албадан эмчилгээнд хамруулах.

45.3.Хяналтад байгаа хүн энэ хуулийн 42.1-д заасны дагуу тогтоосон хугацааны эхний хагаст зан байдлаараа нийтэд аюулгүй болсон гэдгээ нотлон харуулсан бөгөөд цаашид тогтмол хяналт тавих шаардлагагүй бол хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтын үлдсэн хугацаанд энэ хуульд заасан хяналтын түвшинг хөнгөрүүлж болно.

45.4.Энэ хуулийн 45.2-т заасан хяналтад байгаа хүний эерэг зан, төлөв байдлаас хамааран урамшуулах буюу цагдаагийн байгууллага, алба хаагч хяналтад байгаа хүнийг зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад дуудахгүй байх, энэ хуулийн 43.1.2,

43.1.4, 43.1.5-д заасан хугацаа, давтамжийг хуульд зааснаар сунгаж тогтоох болон урьд тогтоосон зарим үүрэг, хориглолт, хязгаарлалтыг цуцлах байдлаар хэрэгжүүлнэ.

45.5.Хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр оролцуулж болно.

2017 онд шинээр баталсан ШШГТХ-д анх удаа нийгэмшүүлэх ажил, нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт гэсэн тусгай зохицуулалт тусгагдсан. Тухайлбал уг хуулийн 218 дугаар зүйлийн 218.1-д “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”, 219 дүгээр зүйлийн 219.1-д “Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэжээ.

Хүснэгт 1. 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийгэмшүүлэх ажлын талаар туссан байдалд хийсэн харьцуулалт

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
<p>Хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: -ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; -насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох; -ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох...</p>	<p>Хорих анги дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: -хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; -хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох; -хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох...</p>
<p>Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт 1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна.</p>	<p>Нийгэмшүүлэх ажил 1.Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.</p>

<p>2.Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.</p> <p>3.Ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно.</p>	<p>2.Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана.</p> <p>3.Хорих анги дахь нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас санхүүжүүлж болно.</p>
	<p>Нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт</p> <p>1.Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, үр чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>2.Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.</p> <p>3.Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно.</p> <p>4.Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм,</p>

	зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.
<p>Хорих анги дахь сургалт</p> <p>1.Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ.</p> <p>2.Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.</p> <p>3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.</p> <p>4.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.</p>	<p>Хорих анги дахь сургалт</p> <p>1.Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ.</p> <p>2.Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна.</p>
	<p>Хорих анги дахь сургалтын хэлбэр</p> <p>1.Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.</p> <p>2.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.</p>
	<p>Хорих анги дахь албадан сургалт</p> <p>Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.</p>

Хүснэгт 2. Нийгэмшүүлэх ажлын зааврын харьцуулалт

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар /2010.11.10/	Нийгмийн ажлын аргачилсан заавар /2018.7.3/
Нийгмийн ажил гэж	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажил нь хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хоригдогчийн нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа, дэмжлэг	“Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил” гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1 дэх хэсэгт зааснаар хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ.

<p>үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа юм.</p>	
<p>Нийгмийн ажилтан гэж</p>	
<p>Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь мэргэжлийн хувьд нийгмийн ажлын боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй эсхүл нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн болон давтан сургалтанд хамрагдан мэргэшсэн цэргийн албан хаагч байна.</p>	<p>Нийгмийн ажилтан гэж хорих байгууллагын нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагчийг тус тус ойлгоно.</p>
<p>Хорих ангийн нийгмийн ажлын зохион байгуулалт, чиг үүрэг</p>	
<p>Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хоригдогчийг чадваржуулах, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлган нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараас бүрдсэн баг ажиллуулах ба мэргэжлийн бие даасан үйл ажиллагаатай байхаар зохион байгуулна.</p>	<p>Хорих ангийн нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>1.хорих ангийн дарга, дэд дарга мэргэшсэн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана;</p> <p>2.мэргэшсэн нэгж нь хоригдлын нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хорих ангийн даргаар батлуулна;</p> <p>3.нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас бүтэн жилээр, сургалтын үр дүнгийн талаарх тайланг, тоон судалгааг сар бүрийн 25-ны дотор хорих ангийн даргад танилцуулан, энэ зааврын 2.1-д заасан нэгжид хүргүүлнэ;</p> <p>Мэргэшсэн нэгж нь хоригдлын дунд явуулах сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад тухайн жилд шаардагдах арга хэмжээний зардлын тооцоог гаргаж, хорих ангийн даргаар уламжлуулан шийдвэрлүүлнэ.</p>
<p>Нийгэмшүүлэх ажлын үе шат</p>	
<p>1. Хоригдогчийн нийгмийн болоод сэтгэл зүйн хэрэгцээнд үндэслэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох.</p>	<p>1.Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил.</p> <p>2.Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил.</p>

<p>2. Хоригдогчид ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.</p> <p>3. Хоригдогчийн хувийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тэдгээрийг чадваржуулах, хувь хүний давуу тал, нөөц боломжийг нээн хөгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.</p> <p>4. Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх.</p> <p>5. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хэрэгжүүлэх нийгмийн ажилд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах,</p> <p>6. Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах;</p> <p>7. Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэлзүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх.</p>	<p>3. Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил.</p>
<p>Судалгааны ажил</p>	
<p>Шинээр ирсэн хоригдогчийг дараах чиглэлээр судлана:</p> <ol style="list-style-type: none"> 1. зан төлөв, 2. биеэ авч яваа байдал, 3. хувийн сэтгэл зүйн онцлог, 4. орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл санааны хямралд орсон эсэх, 5. хувь хүний давуу талууд буюу мэргэжил, боловсрол, спорт, урлагын болон бусад авьяас чадвар, боломжууд, 6. ар гэр, төрөл төрөгсөд, найз нөхөд буюу ойр дотны хүмүүсийн талаар, 7. ажиллаж, амьдарч байсан газар, нутаг орон, 8. урьд нь ял шийтгэл эдэлж байсан тохиолдолд тухайн үеийн ял эдлэлтийн байдал, 9. үйлдсэн гэмт хэргийн байдал. 10. сэтгэцийн эрүүл мэндийн байдал, 	<p>Нийгмийн ажилтан өдөр тутмын үйл ажиллагаандаа дараах бүртгэл, судалгааг гаргасан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. илгээсэн захидлын бүртгэл; 2. өргөдөл, гомдол, санал хүсэлтийн бүртгэл; 3. хоригдлын ар гэртэй уулзсан бүртгэл; 4. номын сангаар үйлчлүүлсэн хоригдлын бүртгэл; 5. сургалт зохион явуулсан бүртгэл; 6. хоригдолтой уулзсан бүртгэл; 7. гэмт хэрэг, нас, мэргэжил, боловсролын судалгаа; 8. хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын судалгаа; 9. хоригдлын гэр бүл, эргэлт уулзалтгүй хоригдлын судалгаа 10. суллагдахын өмнөх хугацаанд сургалтад хамрагдах хоригдлын судалгаа;

Хүснэгт 3.Сэтгэл зүйчийн үйл ажиллагааг зохицуулж ирсэн зааврын харьцуулалт

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны сэтгэл зүйчийн ажлын заавар /2010.11.10/	Сэтгэл зүйн ажлын заавар /2019.6.7/
Сэтгэл зүйч гэж:	
<p>Сэтгэл судлалын чиглэлээр боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байхын зэрэгцээ мэргэшлийн шаардлагын хувьд: -Хуулийн сэтгэл судлал -Сэтгэц - оношлогоо -Хүний хөгжлийн сэтгэлзүй -Сэтгэлзүйн зөвлөгөөний онол-арга зүйн чиглэлээр бие даан мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх арга техникийг эзэмшсэн албан хаагч байна.</p>	<p>Хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг хэлнэ.</p>
Сэтгэл зүйчийн үйл ажиллагаа:	
<ol style="list-style-type: none"> 1.Хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг оношлон тодорхойлох; 2.Хоригдогчид сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх; 3.Хорих байгууллагын нийтэлбан хаагчдад үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх; 4.Сэтгэлзүйн мэргэжлийн үйлчилгээний үр дүнд хоригдогчид гарч буй өөрчлөлтийг үнэлэх; 5.Мэргэжлийн үйлчилгээний явцад гарсан санал дүгнэлтийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн чиглэлд тусгаж ажиллах; 6.Үйлдсэн гэмт хэргийн буюу гэмт хэргийн байдлаа хүлээн зөвшөөрөөгүйн улмаас сэтгэлзүйн стресс, хямралд орсон хоригдогчийг судалгааны аргаар илрүүлэн оношлон мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх; 7.Өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт хийж, өөрийн болон мэргэжлийн хөгжилд хувь нэмэр оруулах; 	<p>Хорих ангийн сэтгэл зүйч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1.Хоригдогчид сэтгэл зүйн судалгаа авах; 2.Хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлох; 3.Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх; 4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулна;
Сэтгэл зүйчийн үйл ажиллагааны баримтжуулалт	
Хоригдогчид зориулсан дараах маягтуудыг нээж хөтлөнө.Үүнд:	Сэтгэл зүйч дараах тэмдэглэл,судалгааг гаргаж

1.Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөний тэмдэглэл, 2.Холбон зуучлах хуудас, 3.Оношлогооны маягт, 4.Үнэлгээний хуудас, 5.Сэтгэл зүйн сорил түүний үр дүнгийн маягт, 6.Сэтгэл зүйчийн тодорхойлолт, 7.Сэтгэл зүйчийн үйлчилгээний цагийн хуваарь	хоригдогчийн мэдээллийн санд баяжилт хийсэнбайна. 1.Сэтгэл зүйн зөвлөгөөний хуудас /гэрээ/; 2.Анхны ярилцлагын тэмдэглэл; 3.Уулзалтын тэмдэглэл; 4.Холбон зуучлах хуудас; 5.Хоригдогчийн гэр бүлтэй хамтран ажилласан бүртгэл; 6.Сэтгэл зүйн тодорхойлолт; 7.Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдогчийн судалгааг улирал бүр гаргах /загварын дагуу/; 8.Зөрчил гаргасан хоригдогчтой уулзсан талаарх тэмдэглэл; 9.Сэтгэл зүйн дүгнэлт; 10.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдах хоригдогчийн судалгаа гаргах;
--	---

Дээрх зааврын хүрээнд хорих ангийн нийгмийн ажилтнууд хоригдлыг нийгэмшүүлэх үйл хэргээ гүйцэтгэсээр иржээ. Судалгааны ажлын явцад бид нийт 21 хорих ангийн 2015-2020 оны хоорондын нийгэмшүүлэх ажлын тайлан мэдээнд дүн шинжилгээ хийн, тухайн үед мөрдөгдөж байсан зааврын хэрэгжилтийг анги тус бүрээр болон жилээр гарган нэгтгэн үзлээ.

Хүснэгт 4. ШШГЕГ-ын харьяа хорих ангиудын нийгэмшүүлэх үйл ажиллагааны зааврын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ /2015-2020/


Хорих анги	ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"-ын 60 заалтаар дүгнэхэд			ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"-ын 41 заалтаар дүгнэхэд		Нийлбэр
	2015	2016	2017	2018	2019	
401	58.3%	56.6%	51.6%	56.0%	78.0%	61,9%
405	58.3%	68.3%	65.0%	65.8%	29.0%	57,2%
407	73.3%	73.3%	73.3%	82.9%	75.6%	75,6%
409	65.0%	65.0%	60.0%	56.0%	80.4%	65,2%
411	65.0%	73.3%	68.3%	56.0%	65.8%	65,6%
413	71.6%	70.0%	71.6%	75.6%	80.4%	73,8%
415	63.3%	51.6%	51.6%	73.1%	78.0%	63,5%
417	53.3%	68.3%	60.0%	65.8%	85.3%	66,5%
419	56.6%	58.3%	33.3%	68.2%	78.0%	58,8%

421	63.3%	63.3%	66.6%	68.2%	73.1%	66,9%
423	56.6%	51.6%	45.0%	65.8%	68.2%	57,4%
425	65.0%	58.3%	37.0%	68.2%	78.0%	61,3%
427	75.0%	68.3%	65.0%	78.0%	73.1%	71,8%
429	65.0%	58.3%	58.3%	60.9%	58.5%	60,2%
433	68.3%	56.6%	71.6%	82.9%	70.7%	70,2%
435	60.0%	65.0%	58.3%	78.0%	80.4%	68,3%
437	73.3%			70.7%	73.1%	72,7%
439	56.6%	66.6%	68.3%	78.0%	80.4%	69,9%
441	2019 оноос нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж эхэлсэн.					
445	71.6%	61.6%	63.3%	75.6%	82.9%	71,0%
457	Архивын нэгж үүсгэж тайлан хадгалагдаагүй.					
461	51.6%	53.3%	50.0%	70.7%	68.2%	58,7%

Хүснэгтээс харахад хорих ангиудын нийгэмшүүлэх ажлын зааврын биелэлт 55-75 орчим хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл энэ нь нийгмийн ажлын зааварт байна уу, эсвэл үйл ажиллагаа, зохион байгуулалтандаа байна уу гэдгийг анхаарах цаг нэгэнт болжээ.


Түүнчлэн судалгааны ажлын явцад өмнө дурдсанчлан урьд хорих ял эдэлж байгаад дахин гэмт хэрэг үйлдэн хорих ял шийтгэгдсэн ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааны дүнг анхаарч үзлээ. Бид судалгааны хүрээгээ 2015-2020 оны хооронд гэж авсан бөгөөд энэ хугацаанд 2015 онд-4506, 2016 онд-4567, 2017 онд- 2942, 2018 онд-3525, 2019 онд-3933 буюу нийт-19473 хоригдол давхардсан тоогоор ял эдэлж байсан байна.

Зураг 9. 2015- 2019 оны нийт хорих ял эдлэгсэдийн судалгаа:




Дээрх ял эдэлж байсан хоригдлуудаас 2015 онд 3445, 2016 онд 1324, 2017 онд 2918, 2018 онд 1813, 2019 онд 2532 буюу нийт-12032 хоригдол суллагдсан байна.

Зураг 10. Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн судалгаа /2015-2020/:



Нийт суллагдсан хоригдлуудаас зөвхөн хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоосон хоригдлуудыг судлан үзвэл 2015 онд 1167 буюу 33,8% , 2016 онд 997 буюу 75,3%, 2017 онд 1115 буюу 38,2%, 2018 онд 1068 буюу 58,9%, 2019 онд 1414 буюу 55,8% нийт-5761 буюу 47,8% нь суллагдсан байна.


Зураг 11.Хугацааны өмнө суллагдсан хоригдлуудын судалгаа /2015-2020/:



Дээрх хугацааны өмнө суллагдсан хоригдлууд нь бүгд засрал хүмүүжлээ олсон, бүрэн нийгэмшсэн гэсэн үндэслэлээр суллагдсан байгаа ба давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 70 орчим хувь нь дээрх хугацаанд хамаарч байгаа нь нийгэмшүүлэх ажлын үр нөлөөнд эргэлзээтэй байдлыг төрүүлж байна.


Давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо 2015 онд 2794 буюу 66,0% , 2016 онд 2172 буюу 47,5%, 2017 онд 1289 буюу 9,8%, 2018 онд 1614 буюу 45,7%, 2019 онд 1910 буюу 48,5% нийт-9779 буюу 50,2% нь байна.

Зураг 12.Давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдлэгсэдийн судалгаа /2015-2020/:



Судалгаанд оролцогчдоос “таныг давтан гэмт хэрэг үйлдэхэд хорих ангид ял эдэлж байсан байдал нөлөөлсөн үү” гэсэн асуултад 213 буюу 18 хувь нь тийм, 860 буюу 68 хувь нь үгүй, 175 буюу 14 хувь нь бага зэрэг нөлөөлсөн гэж хариулсан.

Зураг 13. Давтан гэмт хэрэг үйлдэгчдээс авсан судалгааны дүн /2015-2020/:



2.2.Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг онолын үндэслэлгүй, оновчгүй төлөвлөх, хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийдэггүй, нийгэмшүүлэх ажлыг мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах хэлбэрээр хязгаарлах, нийгэмшлийн байдлыг мэргэжилтэн (нийгмийн ажилтан)-ий хувийн үнэлэмжээр дүгнэдэг зэргээс шалтгаалан хорих анги дахь нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ нь төдийлөн үр дүнтэй бус байгааг ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих байгууллага, олон нийтийн зүгээс шүүмжлэх хандлага ажиглагдаж байна.

Тиймээс хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлэхдээ хоригдлын ял эдлэх хугацаа, зан үйл, хувийн онцлог, гэр бүлийн байдал, боловсрол, мэргэжил, үйлдсэн гэмт хэргийн байдал зэргийг харгалзан тэдний зан үйл, хандлагыг өөрчлөх, нийгэмших үйл явцад нь дэмжлэг үзүүлэх тодорхой онолын үндэслэл, загварт суурилсан хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх, улмаар хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд суурилсан хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг үнэлэх арга зүйг туршин үзэх нь зүйтэй байна.

Энэ талаар ОХУ-ын сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны доктор Сергей Иванович Злобин "...нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдсан ялтнууд давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэл буурдаг болох нь олон судалгаагаар батлагдсан"²⁸ тухай өгүүлсэн бол АНУ-ын "Rhode Island"-ын их сургуулийн судлаач Victoria Miceli "...мэргэжлийн судалгааны байгууллагаар хянуулсан, хорих байгууллагад хэрэгжүүлэх тусгай хөтөлбөрүүд нь ялтныг нийгэмшүүлэхэд бусад ажлаас илүү үр дүнтэй байдаг гэдгийг өнгөрсөн хорин таван жилийн хугацааны үр дүн харуулж байна"²⁹ гэж тэмдэглэсэн байна. Мөн судлаач Doris MacKenzie ялтныг нийгэмшүүлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн хөтөлбөрүүдээс академик болон мэргэжлийн боловсролын хөтөлбөр, ёс суртахууны сургалтын хөтөлбөр (MRT - Moral Recognition Therapy), "шалтгаан нөхцөл – нөхөн сэргээх" хөтөлбөр (R & R - reasoning and rehabilitation), танин мэдэхүй – зан үйлийн эмчилгээний хөтөлбөр (Cognitive behavioral treatment), насанд хүрээгүйчүүдэд зориулсан олон

²⁸ Sergei Ivanovich Zlobin. "Re-socialization of Prisoners in Russia at the Present Stage". World Appl.Sci. 26(5)J.,2013.

²⁹Victoria Miceli. "Analyzing the Effectiveness of Rehabilitation Programs". University of Rhode Island., 2009

шатлалт хөтөлбөр (Multi-systemic therapy) зэрэг хөтөлбөрүүд илүү үр дүнтэй байна гэдгийг өөрийн өгүүлэлдээ онцлон дурджээ³⁰.

Түүнчлэн Австралийн хорих байгууллагад гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг гэмт хэргийн төрлөөр ангилан, онц хүнд гэмт хэрэгтэнд зориулсан хөтөлбөр, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд зориулсан хөтөлбөр, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид зориулсан хөтөлбөр, уур бухимдлыг зохицуулах хөтөлбөр, танин мэдэхүйн чадварын хөтөлбөр, хар тамхи болон архины эмчилгээний хөтөлбөр, хохирогчийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр³¹ зэргийг хэрэгжүүлж байгаа бол зарим улсад хоригдлыг нөхөн сэргээх үр дүнтэй үйл ажиллагааны нэг нь амралт чөлөөт цаг – спортын үйл ажиллагаа ч гэж үздэг³² байна.

Гадаадын зарим оронд хэрэгжиж буй хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн дээрх хөтөлбөрүүд нь ихэвчлэн танин мэдэхүй-зан үйлийн онол, сэтгэл зүйн боловсролын загвар, зан үйлийн өөрчлөлтийн хосолмол онолын загварт голлон суурилсан байхын зэрэгцээ эдгээр хөтөлбөрт хамрагдсан байдлыг харгалзан ялтны нийгэмшлийн байдал, хорих ангиас суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийн үнэлгээ хийдэг нийтлэг жишгийг харгалзан үзэж, хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнг тооцохын тулд тухайн хөтөлбөрийг үнэлэх тохирсон аргачлалын дагуу үнэлгээ хийхээс гадна уг хөтөлбөрт хамрагдаж буй ялтны нийгэм, сэтгэл зүйн байдлыг эхэнд нь үнэлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тодорхой хугацаанд ахиц өөрчлөлтийг үнэлэх, хөтөлбөр *дуусмагц* төгсгөлийн үнэлгээ хийх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Монгол Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын хэрэгжилт, үр нөлөөнд шинжилгээ хийхэд үйлчлүүлэгч болох хоригдлын санал, асуулга чухал үүрэгтэй гэж үзсэн болно. Үүнд:


1. Хоригдлыг хорих байгууллагын дэглэм, зэрэглэл буух нэг үндэслэл нь нийгэмшүүлэх үйл ажиллагааны оролцоо байдаг, тухайлбал, 2015 онд-343, 2016 онд-597, 2017 онд-350, 2018 онд-261, 2019 онд-369 буюу нийт-1920 хоригдол дэглэм буурсан байна.

³⁰MacKenzie, Doris L. "What Works in Corrections: reducing the criminal activities of offenders and delinquents". Cambridge University Press., 2006.p. 331

³¹Prison-based correctional offenderrehabilitation programs. Australian Institute of Criminology., 2011


³²American International Journal of Contemporary Research Vol. 3 No. 1; January 2013

Зураг 14. Дэглэм буурсан хоригдлуудын судалгаа /2015-2020/



Харин эсрэгээрээ нийгэмшүүлэх ажлын үр нөлөө муу байгааг илтгэн харуулах нэг үндэслэл нь дэглэм, зэрэглэл дээшлэх тухай асуудал бөгөөд 2015 онд-82, 2016 онд-19, 2017 онд-21, 2018 онд-40, 2019 онд-44 буюу нийт-206 хоригдол дэглэм дээшилсэн байна.


Зураг 15. Дэглэм дээшилсэн хоригдлуудын судалгаа /2015-2020/



2. Хорих ял эдлүүлэх нөхцөл, журмын талаарх асуулгын дүн:


–“Та хорих ангийн орчин нөхцлийг хэрхэн үнэлж байна вэ” гэсэн асуултад 767 буюу 60% нь сайн, 444 буюу 34% нь дунд зэрэг, 72 буюу 6% нь муу гэж хариулсан.

Зураг 16. Хорих ял эдлүүлэх нөхцөл, журмын талаарх асуулгын дүн:




–“Та хорих ангид хөдөлмөр эрхэлдэг үү” гэсэн асуултад 1013 буюу 79 хувь нь тийм, 265 буюу 21 хувь нь үгүй гэж хариулсан.

Зураг 17. Хорих ангид хөдөлмөр эрхэлдэг талаарх асуулгын дүн:




3.Суллагдан гарахад бэлтгэх ажиллагааны чиглэлээрх асуулгын дүн:
 - “Та суллагдсаны дараа юу хийх төлөвлөгөөтэй байна вэ” гэсэн асуултад 1071 буюу 85 хувь нь ажил хөдөлмөр эрхлэнэ, 120 буюу 9 хувь нь суралцана, 76 буюу 6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан.

Зураг 18. Суллагдсаны дараах төлөвлөгөөны асуулгын дүн:




- “Нийгмийн ажилтан өмнө хорих ангиас суллагдаад оршин суух газар, амьдрах нөхцлийн талаар судалгаа хийж байсан уу” гэсэн асуултад 918 буюу 71 хувь нь тийм, 372 буюу 29 хувь нь үгүй гэж хариулсан.

Зураг 19. Суллагдахын өмнөх хийгдсэн ажлын талаарх асуулгын дүн:




-“Суллагдсаны дараа танд туслалцаа хэрэгтэй бол хорих ангийн нийгмийн ажилтанд хандах уу” гэсэн асуултад 681 буюу 53 хувь нь хандана, 447 буюу 35 хувь нь хандахгүй, 156 буюу 12 хувь нь хүлээн авахгүй байх гэж хариулсан.

Зураг 20. Суллагдсаны дараах эргэх холбооны асуулгын дүн:




-“Хорих ангид явуулсан нийгэмшүүлэх болон сургалтын ажил нь суллагдсаны дараа таньд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болсон уу” гэсэн асуултад 743 буюу 59 хувь нь тийм, 293 буюу 23 хувь нь үгүй, 226 буюу 18 хувь нь бага зэрэг гэж хариулсан.

Зураг 21. Суллагдагдсаны дараах нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн асуулгын дүн:




- “Таны өмнө суллагдсаны дараах нийгмийн байдал” гэсэн асуултад 921 буюу 74 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байсан, 84 буюу 7 хувь нь суллагадаад хүлээн авах орчин байгаагүй, 167 буюу 13 хувь нь ажил хайсан ч олдоогүй, 77 буюу 6 хувь нь ажил хайгаагүй гэж хариулсан.

Зураг 22.Суллагдсаны дараах нийгмийн байдлын судалгаа:



-“Хорих ангиас суллагдсаны дараах хүмүүсийн таньтай харьцаж байсан байдал” гэсэн хариултад 313 буюу 25 хувь нь шоронгоос суллагдсан гээд цэрвэж байсан, 620 буюу 50 хувь нь энгийн хүмүүсийн адил хүлээж авсан, 317 буюу 25 хувь нь мэдэгдээгүй гэж хариулсан.


Зураг 23. Суллагдсаны дараах хүмүүсийн харьцааны талаарх судалгаа:



4.Холбон зуучлах ажиллагааны чиглэлээрх санал асуулга:

- “Гэр бүл, найз нөхдөөс тань эргэлт, уулзалт ирдэг үү” гэсэн асуултад 496 буюу 38% нь байнга, 518 буюу 40% нь заримдаа, 279 буюу 22% нь огт ирдэггүй гэж хариулсан.


Зураг 24. Уулзалтад хамрагддаг талаарх асуулгын дүн:



5.Сэтгэл зүйн үйлчилгээний талаарх санал асуулга:

- “Та хорих ангийн сэтгэл зүйчээр үйлчлүүлдэг үү” гэсэн асуултад 257 буюу 20 % нь байнга, 646 буюу 50% нь шаардлагатай тохиолдолд, 384 буюу 30% нь үгүй гэж хариулсан.


Зураг 25. Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагддаг талаарх асуулгын дүн:



6.Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний талаарх санал асуулга:


- “Та хорих ангид өөрийн хүсэн хүлээж байсан нийгмийн ажлын үйлчилгээг авч чадсан уу” гэсэн асуултад 801 буюу 62% нь тийм, 229 буюу 18% нь үгүй, 262 буюу 20% нь бага зэрэг гэж хариулсан.

Зураг 26. Нийгэмшүүлэх ажлын сэтгэл ханамжийн судалгаа:




- “Хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын үр дүнг та хэрхэн үнэлж байна вэ” гэсэн асуултад 942 буюу 74% нь сайн, 278 буюу 22% нь үр дүн багатай, 59 буюу 4% нь ямар ч үр дүнгүй гэж хариулсан.

Зураг 27. Нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн асуулгын дүн:



- “Та хорих ангийн нийгмийн ажлын үр дүнг дээшлүүлэхэд юун дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна вэ” гэсэн асуултад 374 буюу 29 хувь нь сургалтыг түлхүү явуулж мэргэжил, боловсрол эзэмшүүлэх, 158 буюу 12 хувь нь сэтгэл зүйн үйлчилгээг сайжруулах, 235 буюу 18 хувь нь төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай, 220 буюу 17 хувь нь гэр бүл, найз нөхөдтэй нь холбох ажлыг сайжруулах, 212 буюу 17 хувь нь суллагдсаны дараа ажилд зуучилж өгөх, 83 буюу 7 хувь нь хорих ангийн орчин нөхцөлийг сайжруулах гэж хариулсан.

Зураг 28. Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээрх хоригдлын гаргасан саналын нэгтгэл



Хоригдолд боловсрол олгож буй байдалд хийсэн шинжилгээ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны гүйцэтгэх үндсэн чиг үүрэгт хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэх, мэргэжлийн боловсрол, холбогдох сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох чиглэлээр санал боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг тусгасан байдаг. Харин шүүхээс оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх чиг үүрэг бүхий хорих анги нь хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох үйл ажиллагааг явуулах үүрэгтэйг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль³³-д тусгажээ.

Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ба хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана. Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна.


Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах

³³ Төрийн мэдээлэл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.№24

болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.


Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.

Зураг 29. Нийт сургалтад хамрагдсан хоригдлын тоо




Дээрх судалгаанаас харахад сургалтад хамрагдсан хоригдлын тоо их мэт боловч ихэнхи нь бясалгалд хамрагдсан буюу сэтгэл заслын үйлчилгээнд хамрагдсан байна.

Зураг 30. Үүнээс бясалгалд хамрагдсан хоригдлын тоо:



Зураг 31. Хорих ангид зохион байгуулагдсан сургалтын төрөл:




Эдгээр сургалтыг төрөл тус бүрээр нь авч үзвэл:

Хорих анги дахь ерөнхий боловсролын сургалт:


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлэн сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулахаар хуульчилжээ. Бүрэн дунд боловсрол олгох сургалтад 2012 онд-9, 2013 онд-30, 2014 онд-21, 2015 онд-21, 2016 онд-53, 2017 онд-72, 2018 онд-73, 2019 онд-156 хоригдол хамрагдсан байна.

Зураг 32. 2012-2020 оны хооронд бүрэн дунд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт



Бичиг үсгийн сургалтад 2012 онд-278, 2013 онд-223, 2014 онд-276, 2015 онд-287, 2016 онд-235, 2017 онд-214, 2018 онд-89, 2019 онд-91 хоригдол хамрагдсан байна.

Зураг 33. 2012-2020 оны хооронд бичиг үсгийн сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт




2019 оны эхний хагас жилийн байдлаар бичиг үсэг үл мэдэгч болон бага боловсролтой 468 хоригдол ял эдэлж байснаас Насан туршийн

боловсролын төв, Ажилчин залуучуудын ээлжийн сургуультай хамтран 117 хоригдолд ерөнхий боловсрол олгох сургалтад хамруулж, хорих ангийн нийгмийн ажилтнууд бусад байгууллагатай хамтарч 336 хоригдолд бичиг үсэг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан байна³⁴.

Хорих анги дахь мэргэжил эзэмшүүлэх сургалт:

Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулдаг. Мэргэжлийн дадлага олгох сургалтад 2012 онд-125, 2013 онд-409, 2014 онд-659, 2015 онд-1250, 2016 онд-595, 2017онд-783, 2018 онд-755, 2019 онд-590 хоригдол хамрагдсан байна.


Зураг 34. 2015-2020 оны хооронд мэргэжлийн дадлага олгох сургалтад хамрагдсан хоригдлын тоо:



2019 оны эхний хагас жилийн байдлаар мэргэжлийн боловсрол олгох сургалтын онолын сургалтад 177 суралцагч хамрагдаж амжилттай шалгагдсан 86.5 хувь буюу 153 суралцагчийг үйлдвэрлэлийн дадлагад шилжүүлэн хоёрдугаар ээлжийн мэргэжлийн боловсрол олгох онолын сургалтад хамрагдаж байгаа 160, нийт 313 суралцагчийг мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулж байна. Түүнчлэн аймаг, орон нутгийн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежтой хамтран 190 хоригдлыг мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулан ажиллажээ.

Зураг 35. 2019 оны эхний хагас жил мэргэжлийн дадлага олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт


³⁴ ХЯЭА-ны Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2019 оны тайлан



Хорих анги дахь дээд боловсрол олгох сургалт:

Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад суралцах хүсэлт гаргасан бол хорих ангийн даргын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга шийдвэрлэх ба сургалтыг хорих ангийн байранд явуулна. Дээд боловсрол олгох сургалтад 2012 онд-2, 2013 онд-5, 2014 онд-5, 2015 онд-6, 2016 онд-0, 2017 онд-0, 2018 онд-0, 2019 онд-0 хоригдол хамрагдсан байна³⁵.

Зураг 36. 2012-2020 оны хооронд дээд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт



2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шинээр орсон заалт нь хорих анги дахь албадан сургалтын тухай асуудал бөгөөд монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг

³⁵ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.,2019 он.86 дахь тал


эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулахаар заажээ.

Хоригдлын сурах идэвхи, санаачилгыг дэмжих, нөхцөл бололцоог хангах зорилгоор хоригдол чөлөөт цагт шашны зан үйл үйлдэх, хорих ангийн боломж нөхцөл, харуул хамгаалалтын нөхцөл, шаардлага, зэрэглэлд тохирсон спортын сонирхсон төрлөөр хичээллэх, ном, сонин унших, суралцах, хорих ангийн номын санг ашиглах боломжоор хорих анги хангана, хорих ял эдлэх хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хуваарилсан ажил, үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн, сургалт-хүмүүжлийн ажил болон нийгэмшүүлэх хөтөлбөрт идэвхтэй хамрагдсан, хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж байгаа байдал, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн дарга, алба хаагчаас эерэг үнэлгээ авсан тохиолдолд түүнд шагналын хоног олгоно, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж урамшуулал авч, хорих анги дахь сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцож байсан хоригдол Эрүүгийн хуульд заасан тэнсэн суллагдах хугацаанаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангид ял эдлүүлэх саналыг арга зүйн зөвлөлөөр хэлэлцэж, саналаа прокурорт, прокурор үндэслэлтэй гэж үзвэл шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ зэргээр хуульчилсан байна.

Сургалттай холбоотой асуулгын дүн:

- “Хорих ангид зохиогдож буй сургалтыг хэрхэн үнэлдэг вэ” гэсэн асуултад 899 буюу 70 хувь нь сайн, 309 буюу 24 хувь нь дунд зэрэг, 77 буюу 6 хувь нь муу гэж хариулсан.


Зураг 37. Сургалтад өгсөн үнэлгээ:



- “Та ямар төрлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна вэ” гэсэн асуултад 241 буюу 19 хувь нь боловсрол эзэмших, 372 буюу 29 хувь нь мэргэжил эзэмших, 156 буюу 12 хувь нь гадаад хэлний сургалтад хамрагдах, 157 буюу 12 хувь нь түргэвчилсэн сургалтаар нарийн мэргэжил эзэмших, 293 буюу 23 хувь нь мэдлэг боловсролоо дээшлүүлэх бүхий л


төрлийн сургалтад хамрагдах, 62 буюу 5 хувь нь ямар ч сургалтад хамрагдах хүсэлгүй гэж хариулсан.

Зураг 38. Сургалтын хэрэгцээний судалгаа:




-“Сургалтыг хэрхэн зохион байгуулвал зүйтэй гэж үзэж байна вэ” гэсэн асуултад 626 буюу 49 хувь нь хоригдлын өөрийн хүсэл, сонирхлыг харгалзан, 207 буюу 16 хувь нь хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэлээр, 449 буюу 35 хувь нь мэргэжлийн сургалтын байгууллагыг ашиглан сургалт зохион байгуулах нь зүйтэй гэж хариулсан.

Зураг 39. Сургалтын зохион байгуулалтын талаарх санал асуулгын дүн:




- “Таны бие даан сурч хөгжих хэрэгцээ хорих ангид хангагдсан уу” асуултад 647 буюу 51 хувь нь хангагдсан, 216 буюу 17 хувь нь хангагдаагүй, 356 буюу 28 хувь нь сайжруулах шаардлагатай, 56 буюу 4 хувь нь муу гэж хариулсан.

Зураг 40. Бие даан сурах хэрэгцээний судалгаа:



-“Хорих ангид мэргэжил, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээл” гэсэн асуултад 490 буюу 39 хувь нь хорих ангийн цагийн хувиартай зөрчилддөг, 73 буюу 6 хувь нь хорих ангиас дэмждэггүй, 491 буюу 39 хувь нь мэргэжлийн багш байхгүй, 197 буюу 16 хувь нь сургалтын орчин байхгүй гэж хариулсан.

Зураг 41. Сургалтад учирч буй бэрхшээлийн судалгаа:



ШШГЕГ-ын харьяа нийт 21 хорих ангид хоригдолд зориулсан сургалтын танхим, орчин, багтаамжийн талаарх судалгааг анги тус бүрээр гарган үзвэл, 6 хорих анги зориулалтын сургалтын танхимгүй, хоолны заал, бясалгалын өрөө, номын санд сургалтыг зохион байгуулж байна. Түүнчлэн сургалтын танхимтай хэдий ч дийлэнхи хорих ангиуд сургалт явуулах техник хэрэгсэл, сургалтын материал байхгүй байна.

Хүснэгт 5. Хорих ангиудын сургалтын танхимын багтаамжын судалгаа

Хорих анги	Жилд дунджаар ял эдэлдэг хоригдлын тоо	Сургалтын танхимтай эсэх	Танхимын багтаамж
401-р хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлэг	50-100	Танхимгүй	Номын санд 8-10 хүн багтах боломжтой.
405-р хаалттай хорих анги	70-100	Танхимгүй	Бясалгалын өрөөнд 4 хүн багтах боломжтой.
407-р нээлттэй, хаалттай хорих анги	250-300	Танхимтай	Зөвхөн нээлттэй хорих ангийн 2 дугаар танхимд 20-25 хүний багтаамжтай.
409-р хаалттай хорих анги	800-900	Танхимтай	Төв байранд сургалтын 90 хүний багтаамжтай нэгдсэн танхимтай.
СХТБ	40-80	Танхимтай	Сургалтын танхим-50 Шашны өрөөн-20 Зурагтын өрөөн-20 хүний багтаамжтай.

413-р нээлттэй, хаалттай хорих анги	350-400	Танхимтай	2 тасалгаа бүхий 60 хүний багтаамжтай 1 танхимтай.
415-р нээлттэй, хаалттай хорих анги	250-300	Танхимтай	Хаалттай-25, нээлттэй-25 хүний багтаамжтай 2 танхимтай.
417-р нээлттэй хорих анги	150-200	Танхимтай	1.Нийтийн байрны 100 хүний багтаамжтай 1 заал 2.Сургалтын байранд тус бүр 10 хүний багтаамжтай 9 танхимтай.
419-р нээлттэй хорих анги	200-300	Танхимтай	1.Тусгай зэрэглэлийн байрны 2 давхарт 90 хүний багтаамжтай 1 танхим 2. Тусгай зэрэглэлийн байрны 2 давхарт 20 хүний багтаамжтай номын сан
421-р нээлттэй хорих анги	250-350	Танхимгүй	Хоригдлын байрны 2-р давхарт 32 хүний багтаамжтай номын сантай.
423-р нээлттэй, хаалттай хорих анги	300-400	Танхимтай	1.20 хүний багтаамжтай видео сургалтын өрөө-1 2.20 хүний багтаамжтай бясалгалын өрөө-1 3.60 хүний багтаамжтай сургалтын танхим-1 4.150 хүний багтаамжтай Соёлын төв-1 5.20 хүний багтаамжтай номын сан-1
425-р нээлттэй хорих анги	200-250	Танхимтай	30 хүний багтаамжтай 1 танхимтай.
427-р нээлттэй, хаалттай хорих анги	300-400	Танхимтай	1.Хаалттай дэглэмд-50 хүний багтаамжтай 1 танхим 2.Нээлттэй дэглэмд-50 хүний багтаамжтай 1 танхим 3.Аж ахуйн үйлчилгээний хоригдлын байранд-16 хүний багтаамжтай-1 танхим 4.200 хүний багтаамжтай-Соёлын төв
429-р хаалттай хорих анги	100-200	Танхимтай	80 хүний багтаамжтай-1 танхим
433-р хаалттай хорих анги	100-200	Танхимтай	"Б" хэсэгт 50 хүний багтаамжтай-1 танхим
435-р хаалттай хорих анги	100-200	Танхимтай	1.30 хүний багтаамжтай сургалтын танхим

			2.Номын сан-25 хүний багтаамжтай
437-р нээлттэй хорих анги	100-200	Танхимтай	1.Номын сан-16 хүний багтаамжтай 2.Бясалгалын өрөө-40 хүний багтаамжтай 3.Видео дэлгэцийн өрөө-20 хүний багтаамжтай.
439-р хаалттай хорих анги	100-200	Танхимгүй	1.Хоригдлын 2 дугаар байранд-50 хүний багтаамжтай хоолны заал, 10 хүний багтаамжтай номын сан-1 2.Хоригдлын 3 дугаар байранд 50 хүний багтаамжтай хоолны заал, суллагдах хоригдолд зориулсан 10 хүний багтаамжтай өрөө-1, 40 хүний багтаамжтай номын сан-1 3. Хоригдлын 4 дүгээр байранд-50 хүний багтаамжтай хоолны заал, 10 хүний багтаамжтай номын сан-1
441-р нээлттэй хорих анги	100-200	Танхимгүй	Алба хаагчдын хурлын зааланд сургалт явуулдаг.
445-р нээлттэй хорих анги	100-200	Танхимтай	30 хүний багтаамжтай 1 танхимтай.
457-р нээлттэй хорих анги	100-200	Танхимгүй	25 хүний багтаамжтай 1 номын сантай.

2.3.Хорих байгууллагын нийгмийн ажилтан, түүний чиг үүрэгт хийсэн шинжилгээ

Нийгмийн ажлын аргачилсан зааварт зааснаар нийгмийн ажилтан гэж хорих байгууллагын нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагчийг ойлгоно гэжээ.

Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын үйл ажиллагааны бүтэц, чиг үүргийг судлан үзэхэд:

1.Хорих ял эдлүүлэх албаны нийгэм, сэтгэл зүйн хэлтэс:

1.хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.нийгмийн ажилтныг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах;

3.хоригдлын дунд явуулах сургалтын жишиг хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хяналт тавих;

4.хорих ангийн нийгэмшүүлэх ажил хариуцсан мэргэшсэн нэгжийн үйл ажиллагааг шалган зааварчлах;

5.хорих ангийн нийгэмшүүлэх ажил хариуцсан мэргэшсэн нэгжүүдийн тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийх;

6.төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

2. Хорих ангийн нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгж:

1.хорих ангийн дарга, дэд дарга мэргэшсэн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

2.мэргэшсэн нэгж нь хоригдлын нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хорих ангийн даргаар батлуулах;

3.нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас бүтэн жилээр, сургалтын үр дүнгийн талаарх тайланг, тоон судалгааг сар бүрийн 25-ны дотор хорих ангийн даргад танилцуулан, Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс нэгжид хүргүүлэх;

Мэргэшсэн нэгж нь хоригдлын дунд явуулах сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад тухайн жилд шаардагдах арга хэмжээний зардлын тооцоог гаргаж, хорих ангийн даргаар уламжлуулан шийдвэрлүүлнэ.

3.Нийгмийн ажилтан болон нийгмийн ахлах ажилтан гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 6.Хорих ангийн нийгмийн ажилтан болон ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолтод хийсэн харьцуулалт

Нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт:	Нийгмийн ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолт
--	---

Чиг үүрэг буюу ажлын байрны зорилго:	
<p>Хоригдлыг хорих анги, байгууллагад хүлээн авмагц нийгэмшүүлэх ажлын чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, суллагдан гараад нийгмийн харилцаанд ухамсартайгаар оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино.</p>	<p>Хорих анги, байгууллагын онцлогт тулгуурлан нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх замаар хоригдлыг нийгмийн ажлын үйлчилгээнд тасралтгүй хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах.</p>
Ажлын байранд тавигдах шаардлага:	
<p>Боловсрол:бакалавр-магистр Мэргэжил:нийгмийн ажилтан-эрх зүйч Мэргэшил: нийгмийн ажлын болон удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх Туршлага:нийгэм, сэтгэл зүйн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх /төрийн тусгай албанд 3-аас дээш жил ажилласан байх/</p>	<p>Боловсрол:бакалавр-магистр Мэргэжил:нийгмийн ажилтан-эрх зүйч Мэргэшил: нийгмийн ажлын болон удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх Туршлага:нийгэм, сэтгэл зүйн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх /төрийн тусгай албанд 3-аас дээш жил ажилласан байх/</p>
Ажлын байрны үндсэн зорилт:	
<p><i>1. Хорих анги, байгууллагын нийгэм, сэтгэл зүйн ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг холбогдох хуулийн заалт, журам, зааврын хүрээнд хэрэгжүүлж ажиллах.</i></p> <p>1.1.Хоригдлын нийгэмшүүлэх ажлын хүрээнд хийгдсэн судалгаанд үндэслэн 7 хоног, сар, улирал, жилийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх.</p> <p>1.2.Хоригдлын мэдээллийн санг бүрдүүлэхдээ ажиглалтын, шат дараалсан ярилцлага явуулах, хувийн баримт мэдээлэлд дүгнэлт хийх болон шинжлэх ухааны бусад аргыг ашиглан явуулах.</p> <p>1.3.Хоригдлын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх зүйн орчин болон амьдрах нөхцөлийн талаар таниулан ойлгуулах уулзалт, ярилцлага, бусад арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p><i>1.ШШГЕГ-аас явуулж буй нийгмийн ажлын үйлчилгээний талаархи бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, хоригдлыг нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, биелэлтэнд хяналт тавьж, үр дүнг тооцох.</i></p> <p>1.1.Хорих ангийн нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөний дагуу боловсруулсан нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн жилийн төлөвлөгөөнд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах.</p> <p>1.2.Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын өдөр тутам хэрэгжүүлж буй мэргэжлийн үйл ажиллагаа, хоригдлын дунд зохион явуулах сургалт, нөлөөлийн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, шалган зааварчлах, үр дүнг тооцох, шинэлэг бүтээлч ажлыг бусад анги, байгууллагад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>1.3.Хоригдлын хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлуудыг анги, байгууллагын</p>


	<p>ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.</p> <p>1.4.Хоригдлын дунд явуулах сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад тухайн жилд шаардагдах арга хэмжээний зардлын тооцоог гаргаж шийдвэрлүүлэх.</p>
<p><i>2.Хоригдлын бүртгэл, судалгаа, мэдээллийн сан, нэгдсэн цахим санг хөтлөх.</i></p> <p>2.1.Хоригдол нэг бүрийн хэрэгцээ, хувь хүний эерэг болон сул тал, зан харилцаан дахь бэрхшээлийг илрүүлэн үнэлгээ өгч, ганцаарчилсан болон бүлгээр ажиллах чиглэлийг тодорхойлох.</p> <p>2.2.Шинээр ирсэн хоригдлын мэдээллийн санг бүрдүүлж “Хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн систем”-д талбар орхигдуулахгүйгээр тухай бүр бүртгэх.</p> <p>2.3.Бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэх хүсэлтэй хоригдлын хүсэлтийг харгалзан төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучилж сургалтын хэрэглэгдэхүүний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>2.4.Хоригдлын гэр бүлийг хамарсан уулзалт, нээлттэй өдөрлөг, урлаг, спортын уралдан тэмцээн зохион байгуулах, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх.</p> <p>2.5.Хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийг тодорхойлон ангийн даргад танилцуулах</p>	<p><i>2.Хоригдлыг чадваржуулах чиглэлээр тэдгээрийн хэрэгцээнд тулгуурласан сургалт зохион байгуулах.</i></p> <p>2.1.Хоригдолд суурь боловсрол олгох болон амьдрах ухааны сургалтуудыг мэргэжлийн байгууллага, сургуультай хамтран зохион байгуулах.</p> <p>2.2.Мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадал олгох сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, хоригдол, хоригдогчид мэргэжил эзэмшүүлж, мэргэжлийн үнэмлэх буюу чадамжийн гэрчилгээг олгуулах.</p> <p>2.3.Хорих анги, байгууллагын үйлдвэрлэлийн чиглэл, онцлог нөхцөл байдлыг харгалзан сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих.</p> <p>2.4.Хоригдлоос сургалтын ажлын хэрэгцээ шаардлагын талаарх судалгаа, санал асуулгыг авч нэгтгэн, сургалтын ажлын төлөвлөгөөнд тусгах.</p>
<p><i>3.Хоригдлыг нийгмийн амьдралд бие даан оролцох оролцоог нэмэгдүүлэх, хөгжүүлэх чиглэлээр сургалт, нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах.</i></p> <p>3.1.Бичиг үсэг үл мэдэгч болон өсвөр насны хоригдлыг бичиг үсэг эзэмшүүлэх, суурь боловсрол заавал олгох бусад хоригдолд суурь боловсрол олгох болон амьдрах ухааны сургалтуудыг мэргэжлийн</p>	<p><i>3.Хоригдлын хөдөлмөрлөх, бие даан хөгжих, хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, нийгэм, эрх зүйн баталгааг хангах, ажлын хүрээнд төрийн, болон төрийн бус байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах хэрэгжилтэд хяналт тавих.</i></p> <p>3.1.Төрийн бус байгууллагатай хамтран хоригдлын ял эдлэх хугацаанд нь нийгэм, сэтгэл зүйн</p>

<p>байгууллага, сургууль, хувь хүнтэй хамтран зохион байгуулах.</p> <p>3.2.Мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадал олгох сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.</p> <p>3.3.Сургалтын хөтөлбөрийн дагуу хууль эрх зүйн сургалтыг үе шаттай зохион явуулах.</p> <p>3.4.Гэмт хэргийн хор уршгийг таниулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт, хөдөлмөрт хамрагдахын ач холбогдол, хуулиар олгогдсон эрх зүйн боломжийн талаар таниулан ойлгуулах уулзалт, ярилцлага, яриа таниулгыг хийх.</p>	<p>болон ахуйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хамтарсан сургалт зохион байгуулах.</p> <p>3.2.Хоригдлын гэр бүлийг хамтарсан уулзалт, нээлттэй өдөрлөг, урлаг, спортын уралдан тэмцээн зохион байгуулах.</p> <p>3.3.Суллагдсаны дараа хүлээн авах орчингүй хоригдлыг халамжийн үйл явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хоригдлыг хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэх газарт холбон зуучлах.</p>
<p><i>4.Хоригдлыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход нийгэм, сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэн зуучлах.</i></p> <p>4.1.Суллагдах хугацаа ойртож буй хоригдыг нийгмийн амьдралд гарахад бэлтгэхэд чиглэгдсэн төлөвлөгөө гарган ажиллаж, нийгмийн амьдралын болон цаг үеийн мэдээ мэдээллээр хангах зорилготой гарын авлага, нэвтрүүлэг зэргээр таниулах.</p> <p>4.2.Хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр нийгмийн үйлчилгээний холбогдох байгууллагатай хамтран нийгмийн харилцаанд оролцох боломжийг нээхэд чиглэгдсэн ажлыг хэрэгжүүлэн ажиллах.</p> <p>4.3.Суллагдсаны дараа хүлээн авах орчингүй хоригдлыг халамжийн үйл явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хоригдлыг хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэх газарт холбон зуучлах.</p>	


ХЗДХСайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн “ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив” баталсан тушаалын дагуу нийгмийн ажилтны орон тоо, нормативийг нээлттэй хорих ангид 60-70

хоригдол тутамд-1, хаалттай хорих ангид 50-60 хоригдол тутамд-1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 50-60 хоригдол тутамд-1, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад 60-70 хоригдол тутамд-1, цагдан хорих төвд 50-60 хоригдол тутамд-1, баривчлах төвд 100 хүн тутамд-1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэгт 60-70 хоригдол тутамд-1, согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт 60-70 өвчтөн тутамд-1 нийгмийн ажилтан байхаар тогтоож өгсөн байна.


Зураг 42. 2015-2020 оны хооронд хорих байгууллагад ажиллаж байсан нийгмийн ажилтны судалгаа



Зураг 43. Нийгмийн ажилтны хүйсийн судалгаа



Зураг 44. Мэргэжлийн нийгмийн ажилтны судалгаа




2020 оны 5 дугаар сарын 01-ны байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих байгууллагад нийгмийн ажилтан-52, сэтгэл зүйч-29 ажиллаж байна. Дээрх алба хаагчдыг бакалаврын боловсрол эзэмшсэн мэргэжлээр нь судлан үзвэл, нийгмийн ажилтны орон тоонд ажиллаж байгаа алба хаагчдаас: нийгмийн ажилтан мэргэжилтэй-15, эрх зүйч-36, эдийн засагч-1, сэтгэл зүйч орон тоонд ажиллаж байгаа алба хаагчдаас: сэтгэл зүйч-14, эрх зүйч-11, нийгмийн ажилтан-1, багш-3 байна.


Зураг 45. Нийгмийн ажилтнуудын мэргэжлийн судалгаа /2020.05.01/



Зураг 46 .Сэтгэл зүйчдийн мэргэжлийн судалгаа /2020.05.01/




Зураг 47. Нийгэмшүүлэх чиглэлээр хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын судалгаа:



Нийгмийн ажилтнуудаас авсан санал асуулгын дүн:

1. “Та хорих ангид явагдаж буй нийгэмшүүлэх ажлын үр дүнг хэрхэн үнэлдэг вэ” гэсэн асуултад 35 буюу 70% нь сайн, 15 буюу 30% нь дунд зэрэг, муу гэж хариулсан алба хаагч байхгүй байна.

Зураг 48. Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний судалгаа:




2. “Хорих ангид явагдаж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд юунд дээр анхаарвал зохистой гэж үздэг вэ” гэсэн асуултад 9 буюу 16% нь удирдлагын дэмжлэг, 19 буюу 34% нь эрх зүйн зохицуулалтын оновчтой байдал, 20 буюу 36% нь төсөв, хөрөнгийн дэмжлэг, 6 буюу 11% нь төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, 2 буюу 3% нь бусад зүйлд анхаарах шаардлагатай гэж хариулсан.

Зураг 49. Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээрх саналын судалгаа




3. “Та хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч албан тушаалд ажиллах дүр сонирхолтой юу” гэсэн асуултад 41 буюу 82% нь тийм, 1 буюу 2% нь үгүй, 8 буюу 16% нь албан тушаалаа өөрчлөх сонирхолтой гэж хариулсан.

Зураг 50. Нийгмийн ажилтны ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа




Нийгэмшүүлэх болон сэтгэл зүйн үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын талаар асуулгад мэдээллийн сан үүсгэх ажлыг зөвхөн цахимаар хийх /цахимаар болон цаасаар хийхэд цаг хугацаа их алдаж байна/ гэх саналыг 5, сургалт зохион байгуулахад төсөв хөрөнгө хангалтгүй гэх саналыг 8, ажлын ачаалал их байгаа тул орон тоог жишиг нормативт нийцүүлэх, жишиг нормативыг шинэчлэн тогтоох саналыг 14, гарын авлага, материал дутмаг байгаа тул нэмэгдүүлэх саналыг 3, алба хаагчдад дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйчийг томилох саналыг 1, сургалт зохион байгуулах мэргэшсэн багш дутагдалтай байна гэсэн саналыг 6, гадаад орнуудын сэтгэл зүйчийн ажилтай танилцах саналыг 1 алба хаагч гаргажээ.

Зураг 51. Нийгмийн ажилтны нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр гаргасан саналын судалгаа



Судалгаанд хамрагдсан хоригдлуудаас “Та хариуцсан нийгмийн ажилтныхаа үйл ажиллагаанд ямар дүн өгөх вэ” гэсэн асуултад 991 буюу 77% нь сайн, 234 буюу 18% нь дунд, 60 буюу 5% нь муу гэж хариулсан.

Зураг 52. Нийгмийн ажилтны үйл ажиллагаанд өгсөн хоригдлуудын үнэлгээ



ГУРАВ.ХОРИГДЛЫГ НИЙГЭМШҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ

3.1.Хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой Олон улсын баримт бичиг

Нэгдсэн Үндэстний байгууллагаас хорих ял эдлүүлэх нөхцөл, журмын талаар гишүүн улс орон бүрд хэрэгжүүлбэл зохих нийтлэг стандартыг тогтоож өгсөн байдаг. Эдгээр олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэснийхээ хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх нь НҮБ-ын гишүүн улс орнуудын нэг үүрэг бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10.2 дахь хэсэгт заасан “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэхтэй шууд холбогдож байгаа юм.

Хүний эрх, түүн дотроо хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулах /“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”³⁶, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”³⁷, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”³⁸ зэрэг түгээмэл баримт бичиг болон “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм”³⁹, “Хоригдолтой харьцах үндсэн зарчим”⁴⁰, “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүстэй холбогдуулан НҮБ-аас гаргасан журам”⁴¹/ зэрэг олон улсын эрх зүйн эх сурвалжийн хүрээнд дээр авч үзлээ.

Түүнчлэн Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц⁴², Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц⁴³, Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан

³⁶ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

³⁷ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200 A/XXI/ тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³⁸ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³⁹ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр их хурлаар баталж, эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 C/XXIY/,1977 оны 5 дугаар сарын 13-ны 2076 /LXII// тогтоолоор сайшаасан.

⁴⁰ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 тогтоолоор баталсан.

⁴¹ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 68 дугаар хуралдаанаар баталсан.

⁴² 1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж, 1932 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

⁴³ Ерөнхий ассемблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан.

тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим⁴⁴, Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглал⁴⁵, Хоригдсон буюу саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон харгис хэрцгийгээр хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах ба шийтгэхээс хамгаалахад эрүүлийг хамгаалахын ажилтнууд, тухайлбал, эмч нарын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмууд⁴⁶, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль⁴⁷, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд⁴⁸, Дэлхийн анагаах ухааны холбооны өлсгөлөн зарлагчдын талаарх Мальтын тунхаглал⁴⁹ зэргийг дурдахгүй өнгөрөөж болохгүй юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын холбогдох заалт:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын холбогдох заалт тухайлбал, хэнд ч эрүү шүүлт тулгах, эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй, хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, хүн бүр сурч боловсрох эрхтэй, наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино, анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой, техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой, хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй⁵⁰ зэрэг заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон байдаг билээ.

⁴⁴Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгсдэд харьцах асуудлаар 1990 оны 8 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын наймдугаар хурлаар баталсан.

⁴⁵ Ерөнхий ассемблейн 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 3452 /XXX/ дугаар тогтоолоор баталсан.

⁴⁶ Ерөнхий ассемблейн 1982 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 37/194 дугаар тогтоолоор баталсан.

⁴⁷ Ерөнхий ассемблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 34/169 дугаар тогтоолоор баталсан.

⁴⁸ Кубын Гавана хотод хуралдсан НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгсдэд харьцах асуудлаарх наймдугаар хурлаар 1990 оны 8 дугаар сарын 27-ны өдөр баталсан.

⁴⁹ 1991 оны 11-р сард Мальтийн Сен Жуленсд болсон дэлхийн анагаах ухааны 43-р хурлаар баталж, 1992 оны 9-р сард Испаний Марбеллед болсон 44-р их хурлаар хянан тохиолдуулж, 2006 оны 10-р сард Өмнөд Африкийн Пиланесбергт болсон 57-р их хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан.

⁵⁰ ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014. 6. дахь тал

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын холбогдох заалт:

Пактын хоёрдугаар зүйлд "Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болоод эрх мэдэлдээ байгаа бүх хүн энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг яс үндэс, арьс өнгө, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн хийгээд бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй"⁵¹ гэжээ. Пактад амьд явах, эрх чөлөөтэй байх, биед үл халдах, хууль ба шүүхийн өмнө тэгш эрхтэй байх, тайван замаар цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх хүний үндсэн эрх, эрх чөлөөг заажээ. Онцгой нөхцөлд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, эрх чөлөөг хамгаалахын тулд пактад заасан зарим эрхийг эдлэх явдалд хуулиар хязгаарлалт тогтоож болох бөгөөд амьдрах эрх, түүнчлэн ялгаварлан гадуурхах, тарчлаан зовоох, боолчлох, албадан хөдөлмөрлүүлэхээс хамгаалуулах эрхийг хөндөж үл болно.

Түүнчлэн пактад эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон дэглэмд байлгана.

Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана⁵² гэж заасан байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн холбогдох заалт:

Хүний эрхийн тухай Америкийн улсуудын конвенц /1969 он/, Хүний болон улс төрийн эрхийн тухай Африкийн Харти /1981 он/, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц /1950 он/, Хүний эрхийн тухай Арабын конвенц /1994 он одоо болтол хүчин төгөлдөр болоогүй/ зэрэг баримт бичгүүдэд эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцахыг хориглосон.⁵³

⁵¹ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон Улсын эрх зүй. УБ., 1999. 104 дэх тал

⁵² ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014. 12. дахь тал

⁵³ П.Оюунчимэг. Эрүү шүүлтийн эсрэг Олон улсын эрх зүйн эх сурвалж ба үндэсний илтгэлүүд, нэгдсэн үндэстний байгууллагаас өгсөн зөвлөмжүүд. УБ., 2015. 7 дахь тал

Конвенцийн гол ач холбогдол нь " эрүү шүүлт" гэж юу болохыг бүх талаас нь анх удаа томъёолон гаргаж, эрүү шүүлтийг улс орон бүр өөрийн эрүүгийн хуульдаа тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг тусгах, мөн эрүү шүүлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, тэдгээрт нөхөн төлбөр олгох талаар Засгийн газраас явуулах үйл ажиллагаануудыг тодорхойлон гаргаж өгсөнд оршино.

Конвенцийн заалт ёсоор "эрүүдэн шүүх гэж хэн нэгэн хүн буюу гуравдагч этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэх авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүргээ гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ" гэжээ.

Энэхүү конвенцийн заалтын нийтлэг агуулга нь хоригдогчтой хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглох талаар заасан байдаг.

Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн холбогдох заалт:

1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын Анхдугаар их хурлаас "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм"-ийг баталжээ. Энэ дүрэм НҮБ-ын Нийгэм-эдийн засгийн зөвлөлийн 1957, 1977 оны хурлын тогтоолуудаар сайшаагдсан юм. Энэ дүрмийн үндсэн зарчим нь нэгдүгээрт, хоригдлыг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, улс төрийн болон бусад үзэл бодол, гэр бүл, нийгмийн гарал, эд хөрөнгийн байдлаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй, хоёрдугаарт, хоригдлуудын шашны итгэл үнэмшил, зан суртахууны төлөвшилтөд хүндэтгэлтэй хандах явдал юм.

Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн 7.1-т тусгагдсан Хорих газар бүрт дугаарласан хуудастай хавтасласан дэвтрийн хэлбэртэй бүртгэл байвал зохих бөгөөд түүнд хоригдол бүрийн талаар дараах зүйлийг бичих ёстой.

а/ Хувийн байдалтай нь холбоотой мэдээлэл;

б/ Хоригдсон шалтгаан ба хорих шийдвэр гаргасан байгууллага;

в/ Хорих газарт ирсэн болон гарсан өдөр, цаг;

Хэнийг ч хүчин төгөлдөр хорих тогтоолгүйгээр шоронд хүлээн авах ёсгүй бөгөөд тогтоолын дэлгэрэнгүй утгыг бүртгэлд урьдчилан тусгана.

Төрлүүдэд хуваарилах:

Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс, нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй хэрхэн харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад эсхүл нэг хорих газрын өөр өөр хэсэгт байлгана. Ингэснээр:

а/ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг боломжийн хирээр тусдаа хорих газруудад байлгана. Хэрэв эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэд нэг хорих газарт байгаа бол эмэгтэйчүүдийг тусдаа өрөө тасалгаанд байрлуулбал зохино.

б/ Шүүхээр ял шийтгүүлээгүй хүмүүсийг ялтнуудаас тусад нь байлгана.

в/ Өөрийн үүргээ биелүүлээгүй буюу иргэний бусад хэрэгт холбогдон хоригдож байгаа хүмүүсийг эрүүгийн гэмт хэрэг үйлдэж хоригдож байгаа хүмүүсээс тусад нь байлгавал зохино.

г/ Эрх зүйн зөрчил үйлдсэн бага насны хүмүүсийг насанд хүрэгчдээс тусад нь хорино.

Хоригдлын ахуй нөхцөлийн талаар дүрэмд тусгагдсан:

1.Хоригдлын ашиглаж байгаа бүх өрөө тасалгаа, түүний дотор унтлагын өрөө нь ариун цэврийн бүх шаардлага хангасан байх ёстой бөгөөд тэгэхдээ цаг уурын нөхцөлд цаашаа эдгээр өрөөний хэмжээ, ноогдох талбай, гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалтыг онцгой анхаарвал зохино.

2.Хоригдлуудын амьдарч ажиллаж байгаа өрөө тасалгаанд:

а/Цонх нь байгалийн гэрэлд уншиж, ажиллаж болох хангалттай хэмжээтэй, агааржуулалтын хиймэл системтэй эсэхээс үл хамааран цэвэр агаар орохоор хийгдсэн байвал зохино.

б/Хиймэл гэрэлтүүлэг нь хоригдлын хараанд аюулгүй, уншиж, ажиллаж болохоор хангалттай байвал зохино.

3.Ариун цэврийн төхөөрөмжүүд нь хоригдол бүр шаардлагатай үедээ, цэвэр, тохиромжтой нөхцөлд өөрийн байгалийн хэрэгцээгээ хангаж болохоор хангалттай байвал зохино.

4.Усанд орох төхөөрөмж, шүршүүрийн тоо нь хоригдол бүр тухайн цаг агаарын нөхцөлд тохирох халуун усанд жилийн улирал, газар зүйн байршлыг харгалзан ариун цэврийн ерөнхий шаардлагад нийцэх, усанд орж болохоор өөрөөр хэлбэл ердийн цаг агаарын нөхцөлд ядахдаа 7 хоногт 1 удаа халуун усанд орох боломжтой байх ёстой.

5.Хоригдолд өөрийгөө цэвэр авч явахыг шаардах ёстой. Үүний тулд тэднийг ус болон ариун цэвэр, эрүүл мэндэд нь тодорхой шаардагдах ариун цэврийн хэрэгслээр хангах хэрэгтэй.

6.Хоригдол нь гадаад төрхөө хүний алдар хүндэд нийцэхгүйгээр хадгалж байхын тулд тэдэнд өөрийн сахал үсээ засч янзлахад санаа тавих, эрчүүдэд сахлаа байнга хусах боломж олгох хэрэгтэй.

7.Энгийн хувцас өмсөх эрхгүй хоригдол тухайн цаг агаарт тохирсон, эрүүл мэндээ хэвийн байлгах боломжтой иж бүрэн хувцас тавьж олгох нь зүйтэй. Энэ хувцас нь гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй.

8. Хувцас нь цэвэр бүрэн бүтэн байх ёстой. Ариун цэврийн шаардлагыг хангахуйцаар угаасан дотуур хувцас тавьж олгож байвал зохино.

9.Шоронгийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдол бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалагдах хангалттай тэжээллэг, сайн чанарын сайтар бэлтгэж өгсөн хоол, ундаар хангах ёстой.

10.Хоригдол бүр хэрэгцээтэй үедээ уух ундны устай байх ёстой.

11.Мэргэжлийн эмчилгээ шаардлагатай өвчтөн хоригдлыг тусгай, эсхүл ердийн эмнэлэгт хэвтүүлбэл зохино. Шоронгийн эмнэлгүүд өвчтөнийг зохих ёсоор сувилах эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмтэй байхаас гадна эмнэлгийн хангалттай мэргэшсэн ажилтнуудтай байвал зохино⁵⁴ зэрэг заалтууд нь Монгол Улсын Хорих ял эдлүүлэх ажиллагаанд тусгагдсан байна.

Хоригдолтой харьцах үндсэн зарчмын холбогдох заалт:

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын14-ний өдрийн 45/111 дүгээр тогтоолоор энэхүү зарчмын баталсан ба агуулга нь:

1. Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцаж байна.

2. Яс, үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон өөр бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гарал язгуур болон бусад байдлаар хэрхэвч ч ялгаварлан гадуурхаж болохгүй.

3. Түүнчлэн орон нутгийн нөхцөл байдал шаардагдаж байвал тухайн бүлэгт хоригдлуудын шашны итгэл үнэмшил, соёлын зан заншлыг хүндэтгэх хэрэгтэй.

4. Хорих газрууд нь нийгмийн бүх гишүүдийн сайн сайхан байдал, хөгжилд дөхөм үзүүлэх үндсэн үүрэг, нийгмийн бусад үүргийн сахин хамгаалах явдалтай нийцэж байх ёстой.

5. Хоригдлууд хорих газар байгаагаас үүдэж гарсан шаардлагатай хязгаарлалтаас бусад Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тухайн улс оролцогч болсон тохиолдолд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, энэ пактын нэмэлт протокол зэрэгт заасан хүний эрх, эрх чөлөөг, түүнчлэн НҮБ-ын бусад пактад дурдсан эрх, эрх чөлөөг эдэлнэ.

6. Бүх хоригдол бие хүнийг бүх талаар хөгжүүлэхэд чиглэсэн соёл, боловсролын үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

⁵⁴ ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014. 80-82. дахь тал

7. Ял шийтгэлийн журмаар ганцаарчлан хорих явдлыг хүчингүй болгох буюу түүнийг хязгаарлах хүчин чармайлт гаргаж түүнийг хөхүүлэн дэмжиж байвал зохино.

8. Хоригдлуудад өөрийн орны хөдөлмөрийн талбарт эргэн ажиллахад нь хялбар байх өөртөө болон гэр бүлдээ санхүүгийн тусламж үзүүлэх боломж олгох цалин хөлстэй ажил хийх нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай.

9. Хоригдлууд эрх зүйн байдлаасаа үл шалтгаалан, тухайн оронд байдаг эмнэлгийн тусламж авах ёстой.

10. Хорих ял эдэлсэн хүмүүс олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо, тусламжтайгаар, хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцөлийг бий болговол зохино.

11. Дээр дурдсан зарчмуудыг алагчлалгүйгээр хэрэглэх ёстой.⁵⁵

Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан журмын холбогдох заалт:

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1990 оны 12-р сарын 14-ний өдөр “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалах журам”-ыг батлан гаргасан. Энэхүү журам нь хорих ял эдэлж байгаа насанд хүрээгүй ялтныг ямар нөхцөлд байлгах, тэдний эрхийг хэрхэн хамгаалах талаар Нэгдсэн үндэстний байгууллагаас баталсан олон улсын жишиг шалгуур юм.

Энэхүү журмын дагуу насанд хүрээгүй ялтныг хорих ял эдлүүлэхдээ дараах үндсэн шаардлага тавигддаг. Үүнд:

Хорих газарт насанд хүрээгүй ялтныг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх журмыг нарийвчлан тогтоосон. Тухайлбал: тэдэнд хорих газрын дотоод дэг журмыг зохицуулдаг дүрэм, тавих анхаарал халамж, сахилгын шаардлага, мэдээлэл олж авах ба гомдол гаргах, бусад зөвшөөрөгдсөн арга, түүнчлэн хорих газарт байх үеийн эрх үүргийг бүрэн хэмжээгээр ойлгох боломжийг олгохуйц зайлшгүй чухал бусад асуудлыг заавал тайлбарлаж өгсөн байна.

Түүнчлэн насанд хүрээгүй ялтныг ангилах ба хуваарилах нарийн журмыг тогтоосон. Тухайлбал: уг журмын 28-р зүйлд: “Насанд хүрээгүй ялтныг гагцхүү түүний нас, хувийн онцлог шинж, хүйс, эрх зүйн зөрчлийн төрөл, сэтгэцийн болон бие махбодын байдлын хортой нөлөөлөл ба аюултай нөхцөл байдалд оруулахаас дээд зэргээр хамгаалагдсан

⁵⁵ ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014. 88. дахь тал

тэдгээрийн онцгой хэрэгцээ, эрх зүйн байдал, онцлог шаардлагыг бүрэн харгалзсан нөхцөлд байлгах ёстой. Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй ялтныг хуваарилах үндсэн шалгуур нь янз бүрийн хэрэгтнийг бие махбод, сэтгэл зүй, ёс суртахууны төлөвшил, сайн сайхан байдлыг хамгаалах явдлыг хангах, зарим тодорхой этгээдийн онцлог эрэлт хэрэгцээнд дээд зэргээр нийцсэн тийм төрлийн анхаарал халамжаар хангахад орших ёстой”⁵⁶ зэрэг өргөн агуулгаар заажээ.

НҮБ-аас гаргасан эрх зүйн баримт бичгийн агуулгыг хүлээн зөвшөөрч нэгдсэн орнуудын хувьд тухайн баримт бичгээр тогтоосон нийтлэг байдал, зарчмуудыг үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөх шаардлага тавигддаг байна.

⁵⁶ А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012. 320 дахь тал

3.2.Гадаадын зарим оронд хоригдлыг нийгэмшүүлж буй байдалд хийсэн шинжилгээ

3.2.1.Оросын Холбооны Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

Орос оронд хоригдлын тухайд зөвхөн залхаан цээрлүүлэх бодлого явагддаг, хүмүүжүүлэх болон нийгмийн шинж чанартай арга хэмжээ хэрэггүй гэсэн үзэл бодол олон нийгмийн дунд удаан хугацаанд амь бөхтэй байжээ. Гэвч хоригдлуудад хүнлэг хандахыг эзэн хаан II-р Екатерины зарлигаар тунхаглаж байсан бөгөөд ял шийтгэлийн тухай шинэ хуулийн төсөл байгуулах комиссыг байгуулан, хуулийн 248 дугаар зүйлд "хэрэгжүүлэхэд нэн төвөгтэй хэдий ч хүмүүсийг /ялтнуудыг/ хамгийн сайн найдвартай өөрчлөх хэрэгсэл бол төгс хүмүүжлийг хэрэгжүүлэх асуудал юм" гэсэн байна.

XVIII-р зуунд тус улсын хорих байгууллагын үйл ажиллагааны зорилго нь зөвхөн хашраах цээрлүүлэхээр үл хязгаарлан гэмтнийг засан хүмүүжүүлэх, эрх тэгш хүн болгон нийгэмд буцаахад оршиж байжээ. Хорих байгууллагын нийгмийн ажлыг үүсгэн байгуулсан дараагийн шат нь I-р Александрын хаанчлалын үетэй холбоотой. Эзэн хааны ивээл дор түүний зөвшөөрснөөр хорих анги /шорон/-ийн асран тэтгэх нийгэмлэг гэж байгуулсан бөгөөд түүний зорилго нь гэмт хэрэгтнүүдийг ёс суртахууны хувьд засан хүмүүжүүлэхэд оршиж байв. Энэ зорилгоор ялтнуудыг үйлдсэн гэмт хэргийн төрөл болон оногдуулсан ялаар нь ангилан хуваарилж тэдний загалмайтны ариун шударга ёс, ёс суртахууны зөв номлолоор хүмүүжүүлэх, зөв үйлийг гүйцэтгэхийг шаардан, гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хүнлэг хандахыг тунхаглаж байжээ. Энэхүү нийгэмлэгийг үүсгэн буй болгосноор шоронгийн ахуйд дараах зүйл нэвтэрсэн байна, тухайлбал мужийн шоронгийн хороодын гишүүдэд шорон болон тэнд байгаа хүмүүсийн байгаа байдалтай газар дээр нь танилцахыг зөвшөөрсөн, шоронд хоригдож байгаа хүмүүсийн дунд зохион байгуулж буй үйл ажиллагаанд шашны санваартнуудыг татан оролцуулах болсон, номын санг үүсгэн байгуулсан, ингэхдээ зонхилон шашны сэдэвтэй ном зохиолоор фондоо бүрдүүлж байжээ.

Ялтнуудын дунд явуулах нийгмийн ажлын суурийг тавихад 1866 оны 7 дугаар сарын 4-нд гарсан хууль чухал үүрэгтэй. Уг хуулийн дагуу баривчилсан хүн бүрт оногдох талбайн хэмжээг тогтоосон нас, хүйс болон нийгмийн байдлыг харгалзан байрлуулах байрны тухайд ялгаатай хандан, хувцас, цагаан хэрэгслээр болон хоол хүнс захын хэрэгцээг хангах, тэднээс амьд мэнд гарахад төрийн анхаарал тусгалаа олжээ.

ОХУ-ын эрүүгийн хууль тогтоомжид зааснаар хорих ял нь хугацааны хувьд хоёр сараас хорин жил хүртэл байхаар хуульчилсан байдаг.⁵⁷ ОХУ-ын эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар эрүүгийн ялын зорилго болон ял эдлүүлэх ажиллагаа түүнийг зохицуулж буй хууль тогтоомжийн зорилгыг харилцан уялдаа холбоотой, нэгдмэл нэг ойлголт болгон авч үзсэн байдаг. “Хэрэв ялын зорилго болон эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн зорилгыг харьцуулж үзвэл бүхэлдээ утга санаа давхцаж байна. Энэ тохиолдолд эрүүгийн хууль тогтоомжийн үндсэн ойлголтууд нь эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн зорилготой харилцан уялдаа холбоо бүхий нэгдсэн ойлголт юм”⁵⁸. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар “Эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн зорилго нь ялтан болон бусад этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ялтныг засан хүмүүжүүлэх явдал юм”⁵⁹, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 43 дугаар зүйлд “Ялыг нийгэмд шударга ёсыг сэргээн тогтоох, ялтныг засан хүмүүжүүлэх болон дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ”⁶⁰ гэж тус тус заажээ.

Эндээс авч үзвэл ОХУ-ын хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь ялтныг засан хүмүүжүүлэх, болон тэдгээрийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хэмээн тодорхойлсон бөгөөд энэхүү зорилгын агуулгаас улбаалан хорих ял эдлүүлэх байгууллагын төрөл, үйл ажиллагааны чиглэлийг хууль тогтоомждоо заасан байна. Өөрөөр хэлбэл хуулийн үзэл санаа нь ял эдлүүлэх ажиллагааны гол агуулгыг гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх буюу ялтныг тодорхой арга хэлбэрийг ашиглан хуулийг сахин биелүүлдэг, нийгмийн харилцаанд оролцохдоо бусдын эрх ашгийг дээдлэн хүндэтгэдэг зөв иргэн болгон төлөвшүүлэхэд чиглүүлдэг хэмээн үзэж болох юм.

ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 9 дүгээр зүйлд засан хүмүүжүүлэх ажил гэдгийг “...ялтныг хүн, нийгэм, хөдөлмөр, хүн төрөлхтний аж төрөх ёсны хэм хэмжээ, зан заншил, журмыг хүндэтгэсэн харилцаанд оруулах, хууль сахин биелүүлэх зан үйлийг дэмжин урамшуулах ажиллагааны бүрдэл”, засан хүмүүжүүлэх ажлын арга, хэлбэрийг “...ял эдлүүлэх дэглэм журмыг тогтоох, хүмүүжлийн ажил,

⁵⁷ Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовный кодекс. Москва 2014 г., с.26.

⁵⁸ МГУ им. М.В.Ломоносова “Уголовно-исполнительное право России” Москва 2013 г., с.46

⁵⁹ Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовно-исполнительный кодекс. Москва 2007 г., с.3

⁶⁰ Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовный кодекс. Москва 2014 г., с.20

нийгэмд тустай хөдөлмөр, ерөнхий боловсрол олгох, мэргэжлийн сургалт, нийгмийн нөлөөлөл үзүүлэх"⁶¹ гэж тодорхойлсон байна.

Ял шийтгэгдсэн хүнийг гэмт зан үйлээс татгалзуулах, хөдөлмөр болон сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг тухайн хүнийг хүмүүжүүлэхэд чиглүүлдэг байна.

ОХУ-ын хууль тогтоомжоор засан хүмүүжүүлэх байгууллагын төрлийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд: засан хүмүүжүүлэх газар /исправительные колонии/, хүмүүжлийн хорих газар /воспитательные колонии/, гяндан /тюрьма/, эмчилгээний засан хүмүүжүүлэх газар /лечебные исправительные учреждения/-ыг хамааруулан заажээ.

Үүнээс засан хүмүүжүүлэх газар /исправительные колонии/ насанд хүрсэн ялтны эрхийг хязгаарладаг бөгөөд суурин хэлбэрээр хорих газар /колония поселения/, жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения общего режима/, чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения строгого режима/, онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения особого режима/ хэмээн хуваагддаг байна.

Харин цагдан хорих байр нь засан хүмүүжүүлэх газрын чиг үүргийг хэрэгжүүлдэг хэд хэдэн тохиолдол байдаг ба энэ нь аж ахуй, үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болохыг хүлээх, өөр хорих газарт шилжүүлэх үед, 6 сараас ихгүй хугацаагаар ял шийтгэгдсэн ялтныг өөрийн зөвшөөрсөнөөр цагдан хорих байранд байлгах хуулийн зохицуулалтай байдаг.

Суурин хэлбэрээр хорих газар /колония поселения/-т болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, санаатай гэмт хэрэг үйлдэж хөнгөн ба хүндэвтэр гэмтэл учруулсан, жирийн болон чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх газраас хуульд заасан ялын зохих хувийг эдэлсэний дараа дэглэм хөнгөрүүлсэн ялтны ялыг, жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения общего режима/-т гяндан, онцгой, чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх газарт ял эдлэхээр шийтгэгдсэнээс бусад эрэгтэй, эмэгтэй ялтны ялыг, чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения строгого режима/-т анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, онц аюултай гэмт хэрэгтэн болон, урьд нь хорих ял шийтгэгдэж байсан ялтны ялыг, онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения особого режима/-т онц аюултай гэмт хэрэг давтан үйлдсэн, бүх насаараа хорих ял шийтгэгдсэн, хорих ял эдлүүлэх дэглэм журмыг

⁶¹ Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовно-исполнительный кодекс. Москва 2007 г., с.5

ноцтой зөрчсөнөөс бусад засан хүмүүжүүлэх газраас шилжин ирсэн ялтны ялыг тус тус эдлүүлдэг байна.

Харин гяндан /тюрьма/-д онц хүнд гэмт хэрэг үйлдэж 5-аас дээш жилийн хорих ял шийтгэгдсэн, онц аюултай гэмт хэрэг давтан үйлдсэн, хорих ял эдлүүлэх дэглэм журмыг ноцтой зөрчсөнөөс бусад засан хүмүүжүүлэх газраас шилжин ирсэн ялтны ялыг эдлүүлдэг.

Дээрх хорих газруудаас гадна ОХУ-ын ял эдлүүлэх тогтолцоонд байдаг бас нэг хэлбэр нь эмчилгээний засан хүмүүжүүлэх газар /лечебные исправительные учреждения/ бөгөөд энэ газарт мансуурах, согтуурах донтой, ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, бусад эмчилгээ шаардлагатай ялтныг байлгаж ял эдлүүлдэг. Эцэст нь хүмүүжлийн хорих газар /воспитательные колонии/-т насанд хүрээгүй болон 19 нас хүртэл уг газарт үлдсэн ялтны ялыг эдлүүлдэг.

2019 оны жилийн эцсийн байдлаар ОХУ-д засан хүмүүжүүлэх 707 колони, орон нутгийн 123 колони, бүх насаар хорих ялаар шийтгэгдсэн засан хүмүүжүүлэх 7 колони, насанд хүрээгүй хоригдлын сурган хүмүүжүүлэх 23 колони, 8 хорих анги, нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар засан хүмүүжүүлэх ангид 463.444 хоригдол, цагдан хорих байранд 99.722 хоригдогч нийт 563.166 хоригдол ял эдэлж байна. 2018 оны мөн үеийнхтэй харьцуулахад 39.010 хүнээр нэмэгдсэн байна.

Түүнчлэн нийт хорих байгууллагын ачаалал тогтоосон ачааллаас 20-40 хувиар давсан, эрүүгийн сөрөг нэр нөлөө бүхий этгээдүүдийн үйл ажиллагаанаас үүдэлтэй аюул заналхийлэл өссөн, эрүүгийн ял эдлүүлэх албаны бүтэц, тогтолцоог чанаржуулах нийгэм, эдийн засгийн шаардлага бий болсон байдаг. Тиймээс ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албанаас Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулан ОХУ-ын Засгийн газрын 10 дугаар сарын 14-ны өдрийн 1772 дугаар тогтоолоор батлуулан ажиллажээ. Өөрөөр хэлбэл тухайн үеийн ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй хүндрэл, Европын улс орнуудын жишиг туршлагыг нэвтрүүлэх, эрүүгийн ялын үр нөлөөг дээшлүүлэх, ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааг чанаржуулах үүднээс хөгжлийн шинэ чиг хандлага бүхий зорилтот хөтөлбөр боловсруулан үр дүнд хүрч ажилласан байна.

Энэхүү үзэл баримтлалын үндсэн зорилго нь ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, засан хүмүүжүүлэх газарт нийгэм сэтгэлзүйн ажлыг шинэ шатанд гаргах, шоронгийн дараах нийгэмд дасан зохицох тогтолцоог хөгжүүлэх замаар рецидив гэмт хэргийг бууруулах,

хорих орчныг хүмүүнжүүлэх буюу нийгэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэх явдал юм хэмээн тодорхойлсон байдаг.⁶²

Дээрх зорилгын хүрээнд эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог хөгжүүлэх үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Эрүүгийн ял эдлүүлэх бодлогыг боловсронгуй болгох.

Энэ чиглэлийн хүрээнд ОХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны бүтцийг өөрчлөх, хорих ял эдлүүлэх шинэ төрөл бий болгоход чиглүүлэх, ялтныг нийгэмшүүлэх буюу засан хүмүүжүүлэх шинэ арга хэрэгслийг нэвтрүүлэх, зөв үйл буюу нийгэмшсэн үйлдлийг урамшуулах тогтолцоог баяжуулах, ар гэртэйгээ харилцах боломжийг нэмэгдүүлэх, урьд ял эдэлж байсан болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн гишүүдийг тусад нь ял эдлүүлэх нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ. Түүнчлэн цахим хяналтын хэрэгслийг ашиглан ялтныг хорих газар бус илүү нээлттэй суурин хэлбэрийн газарт ял эдлүүлж зан үйлийн өөрчлөлтөнд орохоос урьдчилан сэргийлэх ажлыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр заасан байна.

2. Хорих ял эдлүүлэх байгууллагын тогтолцоог өөрчлөн байгуулах, түүний зохион байгуулалт, бүтцийн байгууламжийг өөрчлөх.

Энэ чиглэлийн хүрээнд засан хүмүүжүүлэх газруудын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, насанд хүрээгүй хүүхдийг хорих газрыг хүмүүжлийн төв болгон өөрчлөх, зан үйлийн сөрөг өөрчлөлттэй, сэтгэцийн өвчтэй ялтныг тусгаарлан хорих, Европын шоронгийн журамд нийцүүлэн гяндан болон суурин хэлбэрийн хорих газрын загварыг шинээр боловсруулах гэх мэт арга хэмжээнүүд багтжээ.

3. Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх, инновацийн боловсруулалт, шинжлэх ухааны чадавхийг ашиглах.

Энэ чиглэлийн хүрээнд албаны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож хууль сахиулах бусад байгууллагатай холбогдох, мэдээллийн сан бий болгохын зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ял эдлүүлэх, цагдан хорих ажиллагаанд цахим дэд бүтцийг бий болгох, ялтан, хоригдогч цахим шуудан болон бусад үйлчилгээ ашиглах боломж олгох, эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны хөгжлийг дэмжих шинжлэх ухааны төв, лабораториудыг бий болгох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

⁶² Концепция развития уголовно-исполнительной системы до 2020 года. Правительство Российской Федерации. Распоряжение от 14 октября 2010 г. № 1772-р Москва

4. Ялтан болон цагдан хоригдож буй этгээдтэй харьцах олон улсын стандартыг хангах чиглэлийн хүрээнд хорих буюу эрх чөлөө хязгаарлах нөхцөл, журмын талаар дараах үндсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

-Дэглэм болон аюулгүй байдлыг хангах чиглэлээр хорих орчин нөхцлийг хорих газрын төрөл тус бүрээр шинэчлэн тогтоох, хорих газрын объектын хяналт хамгаалалтад инженер техникийн шинэ технологи нэвтрүүлэх, хяналтын цахим тогтолцооны тусламжтайгаар ялтны зан үйлд мониторинг хийх, ялтныг тээвэрлэх автомашин, галт тэргийн хөдөлгөөнд мониторинг хийх, хиймэл дагуулын хяналт бий болгох, орчин үеийн шинэ техник хэрэгсэлээр тоноглох, ажилтнуудыг бэлтгэх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, алба хаах нөхцлийг сайжруулах зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

-Ялтны болон цагдан хоригдож буй материаллаг ахуй нөхцлийн чиглэлээр Европын стандартад тохирсон нөхцөл бүхий цагдан хорих байруудыг шинээр ашиглалтанд оруулах, хүнсний шинэ хангамжийн тогтолцоо бий болгохын зэрэгцээ өөрөө өөрийгөө хангах, хэмнэлт бүхий үнийн хараат бус нөхцлийг бүрдүүлэх, амьдрах талбайн нормативыг нэмэгдүүлэх, бараа ажил үйлчилгээ худалдан авах цахим худалдааг ашиглаж эхлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

-Эмнэлгийн үйлчилгээний чиглэлээр хорих газарт эмнэлгийн үнэ төлбөргүй тусламжийн баталгаат хэмжээг хангах, эмнэлгийн хангамжийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, ариун цэвэр, халдвар судлал, бактерлогийн лабораторийн сүлжээг хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, орчин үеийн аргыг нэвтрүүлэх ажиллагааг шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, хорих газраас суллагдсан халдварт өвчин бүхий хүний эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлыг уламжлал, залгамж чанарыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ.

-Түүнчлэн ялтны хөдөлмөрлөх үйл ажиллагаа, мэргэжлийн бэлтгэлийн чиглэлээр дэглэмийн бүхий л нөхцөлд хөдөлмөрлөх нөхцлийг хангах, ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, суурин хэлбэрийн хорих газар байгуулахад арилжааны байгууллагыг татан оролцуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ялтны хөдөлмөрийн хөлсний тогтолцоог оновчтой болгох, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагыг урьдчилан тодорхойлох, мэргэжлийн болон анхан шатны боловсрол олгох тогтолцоог хөгжүүлж, ялтны заавал

эзэмшвэл зохих боловсролыг олгох мэргэжлийн анхан шатны байгууллага байгуулах гэх мэт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

-Ялтны дунд зохиох нийгэм, сэтгэл зүй, хүмүүжлийн ажлын чиглэлээр ялтны хувийн зан байдал, хохирол төлөлт зэргийг харгалзан ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх, тэнсэн суллах тогтолцоог сэргээх, соёл, спорт, урлагын болон сургалтын арга хэмжээнд татан оролцуулах, энэ арга хэмжээнд олон нийтийн байгууллага, зүтгэлтнүүдийг оролцуулах, урамшууллын болон сахилгын шийтгэлийн оновчтой тогтолцоо бий болгох, хөдөлмөрт болон мэргэжлийн сургалтанд өргөнөөр хамруулах, ялтныг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицоход чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн ажлыг хөгжүүлэх, шашны уламжлалт зан үйлийг чиглэлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, номын сан, сэтгэл заслын орчныг бүрдүүлэх, сургалтын бүхий л хэлбэрийг ажиглан ялтны оюун ухааны хөгжлийн түвшинг дээшлүүлэх болон бусад олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

-Ялтны суллагдсаны дараах нийгэмд дасан зохицох явдлыг хангаж, давтан гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр удаан хугацааны хорих ял эдлээд дуусаж байгаа этгээдэд нийгмийн өөрчлөлтийн тухай бүхий л мэдээллийг багтаасан тусгай дасгалжилт, хөтөлбөр боловсруулан хамруулах, амьдрах орчинтойгоо танилцах боломж олгосон суурин хэлбэрийн хорих газарт шилжүүлэх, ялтныг нийгмийн амьдралд дасгах албаар /probation/ дамжуулан зохих нөхцлийг бүрдүүлэх зэрэг эерэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тогтсон байдаг.⁶³

Энэхүү хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх алба нь 2010 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд хорих орчин нөхцлийг Европ стандартад нийцүүлэх ажлын хүрээнд хорих газруудыг шинэчлэх, шинээр цагдан хорих байруудыг барьж ашиглалтанд оруулах, ялтныг нийгэмшүүлэх ажлыг шинэ түвшинд гаргах ажлыг тасралтгүй зохион байгуулж байгаа талаар албан ёсны мэдээллийн хэрэгслээрээ дамжуулан мэдээлсээр байна.

Ял эдлүүлэх ажиллагааг хүн, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэх зорилгоор ялтныг нийгэмшүүлэх талаар явуулж буй дэлхийн бусад орнуудын жишиг бодлогын дагуу ОХУ-нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны гол цөм болох ялтныг нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд дасан зохицоход бэлтгэх, хорих орчин нөхцөл, үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг ашиглах талаар цаг үеэ олсон

⁶³ Концепция развития уголовно-исполнительной системы до 2020 года. Правительство Российской Федерации. Распоряжение от 14 октября 2010 г. № 1772-р Москва

хөгжлийн үзэл баримтлал боловсруулж, улмаар бодлого, эрх зүйн зохицуулалт, тогтолцооны өөрчлөлтийн талаар тодорхой үр дүнтэй ажиллаж байгаа нь ял эдлэгсэдтэй холбоотой тоон үзүүлэлтээс харагдаж байна.

Оросын Холбооны Улсын ял эдлүүлэх байгууллагын харьяа хорих ангид ял эдэлж буй хоригдлуудыг нийгэмшүүлэх, сэтгэл зүйн байдлыг хангахад хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, сургалт, семинарыг судлаж манай улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн байдалд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд туслах арга замыг бий болгож байна⁶⁴.

ОХУ-н хорих байгууллага нь хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэсэн дараах ажлыг зохион байгуулж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн чиглэлээр:

- Хоригдлын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах болон ял эдлээд суллагдсан этгээдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх;

- Хоригдлын ял эдэлж байгаа дэглэмээс хамааруулан нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэх ганцаарчилсан сургалт, зөвлөмжийг сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

- Орон нутгийн болон мужийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран засан хүмүүжүүлэх ангиудад яаралтай хэрэгцээтэй эм нийлүүлэх болон тоног төхөөрөмжөөр тусламж үзүүлэх;

- Сэтгэцийн эрүүл мэндийн төвтэй хамтран хар тамхи болон мансууруулах төрлийн эм бэлдмэл хэрэглэдэг хоригдлуудад тусгай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хамтарсан сургалт, семинарыг зохион байгуулах;

- Орон нутгийн болон мужийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран төрөл бүрийн халдварт өвчин эмгэгийн талаар урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулдаг.

2. Нийгмийн хангамж, үйлчилгээний чиглэлээр:

- Төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нийгмийн халамжийн байгууллагуудтай хамтран хоригдлыг засан хүмүүжүүлэх колоноос суллагдахад нийгмийн хангамжийг сайжруулах, эд хөрөнгийн туслалцааг үзүүлэх;

- Сайн дурын байгууллагуудын буцалтгүй тусламжыг хоригдолд олгох;

⁶⁴ Х.Цэрэнтогтох. ШШГЕГ. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, чиг хандлага. ЭШХ. ОХУ ба Монгол Улсын хорих байгууллагад ял эдлэгсдийг нийгэмшүүлж буй байдал

- Тэтгэврийн болон хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд нийгмийн халамжийн байгууллагатай хамтран халамж олгох;

- Засан хүмүүжүүлэх ангиас суллагдсан хоригдлын эрх, эрх чөлөөнд халдаж болзошгүй мэдээ, мэдээлэл нийгмийн сошиал сүлжээнд тарахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

- Хоригдлын гэр бүл, төрөл садныг хайх үйл ажиллагааг зохион байгуулж, нийгэм, сэтгэл зүйн хамтарсан ярилцлагыг хоригдлын гэр бүлтэй зохион байгуулж, тусламж дэмжлэг үзүүлдэг.

3.Хөдөлмөр, ажил зуучлалын төвтэй хамтран дараах арга хэмжээг зохион байгуулдаг. Үүнд:

- Хөдөлмөр, ажил зуучлалын төвтэй хамтран дугуй ширээний уулзалтыг “Худалдааны төвүүд дээрхи хөдөлмөр эрхлэлтийн байдал”, “Хэрхэн өөрийн хөдөлмөрийн үйл ажиллагааг зохион байгуулах вэ?”, “Чамайг ажилд авахад юу хэрэгтэй вэ?” сэдвүүдээр зохион байгуулах;

- Мэдлэг, боловсрол олгох хичээлийг засан хүмүүжүүлэх ангид зохион байгуулах;

- Хөдөлмөр, ажил зуучлалын төвөөс ял эдэлж суллагдсан этгээдэд хөдөлмөрлөх эрх зүйн таатай нөхцөлийг санал болгуулах.

4.Урлаг, соёл, спортын чиглэлээр:

- Хоригдлын урлаг, спортын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, идэвхитэй оролцуулах, бие даасан уран бүтээл, тайлан тоглолтонд засан хүмүүжүүлэх колонийн зүгээс санхүү хөрөнгийн тусламж үзүүлэх;

- Засан хүмүүжүүлэх ангид төвлөрсөн нэгдсэн номын сантай байж, сар бүр номын өдөрлөгийг зохион байгуулдаг.

5.Хууль, эрх зүйн чиглэлээр:

- Засан хүмүүжүүлэх хорих ангид ял эдэлж хоригдолд холбоотой батлагдсан хууль, эрх зүйн баримт бичиг, тогтоомж, захирамжийг танилцуулах

- Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, ял эдлүүлэх тухай хууль, бусад хууль, тогтоомжийг нийт хоригдолд нарт ойлгогдох хэмжээнд сургалт, семинар, зөвлөмжийг олгодог⁶⁵.

ОХУ-ын хувьд хоригдолд боловсрол олгох асуудалд онцгой анхаардаг бөгөөд тус улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд: “Тус улсын иргэн бүр боловсрол эзэмших эрхтэй”⁶⁶ гэж заасан нь хорих байгууллагад ял эдэлж буй ялтанд нэгэн адил үйлчилж байна. Учир нь тус улсын ялын бодлогын

⁶⁵ ОХУ-ын Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий даргын тушаал № 73, 264 тоот

⁶⁶“Конституция Российской Федерации” (принята всенародным голосованием 12.12.1993) (от 21.07.2014 N 11-ФКЗ).

тулгуур зарчмын нэг бол ялтныг засан хүмүүжүүлэх замаар, эргэн нийгэмшүүлэхэд орших бөгөөд хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь боловсрол олгоход чиглэдэг.

Энэ зорилгоор тус улсын хорих байгууллагын харьяа сургууль байгуулж, хорих ялаар шийтгүүлсэн ялтанд зохих мэргэжил, боловсрол олгодог. Энэ төрлийн анхны сургуулийг 1860 онд "Москвагийн Төлөвшүүлэн гэгээрүүлэх, Ажил хөдөлмөр эрхлүүлэх байр"-ыг байгуулсан бөгөөд тус сургуулийн сургалтын хөтөлбөр нь гол төлөв шашны сургааль номлолд суурилан ухуулан сэнхрүүлэх замаар тэдний зан үйл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэж байв. 1920 оноос эхлэн уг чиг хандлага өөрчлөгдөж, улмаар шоронд бичиг үсэг тайлагдаагүй 50 хүртлэх насны ялтанд зориулсан сургууль байгуулах нь зүйтэй гэсэн шийдэлд хүрч, энэ талаар анхны журам боловсруулж, мөрдсөн байна.

1958 онд уг журмыг "ЗХУ-ын ДХЯ-ны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын харьяа Ерөнхий боловсролын сургуулийн ажиллах журам" болгон өөрчилсөн. Энэхүү журмаар ялтан бүр шоронд хоригдож байх хугацаандаа бүрэн дунд боловсрол эзэмших эрхээр хангагджээ. Харин 1980 оны дунд үеэс ЗСБНХУ-ын бүх засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид ерөнхий боловсролын дунд сургуулийг байгуулсан байна.

Өнөөдөр тус улсын "Боловсролын тухай хууль"-д хорих байгууллагын зүгээс эрх чөлөөгөө хасуулах буюу хорих ялаар шийтгүүлсэн ялтанд зохих түвшний боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах талаар тусгасан⁶⁷ (тус хуулийн 80 дугаар зүйл). Тус хуулиар хорих газар ял эдэлж буй 30 хүртлэх насны ангилалд багтах ялтанд анхан ба бүрэн дунд шатны ерөнхий боловсрол, харин 30 дээш насны болон тахир дутуугийн I, II групптэй ялтанд тэдгээрийн санал, хүсэлтийг үндэслэн тус тус эзэмшүүлэхээр зохицуулсан⁶⁸. Бүх насаараа хорих ялаар шийтгүүлсэн ялтны хувьд бие даан суралцах хэлбэрээр боловсрол эзэмших боломж нөхцлийг бүрдүүлжээ.

Ерөнхий боловсролоос гадна хорих байгууллагын зүгээс, ямар нэгэн мэргэжил эзэмшээгүй ялтанд мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр шат шатны сургалтыг зохион байгуулж, төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх олгох ажлыг зохион байгуулна. Тус улсын хуулиар хорих байгууллагад ял эдэлж буй ялтанд мэргэжлийн дунд болон дээд боловсролыг эчнээ ба зайны сургалт хэлбэрээр эзэмшүүлэхийг зөвшөөрсөн.

⁶⁷ Федеральный закон "Об образовании в Российской Федерации" от 29.12.2012 N 273-ФЗ.

⁶⁸ "Уголовно-исполнительный кодекс Российской Федерации" от 08.01.1997 N 1-ФЗ.

Хорих ялаар шийтгүүлсэн ялтны боловсрол болон мэргэжил эзэмших эрхийг хангах зорилгоор засан хүмүүжүүлэх колони тус улсын Хууль зүйн яамтай зөвшилцсөний үндсэн дээр ОХУ-ын гүйцэтгэх засаглалын байгууллагын санаачлагаар оройн сургууль, сургалтын талаар зөвлөгөө өгөх цэг зэргийг байгуулан ажиллаж байна. Гэхдээ тухайн засан хүмүүжүүлэх колониос 80-аас доошгүй ялтан суралцах боломжтой тохиолдолд эдгээр сургууль болон цэгийг байгуулна.

2018 оны жилийн эцсийн статистик мэдээгээр тус улсын засан хүмүүжүүлэх колоний харьяа боловсролын байгууллагад ойролцоогоор 60000 гаруй ялтан суралцсанаас 64 хувь нь 5-9 дүгээр анги, 29 хувь нь 10 дугаар анги, 7 хувь нь анхан шатны буюу бага ангид суралцсан байна.

Хорих байгууллагын харьяа үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагын багш, ажилтныг гол төлөв тухайн салбарт алба хааж байсан офицер, ахлагч болон ажилтан нараас сонгон авдаг байна.

ОХУ-д хорих ялаар шийтгүүлсэн ялтан дараах их сургуульд сурч мэргэжлийн дээд боловсрол эзэмших боломжтой. Үүнд:

- Псковын улсын их сургууль;
- Тверийн хөдөө аж ахуйн академи;
- ОХУ-ын нийгмийн ухааны их сургууль;
- Москвагийн физик-инженерийн институт;
- Москвагийн нийгмийн их сургууль;
- Владивостокийн эдийн засаг, нийтийн ахуйн үйлчилгээний их сургууль;
- Уралын нийгмийн боловсролын их сургууль;
- Донын улсын их сургууль;
- Челябинскийн улсын их сургууль;
- Амурын улсын их сургууль;
- Дорнод Европын Олон улсын их сургууль;
- Саратовын нийгэм, эдийн засгийн их сургууль;
- ОХУ-ын санхүү, эдийн засгийн институт;
- "Их сургуулиудын нээлттэй олон улсын бүлэг" ТББ;
- "Боловсрол болон бие бялдрын хөгжлийг зохицуулах төв" байгууллага; Организация "Центр координации образования и физического развития";
- Бусад.

Үүнээс гадна АНУ-ын New York University, ОХУ-ын Балтийн сургалтын төв, Хүмүүнлэгийн академи зэрэг олон улсын болон үндэсний сургалт, мэргэжлийн байгууллагуудтай чиглэлд хамтран ажилладаг⁶⁹.

Хорих ялаар шийтгүүлсэн ялтны хувьд ял эдэлж буй байгууллагын оршин байгаа болон хамтран ажилладаг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгох мэргэжил байхгүй тохиолдолд, Холбооны ял эдлүүлэх ерөнхий газарт албан ёсны хүсэлт гарган өөр их, дээд сургуульд төлбөртэйгээр суралцах эрхтэй.

Тус улсын Холбооны ял эдлүүлэх ерөнхий газар эдгээр сургалтын байгууллагатай гэрээ байгуулсаны үндсэн дээр хорих ялаар шийтгүүлсэн ялтныг сургаж, төгсгөгчдөд мэргэжлийн дээд боловсролын гэрчилгээ олгодог байна.

3.2.2.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг БНХАУ-ын хуулийн дагуу тодорхой хугацаагаар, эсвэл насан туршид нь хорих ялаар, мөн хоёр жилээр ял хойшлуулан цаазаар авах ял шийтгэнэ. 2016 оны байдлаар БНХАУ-д нийт 674 хорих анги байгаагийн 37 нь эмэгтэйчүүдийн, 31 нь насанд хүрээгүй хүүхдийн, бусад нь эрэгтэйчүүдийнх байна.

БНХАУ-ын хорих ангид “Шийтгэл, шинэчлэл хоёрыг хослуулж гэмт хэрэгтэнд засрал олгоно” гэсэн зарчим үйлчилж, хорих ангийн дотоод зохион байгуулалтыг сайжруулах, хууль хэрэгжүүлэхдээ шударга байж хорих ангийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад бүхий л үйл ажиллагаа чиглэдэг. Гол анхаарал хандуулдаг асуудал бол гэмт хэрэгтнийг нийгэмшүүлж, тэднийг нийгэмд эргэн ороход бэлтгэхэд хүчин чармайлт гаргах явдал юм. Үүнд:

-Хоригдлын ёс суртахуун, эрх зүй, соёл, техник, хөдөлмөрийн боловсролыг бэхжүүлэх;

-Хоригдолд чиглэсэн засан сайжруулах үйл ажиллагааны болон боловсрол олгох арга зүйгээ идэвхтэй шинэчлэх;

-Хоригдлын эрүүл мэндийн болон хувь хүний боловсролыг сайжруулах;

-Хоригдлын мэргэшүүлэх сургалт болон суллагдах үеийн сэтгэл зүйн бэлтгэл зэрэгт илүү анхааран ажилладаг.

Сүүлийн жилүүдэд 16590.000 хоригдогчид албадан сургалтад хамрагдаж бичиг үсэг тайлагдсан, 158.000 хоригдогчид бага сургууль

⁶⁹Строева Г. В.Интеллектуально-этическое развитие личности осужденного //Педагогический журнал- 2012-№1-С.129–153.

төгсөж албан ёсны гэрчилгээтэй болсон бол 2.380.000 хоригдогчид мэргэжлийн үр чадварын гэрчилгээ олгосон байна. Хууль сахиулах үйл ажиллагаандаа хэнийг ч алагчлан үзэхгүйгээр, эрүүгийн ял эдлүүлэхдээ хуулийг чанд сахин ажиллахад хорих байгууллагын үнэ цэнэ оршино. Иймээс, хорихоос өөр төрлийн буюу хорих ангиас гадуур ял эдлэх болон ялтнуудыг хугацаанаас өмнө суллахтай холбоотой үйл ажиллагаанд бодит шинэчлэл хийн, хоригдогчдын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хүндэтгэн ажиллах, ирээдүйд олон нийтийн болон хорих байгууллагын хамтын үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Удирдпага, зохион байгуулалтыг сайжруулснаар бүхий л хорих ангийн дотоод бүтэц, үйл ажиллагаа шинэчлэгдэж чадсан. Энэ сайжруулалтын хүрээнд:

1.Хорих анги дахь удирдлагаас явуулж буй үйл ажиллагааг ерөнхий шалгуур болгож бүх хорих ангиудын удирдлагын түвшинг тогтоон, тэдгээрийн мэдлэгийг улам дээшлүүлсэн.

2.Бүхий л хүмүүжлийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулдаг болсон.

3.Хорих ангиудад ял эдлэгсдийг стандартад нийцсэн, шинжлэх ухаанаар батлагдсан орчинд хорих болсон.

Харуул хамгаалалт, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьснаараа хорих ангийн ажиллагааг аюулгүй, тогтвортой байлгаж чаддаг. Хорих ангид ажиллаж байх хугацаандаа алба хаагч бүр өөрийн ажлын байрны аюулгүй байдлыг хангаж ажиллахыг шаарддаг бөгөөд хорих анги бүр үйл ажиллагаагаа аюулгүй, тогтвортой байлгах зорилгоор техник тоног төхөөрөмж болон хяналтын системдээ сайжруулалт хийсэн. Үүний үр дүнд хорих ангиудын аюулгүй, тогтвортой байдал сайжирч, сүүлийн жилүүдэд нэг ч ялтан хорих ангиас оргоогүй.

Хорих байгууллагын бүтэц, зохион байгуулалтад илүү анхааран ажилладаг ба хоригдогчдод шударга зан төлөв эзэмшүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн тусгай сургалтын хөтөлбөр бүхий шинэ төрлийн хорих ангиудыг байгуулж чадсан. Мөн ихэнх хорих ангиуд хорих ангийн барилгын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх шаардлага байгаа гэсэн саналын дагуу өөрчлөлт хийн, техник, тоног төхөөрөмжүүдийг хамтад нь шинэчлэн мэдээллийн технологийн өргөн хэрэглээг дэмжин ажиллах болсон нь үр дүнгээ өгсөн байна.

Хорих ангийн алба хаагчийн хамтын хөгжилд анхаарал хандуулан, тэднийг албан үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээгээр чадвар, чадамжийг нь сайжруулах сургалтад хамруулан ажиллаж, тусгай мэргэжлийн хорих ангийн цагдаагийн офицеруудыг бэлтгэсэн. Үүнээс гадна албан хаагчдад

зориулсан удирдлагын шатнаас холбогдох арга хэмжээ авсны нэг нь хорих ангид ажилладаг цагдаагийн офицеруудыг эрүүл мэндийн хөнгөлөлттэй эмчилгээнд хамруулдаг болсон явдал юм.

БНХАУ-ын хорих ангийн хөгжил, шинэчлэлийн зэрэгцээгээр дараахь асуудал тулгарч байна.

-Эрүүгийн хууль тогтоомжийн бодлого, зохицуулалт шинэчлэгдэхийн хэрээр эрүүгийн гэмт хэрэгтнүүд нь улам бүр ухаалаг болж, хүчирхийлэл улам бүр залуу насныхан дунд тархаж байна. Эдгээр өөрчлөлттэй холбоотойгоор тэдний аюулгүй байдлыг хангахад илүү хүндрэлтэй болж байна.

-Хоригдогчийн сэтгэл зүйн эмчилгээний нөхцөл, механизм, арга зүйг сайжруулж, тэднийг нийгэмшүүлэх үйл ажиллагааг дэмжсэн боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах хэрэгцээтэй байна.

-Хорих ангид ажилладаг цагдаагийн офицеруудын эрх зүйн байдлыг дээшлүүлж, тэдний мэргэжлийн баталгааг сайжруулах хэрэгтэй байна гэж тэмдэглэсэн байна⁷⁰.

3.2.3.Америкèí Нэгдсэн Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

Америкийн нэгдсэн улсад хорих ялыг:

а/ холбооны

б/ мужийн

в/ орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад эдлүүлдэг байна.

Америкийн нэгдсэн улсын орчин цагийн шоронгийн аюулгүй байдал, харуул хамгаалалт нь үндсэн гурван зэрэглэлд хуваагддаг байна.

1.Дээд зэргийн харуул хамгаалалтай шорон: Энэ зэрэглэлийн шоронгууд нь гадуураа 18-25 фут /6-8 метр/ өндөртэй хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ажиглалтын цамхагууд дээр зэвсэглэсэн харуултай байдаг ба хоригдол байрлуулах том барилгуудтай, хоригдлууд нь тус тусын өрөөтэй байдаг байна. Ихэнх дээд зэрэглэлийн хамгаалалттай шорон 1925 оноос өмнө баригдсан байдаг ба дийлэнх гэмт хэрэгтнүүд энэ шоронд хоригдож байжээ. Тэдний олонх нь үүнээс доогуур дэглэмтэй шоронд хоригдох ёстой хүмүүс байжээ. Сүүлийн үед энэ төрлийн хуучирсан шоронг удирдаж ажиллуулахад өртөг өндөртэй, шоронгийн дотоод нөхцлийн талаар албан хаагчдын гомдол гаргах зэрэг асуудал гардаг болжээ

2.Дунд зэргийн харуул хамгаалалтай шорон. Энэ зэрэглэлд хамаарах шоронгууд нь дээгүүрээ өргөст торон хамгаалалт бүхий хоёр давхар

⁷⁰ М.Алтан-Очир.Хорих ял эдлүүлэх дэглэм.УБ.,2020 он.104-105 дахь тал

хашаагаар хүрээлэгдсэн байдаг. Байшин барилгын хувьд янз бүр, 150 шахам ганцаарчлан хорих өрөөнүүдтэй барилга, нийтийн барилга, жижигхэн тасалгаа бүхий том заал зэрэг байшинтай байдаг.

3.Сул харуул хамгаалалттай шорон. Энэ зэрэглэлийн шорон нь хашаагаар хүрээлэгдсэн, зэвсэглэсэн харуулын постгүй, дохиолол, камерын тусламжтайгаар хашаан доторх орчноо хянаж байдаг. Шоронгийн бас нэг төрөл байдаг нь /open prison/ буюу задгай шорон юм. Задгай шоронгууд нь хүрээлэн байгаа орчноо аюулгүй байдлаа хангах хэрэгсэл болгон ашигладаг байна⁷¹.

АНУ-ын хорих байгууллага нэг талаас Хууль зүйн сайд, нөгөө талаас тухайн оршин буй нутаг дэвсгэрийн засаг захиргаанд давхар харъяалагддаг.

АНУ-д нийгмийн ажилтан сэжигтнийг урьдчилан хорих байгууллагад байхад нь ажиллаж эхлэх бөгөөд шүүхийн даалгавраар тухайн хүний талаар болон ойр дотных нь хүмүүсийн тухай лавлагаа бэлтгэж шүүх хуралд танилцуулна. Энэ мэдээлэл шүүх хурлын явцад болон тухайн ялтантай цаашид ажиллахад хэрэгтэй зүйл болдог.

Хорих байгууллага дахь нийгмийн ажлын зорилго нь ялтан бодит байдлыг сайтар ойлгож хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэхэд оршино. Үүний тулд ялтантай үр ашигтай агуулга бүхий харилцаа тогтоож зөв оношлон ажиллах бэлтгэл хийх хэрэгтэй.

Хорих анги доторх төрөл бүрийн гаж үзэгдлээс ялтныг сэргийлэх, шаардлагатай үед түүнд туслах үүргийг нийгмийн ажилтан гүйцэтгэнэ. Чөлөөт амьдралд өөрөөр аж төрөх хэвшилд суралцуулахад чухалчлан анхаарна. Мөн ялтны гэр бүлтэй ажиллах, гэр бүлийн нь нэг хүнийг баривчлахаас үүдэх сэтгэл зүй, нийгмийн болон эдийн засгийн уршгийг гэтлэхэд тэдэнд туслахад нийгмийн ажилтан чухал үүрэгтэй байдаг.

АНУ-ын хорих байгууллагад гэмт хэргийг бууруулахад чиглэсэн олон хөтөлбөр байдаг бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтан шууд оролцоотой. Ялтныг ирэнгүүт бусад ажилтны хамт хүн тус бүрээр судалж нэг бүрчлэн ажиллах хөтөлбөр боловсруулдаг. Тухайлбал:

1. Сэтгэл зүйн боловсруулалт хийх. Шийтгэгдсэн ялаа үндэслэлгүй гэх буюу үүнээс хөнгөн ял авах байсан гэж үзэх, эсхүл ялын хугацаа богиноос бусад хөтөлбөрт оролцох хугацаа хүрэлцэхгүй хүмүүс.

2. Эрчимжүлсэн буюу удаан хугацааны. Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, давтан гэмт хэрэгтэн, мансуурагчид.

3. Дамжлагын. Суллагдахад 9 сар үлдээд байгаа.

⁷¹ Sue titi reid. Criminal justice. 1996.p.335

4. Өргөтгөсөн. Оюуны хомсдолтой хүмүүстэй ажиллах.

Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээс гадна ялтныг суллах тодорхойлолтыг нийгмийн ажилтнууд гаргадаг бөгөөд суллагдсан хүмүүс дараа нь мөн тэдний хяналтад нэг хэсэгтэй байдаг.

АНУ-д сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжлүүлэх шийтгэлийн хэлбэр нэлээд түгээмэл болж байгаа бөгөөд үүнд нийгмийн ажилтны оролцоо чухал байна.

АНУ-ын хорих байгууллагын тогтолцоон дахь нийгмийн ажилтнууд дараах үүрэгтэй. Үүнд:

- Тухайн мужийн оршин суугчдад эрүүгийн эрх зүйн салбарт тохиолдож буй асуудлыг танилцуулж байх

- Ялтнуудын талаарх нийгмийн сэтгэлгээг өөрчлөхөд дэм үзүүлэх буюу тэднийг жирийн иргэдийн адил хүлээн авахыг нийгэмд дасгах.

- Гэмт хэргийн золиос, гэрч болсон хүмүүстэй зохиох хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцох зэрэг болно.

АНУ-ын хувьд нийгмийн ажилтан шүүхэд ч, хорих байгууллагад ч, мөн туршилтын хугацаанд ч байнга оролцоотой байгаа нь тухайн ялтны засрал хүмүүжилд хяналттай, тасралтгүй нөлөөлөх, хорихын өмнөх болон суллагдсаны дараа ч гэсэн хараа хяналттай байлгадаг туршлагатай.

3.2.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

ХБНГУ нь хөгжлийн түвшин, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн, техник технологийн хөгжил зэргээрээ дэлхийд тэргүүлэх улсуудын нэг бөгөөд эрх зүйн баялаг түүхэн уламжлалтай улс юм. ХБНГУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтанд 1975 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хууль, 1976 онд батлагдсан хорих ял эдлүүлэх болон хүмүүжил, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай хуулиуд тус тус хамаарагдана.

ХБНГУ-ын хорих байгууллага нь тухайн муж улсынхаа Хууль зүйн яаманд харьяалагддаг бөгөөд өөрсдийн мужын онцлогт тохирсон хорих ял эдлүүлэх хууль, тогтоомжтой ажээ. Тус улсад хорих ялыг хугацаатай ба хугацаагүй гэж ангилдаг бөгөөд хугацаатай хорих ял нь 1 сараас 15 жил байдаг бол хугацаагүй бүх насаар нь хорих ялыг эрүүгийн хуульд заасан 14 тохиолдолд оногдуулдаг байна. Бүх насаараа хорих ял шийтгүүлсэн этгээд 15 жилээс доошгүй хугацаагаар хорих ял эдэлсэн тохиолдолд шүүх

тухайн үед бий болсон нөхцөл байдлыг харгалзан хорих ялыг нь хугацаатай болгож болно⁷².

ХБНГУ-ын Хорих ял эдлүүлэх болон хүмүүжил, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай хууль нь хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн гол эх сурвалж бөгөөд уг хууль нь 202 зүйлтэй, 1976 онд батлагдаж 2009 онд нэмэлт өөрчлөлт орсон.

Уг хуулийн 2-р зүйлд “Хорих ял эдлүүлэх нь ялтныг цаашид гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн хариуцлагыг ухамсарлуулах, эрх чөлөөт амьдралд нь эргэн ороход туслах зорилготой” гэж хорих ялын зорилгыг тодорхойлсон байна. Мөн 3-р зүйлд “гэм буруугийн үр дагавар нь эрх чөлөөг нь хязгаарлах сөрөг ар хэмжээгээр илэрхийлэгдэх ба хорих ял эдлэх хугацаанд ялтны амьдралыг аль болох нийгмийн нийтлэг байдалтай тэнцэтгэх ёстой гэж заажээ.

ХБНГУ-д хорих ял эдлэгсдийн дэглэмийг шүүхээс шууд тогтоодоггүй байна. Шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон хоригдлыг нээлттэй эсхүл хаалттай хорих ангид ял эдлүүлэх эсэхийг тухайн мужын дамжин өнгөрүүлэх хорих ангид тодорхой шалгууруудыг үндэслэн шийдвэрлэнэ. Хаалттай хорих ангид олон жилийн ялтай, бүх насаараа хорих ял шийтгүүлсэн болон хүнд, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эсвэл тодорхой мэргэжил эзэмших шаардлагатай хоригдлыг харуул хамгаалалтын чанга хяналтан дор ял эдлүүлдэг.

Мэргэжлийн чиг баримжаагүй, зохих мэргэжил эзэмшихэд бүрэн дунд боловсролын мэдлэг хангалттай биш тохиолдолд тухайн хоригдлын санал хүсэлтийг нь харгалзан, тодорхой шалгуурын үндсэн дээр мэргэжил эзэмшүүлэх зорилгоор хаалттай хорих ангид шилжүүлдэг. Хаалттай хорих ангид ялынхаа 2/3-ыг эдэлсэн, зөрчил гаргаагүй хоригдлыг хорих ангийн холбогдох албан хаагчдын тодорхойлолтыг үндэслэн суллагдахад нь бэлтгэх зорилгоор нээлттэй хорих анги руу шилжүүлж, хоригдлыг нийгэмшүүлэх, чөлөөт амьдралд дасгах, бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулна. Гэвч 2 жилээс дээш хугацаагаар хоригдох ял шийтгүүлсэн ялтныг нээлттэй дэглэмд эдлүүлэхийг хориглодог байна.

Хорих ял шийтгүүлэн шинээр ирж буй ялтан нэг бүрт хорих ял эдлүүлэх төлөвлөгөөг гаргадаг бөгөөд энэ нь манай ялтны хувийн хэрэг хөтлөх тухай ойлголтой нэг талаар төстэй. Хорих ял эдлүүлэх төлөвлөгөөнд дараах зүйлс орно. Үүнд:

-Хорих ангид ирсэн он, сар, өдөр;

⁷² Г.Эрхэмбаяр. Магистрын дипломын ажил. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. УБ., 2012. 35 дахь тал

- Ирсэн хорих ангийн харьяалал;
- Гэр бүл болон найз нөхдийн талаарх мэдээлэл;
- Өмнө ял эдэлж байхдаа зөрчил гаргаж байсан эсэх;
- Авъяас чадвар /дэвшил гаргасан эсэх/;
- Эмнэлэгт хэвтэж байсан эсэх;
- Эмчилгээнд хамрагдсан эсэх / хар тамхи, архины эсрэг/;
- Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг;
- Чөлөөгөөр явуулах нөхцөл, хугацаа.

-Ял эдлүүлэх төлөвлөгөөг хэлэлцсэний дараа шийдвэрийн хуулбарыг тухайн хоригдолд 1 хувь өгч танилцуулах ба хоригдол нь ялын төлөвлөгөөнд заагдсан заалтыг дагаж мөрдөх ёстой болно.⁷³

Хаалттай хорих ангиас нээлттэй хорих анги уруу ялтныг шилжүүлэхдээ тухайн хорих ангийн даргын дэргэдэх уг асуудлыг хариуцсан комиссын шийдвэр гаргах ба комиссын шийдвэрийг хууль зүйн яамнаас хянадаг. Хаалттай хорих ангиас нээлттэй хорих анги уруу шилжүүлэх хоригдлын ялын үлдсэн хугацаа нь 2 жилээс илүүгүй байх ёстой. Учир нь нээлттэй хорих ангид үүнээс илүү хугацаанд хоригдвол байнга эрх чөлөө харагдаж, сэтгэл зүйн тогтворгүй байдалд орох магадлалтай байдгаас гадна тухайн хоригдол гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд уг шийдвэрийг гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариулага өндөр байдагтай холбоотой.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, байнга оршин суух хаягтай, гэмт хэрэг үйлдээд оргон зайлаагүй зэрэг хуульд заасан тодорхой үндэслэлээр шүүгч хоригдлыг нээлттэй хорих анги уруу явуулах шийдвэр гаргаж болдог.

Хаалттай хорих ангид ял эдлүүлэх нөхцөл журмын талаар

Нээлттэй хорих ангид хоригдохоос бусад ялтнууд хаалттай хорих ангид ял эдлэх бөгөөд хаалттай хорих анги нь камерийн системтэй. Нэг камерт 2-6 хүн хоригдох бөгөөд хуульд зааснаар нэг хүнд ногдох хорих өрөөний талбайн хэмжээ 5 м², 00-ийн өрөө нь тусдаа байх ёстой, 2-оор болон олноор оруулах зориулалттай өрөөний 00 нь ханаар тусгаарлагдсан байх ёстой. Анх удаа хоригдохоор ирсэн хоригдлыг 2-оор нь хорих өрөөнд оруулдаг нь хорихын нөхцөл байдал, орчинд дасгах, ганцаардах, амиа хорлох аюулаас урьдчилан сэргийлэх зорилготой ажээ. Онц ноцтой гэмт хэрэгтнүүд болон аюулгүй байдлын үүднээс хорих өрөөнд ялтныг нэгээр нь хорьж болно. Шинээр ирсэн ялтныг хэдэн хүний камерт хорих тухай шийдвэрийг гаргахдаа тухайн хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, ял хэргийн болон хувийн байдал зэрэг олон хүчин зүйлүүдийг харгалздаг байна.

⁷³ О.Пүрэвсүрэн. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2014. 36 дахь тал

Хаалттай хорих анги нь хамгаалалтын 3 бүстэй, хашааны өндөр 7 м, гадна харуул хамгаалалтыг хангахад өдрийн цагаар зэвсэг ашиглахгүй, шөнөдөө галт зэвсэгтэй эргүүлийн машинаар явж хяналт тавьдаг. Харуул хамгаалалтын алба нь 3 ээлжээр 24 цагаар ажилладаг. Гадна хамгаалалтыг сайн хангасан учир дотор зонндоо чөлөөтэй байлгах зарчмыг баримталдаг.

Хоригдлыг өдөрт 1 удаа 1 цагаар салхилуулан, тоог өдөрт 4 удаа авдаг ба өглөө 06.00 цагт, өдөр хоолны дараа 13.00 цагт, үдээс хойш ажил буух үед буюу 16.00 цагт, орой амрахад 22.00 цагт тус тус тоо авна. Тоо зөрөх сэжиг гарвал бүх хоригдлыг камерт хийж тоог нарийвчлан авдаг.

Өвчтэй болон өндөр настай хоригдлоос бусад нь хуульд заасны дагуу ажил хийх үүрэгтэй байна. Ажил хийдэг хоригдолд цалин олгох ба цалингаас хорих анги зохих хэмжээний суутгал авч үлдсэнийг нэрийн дансанд нь байршуулдаг. Тухайн хоригдол сард 150 евро зарцуулах эрхтэй ба бусдад учруулсан гэм хорын хохирлыг цалингаас нь суутгаж барагдуулах, хэрэв төлбөргүй бол ар гэрт гуйвуулж болно. Сард 2 удаа хорих анги дахь явуулын дэлгүүрээр үйлчлүүлэх боломжтой.

Хаалттай дэглэмийн ялтны хоногт хэрэглэх хоолны илчлэгийн хэмжээ нь 2300 ккал байна. Амиа хорлох аюултай, өөрийгөө хянах чадваргүй болсон хоригдлыг номхотгох тасалгаанд хорьдог. 3-аас илүү хоног хорих болвол Хууль зүйн яаманд мэдэгдэх үүрэгтэй. Номхотгох өрөө нь тодорхой стандарт шаардлагыг хангасан /хүлэг бүхий ор, зөөлөвчтэй хана, камерийн хяналт гэх мэт/ байх ёстой. Номхотгох өрөөнд хоригдол хоригдож байгаа тохиолдолд эмнэлгийн болон харуул хамгаалалтын ажилтан хажууд нь бэлэн байх ба хяналтын шилэн цонхоор хяналт тавина.

Хаалттай хорих ангид их сургуульд сурах боломжгүй, харин нээлттэй хорих ангид хүсвэл сурах боломжтой.

Хаалттай дэглэмийн хоригдол утсаар ярих эрхтэй. Нэг хоригдлын утсаар ярих дээд хугацаа нь сард 1-1.30 цагийн хооронд байна. Хоригдол утсаар ярих хүсэлтээ захиргаанд тавьж, нууц дугаар авч, урьдчилж мөнгө төлдөг. Хоригдол утсаар ярих зөвшөөрөл авч, үүнд гэрч, хохирогчийн болон гэмт хэрэг хамтран үйлдэгсэд, бусад сэжиг бүхий этгээдүүдийн утасны дугаар байх ёсгүй. Зөрчил гаргавал утсаар ярихыг хязгаарладаг. Хоригдлыг утсаар ярих үед шаардлагатай тохиолдолд хорих ангийн ажилтан хажууд нь зогсож, яриаг хянах боломжтой.

Хуульд зааснаар хоригдол сард 4 удаа 1-ээс илүүгүй цагаар эргэлт авна. Удаан хугацааны болон хоногийн эргэлт байхгүй. Гаднаас эргэлтийн зүйл оруулдаггүй. Урт хугацааны уулзалтыг хорих ангийн даргын хурлаар шийддэг ба энэ нь 7 цагийн хугацаатай байна. 3 сард 1 удаа 20 кг хүртэл

хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйлсээ илгээмжээр авах эрхтэй. Ар гэрийн эргэлт болон цагдаа, өмгөөлөгч нарын уулзалтын өрөө тус тусдаа байна.

Нээлттэй дэглэмийн хоригдолд чөлөө олгох, асуудлыг тухайн ялтны хорих төлөвлөгөөг үндэслэн хорих ангийн дарга, харуул хамгаалалтын ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар хамтын зарчимаар шийдвэрлэдэг. Энэхүү шийдвэрийн үндэслэлд тухайн мужын Хууль зүйн яам хяналт тавьдаг байна.

Хоригдол ялынхаа 2/3-ыг эдэлсэн тохиолдолд хугацааны өмнө тэнсэн харгалзах асуудлыг хэлэлцэнэ. Хугацаанаас өмнө суллах асуудлыг хорих ангийг хариуцдаг мужийн шүүх шийдвэрлэнэ. Хорих ангийн даргаас улсын прокурор тодорхойлолт авдаг⁷⁴.

Хоригдлуудтай харьцах тал дээр ХБНГУ-ын туршлага Европт нэлээд дээгүүрт ордог. Хоригдлыг хуульд захирагдах, өөрийнхөө аливаа алхмын хариуцлагыг хүлээх, өөрийнхөө оршин тогтнохыг хангаж хариуцахад сургадаг. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар хорихын болон нийгмийн амьдралын ялгааг аль болох багасгах нь тухайн хүний унаж уруудах хийгээд давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх үндсэн арга юм.

Германы хууль тогтоомж нь ялтныг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц нийгэмшүүлэхээр засан хүмүүжүүлэх зорилго агуулсан байна. Энэ зорилтын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг. Чухам үүний улмаас Хууль зүйн яам хорих байгууллагад нийгмийн ажилтан, лам, сэтгэл зүйчтэй байлгадаг. Нийгмийн ажилтан нь хорих байгууллага болон нийгмийн хооронд орших амьд гүүр юм. Нийгмийн ажилтнууд ялтныг ирэхэд захиргааны зүгээс хамгийн түрүүнд уулздаг бөгөөд ар гэртэй холбоо барих, ямар нэг асуудал байвал түүнийг шийдвэрлэж өгөхийг санал болгодог. Тэдний үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь өнөөгийн ялтан хэзээ нэгэн цагт нийгэмд эргэн орж бүрэн эрхт гишүүн болно гэдгийг ухамсарлах байдагт оршино.

Нийгмийн ажилтны тоо нь багш, эмч, сэтгэл зүйчийн тооноос 2,5 дахин, санваартнуудын тооноос 4 дахин илүү байхаар зохицуулагдсан байна. Эдгээр мэргэжилтнүүд нийгмийн штаб гэсэн албанд багтдаг бөгөөд аюулгүй байдал болон дэглэмийн гэсэн албадтай зэрэгцэн ажилладаг.

Германы хорих байгууллагын нийгмийн ажлын зохион байгуулалтад хэд хэдэн онцлог байдаг. Тухайлбал, шашны үүрэг мэдэгдэхүйц байдаг. Хорих байгууллага бүрт католик юмуу протестант шашны санваартнууд

⁷⁴ О.Пүрэвсүрэн, Ж.Эрдэнэцэцэг, Ш.Ганцэцэг, Т.Түүл, ХБНГУ-ын зарим хорих ангитай танилцсан тухай ажлын тайлан. УБ. 2009. /Албан хэрэгцээний материал/

ялтнуудтай ажилладаг ба суллагдсаных нь дараа ч хүртэл холбоотой байдаг байна.

Нийгмийн ажлын зохион байгуулалтын нэгэн чухал хэсэг бол хөдөлмөрийн асуудал, сургууль, улмаар мэргэжлийн бэлтгэл хийлгэхэд оршдог. Германы туршлага сонирхолтой бөгөөд тэдний хорих байгууллагад орчин үеийн техникээр тоноглогдсон хэвлэх үйлдвэр ажиллаж, ялтныг цөмийн ректорын гагнуурчны болон автомат шугам дээр ажиллах роботын тохиргооны мэргэжлээр сургаж байх жишээтэй. Ялтан хэдий чинээ нарийн мэргэжил эзэмших нь суллагдсаны дараа ажил олох, амжилттай хөдөлмөрлөхөд дөхөмтэй гэдгийг нийгмийн ажилтнууд бодолцжээ.

Хорих байгууллагын захиргаа, нийгмийн ажилтнууд хөдөлмөрийн биржтэй нягт хамтран ажилладаг бөгөөд аж ахуйн аль чиглэлийн байгууллага өргөжин тэлж байгаатай уялдуулан тэнд ажиллах мэргэжилтэн бэлтгэх, тэр утгаараа сургалтын болон ажлын зориулалттай шинэлэг төхөөрөмж авч тавьдаг байна. Хорих байгууллагад мэргэжилтэй ажилчдын нөөц байгаа, тэр нь ирээдүйд шаардлагатай гэж үздэг байна. Германы нийгмийн ажлын мэргэжилтнүүд асуудалд ийнхүү хандсанаар давтан гэмт хэрэгтэй тэмцэх нэг арга гэж үзэж байгаа юм.

Хорионд байгаа хүмүүсийг зонхилон хоёр хувааж багавтар боловсролтойд нь уншиж бичих, тоо бодох зэргийг заадаг бол бичиг үсэгтэйд нь ерөний боловсролын сургалтыг богиносгосон хувилбараар явуулдаг байна. Сүүлийн үед телевизийн тусламжтайгаар дээд боловсролыг эчнээ эзэмших боломжтой болжээ.

Германы хорих байгууллагад телевизийн буюу алсын зайн сургалт анхаарал хандуулах болжээ. Европын бусад улсын хэд хэдэн телевизийн төвийн сургалтын хөтөлбөрийг хүлээн авах бодит боломж бүрдсэн. Гагцхүү шалгалт, шүүлгийн хувьд хорионд байгаа хүмүүсийн хувьд бэрхшээл гардаг талтай.

Ялтны хорионд байх хугацааг хэд хэдэн үе шатанд хуваадаг.

- 1.Хорих байгууллагын нөхцөлд дасах үе;
- 2.Засран хүмүүжих үе;
- 3.Суллагдахад бэлтгэгдэх үе.

Ял эдлэх бүхий л үе шатанд тэднийг нийгмийн ажилтан судалж үе шат бүрт төлөвлөгөө гарган ажиллаж дүгнэж байдаг. Энэхүү төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгадаг.

1. Хаалттай болон нээлттэй хорихын аль нөхцөлд байх;
2. Эн тэнцүү харьцаа бүхий хэсэгт бусадтай хамт байх эсэх;

3. Ажил хийх, мэргэжил эзэмших, мэргэших болон давтан бэлтгэхэд хамрагдах;

4. Ерөнхий боловсролын мэдлэгээ дээшлүүлэх;

5. Тусгайлсан тусламж үзүүлэх;

6. Ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх;

7. Суллагдахад бэлтгэх шаардлагатай ажил гүйцэтгэх.

Ялтны өөрчлөлтийн байдал болон түүнийг судлах явцад гарч болзошгүй нэмэлт зүйлийг үндэслэн төлөвлөгөөг засварлаж болох бөгөөд ял эдлэх хугацааг харгалзан төлөвлөх ёстой.

Ялтан оршин сууж байгаа байрандаа өөрийн эд зүйлээ зохих хязгаартай байрлуулах эрхтэй. Ойр дотных нь хүмүүсийн гэрэл зураг, мөн өөрт нь чухал зүйлсийг байлгахыг зөвшөөрдөг. Энэ нь сэтгэл зүйн хувьд ялтан нь хүнийхээ хувьд өөрийгөө хадгалан үлдэх, ар гэрийнхэнтэйгээ холбоотой байх зэргээр нийгмийн ажлын хувьд туйлын чухал зүйл юм.

Нэг хэсэг ялтныг бусдаас тусгаарлан нийгмийн эмчилгээний газар байрлуулдаг. Энд зан байдлын талаар илэрхий эвдэрсэн насанд хүрэгсэд, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгчид, сэтгэцийн тодорхой эмгэг бүхий хүмүүс, мөн өмнө нь ял эдэлж байсан залуучууд байдаг. Нийгмийн эмчилгээний газрын зорилго нь эмчилгээний тодорхой хэрэгсэл болон нийгмийн тусламжийн оролцоотойгоор нийгмийн ажилтан болон бусад ажилтны явуулах үйл ажиллагаа бөгөөд тухайн хүн цаашид хариуцлагатайгаар амьдарч гэмт хэрэг дахин үйлдэхгүй байх чадамж эзэмшүүлэхэд оршдог. Энэ байгууллагад сайн дурын үндсэн дээр ирсэн хүмүүст албадлагын арга хэрэглэдэггүй, өөрсдөө хүсвэл эндээс шилжиж болно. Гагцхүү эмчилгээний тусгай хэрэгсэл болон нийгмийн тусламж шаардлагатай хүмүүсийг энд заавал байрлуулах шаардлагатай. Харин энэхүү тусгай эмчилгээний хэрэгсэл, нийгмийн туслалцаа тодорхой үр дүнд эс хүрвэл ялтныг ердийн ангид буцаана. Холбогдох хүмүүсийг нийгмийн эмчилгээний газарт илгээхийн тулд 3 сараас доошгүй хугацаагаар судалсан байх ёстой.

Нийгмийн ажлын өөр нэг хэлбэр бол хорих байгууллагын даргын дэргэд байгуулагддаг зөвлөл юм. Харин түүний бүтцэд тухайн ангийн албан хаагчид ордоггүй. Зөвлөлийн үйл ажиллагааг тухайн мужийн эрх зүйн актаар зохицуулдаг бөгөөд гишүүд шийдвэр гүйцэтгэх үйл явцад нөлөөлөх, ялтнуудын талаар анхаарал тавих үүрэгтэй. Зөвлөлийн гишүүд хорих байгууллагын үйл ажиллагааг сайжруулах эрчимжүүлэх талаар байгууллагын даргад санал тавих хийгээд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэхэд тусламж үзүүлдэг. Зөвлөлийн гишүүд хуулиар олгогдсон эрхтэй, тухайлбал ялтнуудын хоригдож буй нөхцөл байдалтай танилцах

гэх мэт. Германд ял шийтгэгдсэн хүмүүсийг гэр оронд нь ойр орших хориход илгээдэг нь тэдний нийгмийн хэлхээ холбоог аль болох таслахгүйд чиглэгддэг.

Ялтнуудыг хэтэрхий дураар нь байлгаж байна гэх буюу ер нь хорих байгууллагын талаарх иргэдийн буруу ойлголтыг залруулахаар нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулдаг. Тэнд янз бүрийн байгууллага, сургууль, ялтны ар гэрээс олон хүн ирж бодит байдалтай танилцдаг. Нийгмийн ажилтны үүрэг нь ялтанд нийгмийн дэмжлэг үзүүлэхэд оршдог. Тухайлбал, ялтанд тулгараад байгаа нийгмийн асуудлыг гаргаж тавих, хувь хүний тухайд болон хүмүүс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэх, харьцааны соёл, харилцан зөвшилцөл, тэвчээртэй байхыг хэвшүүлэх, нийгмийн тусламжийн эх үүсвэрийг эрж хайх, боловсрол олоход нь туслах гэх мэт. Энэ утгаараа нийгмийн ажилтан ялтныг эхнээсээ аваад ялаа дуусан дуустал хамт явна гэсэн үг юм.

Германы Рейн-Пфалц мужийн хорих байгууллагын нийгмийн ажилтан ажил үүргийнхээ дагуу ялтанд дараах байдлаар тусалдаг байна.

- Өөрийн бололцоо болон юунд сэтгэл түгшиж явдгаа мэдэх;
- Өөрийнхөө зан байдлыг удирдах, өөрт тулгарсан асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд суралцах, ажил мэргэжилд шамдах чавдар эзэмших;
- Хууль баримтлан тухайлсан эрмэлзэл зорилго тавьж тууштай хэрэгжүүлэх;
- Өөрийнхөө болон бусдын өмөн хариуцлага хүлээдэг, түншлэлийн харилцаа тогтоож чаддаг, гэр бүл, төрөл, садан, ойр дотныхоо хүмүүсийн талаар санаа тавьдаг;
- Чөлөөт цагаа зөв өнгөрөөдөг;
- Ял эдэлж байх хугацаандаа сэтгэл санааны болон бие махбодын хохирлоос татгалзах, мөн гэмт хэргийн, заналхийллээс ангид байх зэрэг болно.

Бусад мужийн хорих байгууллагуудад нийгмийн ажилтан мөн дараах төрлийн үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал:

- Ялтны ял эдлэх бүхий л хугацаанд туслалцаа үзүүлэх;
- Хувь хүнд учирсан бэрхшээлийг гэтлэхэд чиглэсэн ганцаарчилсан уулзалт зохион байгуулах;
- Ялтнуудтай хэсэг бүлгээр нь ажиллах;
- Ялтнуудтай нийгмийн гадаад хэлхээ холбоо тогтоох, ялангуяа гэр бүл, ойр дотны хүмүүстэй холбож өгөх, гэр орондоо түр харихыг зөвшөөрөх;
- Хорих ангийн санваартантай уулзуулж ярилцуулах;

- Тэнсэн суллагдсан хүмүүст тусламж үзүүлэх талаар бусад ажилтантай болон бусад байгууллагатай хамтран ажиллах;

- Хорих байгууллагад ажиллахаар суралцаж байгаа дадлагын хүмүүстэй ажиллах.

Германд харьцангуй хөнгөн гэмт хэрэгт яллагдсан болон цөөн жилтэй хүмүүс, мөн суллагдах ялтныг нийгэмд дасгаж байх зорилгоор суллагдахаас нь нэг жилийн өмнө байрлуулдаг “нээлттэй” хэсэг зарим ангид байдаг, мөн бие даасан ийм анги ч байдаг байна.

Ийм газарт цонх нь торгүй, гал тогоондоо хоол ундаа өөрсдөө бэлтгэдэг, жирийн байдлаар хувцаслаж болох, мөн утсаар гэр бүл, ойр дотныхоо хүмүүсрүү ярьж болдог, долоо хоногт нэг удаа гэртээ харьдаг аж. Энэ хэлбэр нэлээд түгээмэл бөгөөд зөвхөн Баруун Рейн-Вестфалийн нийт хорихын 60 хувь нь ийм нөхцөлтэй байна.

Германы Хууль зүйн яамны дэргэд нийгмийн туслалцааны хүрээлэн байгуулагдсан ба тэнд хөдөлмөрийн зах зээлийг судалж гол компаниуд болон шаардлагатай байгууллагуудын хүмүүстэй ажил хэргийн холбоотой ажилладаг бөгөөд суллагдаж буй хүмүүст гэр бүлийн болон санхүүгийн бэрхшээлээ гэтлэхэд нь туслахуйц зөвлөгөө өгдөг байна.

Ялтны ажиллах хугацааны цалингийн гуравны нэгийг хадгалж байдаг бөгөөд суллагдсаны дараах эхний үед хэрэглэх зориулалттай юм. Энэ мөнгийг урьд өмнөх өр зээлийн нэхэмжлэлд хэрхэвч зарцуулдаггүй, гагцхүү тухайн суллагдаж буй хүн нэг хэсэгтээ хэрэглэх цорын ганц зориулалттай.

Хорихоос суллагдах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг тул бэлтгэл ажлыг хэрхэн хангах талаар хуульчилсан байдаг. Чөлөөт амьдралд зугуухан орох бэлтгэл хангахыу тулд хорих дэглэмийг зөөлрүүлж болох ба суллагдахаас гурван сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрхтэй ялтанд сар бүр 6 хоногийн чөлөө олгодог.

Суллагдсан хүмүүсийн 40 хувь нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр хууль давтан зөрчдөггүй гэсэн тооцоо гарсан нь Германы шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын амжилт гэж үздэг.

Хуулийн дагуу суллагдсан хүнд ажил, орон байр олгодог. Суллагдсаны дараа ояих газар хүртэлх замын зардал, мөн ажлын хөлснийх нь хуримтлал, шаардлагатай бол хувцас олгодог. Гэр бүлийнхэнтэй нь холбож өгөх, ажил, орон сууцны зэрэг асуудал шийдвэрлэхийг нийгмийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

Суллагдахаас 6-9 сарын өмнө ялтныг хагас чөлөөт байдалтай ангид ирүүлдэг. Нэг өрөөнд 1-3 хүн байрлана. Энд ирсэн хүн суллагдсаны дараа

хийх ажлаа өөрөө хайж олохоор ажиллах ба эс бүтвэл нийгмийн ажилтны туслалцааг авна. Зохих ажил олоогүй нөхцөлд ямар нэгэн байгууллагад ажиллахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж, хөлсний ажилчны маягаар ажиллах бөгөөд цалингийн 15 хувийг тухайн хүнд өгч бусдыг байр сууц зэргийн зардалд суутгана. Ялтан ар гэрийнхэн болон танил талтайгаа уулзаж тэднийг байрандаа хүлээн авах бололцоотой бөгөөд үүнд хөндлөнгийн ямар нэгэн хяналт шалгалт тавигддаггүй. Чөлөөт цагаараа захиргаанаас чөлөө авч гадуур явж болох бөгөөд энэ нь 22 цаг 30 минут хүртэл зөвшөөрөгддөг.

Энд байх хугацаанд явагдах хүмүүжлийн ажил нь хэсэг бүлгээр нь зохиох ярилцлага бөгөөд үүнийг нийгмийн ажилтан, эсхүл сэтгэл зүйч долоо хоногт хэд хэдэн удаа зохион байгуулдаг.

Суллах тухай шүүхийн шийдвэр гарахаас өмнө ялтныг эмнэлгийн үзлэгт оруулж ангийн дарга уулзаж ярилцдаг.

3.2.5. Англи Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

Англи Улс пенитенциарын шинжлэх ухааны дэлхийд алдар нэрээ дуурсгасан эрдэмтэн Д.Говард /1726-1790/, И. Бентам /1748-1832/ нарын эх орон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр эрдэмтэд тухайн үедээ ял эдлүүлэх чиглэлээр гайхамшигтай төслийг нийгэмд санал болгосон юм. Тэдний санал, санаачилгын үндсэн агуулга нь ял эдлэгсэдийг хөдөлмөр, сургалт хосолсон ажиллагаанд хамруулж, ерөнхий боловсролын сургалтанд оролцуулах, ингэснээр тэднийг гэмт хэргийн ертөнцөөс ангижруулахад чиглэгдэж байв. Эрдэмтдийн шинэ дэвшилтэт санал нь нийгмийн амьдралаас хол хөндийд тооцогдон тухайн үедээ хэрэгжих боломжоор хангагдаагүй байна. Гэвч шинэ дэвшилтэт үзэл санаа нь Английн төдийгүй дэлхий нийт, ялангуяа Оросын ял эдлүүлэх ажиллагааны хөгжилтөд шинэ эрч хүч өгчээ.

XIX зуунд Англи Улсын хорих ял эдлүүлэх ажиллагаанд ноёлж байсан удаан хугацаагаар ганцаарчлан хорих байдлыг өөрчлөн хэсэг бүлгээр нь хорих ажилд шилжсэн байна. Хоригдлын ял эдлэх нийт хугацааг:

а/ туршилтын буюу ганцаарчлан хорих,

б/ хүмүүжлийн буюу албадан хөдөлмөрлөх,

в/ хугацаанаас өмнө тэнсэн суллах буюу нийт ялын дөрөвний гуравыг эдэлсэн байх гэж хувааж байв. Сүүлийн хоёр үе шатны хооронд завсарын буюу хагас чөлөөтэй байх, тэнд ял эдлэгсэдийг харуул хамгаалалтгүйгээр ажиллуулах, гадаад орчинтой чөлөөтэй харьцдаг байх саналыг эрдэмтэн В. Крофт дэвшүүлжээ. Энэ завсарын үе шатны ажиллагаа амжилттай хэрэгжин, хоригдлыг нийгэмшүүлэхэд үр дүнгээ өгөх болсон байна.

17-21 насны ялтныг хорьж ялыг эдлүүлэх “Бросталь” /хотын нэр/ системийн тухай олон улс орон мэдэх болов. Бросталь хотын ял эдлүүлэх байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл хугацаанд ял эдлэгсэдийг хорьж тэднийг албадан хөдөлмөрлүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтанд хамруулж байв.

Англи Улсын ял эдлүүлэх байгууллага нь:

-төвийн

-орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ.

Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Мөн түүнчлэн:

а/ богино хугацаагаар хорих ял эдлэгсэд

б/ торгууль төлөөгүй буюу бага хохиролтой гэмт хэрэг үйлдэгсэд

в/ 21 хүртлэх насны хүүхэд залуучууд хоригддог байна.

Эдгээр төрлүүдэд ял эдлэгсэдийн үйлдсэн гэмт хэргийн байдал, засрал хүмүүжлийн түвшинг судлан тогтоож, улмаар тэднийг ял эдлүүлэх байгууллагын өөр төрөлд шилжүүлэх журам үйлчилдэг. 1969 оноос эхлэн Англи Улсын хорих ял эдлүүлэх төвлөрсөн байгууллага нь хугацааны хувьд гурван төрөлд хуваагдах болов. а/ богино хугацааны буюу 18 сар хүртлэх, б/дунд хугацааны буюу 1.5-5 жил хүртлэх, в/ урт хугацааны буюу 5 жилээс дээш хугацаагаар гэж хуваасныг хорих ял эдлүүлэх ажиллагаанд ялгавартай хандах, зохих үр дүнд хүрэх ач холбогдолтойд тооцдог байна.

Хэдийгээр ял эдлүүлэх төвлөрсөн байгууллагыг дээрх байдлаар ангилан хуваадаг ч үндсэнд нь нээлтэй ба хаалттай гэж ангилдаг. Нээлттэй байгууллагад зэвсэглэсэн хамгаалалт байхгүй, цонх нь төмөр торгүй бөгөөд тэнд хоригдон ял эдлэгсэд гадны байгууллагад очиж хөдөлмөрлөж болдог. Ийм хэлбэрийн байгууллага цөөн байгаа ч цаашид олшруулах чиглэл баримталдаг ажээ. Хаалттай шорон нь зэвсэглэсэн харуул, өндөр бөх бат хана зэргээр нийгмээс хатуу тусгаарлагдсан байдаг онцлогтой.

Англи улсад 135 хорих ангид 65 мянган хоригдол ял эдэлж, тэдэнтэй 43 мянган ажилтан албан хаагчид ажилладаг байна. Хаалттай дэглэмд голдуу алан хядах ажиллагаа явуулсан этгээдүүд ял эдэлдэг тултэнд маш чанд харуул хамгаалалттай байдаг. Нээлттэй дэглэмийн хорих ангиудад хамгаалалтын хашаагүй, харьцангуй боломжтой хөнгөн нөхцөлд ял эдлүүлдэг байна. Хоригдол ажилтнуудын тооны харьцаа хаалттай дэглэмд 1:5, нээлттэйд 1:2 байдаг байна. Хорих ангийн ажил хамгийн хүнд нөхцөлтэйд тооцогддог тул тэнд ажиллагсадын цалин төрийн бусад албан хаагчдынхаас их дээгүүр байдаг байна.

Хорих байгууллагад нийгмийн ажил анх нэвтрүүлсэн улсуудын нэг бол Их Британи юм. Дотоод хэргийн яамны харьяанд байх хорих байгууллагууд нь дараах хэлбэртэй байдаг⁷⁵. Үүнд:

- 3-аас дээш жилийн ялтай ялтны нэгдсэн хорих анги
 - Хэд хэдэн засаг захиргааны нутаг дэвсгэрийг хамарсан 12 сар хүртэлх ялтны орон нутгийн хорих анги
 - 21-ээс дээш насны засрах найдлага бүхий гэмт хэрэг давтан үйлдсэн ялтнуудын хорих анги
 - Тухайн засаг захиргааны анх удаа гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын хорих анги
 - 21 хүртэлх насны хүмүүст зориулсан хорих анги болон хорихын сургууль байдаг.
 - Насанд хүрээгүйчүүдийг богино хугацаагаар засан хүмүүжүүлэх төвүүд байдаг.
- Ял эдлэх хугацааг дараах байдлаар ангилна.
- Туршилтын хугацаа /ганцааранг нь байлгах/
 - Засан хүмүүжүүлэх үе /хамтаар нь байлгаж хөдөлмөр эрхлүүлэх/
 - Хугацаанаас нь өмнө тэнсэн суллах /ялын хугацааны 4/3-ыг эдэлсний дараа/

Европын хорих байгууллагын дүрмийг удиртгал болгон Их Британийн хорих байгууллага нийгмийн ажлын дараа хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хорих байгууллага бүр нийгэм боловсролын төлөвлөгөөтэй байх бөгөөд ялтан бүр авьяас, чадвар, хэрэгцээ шаардлагаа хангах бололцоотой байх;
- Боловсрол нь засан хүмүүжүүлэх үйл явцын салшгүй хэсэг хөдөлмөрлөхийн адил чөлөөт цагаа өнгөрүүлэх үндсэн зүйлийн нэг байх;
- Залуучууд, гадаадын иргэд, үндэстний цөөнхөд боловсрол олгоход чухалчлан анхаарах;
- Онцлох бэрхшээлтэй ялтнуудад тусгайлан хөтөлбөр зохиох;
- Хорихын боловсролын хөтөлбөр нь улс орны боловсролын тогтолцоотой адил төвшинд байж суллагдсаны дараа шууд үргэлжлүүлэн суралцахад саадгүй байх;
- Ялтан мөн хорихоос гадуур суралцах эрхтэй.

Хорих байгууллагад нийгмийн ажил явуулахдаа олон улсын шашны ивээлийн байгууллага болох “Авралын арми” тусламж үзүүлдэг. Энэ

⁷⁵ Лузгин.С.А бусад орчуулсан Б. Шатарбал. “Хорих байгууллагын нийгмийн ажил”, УБ,.2009 он 187 дахь тал

байгууллага 1865 онд байгуулагдсан, дэлхийн 96 улсыг хамарсан 127 хэл дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Тус байгууллагын үзэж байгаагаар ял эдэлнэ гэдэг нь шийтгэл бус, тухай хүний муу зуршлаасаа салах нөхөн сэргэлт байх ёстой гэж үздэг. Авралын армийн нийгмийн ажлын үндсэн зарчим нь:

- Хүн хэдий чинээ унаж уруудсан , ядуу хоосон хэдий ч түүнд эрүүл, цэвэр байж хөдөлмөр хийх боломжийг олгох;
- Тийм хүмүүсийг хөл дээр нь босгоход туслах, ажил хийх чадвартай бол бэлэн өглөгт муу зан сурган улмаар ядууруулах зам руу түлхэхгүй байх, хөдөлмөрлөж өөрийгөө авч явах чадвартай болгох;
- Шашны хүмүүжлийн үр дүнд оюун санаа нь ариусаагүйгээр ахуй байдал сайжрах нь бага нөлөөтэй;
- Эргэлт буцалтгүйгээр унаж уруудна гэж байхгүй, хэрвээ энэ байдлаас гарах хүсэл л байвал тэрээр тусламж авах эрхтэй.

Их Британийн нийгмийн ажил өндөр төвшинд явагддаг ба тэдний үйл ажиллагаанд олон нийтийн болон сайн дурын байгууллагууд ялангуяа ялтнуудын чөлөөт цагийг зөв өнгөрөөх, суллагдаж буй хүмүүсийг эрх чөлөөт амьдралд бэлтгэхэд чиглэсэн үнэтэй тусламж үзүүлдэг.

3.2.6. Франц Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

Францын хорих ял эдлүүлэх тогтолцоо нь төвийн болон орон нутгийн насанд хүрсэн ба насанд хүрээгүйчүүдийг хүмүүжүүлэх тусгай байгууллагаас бүрдэх ба эдгээр нь өөрсдийн онцлог дэглэмүүдтэй байна.

Нэг жил хүртэл хорих ялаар шийтгүүлсэн этгээдэд мэргэжлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулах, боловсрол олгох, эмчийн хяналтанд байлгах, гэр бүлтэйгээ харилцаа холбоотой байх боломж олгосон хагас эрх чөлөөтэй байх ял тухайн этгээд засарч хүмүүжихэд нөлөө үзүүлдэг байна.

Хорих ялыг 5-10 жилийн хугацаатай оноодог. Бусад тохиролдолд хорих ялыг 1-10 жилээр оногдуулна.

Насанд хүрэгчдийн төвийн хорих ангид 1 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хүмүүс ял эдэлдэг.

Шинээр ирсэн бүх хоригдлуудыг ял эдлэх ангид ирмэгц тухайн нөхцөл байдалд дасгах зорилгоор 45 хоног ганцаарчилан хорино. Энэ хугацаандаа засрах найдлагатай, засрахад эргэлзээтэй, засрахгүй гэсэн ангилалд хуваан ялыг эдлүүлдэг.

Засрах найдлагатай ялтнуудыг өдрийн цагаар нийтээр нь ажиллуулж, орой нь тэднийг тусгаарладаг. Ийм ялтан нь гадуур ажил эрхлэх зэрэг нилээд хөнгөлөлтийг эдэлдэг.

Түүнчлэн хагас чөлөөтэй дэглэмд хөдөлмөрлүүлэхээр шилжүүлж, үлгэр жишээч сахилга батын төлөө гэсэн нөхцөлөөр суллах дэвшилтэт систем үйлчилдэг бөгөөд итгэл дааж буй ялтныг хугацаанаас нь өмнө суллах асуудлыг хорих анги өөрөө бие дааж шийддэг байна.

Засрахад эргэлзээтэй, засрахгүй ялтны хувьд хязгаарлагдмал эрхийг эдлэх бөгөөд ял эдлүүлэх асуудлыг тусгай шүүгч хариуцаж хугацаанаас нь өмнө суллах, ялын хугацааг богиносгох хүртэл эрхийг эдэлдэг. Уг дэглэмийн ялтнууд хүмүүжилтэй, ял эдлэх явцдаа ямар нэг зөрчил гаргаагүй бол засрах найдлагатай буюу дээд, илүү нээлттэй дэглэмд шилжүүлж болдог онцлогтой байна.

Дээрх тухайн дэглэмүүдэд ял эдлэх ялтнаар хэдэн арван сорилуудыг бөглүүлж, түүний зан байдал, ямар шалтгаанаар гэмт хэрэг үйлдэх болсон, ар гэр, ахуй амьдрал гээд олон асуудлыг тодорхойлдог. Үүнд мэргэжлийн сэтгэл судлаачид, багш, сурган хүмүүжүүлэгч нар оролцдог тул ямар алдаа гаргахгүй байна. Шүүхээс оноосон ялыг хэсэгчлүүлэн эдлүүлэх эрхтэй заасан байна.⁷⁶

3.2.7. Польш Улсын хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын онцлог:

Польш улсад 156 шоронд 60 гаруй мянган хоригдол ял эдэлж байна. Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь хууль, хуульчилсан актуудын хүрээнд хэрэгжүүлдэг. Шорон нь хагас хаалттай, хаалттай, нээлттэй гэсэн 3 дэглэмтэйгээр хорих ял эдлүүлдэг ба гэмт хэрэг үйлдсэн байдал зэргээс нь шалтгаалаад дээрхи дэглэмүүдэд хуваарилдаг байна.

Нээлттэй дэглэмийн хоригдлууд тусгай хамгаалалтайгаар тухайн шоронгийн ахуй үйлчилгээний болон гадуур аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр ажилладаг ба хагас хаалттай, хаалттай, дэглэмийн хорих ангийн хоригдлууд тухайн ангийн үйлдвэрт /барилгын материал, машины эд анги, засвар, гэр ахуйн барааны сэлбэг зэрэг/ ажилладаг.

Нэг хоригдлын ор, байрны эзэмшилд оногдох талбай 3м² байдаг. Нийт хорих ангиуд ихэвчлэн телекамерын системтэй 4,5-5 өндөр бетонон хашаа, дотор хаалганууд нь зузаан төмрөөр хийгдсэн. Тэнд ажиллагсдын дийлэнх нь сурган, сэтгэл судлалын мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд 1 хүнд дунджаар 50 хоригдол ноогдог гээд бодоход хүний сэтгэл зүйд нь нөлөөлөл үзүүлэхэд онцгой анхаарч байгаа нь харагдаж байна. Хоригдлыг өдөрт 3 удаа 3800 ккалын ичлэг бүхий хоолоор хангадаг.

⁷⁶ Н.Батдорж. Герман, Франц улсын хууль тогтоомжийн дагуу хорих ялыг эдлүүлэх онцлог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал /сэтгүүл/. УБ., 2014. №2 30 дэх тал

Хорих ангид тогтоосон дэглэм зөрчигдөд сахилгын байранд 28 хүртэл хорьдог байна. Хаалттай хорих ангиудад ихэвчлэн онц аюултай гэмт хэрэгтнүүд байдаг, тул ажил хийддэггүй. Нийт хорих ангиудад “Кофедаг” гэж нэрлэгддэг Польш дахь Засгийн газрын бус олон нийтийн байгууллагын нийгэмлэг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг нийгэмлэгийн үйл ажиллагааны чиглэл нь:

а/ шорон дахь хүчирхийлэлийг багасгахад чиглэсэн сургалтыг зохион байгуулж тодорхой зөвлөмж бэлтгэн хорих ангиудад тараах;

б/ хоригдлыг суллахын өмнө эрх чөлөөт нийгмийн байдалд дасгах зорилгоор хуулийн зөвлөмж өгөх;

в/ суллагдсан хүмүүс нийгмийн эмзэг давхаргат хамаарах хүмүүст компьютер, мэдээллийн болон оёдлын сургалтыг үнэ төлбөргүй явуулах;

г/ суллагдаад орон гэргүй хүмүүст 7 хоног байрлах үнэ төлбөргүй байраар хангах ажиллагааг үзүүлдэг. Дэглэмээс хамааран харилцан адилгүй эргэлт, уулзалт өөр өөр байдаг.

Урьдчилан хорих байрууд нь хорих байгууллагын харьяанд үйл ажиллагааг явуулдаг байна.

3.2.8. Финляндын хорих байгууллагын нийгмийн ажлын онцлог

Финляндын хорих байгууллага онцгой, жирийн, нээлттэй гэсэн гурван төрлийн дэглэмд хуваагддаг. Онцгой дэглэмийн ялтныг нийгмээс болон бусдаас чанд тусгаарласан нарийн хяналтад байлгадаг. Жирийн дэглэмийнхэн хоорондоо уулзаж болох ба хянагчийн харгалзаатайгаар гадуур явж болно. Нээлттэй хорих байгууллагад оргох зугтахаас сэргийлсэн хашаа, тор байхгүй, ялтан өрөөнийхөө түлхүүрийг өөрөө эзэмшиж дотор чөлөөтэй явах, мөн энгийн хувцас өмсдөг. Аль ч дэглэмд хоригдож байгаа ялтан ганцаараа нэг өрөөнд байдаг.

Нийгмийн ажилтан ялтныг анх ирэхэд уулзаж ярилцан төлөвлөгөө гарган ажилладаг бөгөөд гаран гартал, мөн суллагдсанаас хойш ч гэсэн холбоотой ажилладаг. Скандиновын бусад улсын нэгэн адил Финляндад ялтан ажиллах юм уу суралцах ёстой бөгөөд зардлыг нь төр хариуцдаг. Ажил, сургууль амралтын өдрүүдэд амардаг. Сургуульд суралцах хүсэлтэй хүмүүсийн дэглэмээс шалтгаалан гадагш гарч суралцах буюу дэглэм таарахгүй бол гаднаас багш ирүүлж сургалт явуулдаг.

Финляндад зарим хорих ялын оронд 8 хүртэл сарын хугацаагаар албадан ажил хийлгэдэг хуультай. 20-200 цагийн ажлыг 7 хоногт 2 удаа, 3-4 цаг ажилладаг. Энэ шийтгэлийг хүлээсэн нөхцөлд үндсэн ажил, сургуулиас хөндийрөлгүй, гэр орондоо байж гүйцэтгэнэ.

Финляндын хуулиар ялтныг аль болох ердийн аж амьдралын нөхцөлд ойр байлгах, хоригдоно гэдэг нь уг утгаараа хүнд шийтгэл тул түүнийг янз бүрийн нэмэлт зүйлсээр аль болох хүндрүүлэхгүй байх, улмаар ямарваа нэг анкет, баримт бичигт ял эдэлж байсныг дурдахгүй байхаар тусгагдсан байдаг.

3.2.9.Швейцарын хорих байгууллагын нийгмийн ажлын туршлага

Швейцарын хорих байгууллагын нийгмийн ажил нь дотроосоо болон гаднаас гэсэн хоёр хэлбэрээр явагдах бөгөөд тэдний үйл ажиллагааны туйлын зорилго нь ял эдэлж байгаа хүмүүсийг дахиад хориход эргэж ирэхгүй байхаар хүмүүжүүлэхэд оршдог. Швейцарын эрүүгийн хуульд хорихоос суллагдаж буй хүмүүст нийгмийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих тухай заалт орсноор ХХ зууны дунд үеэс нийгмийн ажил идэвхтэй хөгжиж эхэлсэн байна. Швейцарын хорих байгууллагын нийгмийн ажил хоёр төрлийн загвараар явагддаг. Нэгдүгээрт, хүн амын нийгмийн асуудлыг бүхэлд нь хариуцсан ажилтнууд ялтнуудыг давхар хариуцах буюу хорих ангид тогтмол ирж ялтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэдэг юм. Ердийн нөхцөлд ялтан нийгмийн ажилтантай уулзах хүсэлтийг хорих ангийн захиргаагаар уламжлан тавих ба гадуур ажилладаг нийгмийн ажилтан 10 хоногийн дотор ирж уулзан тулгарсан асуудлыг хамтран шийдвэрлэх төлөвлөгөө гаргаж ажилладаг. Хоёрдугаарт, нийгмийн ажилтнууд тухайн хорих ангийн бүтцэд багтдаг хэлбэр нэлээд түгээмэл байдаг. Тэд хүсэлт гаргасан ялтнуудыг ажлын байрандаа хүлээн авч уулзан тавьсан асуудлыг нь шийдвэрлэхэд тусалдаг. Мөн ялтнуудын байгаа газраар явж ажилладаг. Ялтнуудыг ирээд 2-3 сар болж байхад нэг бүрчлэн уулзаж тэднийг судалдаг. Швейцарт 600 ялтантай ангид 5-6 нийгмийн ажилтан буюу жилд 60-80 үйлчлүүлэгч ноогддог. Швейцарын нийгмийн ажилтны албаны үүрэгт дараах зүйл багтдаг⁷⁷. Үүнд:

- Ялтныг судалж дүгнэлт хийх, тухайлбал, түүний нийгмийн хэлхээ холбоо, нийгмээс хир гажсан байдал, нийгмийн бэрхшээл;
- Түүнийг ял эдлэх хугацаанд нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх төлөвлөгөөг хамтран гаргах;
- Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж шаардлагатай туслалцаа үзүүлэх;

⁷⁷ Лузгин.С.А бусад орчуулсан Б. Шатарбал. "Хорих байгууллагын нийгмийн ажил", УБ,.2009 он. 186 дахь тал

- Ялантай холбоотой бүхий л баримт бичгийн бүрдлийг хөтлөх /сайшаал шийтгэл гэх мэт/;

- Ялтны гэр бүл, санхүү, эд хөрөнгө, тэтгэврийн зэрэг асуудлыг шийдвэрлэх;

- Гэр бүлтэй холбоо бариулах, ажил биеийн тамир, соёл, гэгээрлийн зэрэг арга хэмжээг зохион байгуулах;

- Ялтныг суллахад бэлтгэх, ахуйн болон ажлын асуудлыг шийдвэрлэхэд туслах зэрэг болно.

Нийгмийн ажилтан ялтны өөрөө хүсэлт тавьсны дагуу үйл ажиллагаа явуулдаг. Сүүлийн үед нийгмийн алба нь сэтгэл зүйч, сэтгэл мэдрэлийн эмч зэрэг нарийн мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах, тэдний туслалцааг авахад ихээхэн анхаарч байна. Энэ тохиолдолд нийгмийн ажилтан дээрх мэргэжилтэн болон ялтны хооронд холбон зуучлах үүрэг гүйцэтгэж байна. Швейцарын хорих байгууллагын нийгмийн үйл ажиллагаа нь хөдөлмөр, ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалт, биеийн тамир, соёл оюуны гэсэн хэлбэрээр явагддаг бөгөөд ажил хийх нь ялтны заавал гүйцэтгэх үүрэг, бусад нь сайн дурын үндсэн дээр хамрагддаг. Сургалтанд хамрагдсан тохиолдолд ажлаас чөлөөлж амжилттай төгссөн тохиолдолд хугацаанаас нь өмнө сулладаг. Швейцарын хорих байгууллагын нийгмийн ажил нь ялтны ял эдлэх бүхий л хугацаанд тасралтгүй үйл ажиллагаа явуулдагараа онцлогтой юм.

3.2.10. Япон улс⁷⁸-ын хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын онцлог:

XIX зууны хоёрдугаар хагасаас капитализмын хөгжлийн явцад Япон улс барууны орнуудын Эрүү, Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн агуулгыг өөрийн орны нөхцөлд авч хэрэглэх ажиллагаа эхэлжээ. Японы 1882 онд батлагдсан Эрүүгийн хуулийн агуулгын үндсэн үзэл санаанд Францын адил төсөөтэй хуулийн үзэл санаа тусгагдсан байна. Харин одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд XX зууны эхэн үед Герман улсад хэрэглэгдэж байсан зохих хуулийн агуулгыг тусган баталжээ. Дэлхийн II дайны дараа Япон улс өөрийн орны эрүүгийн хууль тогтоомждоо үндэсний онцлогоо тусгасан дорвитой өөрчлөлтүүдийг удаа дараа хийсэн байна. Япон улсын Шоронгийн тухай хууль 1908 онд батлагдан зохих нэмэлт, өөрчлөлт орсоор XX зуунтай золгосон ажээ. Мөн 1950 онд "Суллагдагчдад тусламж үзүүлэх тухай", 1958 онд "Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай" хуульд батлагдан гарч үйлчлэх болов. Түүнчлэн "Шоронгийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн зарчим", "Ялтныг ангилах

⁷⁸ М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. 2020 он., УБ хот. 94-106 дахь тал.

тухай товч удирдамж” нэртэйгээр дээд байгууллагын баталсан эрхийн актууд нь ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад хамаарагддаг байна.

Япон улсын ял нь бага хэмжээний торгууль, торгууль, эрүүгийн баривчилгаа, албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих, цаазаар авах гэсэн төрөлтэй байдаг. Торгох нь хамгийн өргөн хэрэглэгддэг ялын төрөл юм.

Нийт шийтгүүлэгчдийн 90 орчим хувь нь торгох ялд хамаарагддаг. Энэ нь нэгд, авто замын осол зөрчилтэй холбогдсон гэмт хэрэг их гардаг, хоёрт, богино хугацааны хорих ялыг аль болох цөөн оногдуулах эрмэлзлэлтэй байдаг зэргээр тайлбарлагдана. Эрүүгийн баривчлах ялыг хор хохирлоор бага хэрэг үйлдэгчдэд 1-30 хоногийн хугацаагаар оногдуулдаг байна.

Албадан хөдөлмөрлүүлэх буюу албадан хөдөлмөрлүүлэхгүй хорих ялыг 1 сараас 15 жил, эсхүл бүх насаар нь хорихоор оногдуулдаг. Бүх насаар нь хорихоор ял оногдуулдаг гэх боловч тэр нь харьцангуй ойлголт юм. Хэрэв бүх насаар нь хорих ялаар шийтгүүлэгчид 10 жил хорих ял эдэлж засрал олсноо харуулсан бол хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болдог байна.

Япон улсын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих, баривчлах байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага багтана.

Японы ял эдлүүлэх байгууллага нэлээд төвлөрсөн байдалтай боловч нарийвчилсан ангилалтай байдаг.

Хорих ял шийтгүүлсэн бүх хоригдол эхлээд ангилан хуваарилах төвд ирдэг, дараа нь тэднийг доорх байдлаар хуваарилан ялыг нь эдлүүлдэг байна.

- Бага, багавтар хэмжээний гэмт хэрэг үйлдэгчид;
- Гадаадын иргэд;
- 8-аас дээш жил ял эдлэх хүмүүс;
- 20 хүртэлх насны залуучууд;
- Сэтгэцийн болон бусад өвчнөөр өвчлөгчид, биеийн эрүүл мэндээр сул дорой хүмүүсийг тус тусад нь байлгаж ял эдлүүлдэг.

Японд хоригдолд засрал олгох үндсэн хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах эрх зүйн үндэс нь хөдөлмөрийн хууль юм. Хоригдол өдөрт 8, долоо хоногт 44 цаг ажилладаг байна. Хоригдлын дунд нөлөөллийн ажил зохиохдоо аль болохоор олныг хамарч хавтгайруулахгүй байхыг хичээдэг онцлогтой. 2006 оны 11 дүгээр сард БНХАУ-ын Тянжин хотод болсон Ази, номхон

далайн орнуудын хорих байгууллагын удирдах ажилтны 36 дугаар бага хуралд профессор Кожи Ёшимарагийн тавьсан илтгэлд Япон улсын хорих ял эдлүүлэх байгууллагын сүүлийн үеийн байдал, шинэчлэлт, өөрчлөлтийн талаар нэлээд дэлгэрэнгүй тусгасан байна.Тэрээр илтгэлдээ:

-Сүүлийн 10 жилийн дунджаар гэмт хэргийн болон ял эдлэгчдийн тоо буурсан;

- Харин эмэгтэй ялтан болон өндөр настай ялтны тоо өссөн, тэдэнд зориулсан төсөл, хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгаа тухай, түүнчлэн олон нийтийн байгууллагын ажиллагааны талаар:

Японд ялтныг ялын хугацаанаас өмнө суллахдаа олон нийтийн байгууллагатай хамтарсан нийгэмшүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулсны дараагаар сулладаг. Энэхүү үйл ажиллагаа нь тухайн ялтныг суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд тухайн ялтан “Чин сэтгэлийн ухаарал” олсон байх нь ялын хугацаанаас өмнө суллах үндэслэл болдог. Энэхүү ажиллагаа нь зөвхөн ялын хугацаанаас өмнө суллагдах ялтанд чиглэдэггүй, ялын хугацаанаас өмнө суллагаад нийгмийн дунд амьдарч байгаа хүмүүст зөвлөгөө өгч тэдэнтэй хамтран ажиллахад чиглэдгээрээ онцлогтой.

Ялтнууд “Чин сэтгэлийн ухаарал” олсон байх нь маш чухал бөгөөд ингэж ухаарснаараа тухайн ялтан дахин гэмт хэрэг үйлдэх магадлал нь буурч, ялын хугацаанаас өмнө суллагдсаны дараа эрүүгийн ял эдлүүлэх байгууллагаас явуулдаг аливаа хөтөлбөрт идэвхтэй оролцож, хариуцлагатай ханддаг.

Японы хорих байгууллагын холбоо нь суллагдсан ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын бодлогод тусгаж өгсөн. Жишээ нь; 2015 онд анх санаачилж, 2016 онд дахин шинэчилсэн “Үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Гэмт хэрэг дахин бүү үйлд, тэднээр гэмт хэрэг дахин бүү үйлдүүл”, “Илүү гэрэл гэгээтэй нийгмийг байгуулахын тулд нийгмийн гишүүн бүр нийгэмшүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцъё” уриатай хөтөлбөр юм. Эдгээр хөтөлбөрүүд дараахь 10 асуудалд илүү анхааран ажилладаг. Тухайлбал,

1.Ялтанд чиглэсэн илүү үр дүнтэй засан хүмүүжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.Ялтныг суллагдсаны дараа тэднийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх

3.Насанд хүрээгүй ялтнуудад төрөлжүүлсэн боловсрол олгох;

4.Өндөр настай ялтнуудад чиглэсэн тусгай засан хүмүүжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

5.Эрүүгийн ял эдлүүлэх байгууллагад ажиллаж байгаа эмэгтэй алба хаагчдыг урам зоригтойгоор ажлаа хийхэд нөлөөлөх зорилгоор эрх зүйн байдлыг дээрдүүлэх;

6.Хорих ангийн удирдлагууд нээлттэй, ил тод байдлыг дэмжин ажиллах;

7.Нийтийн дунд тархсан хорих ангийн талаарх таагүй ойлголтыг тайлбарлан сурталчилж сайжруулах;

8.Газар хөдлөлтөд тэсвэртэй хорих анги барьж байгуулах;

9.Хорих анги дахь эрүүл мэндийн үйлчилгээг улам сайжруулах;

10.Хорих ангид ажилладаг офицеруудын үүргийн талаарх ойлголтыг сайжруулахаас гадна тэдний албан үүргээ гүйцэтгэх орчин, нөхцөл, хангамжийг улам сайжруулах чиглэлийн ажил багтана.

Эдгээрээс гадна алба хаагчдын боловсрол, тэр тусмаа ялтантай харилцахад шаардагдах мэдлэг, үр чадварыг олгохыг илүү эрмэлздэг бөгөөд алба хаагчдаа сургалтад хамруулах ажил тогтмолжсон.

Профессор Кожи Ёшимараагийн илтгэлд онцлон дурдсан, ялангуяа Япон улсын хорих ял эдлүүлэх байгууллагад “Хорих байгууллагын холбоо” болон олон хэлбэрийн уриа бүхий хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа зэрэг нь Монгол улсын хувьд туршлага болох сайн жишээ гэж үзэж байна.

А) Эмэгтэй ялтны тоо жилээс жилд өсөж байна. Сүүлийн жилүүдэд хорих байгууллагад хийгдсэн нэг томоохон ажил бол “эрүүгийн ял эдлүүлэх байгууллага дахь эмэгтэйчүүдэд зориулсан бүс нутгийн дэмжпэг” төсөл хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бүс нутгуудад эрүүгийн ял эдэлж байгаа эмэгтэй ялтан болон алба хаагчидтай долоо хоногт хэд хэдэн удаа мэргэжлийн эмч, эрүүл мэндийн ажилтан, сувилагч нар шууд уулзаж эрүүл мэндийн үзлэг хийж, тэдний асуусан асуултад хариулж, зөвлөгөө өгөх явдал байдагт оршино.

Б) Эрүүгийн ял эдэлж буй хоригдогчдын дунд өндөр настай хүмүүсийн эзлэх хувь нь улам өсөж байна. 60 буюу түүнээс дээш настай хоригдогчдын тоо 2015 онд 3700-д хүрч, нийт ял эдэлж буй хоригдлуудын 17,1 хувь болов. Өндөр настай хоригдогчдыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх болон тэднийг нийгэмшүүлэх зорилгоор эрүүгийн ял эдлүүлэх байгууллага нь:

-Тэдний ажлын нөхцөлийг болон хүнс тэжээлийг сайжруулах;

-Тэдэнд эрүүл байхын ач холбогдлыг ойлгуулах, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн систем болон бусад холбогдох асуудлаар зөвлөгөө өгөх;

-Танин мэдэхүйн чадвар болон биеийн хөгжил нь буурсан хоригдогч нарт туслалцаа үзүүлэх;

-Суллагдсаны дараа дэмжлэг, халамж хэрэгтэй байгаа ялтнуудын амьдралд туслах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, хорих ангийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор Хорих байгууллагын товчоо “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2015 онд анх санаачилж, 2016 онд дахин шинэчилсэн юм. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ.

-Давтан гэмт хэрэг үйлдэхийг бууруулахад нөлөөлж чадахуйц засан хүмүүжүүлэх үйл ажиллагаа явуулах;

-Эмэгтэйчүүдийн эрүүгийн ял эдлүүлэх нөхцөлийг сайжруулах, холбогдох журмыг улам илүү боловсронгуй болгох;

-Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал юм.

3.2.11. Канад улсын хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын онцлог:

Канадын Хорих байгууллага буюу CSC (англи товчлол) нь эрүүгийн гэмт хэрэг үйлдэж хоёр болон түүнээс дээш жилээр ял шийтгэгдсэн этгээдийг засан сайжруулж, нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий Канадын холбооны засгийн газрын байгууллага юм. Энэхүү байгууллагын төв нь Оттавад байрладаг.

Канадын уугуул иргэд болон уугуул биш иргэдийн хоорондын зөрчилдөөний улмаас үүсэж байгаа гэмт хэргийн гаралтыг бууруулахын тулд эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх хэрэгтэй гэж хорих байгууллагын зүгээс үздэг байна.

Канадын хорих байгууллагын системийг өргөн цар хүрээтэй, засан хүмүүжүүлэх ажиллагааг илүү үр дүнтэй байлгах үүднээс засгийн газрын харьяа болон засгийн газрын бус байгууллагуудтай хамтын ажиллагаа явуулж байна. Үүнтэй холбоотойгоор Канадын анхны сайн дурын байгууллагуудын холбоог үүсгэн холбооны хамтрагчаар доор нэр дурдсан байгууллагууд ажилладаг.

Засгийн газрын байгууллага, агентлаг:

- Канадын хорих байгууллага;
- Канадын эрүүл мэндийн байгууллага;
- Хорих байгууллагын мөрдөн байцаах алба;
- Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирсон “Омбудсман” /хүний эрхийн/ хохирогчдын байгууллага;
- Ялын хугацаанаас өмнөх суллах асуудал эрхэлсэн зөвлөл;
- Орон нутгийн засаг захиргаа;
- Канадын эрүүл мэндийн байгууллага буюу Засгийн газрын бус

байгууллага: “Жон Ховард” нийгэмлэг

- Канадын хорих байгууллагын “Элизабет фрай” нийгэмлэг;
- “Квебек” нийгэмлэгийн нөхөн сэргээх байгууллагуудын холбоо;
- Хорих байгууллага дахь аврагч арми болон хууль зүйн үйлчилгээ үзүүлэх алба;
- Канадын “Гэгээн Леонардын” нийгэмлэг.

Хүчирхийлэл, хүнд гэмт хэрэг олон удаа давтан үйлдсэн гэмт хэрэгтний тоо нэмэгдэж байгаагаас гадна галт зэвсэг, зохион байгуулалттай гэмт хэрэг, түүхийн үнэт өвийг устган сүйтгэсэн гэмт хэргийн тоо мөн нэмэгдэж байна. Эдгээр гэмт хэрэг үйлдэгчдийн ихэнх хувийг элэгний С вирус, ДОХ болон оюун ухааны самууралтай уугуул иргэд эзэлж байна.

- 10 хоригдогч тутмын 9 нь гэмт хэрэг давтан үйлдэж байсан хэрэгтэн байна.

- Хоригдогчид дайсагнасан, түрэмгийлсэн, хүчирхийллийн гэмт хэрэг дахин давтан үйлдсэн олон удаагийн эрүүгийн гэмт хэрэгтнүүд байна;

- Гэмт хэрэг үйлдэгчдийн ихэнх нь өндөр хамгаалал бүхий хорих ангид ял эдлүүлэхээр шийтгэгдэж байна;

- 6 эрэгтэй ялтан тутмын 1 нь, 10 эмэгтэй ялтан тутмын 1 нь галт зэвсэг, зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдож ял эдэлж байна;

- Оюун ухааны самууралтай эрэгтэй ялтны тоо 12%, эмэгтэй ялтны тоо 26% болж тус тус өссөн байна;

- Ойролцоогоор 5 хоригдогч тутмын 4 нь ямар нэгэн төрлийн сэтгэцэд нөлөөлөх бэлдмэл хэрэглэдэг, 2 хоригдогч тутмын 1 нь хар тамхи хэрэглэсэн, мансууруулах, согтууруулах эм бэлдмэл, бодис хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдсэн байна. Канадын хорих байгууллага нь аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавин нийтийн аюулгүй байдалд тогтмол анхаарал хандуулахын зэрэгцээгээр албан хаагч, хоригдогчдыг аюулгүй, найдвартай ажлын байраар болон амьдрах орчноор ханган ажилладаг⁷⁹.

⁷⁹ М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. 2020 он., УБ хот. 98 дахь тал.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ

4.1.Дүгнэлт

Монгол Улсын хорих байгууллагын хөгжлийн явцад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх явцад тэднийг сургах-хүмүүжүүлэх явдлыг нэн тэргүүний зорилгоо хэмээн тодорхойлж үйл ажиллагаагаа явуулж ирсэн билээ.Тухайлбал, 1925 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн Засгийн газрын 16 дугаар хурлын 4 дүгээр зүйлд баталсан “Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм”-д: Ялтан нарт лекц хэмээн сайн суртал журам, одоо цагийн улс төрийн шинэ хуучин байдал зэргийг ялган салгаж тодорхойлон хэлж ухуулахуйд олон сургуулийн багш, оюутан, сургуулийн шавь нар мэтийн эрдэмтнийг урин ирүүлж ухуулан гэгээрүүлбээс тустай бөгөөд одоо гяндангийн газар байшин савгүй тул энэ лекцийг өдрийн дулаан сайныг үзэж сар бүр хоёр удаа гяндангийн хашаан дотор ухуулан уншуулж, сэнхрүүлэн хэрэглэвээс зохино, 1929 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын 19 дүгээр хурлын 1 дүгээр зүйл, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлын 2 дугаар зүйлд баталсан “Аливаа хэрэгтэн, ялтнаар ажил, үйлдвэр хийлгэх тухай дүрэм”-д Ялтны хөдөлмөрийн зорилгыг “Хоригдогсдын ажил үйлдвэр бол тэднийг сургаж боловсруулах ба засан сайжруулахыг хичээсэн хэрэг болно, хоригдогсдоор ажил үйлдвэр хийлгүүлэх нь тэднээр ажил үйлдвэр хийлгэж дадал олгохоос гадна аливаа ажил үйлдвэрийн зүйлүүдээс нэгийг сурваас гяндангаас гарахдаа ажил хийж амьдарч чадах болно” гэж тодорхойлсон байна.

Түүнчлэн үе үеийн эрүүгийн хууль тогтоомжид ялын зорилгыг хуульчлахдаа 1926, 1929, 1934 оны Шүүх цаазны бичигт ... нэгэнт гэмт хэрэг үйлдэгсдийг засруулах гэж тодорхойлоод ял шийтгэх явдал нь хүний бие махбодыг зовоох буюу хүн гэсэн нэр төрийг доромжлох зорилготой байж үл болно, 1942 оны Эрүүгийн хуульд ... гэмт явдал үйлдэгсдийг засан хүмүүжүүлэх, 1961 оны Эрүүгийн хуульд "ял шийтгэх явдал бол шийтгэгчдийг хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын ажил байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгон засан хүмүүжүүлэх, тэрчлэн шийтгэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс ба бусад гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой, 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд ... засан хүмүүжүүлэх болон дахин хүмүүжүүлэх, 1993 оны Эрүүгийн хуульд ... засан хүмүүжүүлэх, 2002 оны Эрүүгийн хуульд ... хүмүүжүүлэх, 2015 оны

Эрүүгийн хуульд ... гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зэргээр заажээ.

1921-1990 он хүртэлх хугацаанд явцад хорих ял эдлүүлэх ажиллагаанд гэмт хэрэг үйлдсэн ялтныг социалист амьдарлын хэв маяг, үзэл суртлаар сурган хүмүүжүүлэх, нийтийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд түлхүү анхаарал хандуулж ирсэн бол 1990 оноос хойш хоригдлыг нийгэмшүүлэх асуудлыг хуульчлан хэрэгжүүлж иржээ.

Хүний нийгмийн амьдралд оролцон, хөгжиж төлөвших, зохицон амьдрах чадвар эзэмших нь нийгэмшлийн үндсэн асуудал бөгөөд үүнийг судлан үзэхэд эн тэргүүний шалгуурын үзүүлэлтийн нэг болох хүний хөгжлийг судлан тодорхойлох, түүнийг үнэлэх, хөгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулсаар иржээ. Нийгмийн ажил нь хүний сайн сайхан, тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн шинжлэх ухаан болон хөгжиж байна.

Нэг.Судалгааны ажлын удирдлага, зохион байгуулалт:

Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохдоо эрдэм шинжилгээ, судалгаа-боловсруулалтын ажлын нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, ажиглалт болон ярилцлагыг ашиглаж боловсруулалт хийсэн болно.

Хорих ял эдэлж буй хоригдлуудаас сонгон зөвхөн урьд хорих ял эдэлж байсан 1289 буюу нийт хоригдлын 30,2%-иас нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний талаар судалгаа авлаа. Хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх зорилго бүхий асуулгыг хорих ангийн 50 нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдээс авч дүнг судалгааны ажилдаа ашигласан болно. Түүнчлэн нийт 21 хорих ангийн 2015-2020 оны нийгэмшүүлэх ажлын чиглэлээр хийгдсэн тайлан, мэдээ болон нийгмийн ажилтан, нийгмийн ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийсэн болно.

Хорих ангиудын нийгэмшүүлэх ажлын тайлан нь нэгдсэн стандарт, загваргүй учраас нэгтгэх, үр дүнг тооцоход хүндрэлтэй байлаа.

Хоёр.Нийгмийн ажлын эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхэлжээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсон ба тухайлбал, хорих ял эдлүүлэх төрөл, дэглэм, зэрэглэлийг шинээр тогтоон нээлттэй, хаалттай хорих анги, энгийн ба

тусгай зэрэглэл, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой болон бусад асуудлуудыг шинээр хуульчилж өгсөн байна. Тухайлбал, 2017 онд шинээр баталсан ШШГТХ-д анх удаа нийгэмшүүлэх ажил, нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт гэсэн тусгай зохицуулалт тусгагдсан. Тухайлбал уг хуулийн 218 дугаар зүйлийн 218.1-д “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”, 219 дүгээр зүйлийн 219.1-д “Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэжээ.

Шинэ хуульд нийцүүлэн ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 тоот тушаалаар “Нийгмийн ажлын аргачилсан заавар”, 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн сэтгэл зүйн ажлын заавар”-ыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа даган мөрдөж байна. Хорих ангиудын нийгэмшүүлэх ажлын зааврын биелэлт 55-75 орчим хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл энэ нь нийгмийн ажлын зааварт байна уу, эсвэл үйл ажиллагаа, зохион байгуулалтандаа байна уу гэдгийг анхаарах цаг нэгэнт болжээ.

Өнөөгийн байдлаар хоригдогчийг нийгэмшүүлэх чиглэлээр зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хязгаарлахгүйгээр хорих байгууллагаас суллагдсан хүнд тавих хяналт, бусад чиглэлээр холбогдох зарим хууль тогтоомжид тусгалаа олсон байна.

Судалгааны ажлын явцад 1293 хоригдлоос “та хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлыг хэрхэн ойлгодог вэ” гэсэн асуултад 514 буюу 40% нь хүний эрхийг хангахад чиглэсэн үйлчилгээ, 189 буюу 14% нь ахуй нөхцөлийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээ, 359 буюу 28% нь сургалтын үйл ажиллагаа, 231 буюу 18% нь сайн мэдэхгүй гэж хариулсан нь хоригдлууд дийлэнхи нь нийгэмшүүлэх ажил гэж юу болох, ямар учраас тухайн ажлыг явуулах ёстой талаар нэгдсэн ойлголт байхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Гурав.Нийгэмшүүлэх ажлын үр нөлөө:

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө, гэрээг онолын үндэслэлгүй, оновчгүй төлөвлөх, хэрэгжиж буй хөтөлбөр, төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтэд явцын үнэлгээ хийдэггүй, нийгэмшүүлэх ажлыг мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах хэлбэрээр хязгаарлах, нийгэмшлийн байдлыг мэргэжилтэн (нийгмийн ажилтан)-ий хувийн үнэлэмжээр дүгнэдэг зэргээс шалтгаалан хорих анги дахь нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ нь төдийлөн үр дүнтэй бус байна.

Нийт суллагдсан хоригдлуудаас зөвхөн хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоосон хоригдлуудыг судлан үзвэл 2015 онд 1167 буюу 33,8% , 2016 онд 997 буюу 75,3%, 2017 онд 1115 буюу 38,2%, 2018 онд 1068 буюу 58,9%, 2019 онд 1414 буюу 55,8% нийт-5761 буюу 47,8% нь суллагдсан байна. Дээрх хугацааны өмнө суллагдсан хоригдлууд нь бүгд засрал хүмүүжлээ олсон, бүрэн нийгэмшсэн гэсэн үндэслэлээр суллагдсан байгаа ба давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 70 орчим хувь нь дээрх хугацаанд хамаарч байгаа нь нийгэмшүүлэх ажлын үр нөлөөнд эргэлзээтэй байдлыг төрүүлж байна.

Дөрөв.Нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт:

Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ба хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана. Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна.

Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, үр чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.

Хоригдлуудаас “хорих ангийн нийгмийн ажлын үр дүнг дээшлүүлэхэд юун дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна вэ” гэсэн асуултад 374 буюу 29% нь сургалтыг түлхүү явуулж мэргэжил, боловсрол эзэмшүүлэх, 158 буюу 12% нь сэтгэл зүйн үйлчилгээг сайжруулах, 235 буюу 18% нь төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай, 220 буюу 17% нь гэр бүл, найз нөхөдтэй нь холбох ажлыг сайжруулах, 212 буюу 17% нь суллагдсаны дараа ажилд зуучилж өгөх, 83 буюу 7% нь хорих ангийн орчин нөхцөлийг сайжруулах гэж хариулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны гүйцэтгэх үндсэн чиг үүрэгт хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэх, мэргэжлийн боловсрол, холбогдох сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох чиглэлээр санал боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг тусгасан байдаг. Харин шүүхээс оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх чиг үүрэг бүхий хорих анги нь хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох үйл ажиллагааг явуулах үүрэгтэйг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгажээ.

Хорих ангид явуулах нийгэмшүүлэх ажил нь өнөөгийн мөрдөгдөж буй хууль тогтоомж, нийгэмшүүлэх ажлын онолын хувьд явуулж буй хэлбэр нь эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх зэрэг зөвхөн “Сургалт”-ын хүрээнд явагддаг болох нь харагдаж байна.

Хорих ангиудад 2015 онд-1307, 2016 онд-1403, 2017 онд-2234, 2018 онд-2896, 2019 онд-8355 хоригдол сургалтад хамрагдсан гэсэн тоо баримт байгаа боловч судалгаанаас харахад 80-90% нь бясалгалд хамрагдсан буюу сэтгэл заслын үйлчилгээнд хамрагдсан байна. Хоригдлуудаас “та ямар төрлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна вэ” гэсэн асуултад 241 буюу 19 хувь нь боловсрол эзэмших, 372 буюу 29 хувь нь мэргэжил эзэмших, 156 буюу 12 хувь нь гадаад хэлний сургалтад хамрагдах, 157 буюу 12 хувь нь түргэвчилсэн сургалтаар нарийн мэргэжил эзэмших, 293 буюу 23 хувь нь мэдлэг боловсролоо дээшлүүлэх бүхий л төрлийн сургалтад хамрагдах, 62 буюу 5 хувь нь ямар ч сургалтад хамрагдах хүсэлгүй гэж хариулсан.

ШШГЕГ-ын харьяа нийт 21 хорих ангид хоригдолд зориулсан сургалтын танхим, орчин, багтаамжийн талаарх судалгааг анги тус бүрээр гарган үзвэл, 6 хорих анги зориулалтын сургалтын танхимгүй, хоолны заал, бясалгалын өрөө, номын санд сургалтыг зохион байгуулж байна. Түүнчлэн сургалтын танхимтай хэдий ч дийлэнхи хорих ангиуд сургалт явуулах техник хэрэгсэл, сургалтын материал байхгүй байна.

Тав. Нийгмийн ажилтан, түүний чиг үүрэг:

2003 оноос эхлэн хоригдлыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий "Нийгмийн ажилтан"-ны орон тоо батлагдсанаар өнөөгийн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийгмийн ажилтан ажиллах болж, 2006 оноос "Сэтгэл зүйч"-ийн орон тоог бий болгосноор одоогийн "Хорих байгууллагын нийгмийн ажилтан-сэтгэл зүйч" гэсэн нэр томъёо гарч ирсэн байна. 2008 оны 2 дугаар сараас ШШГЕГ-т "Сургалт, нийгмийн ажлын тасаг"-ийг бий болгож, 2010 онд онд "Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтэс", 2012 оноос "Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс" нэртэйгээр өргөтгөн зохион байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийгмийн ажлын аргачилсан зааварт зааснаар нийгмийн ажилтан гэж хорих байгууллагын нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагчийг ойлгоно гэжээ.

2020 оны 5 дугаар сарын 01-ны байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих байгууллагад нийгмийн ажилтан-52, сэтгэл зүйч-29 ажиллаж байна. Дээрх алба хаагчдыг бакалаврын боловсрол эзэмшсэн мэргэжлээр нь судлан үзвэл, нийгмийн ажилтны орон тоонд ажиллаж байгаа алба хаагчдаас: нийгмийн ажилтан мэргэжилтэй-15, эрх зүйч-36, эдийн засагч-1, сэтгэл зүйч орон тоонд ажиллаж байгаа алба хаагчдаас: сэтгэл зүйч-14, эрх зүйч-11, нийгмийн ажилтан-1, багш-3 байна. Нийгмийн ажил нь өөрөө шинжлэх ухааны түвшиний мэргэжлийн үйл ажиллагаа байдаг тул өөр мэргэжлийн алба хаагч явуулах боломжгүй юм.

Нийгмийн ажилтнуудаас "хорих ангид явагдаж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд юунд дээр анхаарвал зохистой гэж үздэг вэ" гэсэн асуултад 9 буюу 16% нь удирдлагын дэмжлэг, 19 буюу 34% нь эрх зүйн зохицуулалтын оновчтой байдал, 20 буюу 36% нь төсөв, хөрөнгийн дэмжлэг, 6 буюу 11% нь төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, 2 буюу 3% нь бусад зүйлд анхаарах шаардлагатай гэж хариулсан. Түүнчлэн "та хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч албан тушаалд ажиллах дүр сонирхолтой юу" гэсэн асуултад 41 буюу 82% нь тийм, 1 буюу 2% нь үгүй, 8 буюу 16% нь албан тушаалаа өөрчлөх сонирхолтой гэж хариулсан. Судалгаанаас харахад нийгмийн ажилтны үйл

ажиллагаанд үзүүлэх дэмжлэг, түүнд тавих хяналтын асуудлыг тусгайлан бодлогын түвшинд авч үзэх шаардлага нэгэнт үүсчээ.

Зургаа.Гадаадын зарим орны нийгэмшүүлэх ажлын туршлага:

Нийгэмшүүлэх үйл ажиллагаанд хамаатуулж болох “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”зэрэг түгээмэл баримт бичиг болон “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм”, “Хоригдолтой харьцах үндсэн зарчим”, “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүстэй холбогдуулан НҮБ-аас гаргасан журам”/ зэрэг олон улсын эрх зүйн эх сурвалж, түүний агуулга Монгол Улсын үндэсний хууль тогтоомжид нэгэнт хангалттай тусч өгсөн байна.

Гадаадын ихэнхи орны хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх явдал мөн гэж тодорхойлон, түүнийгээ хэрэгжүүлэхэд тусгайлсан “хөтөлбөр”-үүдийг хэрэгжүүлэх, үүндээ төр, төрийн бус байгууллага, иргэд, хоригдлын өөрсдийн оролцоог өргөнөөр ашигладаг байна.

4.2.Зөвлөмж

1.Монгол Улс эрүүгийн ялын гүйцэтгэлийн үндсэн бодлого буюу хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилгоо нийгэмшүүлэх асуудал гэж тодорхойлж, үүнийгээ эрх зүйн зохицуулалтын хүрээнд баталгаажуулах;

2.Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос “Төрөөс нийгмийн ажлын талаар баримтлах бодлогын баримт бичиг”-ийг боловсруулахаар ажлын хэсэг гарч, хэлэлцэгдэж буй энэ үед хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх асуудлыг зохицуулсан үзэл санааг тусгаж өгөхөөр санал гаргах;

3.Нийгэмшүүлэх ажлыг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх заавар” болгон шинэчлэн боловсруулан, тус зааварт хорих болон хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн болон, хорихоос суллагдсан хүмүүсийг хэрхэн нийгэмшүүлэх, түүнд төр, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, хөрөнгө, санхүүг шийдвэрлэх талаар тусган Нийгэм, хамгаалалын болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Сайд нарын хамтарсан тушаалаар батлуулан, нийт улсын хэмжээнд дагаж мөрддөг байх;

4.Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажил нь зөвхөн журам, зааврын хүрээнд хэрэгжихгүй гэдэг нь нэгэнт тодорхой тул зорилтот бүлэгт тохирсон хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх;

5.Хоригдол боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшүүлэх хүрээнд бичиг үсгийн, ерөнхий боловсролын, мэргэжлийн боловсролын, амьдрах ухааны гэсэн төрлөөр тодорхой дагнасан хөтөлбөрийг холбогдох мэргэжилтнүүдийн тусламжтайгаар “Хоригдолд боловсрол олгох хөтөлбөр”-ийг боловсруулах;

6.Хорих ял эдлүүлэх албаны Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс нь нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрүүдийг боловсруулан нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

7.Нийгмийн ажилтнуудын ажлын байрны үйл ажиллагаа, чиг үүрэг, гүйцэтгэлтэд мониторинг хийн аттестачлан, мэргэшсэн нийгмийн ажилтны нөөцийг бүрдүүлэх зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг.Хууль,тогтоомж:

Үндсэн хууль

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай

Нийгмийн ажилтны аргачилсан заавар

Сэтгэл зүйн ажлын заавар

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага:

Ж.Амарсанаа “”Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь”, УБ. 2004

Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.,2018 он

Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.,2019 он

М.Алтан-Очир.Хорих ял эдлүүлэх дэглэм.УБ.,2020 он

А.Думбарай, А.Лхагва, Л.Чүлтэмсүрэн. БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар гарсан хууль, эрхийн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1991

М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон Улсын эрх зүй. УБ., 1999

А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2011

А.Лхагва. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт /1931-2005/. УБ.,2005 он

А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012

С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008

Б.Туяа. Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид.УБ.,2003

Л.Уранцэцэг, М.Дэлгэржав. Нийгмийн сэтгэл судлал. УБ.,2012

А.Гидденс. Социологи.УБ.,2006

Д.Солонго. Хувь хүнтэй ажиллах нийгмийн ажил. УБ., 2010

С.А.Лузгин, М.И. Кузнецов, В.Н. Казанцев, Хорих байгууллагын нийгмийн ажил: Сургалтын гарын авлага. Орос хэлнээс орчуулсан Д.Шатарбал. УБ. 2009

О.Пүрэвсүрэн. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2014

Каратис Чех ТББ.Хорих байгууллага дахь нийгмийн ажил.УБ.,2015
ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан
Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ.,
2014

Гурав.Гадаад хэл дээрх материал

А.Я.Сухарев "Российская юридическая энциклопедия" М.1999;
ДавыдоваВ.В, Запорожца А.В(ред.),Психологический словарь. 1983
Фролов И.Т. (ред.). Философский словарь., 2001, Москва
Robert L. Barker, Douglas M. Branson. Forensic Social Work. Legal
Aspects of Professional Practice, 1993. The Haworth Press, Inc., Binghamton,
NY

Sergei Ivanovich Zlobin. "Re-socialization of Prisoners in Russia at the
Present Stage". World Appl.Sci. 26(5)J.,2013.

Victoria Miceli. "Analyzing the Effectiveness of Rehabilitation Programs".
University of Rhode Island., 2009

MacKenzie, Doris L."What Works in Corrections: reducing the criminal
activities of offenders and delinquents". Cambridge University Press., 2006

Prison-based correctional offenderrehabilitation programs. Australian
Institute of Criminology., 2011

American International Journal of Contemporary Research Vol. 3 No. 1;
January 2013

Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовный
кодекс. Москва 2014

МГУ им. М.В.Ломоносова "Уголовно-исполнительное право России"
Москва 2013

Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовно-
исполнительный кодекс. Москва 2007 г., с.3

Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовный
кодекс. Москва 2014

Кодекс Российской Федерации. Официальный текст. Уголовно-
исполнительный кодекс. Москва 2007 г., с.5

Концепция развития уголовно-исполнительной системы до 2020
года. Правительство Российской Федерации. Распоряжение от 14 октября
2010

Строева Г. В.Интеллектуально-этическое развитие личности
осужденного //Педагогический журнал- 2012

Sue titi reid. Criminal justice. 1996

Дөрөв.Судалгааны тайлан, бусад материал:

Н.Гантулга. Ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаан дахь хамтын оролцоо. Хууль сахиулахуй сэтгүүл /тусгай дэвтэр/. УБ., 2015

Б.Сүх-Îчир. Бодит жишээтэй ажиллах арга зүй. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүл. 2014. №3

Г.Баттулга. “Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлж буй олон улсын туршлага” “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2016 он

ШШГЕГ.Сүлд инфо сэтгүүл

ШШГСудлал сэтгүүл

Тав.Цахим хаяг:

www.cd.gov.mn

www.mojha.gov.mn

<http://didacts.ru/termin/socializacija.html>

ХАВСРАЛТ

Нийгэмшүүлэх ажлын заарын хүрээнд хорих ангиудаас хийж гүйцэтгэсэн ажилд өгсөн үнэлгээ:

401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"	2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019		
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	3.2.1	+	+	
	3.3	+	+	+	3.2.2.	+	+	
	3.4	+	+	+	3.2.3			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.5	+	
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3					3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8		+
	4.5	+	+	+		3.2.9		
	4.7							
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+			Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1		
	5.1.2	+	+	+		3.3.2		
	5.1.3	+	+	+		3.3.3	+	+
	5.1.4	+	+	+		3.3.4		
	5.1.6					3.3.5		41
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, тусалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.6		+
	5.2.2	+				3.3.7		
	5.2.3					3.3.8	13	13
	5.2.4	+	+	+		3.3.9		+
	5.2.5					3.3.10		14
	5.2.6	+			3.3.11	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1				3.3.12	+	+	
	5.3.2				3.3.13		+	
	5.3.3				3.3.14			
	5.3.4				Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	2	+
	5.3.6	+	+	+		3.4.2	+	+
	5.3.7	+	+	+		3.4.3		
	5.3.9					3.4.4.		+
	5.3.11			+	3.4.5	11	+	
5.3.12				Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
					4.2			
					4.3.5	+	+	
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн	5.4.1		+		4.3.6		+	
	5.4.2							
	5.4.3				Сургалт	5.2	14	3

нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.4	+	+			5.3	43	+
	5.4.6					5.4	+	+
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1					5.5	+	+
	5.5.2	+	+	+		5.6	+	+
	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4					Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+
	5.5.5	+	+	+	6.2		+	+
	5.5.6				6.3		+	+
	5.5.7			+	6.4		+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
	Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+			
5.6.2		+	+	+				
5.6.3		69	40	39				
5.6.4			+					
5.6.5		+	+	+				
5.6.6		+						
5.6.7								
5.6.8								
5.6.9			+					
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+				
	5.7.2	+	+	+				
	5.7.3							
	5.7.4	+	+	+				
	5.7.5	+	+	+				
	5.7.6	+	+	+				
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

405 дугаар хаалттай хорих анги /тусгай нэгж/

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
	4.1	+	+	+		3.2.5		+
	4.2	+	+	+		3.2.6	+	+

Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.3	+	+		Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9		
	4.7					3.3.1	+	
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1					3.3.2		
	5.1.2	+	+	+		3.3.3	+	+
	5.1.3	+	+	+		3.3.4		+
	5.1.4	+	+	+		3.3.5	31	+
	5.1.6					3.3.6		+
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.7		
	5.2.2	+	+	+		3.3.8	22	+
	5.2.3					3.3.9		+
	5.2.4	+	+	+		3.3.10	15	27
	5.2.5	+	+	+		3.3.11	+	+
	5.2.6		+	+	3.3.12	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	10	+	8	3.3.13			
	5.3.2				3.3.14			
	5.3.3				3.4.1	36	+	
	5.3.4		+	36		3.4.2	+	+
	5.3.6					3.4.3		
	5.3.7	+	+	+		3.4.4		
	5.3.9				3.4.5	+	+	
	5.3.11				4.1	+	+	
5.3.12		+	+	4.2		+		
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1		+	+		4.3.5	+	+
	5.4.2					4.3.6	+	+
	5.4.3				5.2	9		
5.4.4	+	+	+	5.3			25	
5.4.6				5.4	+	+		
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1					5.5		
	5.5.2	+	+		+		5.6	+
	5.5.3		+		+	5.7	+	+
	5.5.4				6.1		+	+
	5.5.5	+	+	+		6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7	+	+	+		6.4	+	+
	5.5.8				Бүртгэл судалгаа мэдээллийн сан			
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3		+	19				

	5.6.4	+	+	+
	5.6.5	+	+	
	5.6.6			
	5.6.7	62	+	10
	5.6.8			
	5.6.9			
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+
	5.7.2	16	+	25
	5.7.3	+	+	+
	5.7.4	+	+	+
	5.7.5	+	+	+
	5.7.6	+	+	+
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+	3.2.5		+	
	4.2	+	+	+	3.2.6	+	+	
	4.3	+	+	+	3.2.7	+	+	
	4.4	+	+	+	3.2.8	+	+	
	4.5	+	+	+	3.2.9	7		
	4.7	+	+	+				
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1		
	5.1.2	+	+	+		3.3.2		
	5.1.3	+	+	+		3.3.3	+	+
	5.1.4	+	+	+		3.3.4		
	5.1.6	+	+	+		3.3.5	+	+
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван	5.2.1	+	+	+		3.3.6	+	+
	5.2.2	+	+	+		3.3.7	89	
	5.2.3	+	+	+		3.3.8	24	32
		+	+	+		3.3.9	+	+
	5.2.4	+	+	+		3.3.10	3	32

туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.5					3.3.11	+	+	
	5.2.6					3.3.12	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	+	+	+		3.3.13	+	+	
	5.3.2					3.3.14	89		
	5.3.3					3.4.1	40	+	
	5.3.4	53	+	+			3.4.2	+	+
	5.3.6	+	+	+			3.4.3		
	5.3.7	+	+	+			3.4.4.		
	5.3.9					3.4.5	15	+	
	5.3.11					4.1	+	+	
5.3.12				4.2	+				
				4.3.5	+		+		
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1				4.3.6	+	+		
	5.4.2					5.2	29	22	
	5.4.3					5.3	30	58	
	5.4.4	+	+	+	5.4	100	+		
	5.4.6				5.5	+	+		
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				5.6	+	+		
	5.5.2	+	+	+		5.7	+	+	
	5.5.3	+	+	+		6.1	+	+	
	5.5.4						6.2	+	+
	5.5.5	+	+	+	6.3		+	+	
	5.5.6				6.4		+	+	
	5.5.7	+	+	+					
	5.5.8	+	+	+					
	5.5.9	+	+	+					
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+					
	5.6.2	+	+	+					
	5.6.3	2112	186	117					
	5.6.4	+	+	+					
	5.6.5	+	+	+					
	5.6.6								
	5.6.7	1226	834	408					
	5.6.8								
	5.6.9	+	+	+					
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+					
	5.7.2	+	+	+					
	5.7.3	+	+	+					
	5.7.4	+	+	+					
	5.7.5	+	+	+					
	5.7.6	+	+	+					
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+					

7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх	+	+	+
--	---	---	---

409 дүгээр хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"	2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019			
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+		
	3.3	+	+		3.2.2	+	+		
	3.4	+	+		3.2.3				
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+		3.2.5		+		
	4.2	+	+		3.2.6		+		
	4.3	+	+		3.2.7	+	+		
	4.4				3.2.8	+	+		
	4.5	+	+		3.2.9	20			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+		3.3.1				
	5.1.2	+	+		3.3.2		+		
	5.1.3	+	+		3.3.3		+		
	5.1.4	+	+		3.3.4		305		
	5.1.6				3.3.5	356	305		
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+		Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.6	+	+	
	5.2.2	+	+	3.3.7					
	5.2.3			3.3.8		+	19		
	5.2.4	+	+	3.3.9		+	+		
	5.2.5			3.3.10		62	79		
	5.2.6			3.3.11		+	+		
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	+	14	12		3.3.12	+	+	
	5.3.2					3.3.13	+	+	
	5.3.3					3.3.14			
	5.3.4	+	17	59		Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1		+
	5.3.6						3.4.2		+
	5.3.7	+	+	+			3.4.3		
	5.3.9						3.4.4		+
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг	5.3.11					3.4.5		+	
	5.3.12	+	+		Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
	5.4.1					4.2			
5.4.2	+	+		4.3.5			+		
					4.3.6		+		

өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.3				Сургалт	5.2	17		
	5.4.4	+	+	+		5.3	18	18	
	5.4.6					5.4	+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1					5.5		+	
	5.5.2	+	+	+		5.6	+	+	
	5.5.3	+	+	+		5.7	+	+	
	5.5.4	+	+			Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+
	5.5.5						6.2	+	+
	5.5.6						6.3	+	+
	5.5.7				6.4		+	+	
	5.5.8	+	+	+					
5.5.9	+	+	+						
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+					
	5.6.2	+	+	+					
	5.6.3	+	183	721					
	5.6.4	+	+	+					
	5.6.5								
	5.6.6								
	5.6.7	+	289	425					
	5.6.8								
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+					
	5.7.2	+	+	+					
	5.7.3	+	+	+					
	5.7.4	+	+	+					
	5.7.5	+	+	+					
	5.7.6	+	+	+					
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+					
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+					

413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.	+	+
	3.4	+	+	+		3.2.3		

Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5		+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9	18	
	4.7	+	+	+		3.3.1		+
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.2		
	5.1.2	+	+	+		3.3.3	+	+
	5.1.3	+	+	+		3.3.4	+	
	5.1.4	+	+	+		3.3.5	27	+
	5.1.6					3.3.6	+	+
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.7	+	
	5.2.2	+	+	+		3.3.8	11	+
	5.2.3	+	+	+		3.3.9	+	+
	5.2.4	+	+	+		3.3.10	29	87
	5.2.5					3.3.11	+	+
	5.2.6					3.3.12	+	+
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	+	+	+		3.3.13		+
	5.3.2					3.3.14		
	5.3.3					Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	55
	5.3.4	+	+	+	3.4.2		+	+
	5.3.6				3.4.3			
	5.3.7	+	+	+	3.4.4			+
	5.3.9				3.4.5			+
	5.3.11				Уулзалт зөвлөгөө	4.1	+	+
5.3.12	+	+	+	4.2		+		
				4.3.5		+	+	
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1				4.3.6		+	
	5.4.2				Сургалт	5.2	44	33
	5.4.3					5.3	147	82
	5.4.4	+	+	+		5.4	+	+
	5.4.6	+	+	+		5.5	+	+
				5.6		+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	5.7	+	+
	5.5.2	+	+	+		6.1	+	+
	5.5.3	+	+	+		6.2	+	+
	5.5.4					6.3	+	+
	5.5.5	+	+	+		6.4	+	+
	5.5.6							
	5.5.7							
	5.5.8	+	+	+				
5.5.9	+	+	+					
	5.6.1	+	+	+				

Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.2	+	+	+
	5.6.3	+	+	+
	5.6.4	+	+	+
	5.6.5	+	+	+
	5.6.6			
	5.6.7	+	+	+
	5.6.8			
	5.6.9	+	+	+
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+
	5.7.2	+	+	+
	5.7.3	+		+
	5.7.4	+	+	+
	5.7.5	+	+	+
	5.7.6	+	+	+
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5		
	4.2					3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4					3.2.8		+
	4.5	+	+	+		3.2.9	98	141
	4.7					3.3.1		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+	3.3.2	245	+	
	5.1.2				3.3.3	+	+	
	5.1.3	+	+	+	3.3.4			
	5.1.4	+	+	+	3.3.5	180	231	
	5.1.6				3.3.6		+	
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн	5.2.1	+	+	+	3.3.7			
	5.2.2	+	+	+	3.3.8	38	32	

болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.3				Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.3.9	+	+
	5.2.4	+	+	+		3.3.10	15	37
	5.2.5					3.3.11	+	+
	5.2.6	+				3.3.12	+	+
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	+	18			3.3.13		+
	5.3.2					3.3.14		
	5.3.3					3.4.1	+	+
	5.3.4	+	37	40		3.4.2	+	+
	5.3.6					3.4.3	+	
	5.3.7	+	+	+		3.4.4.		
	5.3.9					3.4.5	+	+
	5.3.11					Уулзалт зөвлөгөө	4.1	+
5.3.12				4.2	+			
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1	+		+	4.3.5		+	+
	5.4.2				4.3.6		+	+
	5.4.3				5.2	18	13	
	5.4.4	+	+	+	5.3	70	130	
	5.4.6				5.4	+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				Сургалт	5.5		+
	5.5.2	+	+	+		5.6	+	+
	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4					Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+
	5.5.5	+			6.2		+	+
	5.5.6				6.3		+	+
	5.5.7	+		+	6.4		+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3	+		209				
	5.6.4	+	+					
	5.6.5							
	5.6.6							
	5.6.7	624	266	106				
	5.6.8							
	5.6.9	+						
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+				
	5.7.2	+	+	+				
	5.7.3							
	5.7.4	+	+	+				
	5.7.5	+	+	+				

	5.7.6	+	+	+
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

417 дугаар нээлттэй хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5		+
	4.2		+			3.2.6	+	+
	4.3	+	+			3.2.7	+	+
	4.4		+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9	29	26
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1		+			3.3.1		
	5.1.2		+	+		3.3.2		
	5.1.3	+	+	+		3.3.3	+	+
	5.1.4	+	+	+		3.3.4		
	5.1.6					3.3.5	72	1164
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.6		+
	5.2.2		+		3.3.7		+	
	5.2.3				3.3.8	+	+	
	5.2.4	+	+	+	3.3.9	+	+	
	5.2.5		+		3.3.10	13	30	
	5.2.6	+	+	+	3.3.11	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	9	10		3.3.12	+	+	
	5.3.2				3.3.13		+	
	5.3.3				3.3.14		+	
	5.3.4	32	20	27	3.4.1	+	+	
	5.3.6	+		+	3.4.2		+	
	5.3.7	+	+	+	3.4.3			
	5.3.9				3.4.4.		+	
	5.3.11				3.4.5	+	+	
	Уулзалт зөвлөгөө	5.3.12				4.1	+	+
						4.2		

Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1	+			Сургалт	4.3.5	+	+
	5.4.2		+			4.3.6		+
	5.4.3					5.2	38	18
	5.4.4		+			5.3	48	56
	5.4.6			+		5.4	+	+
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	5.5	+	+
	5.5.2	+	+	+		5.6	+	+
	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4					6.1	+	+
	5.5.5	+	+	+	6.2	+	+	
	5.5.6			+	6.3	+	+	
	5.5.7			+	6.4	+	+	
	5.5.8	+	+	+				
5.5.9	+	+	+					
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3			5				
	5.6.4	+	+	+				
	5.6.5			+				
	5.6.6	+	+					
	5.6.7			137				
	5.6.8							
	5.6.9		+	+				
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+				
	5.7.2	+	+	+				
	5.7.3			+				
	5.7.4	+	+	+				
	5.7.5	+	+	+				
	5.7.6	+	+	+				
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

419 дүгээр нээлттэй хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"	2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019	
	3.1	+	+	+	3.2.1	+	+

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.3	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.2.	+	+	
	3.4	+	+	+		3.2.3			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1					3.2.5		+	
	4.2					3.2.6	+	+	
	4.3	+	+	+		3.2.7	+	+	
	4.4	+	+	+		3.2.8	+	+	
	4.5	+	+	+		3.2.9			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1		+			Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1		
	5.1.2		+				3.3.2		
	5.1.3	+	+	+			3.3.3	+	+
	5.1.4	+	+	+	3.3.4				
	5.1.6				3.3.5		54	140	
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+	3.3.6			+	
	5.2.2		+		3.3.7			+	
	5.2.3				3.3.8		+	2	
	5.2.4	+	+	+	3.3.9		+	+	
	5.2.5		+		3.3.10		16	9	
	5.2.6				3.3.11		+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	45	24	8	3.3.12		+	+	
	5.3.2				3.3.13			+	
	5.3.3				3.3.14				
	5.3.4	267	44	88	Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+	
	5.3.6	+	+			3.4.2	+	+	
	5.3.7	+				3.4.3			
	5.3.9					3.4.4.			
	5.3.11			2	Уулзалт зөвлөгөө	3.4.5	+	+	
5.3.12				4.1		+	+		
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1			+	Уулзалт зөвлөгөө	4.2	+	+	
	5.4.2					4.3.5	+	+	
	5.4.3				Сургалт	4.3.6	+	+	
	5.4.4	+	+			5.2	20	18	
	5.4.6					5.3	98	46	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				Сургалт	5.4	+	+	
	5.5.2	+	+			5.5			
	5.5.3	+				5.6	+	+	
	5.5.4					5.7	+	+	
	5.5.5	+	+		Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+	
	5.5.6					6.2	+	+	
	5.5.7	+				6.3	+	+	
					6.4	+	+		

	5.5.8	+	+	
	5.5.9	+	+	+
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+
	5.6.2	+	+	+
	5.6.3	222	109	
	5.6.4	+	+	
	5.6.5			
	5.6.6			
	5.6.7	366	113	
	5.6.8			
	5.6.9	+	+	+
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	
	5.7.2	+	+	
	5.7.3			
	5.7.4	+	+	
	5.7.5	+	+	
	5.7.6	+	+	
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

421 дүгээр нээлттэй хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5		+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3		+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9	232	
	4.7					3.3.1		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1		+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.2		
	5.1.2	+	+	+		3.3.3	+	+
	5.1.3	+	+	+		3.3.4		
	5.1.4	+	+	+		3.3.5		857

	5.1.6					3.3.6		+
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.7		
	5.2.2	+	+	+		3.3.8		
	5.2.3					3.3.9	+	+
	5.2.4	+	+	+		3.3.10	26	14
	5.2.5					3.3.11	+	+
	5.2.6					3.3.12	+	+
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	11	6	10		3.3.13	+	+
	5.3.2					3.3.14		
	5.3.3				Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+
	5.3.4	64	22	24		3.4.2	+	+
	5.3.6	+	+	+		3.4.3	+	
	5.3.7	+	+	+		3.4.4.		
	5.3.9					3.4.5	+	+
	5.3.11			23	Уулзалт зөвлөгөө	4.1	+	+
5.3.12				4.2		+		
5.4.1	+			4.3.5		+	+	
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.2					4.3.6	+	+
	5.4.3				Сургалт	5.2	4	7
	5.4.4	+	+	+		5.3		20
	5.4.6					5.4	+	+
	5.5.1					5.5		
5.5.2	+	+	+	5.6		+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+
	5.5.5	+				6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7			+		6.4	+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
	Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+			
		5.6.2	+	+	+			
5.6.3		1066		+				
5.6.4		+	+	+				
5.6.5		+	+					
5.6.6								
5.6.7		128	234	119				
5.6.8								
5.6.9		+	+	+				
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад	5.7.1	+	+	+				
	5.7.2	+	+	+				

бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.3		+	+
	5.7.4	+	+	+
	5.7.5	+	+	+
	5.7.6	+	+	+
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+		3.2.1	+	+	
	3.3	+	+	+		3.2.2	+	+	
	3.4					3.2.3			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+		+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.5			
	4.2	+				3.2.6	+	+	
	4.3	+	+	+		3.2.7	+	+	
	4.4	+	+	+		3.2.8	+	+	
	4.5	+	+	+		3.2.9			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1			
	5.1.2		+	+		3.3.2		+	
	5.1.3	+	+	+		3.3.3	+	+	
	5.1.4	+	+	+		3.3.4			
	5.1.6					3.3.5			
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+		+		3.3.6			
	5.2.2	+	+	+		3.3.7		+	
	5.2.3	+				3.3.8			
	5.2.4	+	+	+		3.3.9	+	+	
	5.2.5					3.3.10	6		
	5.2.6	+				3.3.11	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	17	20	3		Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.3.12	+	+
	5.3.2		+				3.3.13		+
	5.3.3						3.3.14		
	5.3.4	104	106	54	3.4.1		+	+	
	5.3.6	+	+	+	3.4.2		+	+	
	5.3.7			+	3.4.3		+		
					3.4.4				

	5.3.9					3.4.5	+	+
	5.3.11	38	7		Уулзалт зөвлөгөө	4.1	+	+
	5.3.12		+	+		4.2	+	
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1					4.3.5	+	+
	5.4.2				4.3.6	+	+	
	5.4.3				Сургалт	5.2	13	48
	5.4.4	+	+			5.3	117	141
	5.4.6					5.4	+	+
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1					5.5		+
	5.5.2	+				5.6	+	+
	5.5.3	+	+		5.7	+	+	
	5.5.4				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+
	5.5.5	+	+			6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7			+		6.4	+	+
		5.5.8						
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+		+				
	5.6.3	1651	2380	38				
	5.6.4	+	+	+				
	5.6.5							
	5.6.6	+						
	5.6.7	402						
	5.6.8							
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1		+					
	5.7.2	+		+				
	5.7.3	+						
	5.7.4		+					
	5.7.5		+					
	5.7.6		+					
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

425 дугаар нээлттэй хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх	2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар	2018	2019
---	------	------	------	---	------	------

албаны нийгмийн ажилтны ажлын заавар"					батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"				
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+	
	3.3	+	+	+		3.2.2.	+	+	
	3.4	+	+	+		3.2.3			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5		+	
	4.2	+		+		3.2.6	+	+	
	4.3	+	+	+		3.2.7	+	+	
	4.4	+	+	+		3.2.8	+	+	
	4.5		+	+		3.2.9		206	
	4.7	+				3.3.1		+	
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+		3.3.2		+	
	5.1.2	+		+	3.3.3	+	+		
	5.1.3	+	+	+	3.3.4				
	5.1.4	+	+	+	3.3.5		228		
	5.1.6				3.3.6		+		
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.7			
	5.2.2		+	+		3.3.8			
	5.2.3	+	+	+		3.3.9	+	+	
	5.2.4	+	+	+		3.3.10	37	58	
	5.2.5					3.3.11	+	+	
	5.2.6	+				3.3.12	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	56	26	18		3.3.13	+	+	
	5.3.2					3.3.14			
	5.3.3					Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+
	5.3.4	179	85	84			3.4.2	+	+
	5.3.6				3.4.3		+		
	5.3.7	+	+	+	3.4.4.				
	5.3.9	13	11		3.4.5	+	+		
	5.3.11	75			Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
5.3.12	+			4.2		+			
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1				4.3.5	+	+		
	5.4.2				4.3.6	+	+		
	5.4.3				Сургалт	5.2	16	11	
	5.4.4	+	+	+		5.3	65	62	
	5.4.6			+		5.4	+	+	
				5.5					
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус	5.5.1	+			5.6	+	+		
	5.5.2	+	+		5.7	+	+		
	5.5.3	+	+	+					
	5.5.4				6.1	+	+		

байгууллагын оролцоог хангах	5.5.5	+	+	+	Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7	+		+		6.4	+	+
	5.5.8	+	+					
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3	1922	23	124				
	5.6.4	+	+	+				
	5.6.5							
	5.6.6							
	5.6.7	107	122	153				
	5.6.8							
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+				
	5.7.2	+	+	+				
	5.7.3		+					
	5.7.4		+	+				
	5.7.5			+				
	5.7.6			+				
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

427 дугаар хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5	+	+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9		
	4.7					Хорих өрөөнд хуваарилан хорих ял	3.3.1	
	5.1.1	+	+	+	3.3.2			

Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.2	+	+	+	эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.3	+	+	
	5.1.3	+	+	+		3.3.4			
	5.1.4	+	+	+		3.3.5	110	46	
	5.1.6					3.3.6	+	+	
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.7			
	5.2.2	+	+	+		3.3.8	23	+	
	5.2.3					3.3.9	+	+	
	5.2.4	+	+	+		3.3.10	15	50	
	5.2.5	+	+			3.3.11	+	+	
	5.2.6	+	+			3.3.12	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	15		38		3.3.13	+	+	
	5.3.2					3.3.14			
	5.3.3					Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+
	5.3.4	121	72	63			3.4.2	+	+
	5.3.6	+	+		3.4.3				
	5.3.7	+	+	+	3.4.4		+	+	
	5.3.9				3.4.5		+	+	
	5.3.11	18	17		Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
5.3.12				4.2					
5.4.1	+	+	+	4.3.5		+	+		
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.2	+	+	+	4.3.6	+			
	5.4.3				Сургалт	5.2	27	17	
	5.4.4	+	+	+		5.3	67	83	
	5.4.6	+				5.4	+	+	
	5.5.1					5.5	+		
5.5.2	+	+	+	5.6		+	+		
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.3	+	+	+	Бүртгэл судалгаа мэдээллийн сан	5.7	+	+	
	5.5.4					6.1	+	+	
	5.5.5	+		+		6.2	+	+	
	5.5.6					6.3	+	+	
	5.5.7			+	6.4	+	+		
	5.5.8	+	+	+					
	5.5.9	+	+	+					
	Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
5.6.2		+	+	+					
5.6.3		110	26	202					
5.6.4		+	+	+					
5.6.5									
5.6.6		+	+						
5.6.7									
5.6.8									

	5.6.9	+		+
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+
	5.7.2	+	+	+
	5.7.3	+	+	
	5.7.4	+	+	+
	5.7.5	+	+	+
	5.7.6	+	+	+
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.		
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.5		
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+		+		3.2.8	+	
	4.5	+	+	+		3.2.9	78	71
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1		
	5.1.2	+	+	+		3.3.2		+
	5.1.3	+	+	+		3.3.3	+	+
	5.1.4	+	+			3.3.4		
	5.1.6					3.3.5	7	30
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+		+		3.3.6		
	5.2.2	+	+	+		3.3.7		
	5.2.3					3.3.8	+	+
	5.2.4	+		+		3.3.9	+	+
	5.2.5					3.3.10	8	29
	5.2.6					3.3.11	+	+
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт	5.3.1	+	9	2		3.3.12	+	+
	5.3.2					3.3.13		+
	5.3.3					3.3.14		
					3.4.1	+		

зохион байгуулах ажиллагаа.	5.3.4	+	21		Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.2			
	5.3.6	+	+			3.4.3			
	5.3.7	+	+	+		3.4.4.			
	5.3.9					3.4.5	+		
	5.3.11				Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
	5.3.12	+	+			4.2			
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1	+	+			4.3.5			
	5.4.2				4.3.6				
	5.4.3				Сургалт	5.2	3	12	
	5.4.4			+		5.3	55	37	
	5.4.6					5.4	+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1					5.5	+		
	5.5.2	+		+	5.6	+	+		
	5.5.3	+	+	+	5.7	+	+		
	5.5.4				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+	
	5.5.5					6.2	+	+	
	5.5.6					6.3	+	+	
	5.5.7					6.4	+	+	
	5.5.8	+	+	+	Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	
5.5.9	+	+	+	5.6.2		+	+		
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.6.1	+	+	+		5.6.3	+	12	12
	5.6.2	+	+	+		5.6.4	+	+	+
	5.6.3	+	12	12		5.6.5			
	5.6.4	+	+	+		5.6.6			
	5.6.5					5.6.7	+	94	263
	5.6.6					5.6.8			
	5.6.7	+	94	263		5.6.9	+	+	+
	5.6.8				Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+
	5.6.9	+	+	+		5.7.2	+	+	+
5.7.1	+	+	+	5.7.3		+	+	+	
5.7.2	+	+	+	5.7.4		+	+	+	
5.7.3	+	+	+	5.7.5		+	+	+	
5.7.4	+	+	+	5.7.6		+	+	+	
5.7.5	+	+	+	6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа	+	+	+		
5.7.6	+	+	+	7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх	+	+	+		

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлтын ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+	
	3.3	+	+	+		3.2.2.	+	+	
	3.4	+	+	+		3.2.3			
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5	+	+	
	4.2	+	+	+		3.2.6	+	+	
	4.3	+	+	+		3.2.7	+	+	
	4.4	+	+	+		3.2.8	+	+	
	4.5	+	+	+		3.2.9	45		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	4.7			+		Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1		
	5.1.1	+	+	+	3.3.2			+	
	5.1.2	+	+	+	3.3.3		+	+	
	5.1.3	+	+	+	3.3.4				
	5.1.4	+	+	+	3.3.5		165		
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.1.6				3.3.6		+	+	
	5.2.1	+	+	+	3.3.7				
	5.2.2	+	+	+	3.3.8		+	+	
	5.2.3			+	3.3.9		+	+	
	5.2.4	+	+	+	3.3.10		+	+	
	5.2.5				3.3.11		+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.2.6	+	+		3.3.12		+	+	
	5.3.1	+	26	68	3.3.13		+	+	
	5.3.2				3.3.14				
	Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.3				Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+
		5.3.4	+	72	145		3.4.2	+	+
		5.3.6					3.4.3	+	
		5.3.7	+	+	+		3.4.4.	+	
		5.3.9					3.4.5	+	+
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.3.11				Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
	5.3.12					4.2			
	5.4.1	+		+		4.3.5	+	+	
	Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг,	5.4.2	+		+	Сургалт	4.3.6	+	
		5.4.3					5.2	27	42
5.4.4		+	+	+	5.3		126	43	
5.4.6					5.4		+	+	
5.5.1				5.5	+				
5.5.2	+	+	+	5.6	+		+		
5.5.3	+	+	+	5.7	+		+		

төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.4				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+
	5.5.5			+		6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7					6.4	+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3	+	1354	2964				
	5.6.4	+	+	+				
	5.6.5	+	+	+				
	5.6.6		+					
	5.6.7	+	58	94				
	5.6.8							
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+		+				
	5.7.2	+		+				
	5.7.3	+						
	5.7.4	+		+				
	5.7.5	+		+				
	5.7.6	+		+				
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

435 дугаар хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"	2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	3.2.1	+	+
	3.3	+	+	+	3.2.2	+	+
	3.4	+	+	+	3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+	3.2.5	+	+
	4.2	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+	3.2.7	+	+
	4.4	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+	3.2.9		
	4.7				3.3.1		+

Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.2		+	
	5.1.2	+	+			3.3.3	+	+	
	5.1.3	+	+	+		3.3.4			
	5.1.4	+	+	+		3.3.5	100	125	
	5.1.6					3.3.6	+	+	
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.7			
	5.2.2	+	+	+		3.3.8	15		
	5.2.3					3.3.9	+	+	
	5.2.4	+	+	+		3.3.10	10	23	
	5.2.5					3.3.11	+	+	
	5.2.6			+		3.3.12	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	6	18	15		3.3.13	+	+	
	5.3.2					3.3.14			
	5.3.3					3.4.1	+	+	
	5.3.4	41	70	28	3.4.2	+	+		
	5.3.6	+	+	+	3.4.3	2			
	5.3.7	+	+	+	3.4.4.	+	+		
	5.3.9				3.4.5	+	+		
	5.3.11				4.1	+	+		
5.3.12				4.2					
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1		+		Уулзалт зөвлөгөө	4.3.5	+	+	
	5.4.2		+			4.3.6	+	+	
	5.4.3					5.2	1	25	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.4.4	+	+		Сургалт	5.3	29	53	
	5.4.6					5.4	+	+	
	5.5.1					5.5		+	
	5.5.2	+	+	+		5.6	+	+	
	5.5.3	+	+	+		5.7	+	+	
	5.5.4					Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+
	5.5.5						6.2	+	+
	5.5.6						6.3	+	+
	5.5.7						6.4	+	+
	5.5.8	+	+	+					
5.5.9	+	+	+						
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+					
	5.6.2	+	+	+					
	5.6.3	28	100	268					
	5.6.4	+	+	+					
	5.6.5								
	5.6.6			+					
	5.6.7		424	237					

	5.6.8			
	5.6.9	+		
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+
	5.7.2	+	+	+
	5.7.3		+	+
	5.7.4	+	+	+
	5.7.5	+	+	+
	5.7.6	+	+	+
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

437 дугаар нээлттэй хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015-2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+		3.2.2	+	+
	3.4	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+		3.2.5	+	+
	4.2	+		3.2.6	+	+
	4.3	+		3.2.7	+	+
	4.4	+		3.2.8	+	+
	4.5	+		3.2.9		
	4.7	+		3.3.1		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+		3.3.2		
	5.1.2	+		3.3.3	+	+
	5.1.3	+		3.3.4		
	5.1.4	+		3.3.5		108
	5.1.6	+		3.3.6	+	+
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, тусалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.7	+	
	5.2.2	+		3.3.8	+	+
	5.2.3	+		3.3.9		+
	5.2.4	+		3.3.10		21
	5.2.5			3.3.11	+	+
	5.2.6			3.3.12	+	+
Хоригдогчийг чадваржуулах	5.3.1	12		3.3.13	+	+
	5.3.2			3.3.14	+	

чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.3		Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+	
	5.3.4	18		3.4.2	+	+	
	5.3.6	+		3.4.3			
	5.3.7	+		3.4.4.			
	5.3.9			3.4.5	+	+	
	5.3.11			Уулзалт зөвлөгөө	4.1	+	+
	5.3.12				4.2		
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1	+		4.3.5	+	+	
	5.4.2	+		4.3.6	+	+	
	5.4.3		Сургалт	5.2	24	25	
	5.4.4	+		5.3	14	35	
	5.4.6			5.4	+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1			5.5			
	5.5.2	+		5.6	+	+	
	5.5.3	+		5.7	+	+	
	5.5.4		Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+	
	5.5.5	+		6.2	+	+	
	5.5.6			6.3	+	+	
	5.5.7			6.4	+	+	
	5.5.8	+					
	5.5.9	+					
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+					
	5.6.2	+					
	5.6.3	125					
	5.6.4	+					
	5.6.5	+					
	5.6.6						
	5.6.7	140					
	5.6.8						
5.6.9	+						
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+					
	5.7.2	+					
	5.7.3						
	5.7.4	+					
	5.7.5	+					
	5.7.6	+					
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа							
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх							

439 дүгээр хаалттай хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5	+	+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+		Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1	
	5.1.2	+	+	+	3.3.2			
	5.1.3	+	+	+	3.3.3		+	+
	5.1.4	+	+	+	3.3.4			
	5.1.6				3.3.5		128	27
	Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+		3.3.6	+
5.2.2		+	+	+	3.3.7		+	+
5.2.3					3.3.8		+	+
5.2.4		+	+	+	3.3.9			+
5.2.5					3.3.10		8	44
5.2.6					3.3.11		+	+
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	18	4	19	3.3.12		+	+
	5.3.2				3.3.13		+	+
	5.3.3				3.3.14		+	+
	5.3.4	9	56	22	Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+
	5.3.6	+	+	+		3.4.2	+	+
	5.3.7	+	+	+		3.4.3		
	5.3.9					3.4.4		
	5.3.11		4	2	3.4.5	+	+	
5.3.12				Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1					4.2		
	5.4.2	+	+		+	4.3.5	+	+
	5.4.3				4.3.6	+	+	
	5.4.4	+	+	+	Сургалт	5.2	13	19
	5.4.6			+		5.3	+	20
5.5.1				5.4		+	+	
					5.5	+	+	

Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.2	+	+	+	Бүртгэл судалгаа мэдээллийн сан	5.6	+	+
	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4					6.1	+	+
	5.5.5	+	+			6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7			+		6.4	+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3							
	5.6.4	+	+	+				
	5.6.5	+						
	5.6.6							
	5.6.7	+	53	106				
	5.6.8							
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1		+	+				
	5.7.2		+	+				
	5.7.3		+	+				
	5.7.4		+	+				
	5.7.5		+	+				
	5.7.6		+	+				
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

445 дугаар нээлттэй хорих анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"	2018	2019	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5	+	+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+

	4.5	+	+	+		3.2.9			
	4.7					3.3.1		+	
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+		3.3.2			
	5.1.2	+	+	+		3.3.3	+	+	
	5.1.3	+	+	+		3.3.4			
	5.1.4	+	+	+		3.3.5	+	61	
	5.1.6					3.3.6	+	+	
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, тусалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+	Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.7	+	+	
	5.2.2	+	+	+		3.3.8	+	+	
	5.2.3					3.3.9	+	+	
	5.2.4	+	+	+		3.3.10		81	
	5.2.5			+		3.3.11	+	+	
	5.2.6		+			3.3.12	+	+	
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	+	12	10		3.3.13	+	+	
	5.3.2					3.3.14	+	+	
	5.3.3					Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	+	+
	5.3.4	+	74	202			3.4.2	+	+
	5.3.6						3.4.3		
	5.3.7	+		+			3.4.4		
	5.3.9					3.4.5	+	+	
	5.3.11					Уулзалт зөвлөгөө	4.1	+	+
5.3.12	+			4.2					
				4.3.5	+		+		
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1	+			4.3.6	+	+		
	5.4.2	+	+	+	Сургалт	5.2	16	22	
	5.4.3					5.3	20	17	
	5.4.4	+	+	+		5.4	+	+	
	5.4.6					5.5		+	
				5.6		+	+		
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+	
	5.5.2	+	+	+		6.2	+	+	
	5.5.3	+	+	+		6.3	+	+	
	5.5.4					6.4	+	+	
	5.5.5	+	+						
	5.5.6								
	5.5.7	+		+					
	5.5.8	+	+	+					
	5.5.9	+	+	+					
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+					
	5.6.2	+	+	+					
	5.6.3	+	+						
	5.6.4	+	+	+					
	5.6.5	+		+					
	5.6.6								

	5.6.7	+	219	196
	5.6.8			
	5.6.9	+	+	+
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+
	5.7.2	+	+	162
	5.7.3	+		
	5.7.4	+		
	5.7.5	+	+	+
5.7.6	+	+	+	
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+

Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5	+	+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9		
	4.7					3.3.1		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+		3.3.2		
	5.1.2	+	+	+		3.3.3	+	+
	5.1.3	+	+	+		3.3.4		
	5.1.4	+				3.3.5	68	114
	5.1.6				3.3.6	+	+	
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+	3.3.7	+	+	
	5.2.2	+	+	+	3.3.8	35	25	
	5.2.3				3.3.9			
	5.2.4	+	+	+	3.3.10	10		
	5.2.5				3.3.11	+	+	
	5.2.6				3.3.12	+	+	
	5.3.1				3.3.13	+	+	

Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.2				Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.3.14	+	+
	5.3.3					3.4.1	+	+
	5.3.4	12	16			3.4.2	+	+
	5.3.6	+				3.4.3		
	5.3.7	+	+	+		3.4.4.		
	5.3.9					3.4.5	+	+
	5.3.11					Уулзалт зөвлөгөө	4.1	+
5.3.12				4.2				
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1		+	+	Уулзалт зөвлөгөө	4.3.5	+	+
	5.4.2			+		4.3.6	+	+
	5.4.3					Сургалт	5.2	
	5.4.4	+	+	+	5.3			
	5.4.6				5.4	+	+	
Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	5.5		
	5.5.2	+	+	+		5.6	+	+
	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4					6.1	+	+
	5.5.5					6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7		+			6.4	+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3	+	32	+				
	5.6.4	+	+	+				
	5.6.5		+					
	5.6.6							
	5.6.7	1896	3310	3846				
	5.6.8							
	5.6.9	+	+	+				
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1							
	5.7.2							
	5.7.3							
	5.7.4							
	5.7.5							
	5.7.6							
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"		2015	2016	2017	ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"		2018	2019
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа	3.1	+	+	+	Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.2.1	+	+
	3.3	+	+	+		3.2.2.	+	+
	3.4	+	+	+		3.2.3		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ	4.1	+	+	+		3.2.5		+
	4.2	+	+	+		3.2.6	+	+
	4.3	+	+	+		3.2.7	+	+
	4.4	+	+	+		3.2.8	+	+
	4.5	+	+	+		3.2.9		
Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох	5.1.1	+	+	+		Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил	3.3.1	
	5.1.2	+	+	+	3.3.2			
	5.1.3	+	+	+	3.3.3		+	+
	5.1.4	+	+	+	3.3.4			
	5.1.6				3.3.5			
Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.	5.2.1	+	+	+	3.3.6			
	5.2.2	+	+	+	3.3.7			
	5.2.3				3.3.8		26	20
	5.2.4	+	+	+	3.3.9			+
	5.2.5				3.3.10			9
	5.2.6	+	+	+	3.3.11		+	+
Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.	5.3.1	21	9	6	3.3.12		+	+
	5.3.2				3.3.13			
	5.3.3				3.3.14			
	5.3.4	70	35	6	Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил	3.4.1	72	+
	5.3.6		+	+		3.4.2		
	5.3.7					3.4.3		
	5.3.9		+			3.4.4.		
	5.3.11	+			3.4.5	+	+	
5.3.12		+		Уулзалт зөвлөгөө	4.1	+	+	
Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа	5.4.1					4.2	+	
	5.4.2	+	+			4.3.5	+	+
	5.4.3				4.3.6		+	
	5.4.4	+	+	+	Сургалт	5.2	20	+
	5.4.6					5.3	36	+
					5.4	+	+	

Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхжуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах	5.5.1				5.5	+	+	
	5.5.2	+	+	+		5.6		+
	5.5.3	+	+	+		5.7	+	+
	5.5.4				Бүртгэл судалгаа мэдээллийн сан	6.1	+	+
	5.5.5			+		6.2	+	+
	5.5.6					6.3	+	+
	5.5.7	+	+	+		6.4	+	+
	5.5.8	+	+	+				
	5.5.9	+	+	+				
Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа	5.6.1	+	+	+				
	5.6.2	+	+	+				
	5.6.3	27	+	16				
	5.6.4	+	+	+				
	5.6.5		+					
	5.6.6		+	+				
	5.6.7		22	6				
	5.6.8							
	5.6.9	+	+	+				
Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа	5.7.1	+	+	+				
	5.7.2	+	+	+				
	5.7.3	+	+	+				
	5.7.4	+	+	+				
	5.7.5	+	+	+				
	5.7.6	+	+	+				
6.Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа		+	+	+				
7.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх		+	+	+				

	ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"-ын 60 заалтаар дүгнэхэд			ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Нийгмийн ажлын аргачилсан заавар"-ын 41 заалтаар дүгнэхэд	
	2015	2016	2017	2018	2019
401	58.3%	56.60%	51.60%	56.00%	78.00%
405	58.30%	68.30%	65.00%	65.80%	29.00%
407	73.3.%	73.30%	73.30%	82.90%	75.60%
409	65.00%	65.00%	60.00%	56.00%	80.40%
411	65.00%	73.30%	68.30%	56.00%	65.80%
413	71.60%	70.00%	71.60%	75.60%	80.40%
415	63.30%	51.60%	51.60%	73.10%	78.00%
417	53.30%	68.30%	60.00%	65.80%	85.30%
419	56.60%	58.30%	33.30%	68.20%	78.00%
421	63.30%	63.30%	66.60%	68.20%	73.10%
423	56.60%	51.60%	45.00%	65.80%	68.20%
425	65.00%	58.30%	37.00%	68.20%	78.00%
427	75.00%	68.30%	65.00%	78.00%	73.10%
429	65.00%	58.30%	58.30%	60.90%	58.50%
433	68.30%	56.60%	71.60%	82.90%	70.70%
435	60.00%	65.00%	58.30%	78.00%	80.40%
437	73.30%			70.70%	73.10%
439	56.60%	66.60%	68.30%	78.00%	80.40%
441	2019 оноос нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж эхэлсэн				
445	71.60%	61.60%	63.30%	75.60%	82.90%
457	Архивын нэгж үүсгэж тайлан хадгалаагүй				
461	51.60%	53.30%	50.00%	70.70%	68.20%